Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч хэрэг хянан шийдвэрлэхэд нэг хэрэгт дунджаар 466.3 минут буюу 7.8 цаг 1 ажлын өдөр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хийж байна. Хэргийг шүүгч хүлээн авах шатанд дунджаар 8.6 хувь буюу 40 минутыг зарцуулж байна. Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шатны ажиллагаанд 88.7 хувь буюу 413.5 минутыг зарцуулж байна. Хэргийг эцэслэн шийдвэрлэсний дараах ажиллагааны шатанд 2.8 хувь буюу 12.9 минутыг зарцуулж байна.

Хүснэгт 83. Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн ачаалал дундаж

Ажиллагаа	Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Дархан-Уул аймаг дахь иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Дундаж	Эзлэх хувь
Хэргийг шүүгч хүлээн авах үе шат	35.5	44.5	40.0	8.6
Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шат	369.2	457.7	413.5	88.7
Хэргийг эцэслэн шийдвэрлэсний дараах ажиллагаа	10.7	15	12.9	2.8
Нийт хугацаа	415.4	517.2	466.3	100

Ерөнхий шүүгчийн хувьд хийгддэг ажиллагаанд дунджаар 155 минут буюу 2.5 цагийг шүүгчээс илүүгээр зарцуулж байна. Бусад ажиллагаанд дунджаар 300 минут буюу 5 цаг зарцуулж байна.

3.3. ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХ ДЭХ ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ АЧААЛЛЫН СУДАЛГААЫ

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх дэх шүүн таслах ажиллагаанд зарцуулж буй хугацааг хуульд заасан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны онцлогт тулгуурлан авч үзэж, холбогдох асуумжийн дагуу ажлын байранд ажиглан тодорхойлов.

Захиргааны хэргийн давж заалдах шатны нэг шүүгч жилд дунджаар 62.6 хэрэг, маргаан хянан шийдвэрлэдэг бол нэг хэргийг эцэслэн шийдвэрлэхэд **ажлын 10.4 өдөр** зарцуулж байна. Өөрөөр хэлбэл захиргааны хэргийн давж заалдах шатны нэг шүүгч жилд 62.6 хэрэг, маргааныг эцэслэн шийдвэрлэхэд 651.04 ажлын өдрийг зарцуулахаар байна.

Шүүгч Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу жилд дунджаар ажлын 52 долоо хоног 2080 цаг ажиллах ёстой бөгөөд үүнээс ээлжийн амралтыг дунджаар ажлын дөрвөн долоо хоног гэж тооцвол 48 долоо хоног буюу 1920 цаг (ажлын өдөрт 8 цаг) ажиллана. Захиргааны нэг хэрэгт дунджаар 83.6 цаг зарцуулж байгааг харгалзан тооцоход жилд нэг шүүгч дунджаар 22.9 хэрэг (1920цаг/83.6 цаг) шийдвэрлэх боломжтой байна.

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч 1 жилд дунджаар 62.6 хэрэг хянан шийдвэрлэдэг, нэг хэрэг хянан шийдвэрлэхэд нийт 10.4 өдөр зарцуулахаар байна гэсэн дүн гарсан нь **ХААИС-ийн судлаачдын багийн гаргасан Захиргааны хэргийн шүүгч 1 жилд дунджаар 34 хэрэг хянан шийдвэрлэнэ гэж дүгнэснээс даруй 1.8 дахин их байна.**

ХААИС-ийн судлаачдын дүгнэлтэд Захиргааны хэргийн Давж заалдах шатны шүүх 16.4 шүүгчийн орон тоо дутагдалтай ажиллаж байна гэсэн дүгнэсэн нь үндэслэлтэй байна.

I.Захиргааны хэргийн давж заалдах шатны Ерөнхий шүүгч болон шүүгчийн ажиллагааны ачааллын судалгаа

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн ажиллагаанд нийт 42 ажиллагаа багтсан байна. Ерөнхий шүүгч, шүүгч захиргааны 1 хэрэг, маргаан шийдвэрлэхэд дунджаар 5015.5 минут /83.6 цаг, ажлын 10.4 өдөр/ зарцуулж байна.

Хүснэгт 84. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн ажиллагаа /хугацаагаар/

Ажиллагаа	Ерөнхий шүүгч болон шүүгч		
	Дундаж	Эзлэх хувь	
Улсын тэмдэгтийн хураамж төлсөн эсэхийг шалгах	11.4	0.2	
Гомдол, түүнд хавсаргасан баримттай уншиж танилцах	387.3	7.7	
Гомдлыг хүлээн авахаас татгалзах үндэслэл байгаа эсэхийг шалгасан туслахын ажиллагааг хянах	54.5	1.1	
Нөлөөллийн мэдүүлэг хөтөллдөг талаар мэдээлэл өгсөн баримтыг хянах	17.5	0.3	
Хариу тайлбартай танилцах	162.3	3.2	
Гомдол гаргаагүйд тооцох	61.4	1.2	
Хэргийн оролцогчоос ХХША-тай холбоотой хүсэлт гаргасан тохиолдолд шийдвэрлэх, захирамж гаргах	60.0	1.2	
Хэргийн материалыг уншиж судлах	Уншиж судлах	632.7	12.6
	АШШ-ны журам зөрчсөн эсэхийг хянах	349.1	7.0
	Түүвэр гаргах	91.4	1.8
	Шаардлагатай хууль, тогтоомжийг судлах	136.4	2.7
	Шүүхийн практик судлах	109.1	2.2
Шүүх хуралдааныг хэзээ товловол боломжтойг тодруулах, шүүх хуралдааныг товлох талаар шүүгчийн туслахад чиглэл өгөх	13.2	0.3	
Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх тухай захирамжийг хянах, гарын үсэг зурах	Боловсруулсан	36.8	0.7
	Хянасан, гарын үсэг зурсан	20.9	0.4
Хэргийн оролцогчдод шүүх хуралдааны тов мэдэгдэх хуудсыг хянаж, гарын үсэг зурах	17.5	0.3	
Шүүх хуралдаан	Шүүх хуралдаан явагдсан	94.1	1.9
	Зөвлөлдөх	30.0	0.6
	Илтгэгч	28.6	0.6
Шүүх хуралдааны тэмдэглэл хянаж, гарын үсэг зурах	49.1	1.0	

Шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурах	Шүүгчийн захирамж	Боловсруулсан	88.6	1.8
		Хянасан, гарын үсэг зурсан	24.5	0.5
	Шүүхийн шийтгэвэр	Боловсруулсан	75.0	1.5
		Хянасан, гарын үсэг зурсан	24.5	0.5
	Шүүхийн тогтоол	Боловсруулсан	113.2	2.3
		Хянасан, гарын үсэг зурсан	24.5	0.5
Шүүхийн магадлал	Боловсруулсан	545.5	10.9	
	Хянасан, гарын үсэг зурсан	163.6	3.3	
Бүрэлдэхүүнд даргалагч	Магадлал	Боловсруулсан	73.6	1.5
		бусад шүүгчдийн саналыг тусгах	95.5	1.9
	Тогтоол	хянаж, гарын үсэг зурсан	30.0	0.6
		бусад шүүгчдийн саналыг тусгах	68.2	1.4
		Боловсруулсан	98.2	2.0
	Тэмдэглэл	хянаж, гарын үсэг зурсан	30.0	0.6
		Саналыг тусгаж, засвар оруулах	84.5	1.7
Бүрэлдэхүүн	Магадлалын төсөлд санал өгөх	хянаж, гарын үсэг зурсан	24.5	0.5
		Тогтоолын төсөлд санал өгөх	42.3	0.8
	Тогтоолын төсөлд санал өгөх	49.1	1.0	
Илтгэгч	Магадлал, тогтоол	Төсөл бичих	632.7	12.6
		даргалагч, бүрэлдэхүүнээс ирүүлсэн саналуудыг төсөл тусгах эсэх	111.8	2.2
		Саналыг тусган боловсруулах	231.8	4.6
		Гарын үсэг зурах	20.5	0.4
Нийт хугацаа /минутаар/			5015.5	100.0


Үүнээс хамгийн их хугацааг хэргийн материалыг уншиж судлахад 632.7 минут, магадлал тогтоолын төсөл бичихэд 632.7 минут, шүүхийн магадлал боловсруулахад 545.5 минут, гомдол, түүнд хавсаргасан баримттай уншиж танилцахад 387.3 минут, хэргийн материалыг уншиж анхан шатны журам зөрчсөн эсэхийг хянахад 349.1 минутыг тус тус зарцуулж байна.

График 55. Хэргийн материалыг уншиж судлах хугацаа



Хэргийн материалыг уншиж судлахад 1318.6 минут зарцуулж байгаа бөгөөд нийт ажиллагааны 26.1 хувийг эзэлж байна. Үүнээс хэргийн материалыг уншиж судлахад 632.7 минут, АШШ-ны журам зөрчсөн эсэхийг хянахад 349.1 минут, шаардлагатай хууль, тогтоомжийг судлахад 136.4 минут, шүүхийн практик судлахад 109.1 минут, түүвэр гаргахад 182.7 минутыг тус тус зарцуулж байна.

График 56. Шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурах хугацаа



Шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурахад 1059.5 минут зарцуулж байгаа бөгөөд нийт ажиллагааны 21 хувийг эзэлж байна. Үүнээс шүүхийн магадлал боловсруулах хянаж гарын үсэг зурахад 709.1 минут, шүүхийн тогтоол боловсруулах, хянаж гарын үсэг зурахад 137.7 минут, шүүгчийн захирамж боловсруулах хянаж гарын үсэг зурахад 113.2 минут, шүүхийн шийтгэвэр боловсруулах хянаж гарын үсэг зурахад 99.6 минут тус тус зарцуулж байна.

Хүснэгт 85. Маргааны төрлөөр зарцуулах хугацаа


№	Маргааны төрөл	Нийт хугацаа /минутаар/	Эзлэх хувь
1.	Газрын	5415	4.9
2.	Төрийн албаны	5415	4.9
3.	Төрийн хяналт, шалгалттай холбоотой	5415	4.9
4.	Ашигт малтмалтай холбоотой	5415	4.9
5.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авахтай холбоотой /тендер/	5415	4.9
6.	Татварын	5965	5.4
7.	Улсын бүртгэлтэй холбоотой	5965	5.4
8.	Нийгмийн даатгалтай холбоотой	5965	5.4
9.	Тусгай зөвшөөрөлтэй холбоотой	5965	5.4
10.	Барилгын эрх зүйн маргаан	5965	5.4
11.	Улсын байцаагчийн акттай холбоотой	5965	5.4
12.	Байгаль орчныг хамгаалахтай холбоотой	5965	5.4
13.	Боловсролтой холбоотой	5965	5.4
14.	Санхүүгийн зохицуулах хороотой холбоотой	5965	5.4
15.	Хүүхдийн эрхтэй холбоотой	3555	3.2
16.	Шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах, хэрэглэгчийн эрх ашигтай холбоотой	3735	3.4
17.	Зохиогчийн эрх, барааны тэмдэгтэй холбоотой	3765	3.4
18.	Нийтийн өмчийг хамгаалахтай холбоотой	3675	3.3
19.	Гаальтай холбоотой маргаан	3675	3.3
20.	Оюуны өмчтэй холбоотой	3765	3.4
21.	Нийтийн эрүүл мэндтэй холбоотой	3705	3.4
22.	Зам тээвэртэй холбоотой маргаан	3705	3.4
23.	Дундаж	5015.45	100.0

Маргааны төрлийн хувьд Ерөнхий шүүгч болон шүүгч захиргааны 1 хэрэг, маргаан эцэслэн шийдвэрлэхэд дунджаар 5015.5 минут зарцуулж байгаа бөгөөд хамгийн их хугацааг татвар, улсын бүртгэл, нийгмийн даатгал, тусгай зөвшөөрөл, барилга, улсын байцаагчийн акт, байгаль орчныг хамгаалах, боловсрол, санхүүгийн зохицуулах хороотой холбоотой хэрэг, маргаануудад зарцуулж байна.

Захиргааны хэргийн давж заалдах шатны 1 шүүгч жилд дунджаар 62.6 хэрэг, маргаан хянан шийдвэрлэдэг бол 1 хэргийг эцэслэн шийдвэрлэхэд ажлын 10.4 өдөр зарцуулж байна. Өөрөөр хэлбэл захиргааны хэргийн анхан шатны 1 шүүгч жилд 62.6 хэрэг, маргааныг эцэслэн шийдвэрлэхэд 651.04 ажлын өдрийг зарцуулахаар байна.


II. Бусад ажиллагаа

График 57. Ерөнхий шүүгчийн бусад ажиллагаа



Ерөнхий шүүгчийн хувьд бусад ажиллагаанд 780 минутыг дунджаар зарцуулж байна. Шүүх бүрэлдэхүүнд ороход 600 минут, захиргааны хэргийн бүртгэл хяналтын нэгдсэн системд ажиллагаа хийхэд 60 минут, шүүгчдийн зөвлөгөөний тогтоол хянахад 120 минут тус тус зарцуулж байна.

График 58. Шүүгчийн бусад ажиллагаа



Шүүгчийн хувьд бусад ажиллагаанд 700 минутыг дунджаар зарцуулж байна. Шүүх бүрэлдэхүүнд ороход 400 минут, захиргааны хэргийн бүртгэл хяналтын нэгдсэн системд ажиллагаа хийхэд 120 минут, шүүгчдийн зөвлөгөөний тогтоол хянахад 180 минут тус тус зарцуулж байна.

III. Захиргааны хэргийн давж заалдах шатны Ерөнхий шүүгч болон шүүгчийн туслахын ажиллагааны ачааллын судалгаа

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн ерөнхий шүүгчийн болон шүүгчийн ажиллагаанд нийт 21 ажиллагаа багтсан байна. Ерөнхий шүүгчийн болон шүүгчийн туслах захиргааны 1 хэрэг, маргаан шийдвэрлэх ажиллагааг гүйцэтгэхэд дунджаар 5487 минут /91.5 цаг, ажлын 11.4 өдөр/ зарцуулж байна.

Хүснэгт 86. Захиргааны хэргийн давж заалдах шатны Ерөнхий шүүгч болон шүүгчийн туслахын ажиллагааны ачаалал


Ажиллагаа /минутаар/	Ерөнхий шүүгчийн болон шүүгчийн туслах
----------------------	--

		Дундаж	Эзлэх хувь	
Хэргийг хүлээн авах, шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээс өмнөх үе шат	Гомдол, түүнд хавсаргасан баримттай уншиж танилцан шүүгчид танилцуулах	188.2	3.4	
	Гомдлыг хүлээн авахаас татгалзах үндэслэл байгаа эсэхийг шалгаж, захирамжийн төсөл боловсруулах	94.1	1.7	
	Нөлөөллийн мэдүүлэг танилцуулах	32.7	0.6	
	Итгэмжлэлийн хугацаа шалгах	62.7	1.1	
	Хэргийн материал танилцуулах	501.8	9.1	
	Уншиж судлах	785.5	14.3	
	ХХША-г төлөвлөх	152.7	2.8	
	Хэргийн материалтай танилцах	501.8	9.1	
	Түүвэр хийх	501.8	9.1	
	Шаардлагатай хууль тогтоомжийг судлах	501.8	9.1	
Шүүхийн практик судлах	752.7	13.7		
Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шат	Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх тухай захирамжийн төсөл боловсруулах	250.9	4.6	
	Шүүх хуралдааны товыг зард бүртгүүлэх	31.4	0.6	
	Хэргийн оролцогчдод шүүх хуралдааны тов мэдэгдэх	утсаар	125.5	2.3
	Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхтэй холбоотой шаардлагатай хууль тогтоомж, шүүхийн практик судлах	752.7	13.7	
	Шүүх хуралдаан даргалагч, шүүх бүрэлдэхүүн томилсныг албажуулах тухай Ерөнхий шүүгчийн захирамжийг боловсруулах, хэрэгт хавсаргах	125.5	2.3	
	Шүүх хуралдааны заалыг бэлтгэх	62.7	1.1	
Хэргийг шийдвэрлэсний дараах ажиллагаа	Шүүх хуралдааны тэмдэглэл хянах	125.5	2.3	
	Шүүх хуралдаан хойшлуулах захирамжийн төсөл боловсруулах	85.6	1.6	
	Шүүхийн магадлалын төсөл боловсруулах	188.2	3.4	
	Хэргийг эмхэтгэх	106.4	1.9	
	Шүүхийн шийдвэрийг гардуулах	58.6	1.1	
Нийт хугацаа		5487.0	100.0	

Хэргийг хүлээн авах, шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээс өмнөх үе шат 3574.1, хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шат 1348.6 минут, хэргийг шийдвэрлэсний дараах ажиллагаа 564.3 минут тус тус зарцуулж байна.

Хэргийг хүлээн авах, шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээс өмнөх үе шатнаас хэргийн материалтай танилцах ажиллагаа хамгийн өндөр байгаа бөгөөд энэ үе шатны ажиллагааны 75.4 хувийг эзэлж байна.

График 59. Хэргийн материалтай танилцах



Хэргийн материалыг уншиж судлахад 2694.6 минут зарцуулж байгаа бөгөөд нийт ажиллагааны 49.1 хувийг эзэлж байна. Үүнээс хэргийн материалыг уншиж судлахад 785.5 минут, ХХША-г төлөвлөхөд 152.7 минут, шаардлагатай хууль, тогтоомжийг судлахад 501.8 минут, шүүхийн практик судлахад 752,7 минут, түүвэр гаргахад 501.8 минутыг тус тус зарцуулж байна.

Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шатанд хамгийн өндөр хугацааг хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхтэй холбоотой шаардлагатай хууль тогтоомж, шүүхийн практик судлахад 752.7 минут, хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх тухай захирамжийн төсөл боловсруулахад 250.9 минут тус тус зарцуулж байна.

Хэргийг шийдвэрлэсний дараах үе шатнаас хамгийн өндөр хугацааг шүүхийн магадлалын төсөл боловсруулахад 188.2 минут, шүүх хуралдааны тэмдэглэл хянахад 125.5 минут, хэргийг эмхэтгэхэд 106.4 минут тус тус зарцуулж байна.

График 60. Маргааны төрлөөр зарцуулах хугацаа
Нийт хугацаа /минутаар/ Эзлэх хувь

№	Маргааны төрөл	Нийт хугацаа /минутаар/	Эзлэх хувь
1.	Газрын	5850	4.8
2.	Төрийн албаны	5130	4.2
3.	Төрийн хяналт, шалгалттай холбоотой	2550	2.1
4.	Ашигт малтмалтай холбоотой	5130	4.2
5.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авахтай холбоотой /тендер/	10092	8.4
6.	Татварын	10092	8.4
7.	Улсын бүртгэлтэй холбоотой	5130	4.2
8.	Нийгмийн даатгалтай холбоотой	5130	4.2
9.	Тусгай зөвшөөрөлтэй холбоотой	5130	4.2
10.	Барилгын эрх зүйн маргаан	5130	4.2
11.	Улсын байцаагчийн акттай холбоотой	5130	4.2
12.	Байгаль орчныг хамгаалахтай холбоотой	5130	4.2
13.	Боловсролтой холбоотой	5130	4.2
14.	Санхүүгийн зохицуулах хороотой холбоотой	5130	4.2
15.	Хүүхдийн эрхтэй холбоотой	5130	4.2
16.	Шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах, хэрэглэгчийн эрх ашигтай холбоотой	2580	2.1
17.	Зохиогчийн эрх, барааны тэмдэгтэй холбоотой	5190	4.3
18.	Нийтийн өмчийг хамгаалахтай холбоотой	5190	4.3
19.	Гаальтай холбоотой маргаан	5190	4.3


20.	Оюуны өмчтэй холбоотой	5850	4.8
21.	Нийтийн эрүүл мэндтэй холбоотой	5850	4.8
22.	Зам тээвэртэй холбоотой маргаан	5850	4.8
23.	Дундаж	5487	4.5

Маргааны төрлийн хувьд Ерөнхий шүүгчийн болон шүүгчийн туслахын захиргааны 1 хэрэг, маргаан эцэслэн шийдвэрлэх ажиллагааг гүйцэтгэхэд дунджаар 5487 минут зарцуулж байгаа бөгөөд хамгийн их хугацааг татвар, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авахтай холбоотой маргаануудад зарцуулж байна.

Захиргааны хэргийн давж заалдах шатны 1 шүүгч жилд дунджаар 62.6 хэрэг, маргаан хянан шийдвэрлэдэг бол 1 хэргийг эцэслэн шийдвэрлэх ажиллагааг шүүгчийн туслах гүйцэтгэхэд ажлын 11.4 өдөр зарцуулж байна. Өөрөөр хэлбэл захиргааны хэргийн давж заалдах шатны 1 шүүгчийн туслах жилд 713.6 ажлын өдөр ажиллахаар байна. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 1 шүүгчийн туслах жилд 22.8 хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг гүйцэтгэх боломжтой байна.


IV. Бусад ажиллагаа

График 61. Ерөнхий шүүгчийн туслахын бусад ажиллагаа



Ерөнхий шүүгчийн туслахын хувьд бусад ажиллагаанд 1320 минутыг дунджаар зарцуулж байна. Захиргааны хэргийн бүртгэл хяналтын нэгдсэн системд ажиллагаа хийхэд 480 минут, албан бичгийн төсөл боловсруулахад 240 минут, баримт хөтлөхөд 120 минут, live.shuukh.mn-д зар оруулахад 600 минут тус тус зарцуулж байна.

График 62. Шүүгчийн бусад ажиллагаа.



Шүүгчийн хувьд бусад ажиллагаанд 1080 минутыг дунджаар зарцуулж байна. Захиргааны хэргийн бүртгэл хяналтын нэгдсэн системд ажиллагаа хийхэд 480 минут, баримт хөтлөхөд 120 минут, live.shuukh.mn-д зар оруулахад 480 минут тус тус зарцуулж байна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Анхан шатны шүүх

Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгчийн 1 хэргийг хянан шийдвэрлэхэд зарцуулж буй дундаж хугацаа **2327.8** минут, **38.7** цаг, **4.8** ажлын өдөр, иргэний 1 хэргийг хянан шийдвэрлэхэд зарцуулж буй дундаж хугацаа **1309.5** минут, **21.8** цаг, **2.7** ажлын өдөр, захиргааны 1 хэргийг хянан шийдвэрлэхэд зарцуулж буй дундаж хугацаа **3440.4** минут, **57.3** цаг, **7.2** ажлын өдөр тус тус зарцуулж байна.

2018 онд Шүүхийн ерөнхий зөвлөлийн захиалгаар Хөгжлийн санаачилга, бодлого судалгааны төвийн хийсэн судалгаанд жилд дунджаар эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн нэг шүүгч 75 хэрэг, иргэний хэргийн анхан шатны шүүхийн нэг шүүгч 200, захиргааны хэргийн анхан шатны шүүхийн нэг шүүгч 42 хэрэг шийдэх нь шүүхийн шийдвэр чанартай бөгөөд үндэслэл бүхий шийдвэр гарна” гэж санал асуулгад хариулсан талаар дурдсан байна.⁴

Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгч ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэхэд нэг хэрэгт дунджаар 2327.8 минут буюу 38.7 цаг 4.8 хоногт хянан шийдвэрлэх ажиллагаа хийж байна.

Хөгжлийн санаачилга, бодлого судалгааны төвийн хийсэн судалгааны үр дүнгээр эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн нэг шүүгч жилд дунджаар 75 хэрэг хянан шийдвэрлэвэл 360 өдөр /ажлын 8 цагаар ажиллавал/ зарцуулахаар байна.

Жилд хөдөлмөрийн тухай хуульд заасан бүх нийтээр амрах болон тэмдэглэлт баярын өдөр, ээлжийн амралтын өдрийг хасаж тооцоход 250 орчим өдөр ажиллах ёстой гэж үзвэл эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч даруй 1.4 дахин их ачаалалтай ажиллаж байна.

Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгч зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэхэд нэг хэрэгт дунджаар 195.4 минут буюу 3.2 цаг 0.4 хоногт хянан шийдвэрлэх ажиллагаа хийж байна. Хэргийн материалтай танилцах шатанд 34 хувь буюу 66.5 минутыг, Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шатанд 14.3 хувь буюу 27.9 минутыг, Шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурах үе шатанд 35.8 хувь буюу 69.9 минутыг, Хэрэг хянан шийдвэрлэсний дараах ажиллагаанд 16 хувь буюу 31.2 минутыг тус тус зарцуулж байна.

Хөдөө аж ахуйн их сургуулийн багш нараас бүрдсэн судалгааны багийн үр дүнгээр 1 эрүүгийн хэрэгт 2.4 иргэний хэрэг, 10.2 зөрчлийн хэрэг дүйцүүлэн бодох боломжтой бөгөөд захиргааны хэргийг дүйцүүлэн бодох боломжгүй байна гэсэн дүгнэлтийг гаргасан байна.

Энэ судалгааны үр дүнгээр 1 Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэж буй хугацаа нь 1.7-2.0 иргэний хэрэг хянан шийдвэрлэсэн хугацаатай тэнцэж байна. Мөн 1 эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэж буй буй хугацаа нь 11.9 зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэсэн хугацаатай тэнцэж байна.

Иргэний хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгч ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэхэд нэг хэрэгт дунджаар 1309.5 минут буюу 21.8 цаг 2.7 ажлын өдөр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хийж байна.

Хөгжлийн санаачилга, бодлого судалгааны төвийн хийсэн судалгааны үр дүнгээр иргэний хэргийн анхан шатны шүүхийн нэг шүүгч жилд дунджаар 200 хэрэг хянан шийдвэрлэвэл 545 өдөр /ажлын 8 цагаар ажиллавал/ зарцуулахаар байна.

Жилд хөдөлмөрийн тухай хуульд заасан бүх нийтээр амрах болон тэмдэглэлт баярын өдөр, ээлжийн амралтын өдрийг хасаж тооцоход 250 орчим өдөр ажиллах ёстой

⁴ Шүүгчийн ажлын ачаалал тодорхойлох судалгааны тайлан. Хөгжлийн санаачлага, бодлого судалгааны төв, Шүүхийн ерөнхий зөвлөл. 2018 он. 68 дахь тал.

гэж үзвэл иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч даруй 2 дахин их ачаалалтай ажиллаж байна.

Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгчийн ажиллагааг 4 хэсэгт хуваан үзсэн бөгөөд нийт 3440.4 минут /57.3 цаг, 7.2 ажлын өдөр/ зарцуулж байна.

Энэ тоотой харьцуулж үзвэл дээрх ажиглалтын үр дүнгээр гарсан хугацаатай харьцуулж үзвэл захиргааны хэргийн анхан шатны шүүхийн нэг шүүгч 42 хэргийг хянан шийдвэрлэхэд 302.4 ажлын өдөр/ ажлын 8 цаг/ зарцуулна гэсэн тооцоолол гарч байна.

Сүүлийн 5 жилийн хугацаанд улсын дунджаар захиргааны хэргийн анхан шатны шүүхийн нэг шүүгч 23.9 хэрэг хянан шийдвэрлэсэн байх бөгөөд үүнийг ажиглалтын үр дүнгээр гарсан хугацаатай харьцуулж үзвэл 172.1 ажлын өдөр /ажлын 8 цаг/ зарцуулсан гэсэн үр дүн гарч байна. Харин нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүхийн нэг шүүгчийн дундаж 54.1 хэрэг хянан шийдвэрлэсэн байгаа нь 384.1 ажлын өдөр / ажлын 8 цаг/ зарцуулсан нь харьцангуй өндөр хугацаа зарцуулсан байна. Шүүгч Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу жилд дунджаар ажлын 52 долоо хоног 2080 цаг ажиллах ёстой бөгөөд үүнээс ээлжийн амралтыг дунджаар ажлын дөрвөн долоо хоног амарна гэж тооцвол 48 долоо хоног буюу 1920 цаг ажиллах ёстой байна. Дунджаар 54.1 хэрэг хянан шийдвэрлэж буй Нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүхийн нэг шүүгч жилд дунджаар 3072 цаг ажилласан нь өндөр ачаалалтай ажилласныг харуулж байна.

Давж заалдах шатны шүүх

Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгчийн 1 хэргийг хянан шийдвэрлэхэд зарцуулж буй дундаж хугацаа **3705.3** минут, **61.7** цаг, **7.7** ажлын өдөр, иргэний 1 хэргийг хянан шийдвэрлэхэд зарцуулж буй дундаж хугацаа **466.3** минут буюу **7.8** цаг **1** ажлын өдөр, захиргааны 1 хэргийг хянан шийдвэрлэхэд зарцуулж буй дундаж хугацаа **5015.5** минут, **83.6** цаг, **10.4** ажлын өдөр тус тус зарцуулж байна.

Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн нэг шүүгч хэргийн материалтай танилцах шатанд 59.2 хувь буюу 2192.3 минутыг, Хэрэг хүлээн авснаас хойших ажиллагааны шатанд 3.2 хувь буюу 118.1 минутыг, Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шатанд 9.1 хувь буюу 338 минутыг, Шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурах үе шатанд 27 хувь буюу 1001.7 минутыг, Хэрэг хянан шийдвэрлэсний дараах ажиллагаанд 1.5 хувь буюу 55.3 минутыг тус тус зарцуулж байна.

Жилд хөдөлмөрийн тухай хуульд заасан бүх нийтээр амрах болон тэмдэглэлт баярын өдөр, ээлжийн амралтын өдрийг хасаж тооцоход 250 орчим өдөр ажиллах ёстой гэж үзвэл эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн нэг шүүгч жилд 32.5 хэргийг хянан шийдвэрлэх боломжтой байна.

Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн нэг шүүгч хэргийг шүүгч хүлээн авах шатанд дунджаар 8.6 хувь буюу 40 минутыг зарцуулж байна. Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шатны ажиллагаанд 88.7 хувь буюу 413.5 минутыг зарцуулж байна. Хэргийг эцэслэн шийдвэрлэсний дараах ажиллагааны шатанд 2.8 хувь буюу 12.9 минутыг зарцуулж байна. Ерөнхий шүүгчийн хувьд хийгддэг ажиллагаанд дунджаар 155 минут буюу 2.5 цагийг шүүгчээс илүүгээр зарцуулж байна. Бусад ажиллагаанд дунджаар 300 минут буюу 5 цаг зарцуулж байна.

Жилд хөдөлмөрийн тухай хуульд заасан бүх нийтээр амрах болон тэмдэглэлт баярын өдөр, ээлжийн амралтын өдрийг хасаж тооцоход 250 орчим өдөр ажиллах ёстой гэж үзвэл иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн нэг шүүгч жилд 250 орчим хэргийг хянан шийдвэрлэх боломжтой байна.

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч хэргийн материалыг уншиж судлахад 2694.6 минут зарцуулж байгаа бөгөөд нийт ажиллагааны 49.1 хувийг эзэлж байна. Үүнээс хэргийн материалыг уншиж судлахад 785.5 минут, ХХША-г төлөвлөхөд 152.7 минут, шаардлагатай хууль, тогтоомжийг судлахад 501.8 минут, шүүхийн практик судлахад 752,7 минут, түүвэр гаргахад 501.8 минутыг тус тус зарцуулж байна. Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шатанд хамгийн өндөр хугацааг хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхтэй холбоотой шаардлагатай хууль тогтоомж, шүүхийн практик судлахад 752.7 минут, хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх тухай захирамжийн төсөл боловсруулахад 250.9 минут тус тус зарцуулж байна. Хэргийг шийдвэрлэсний дараах үе шатнаас хамгийн өндөр хугацааг шүүхийн магадлалын төсөл боловсруулахад 188.2 минут, шүүх хуралдааны тэмдэглэл хянахад 125.5 минут, хэргийг эмхэтгэхэд 106.4 минут тус тус зарцуулж байна.

Жилд хөдөлмөрийн тухай хуульд заасан бүх нийтээр амрах болон тэмдэглэлт баярын өдөр, ээлжийн амралтын өдрийг хасаж тооцоход 250 орчим өдөр ажиллах ёстой гэж үзвэл захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн нэг шүүгч жилд 24.03 хэргийг хянан шийдвэрлэх боломжтой байна.

2.1. ШҮҮХЭД ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ АЧААЛЛЫН АЖЛЫН БАЙРАН ДАХЬ СУДАЛГААНЫ ТАЙЛАНД ҮНДЭСЛЭСЭН ХУУЛЬ ЗҮЙН ДҮГНЭЛТ

АГУУЛГА

1. Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх
 - 1.1. Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа
 - 1.2. Зөрчлийн хэрэг
 - 1.3. Шүүгчийн орон тоо
 - 1.4. Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх
2. Иргэний хэргийн анхан шатны шүүх
 - 2.1. Бага үнийн дүнтэй нэхэмжлэл
 - 2.2. Иргэний хэргийн анхан шатны шүүхийн эвлэрүүлэн зуучлах ажиллагаа
 - 2.3. Шүүгчийн орон тоо
 - 2.4. Иргэний хэргийн Давж заалдах шатны шүүх
3. Захиргааны хэргийн анхан шатны шүүх
 - 3.1. Шүүгчийн туслах
 - 3.2. Шүүгчийн орон тоо
 - 3.3. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх

Нэг. Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх

Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд хийгдсэн ажлын байрны зураг авалтыг дараах өгөгдлийн дагуу явуулж, тайланг ирүүлсэн байна. Үүнд:

- Хэргийн материалтай танилцах
- Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шат
- Шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурах
- Хэрэг хянан шийдвэрлэсний дараах ажиллагаа гэсэн өгөгдлүүд багтсан байна.

Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүдээс Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх, Налайх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүдэд зураг авалт хийгдэж хэрэг хянан шийдвэрлэх дараах дундаж хугацаа гарсан байна.

Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгч ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэхэд нэг хэрэгт дунджаар **2327.8** минут буюу **38.7** цаг **4.8** хоногт хянан шийдвэрлэх ажиллагаа хийж байна. Үүнээс хэргийн материалтай танилцах шатанд **25.4** хувь буюу **590.2** минутыг, Хэрэг хүлээн авснаас хойших ажиллагааны шатанд **7.3** хувь буюу **169.1** минутыг, Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шатанд **37.1** хувь буюу **862.4** минутыг, Шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурах үе шатанд **27.5** хувь буюу **640.8** минутыг, Хэрэг хянан шийдвэрлэсний дараах ажиллагаанд **2.8** хувь буюу **64.8** минутыг тус тус зарцуулж байна.

Хөгжлийн санаачилга, бодлого судалгааны төвийн хийсэн судалгааны үр дүнгээр эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн нэг шүүгч жилд дунджаар 75 хэрэг хянан шийдвэрлэвэл 360 өдөр /ажлын 8 цагаар ажиллавал/ зарцуулахаар байна.

Хөдөө аж ахуйн их сургуулийн багш нараас бүрдсэн судалгааны багийн үр дүнгээр 1 эрүүгийн хэрэгт 2.4 иргэний хэрэг, 10.2 зөрчлийн хэрэг дүйцүүлэн бодох боломжтой бөгөөд захиргааны хэргийг дүйцүүлэн бодох боломжгүй байна гэсэн дүгнэлтийг гаргасан байна.

Ажлын байрны зураг авалтын дүнгээс үзэхэд иргэний хэргийг ердийн журмаар хянан шийдвэрлэж байгаа дундаж хугацаа **2.7** хоног байгаа бол эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэж буй хугацаа **4.8** хоног байна. Энэ нь 1 эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэж буй хугацаа нь **1.7-2.0** иргэний хэрэг хянан шийдвэрлэсэн хугацаатай тэнцэж байна.

Судалгааны хүснэгтээс үзэхэд Налайх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх нь хэргийн материалтай танилцах, хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шат, шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурах ажиллагаануудад төвийн дүүргийн шүүхээс харьцангуй өндөр байгаа нь хэргийн ачаалал багатай учир хавтаст хэргийг уншиж судлах, мөн шүүх хуралдааны заалны хүрэлцээгүй байдал үүснэ гэх ойлголт байхгүй учир шүүх хуралдаанд оролцогч нарын эрхийг бүрэн хангуулж, нотлох баримт шинжлэн судлахад техник тоног төхөөрөмж ашигладаг гэх мэт хүчин зүйл нөлөөлж байгаатай холбон

тайлбарлаж болохоор байна. Энэ талаар шүүгч нар мөн ярилцлагын явцад илэрхийлж байсан юм.

Судалгаанаас үзэхэд Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч нь нэг хэрэгт дунджаар **2712.8** минут буюу **5.6** хоногийн хугацаа зарцуулж байгаа нь жилд дунджаар шийдвэрлэх хэвийн ачаалал буюу ХААИС-ийн судлаачдын гаргасан хэвийн ачаалал буюу 85 хэргээс давсан ачаалалтай ажиллаж байгаа нь харагдаж байна. Учир нь нэг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд 5.6 хоногийн хугацаа шаардагдах нь туйлын үнэн гэж үзвэл нэг шүүгч жилд дунджаар 48 хэрэг хянан шийдвэрлэх нь хэвийн ачаалалтай байхаар байна.

1.1. Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хувьд

Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгч **хялбаршуулсан журмаар** хэрэг хянан шийдвэрлэхэд нэг хэрэгт дунджаар **385.5** минут буюу **6.4** цаг **0.8** хоногт хянан шийдвэрлэх ажиллагаа хийж байна.

Хэргийн материалтай танилцах шатанд **38.1** хувь буюу **146.9** минутыг, Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шатанд **11.2** хувь буюу **43.2** минутыг, Шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурах үе шатанд **37.9** хувь буюу **146.3** минутыг, Хэрэг хянан шийдвэрлэсний дараах ажиллагаанд **12.7** хувь буюу **49.2** минутыг тус тус зарцуулж байна.

Энэ нь иргэний хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэхэд зарцуулж буй 1 ажлын хоногтой ойролцоо байна.

1.2. Зөрчлийн хэргийн тухайд: Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгч зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэхэд нэг хэрэгт дунджаар **195.4** минут буюу **3.2** цаг **0.4** хоногт хянан шийдвэрлэх ажиллагаа хийж байна.

Хэргийн материалтай танилцах шатанд 34 хувь буюу 66.5 минутыг, Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шатанд 14.3 хувь буюу 27.9 минутыг, Шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурах үе шатанд 35.8 хувь буюу 69.9 минутыг, Хэрэг хянан шийдвэрлэсний дараах ажиллагаанд 16 хувь буюу 31.2 минутыг тус тус зарцуулж байна.

ХААИС-ын багийн судалгааны үр дүнгээс 1 эрүүгийн хэргийг **10.2** зөрчлийн хэрэгт дүйцүүлэн бодох боломжтой гэж дүгнэсэн.

Ажлын байрны зураг авалтад хийсэн дүнгээр ердийн журмаар нэг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хугацаа **4.8** хоног байгаа нь **12** зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх хугацаатай тэнцэж байна.

1.3. Шүүгчийн орон тооны хувьд: ХААИС-ын судалгааны багийн дүнгээр улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд төвийн дүүрэгт 28, аймагт 2.5 шүүгч дутагдалтай, харин захын дүүргүүдэд 3 шүүгч илүү ажиллаж байна гэсэн дүн гарсан нь ажлын байрны зураг авалтад хийгдсэн судалгааны дүнтэй нийцэж байна.

1.4. Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх: ХААИС-ийн судалгааны багийн дүгнэлтээр Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй эрүү, иргэн, захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд 108 шүүгч (5 жилийн дунджаар) ажиллаж байна гэсэн тооцоо гарсан байна. Эдгээр давж заалдах шатны шүүхэд ажиллавал зохих 121 шүүгч байна гэсэн тооцоо гарсан.

Нийслэлийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд 15 шүүгч нэмж ажиллуулах, харин аймгийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхээс 23.7 шүүгчийг ачаалал ихтэй шүүхэд ажиллуулах нь зүйтэй гэж дүгнэсэн байна.

Хоёр. Иргэний хэргийн анхан шатны шүүх

Иргэний хэргийн анхан шатны шүүхэд хийгдсэн ажлын байрны зураг авалтыг дараах өгөгдлийн дагуу явуулж, тайланг ирүүлсэн байна. Үүнд:

-Хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэх шат

-Хэрэг үүсгэснээс хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх шийдвэр гаргах хүртэлх хугацааны ажиллагаа

-Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шат

-Хэргийг эцэслэн шийдвэрлэсний дараах ажиллагаа

-Бусад ажиллагаа гэх үндсэн 5 ойлголт хамаарсан байна.

Иргэний хэргийн анхан шатны шүүхийн тухайд Хан-Уул дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх болон Багануур дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч болон шүүгч, ерөнхий шүүгчийн болон шүүгчийн туслах тус бүрийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ачааллыг ажиглалтын байдлаар судалсан.

Судалгааны үр дүнгээс үзэхэд Ерөнхий шүүгч болон шүүгчийн тухайд:

Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч **ердийн журмаар** хэрэг хянан шийдвэрлэхэд нэг хэрэгт дунджаар **1309.5** минут буюу **21.8** цаг **2.7** ажлын өдөр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хийж байна.

Үүнийг задалбал Иргэний хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэх шатанд дунджаар **4.5** хувь буюу **59.3** минутыг зарцуулж байна.

Хэрэг үүсгэснээс хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх шийдвэр гаргах хүртэлх хугацааны ажиллагаанд **42.7** хувь буюу **559** минутыг зарцуулж байна. Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шатанд **3.4** хувь буюу **44.5** минутыг зарцуулж байна.

Ерөнхий шүүгчийн хувьд хуульд заасан нийт ажиллагаанд дунджаар **206** минут буюу **3.4** цагийг шүүгчээс илүүгээр зарцуулж байна.

Бусад ажиллагаанд дунджаар 262.5 минут буюу 4.3 цаг зарцуулж байна.

Харин иргэний хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэхэд нэг хэрэгт дунджаар **405** минут буюу **6.7** цаг **1** ажлын хоногт хянан шийдвэрлэх ажиллагаа хийж байна.

Үүнийг задалбал Иргэний хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэх шатанд дунджаар **10** хувь буюу **44** минутыг зарцуулж байна. Хэрэг үүсгэснээс шийдвэр гаргах хүртэлх хугацааны ажиллагаанд **80.7** хувь буюу **348** минутыг зарцуулж байна. Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шатанд **3.2** хувь буюу **13** минутыг зарцуулж байна. Хэргийг эцэслэн шийдвэрлэсний дараах ажиллагаанд дунджаар **3.2** хувь буюу **13** минутыг зарцуулж байна.

Хөгжлийн санаачилга, бодлого судалгааны төвийн хийсэн судалгааны үр дүнгээр иргэний хэргийн анхан шатны шүүхийн нэг шүүгч жилд дунджаар 200 хэрэг хянан шийдвэрлэвэл 545 өдөр /ажлын 8 цагаар ажиллавал/ зарцуулахаар байна.

Жилд хөдөлмөрийн тухай хуульд заасан бүх нийтээр амрах болон тэмдэглэлт баярын өдөр, ээлжийн амралтын өдрийг хасаж тооцоход 250 орчим өдөр ажиллах ёстой гэж үзвэл иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч даруй 2 дахин их ачаалалтай ажиллаж байна.

ХААИС-ын судалгааны багийн ирүүлсэн дүгнэлтэд Иргэний хэргийн шүүгч жилд 250 хэрэг хянан шийдвэрлэх нь хэвийн ачаалалтай гэж үзэхээр байна гэжээ. Энэ нь шүүгч 1 жилд ойролцоогоор ажлын нэг өдөрт нэг иргэний хэрэг хянан шийдвэрлэхээр харагдаж байгаа нь ажлын байранд хийгдсэн зураг авалтын дүнгээс гарсан шүүгч хялбаршуулсан хэргийг хянан шийдвэрлэхэд 1 өдөр зарцуулж байна гэсэн дүнтэй тохирч байна.

Харин шүүгч ердийн хэргийг хянан шийдвэрлэхэд нийт **2.7** ажлын өдөр, бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэхэд нэг хэрэгт **801.6** минут буюу **13.4** цаг **1.6** хоногт хянан шийдвэрлэх ажиллагаа хийж байгаа нь ачаалалтай ажиллаж байгааг харуулж байна.

2.1. Бага үнийн дүнтэй нэхэмжлэлийн тухайд

Иргэний хэргийн анхан шатны шүүхэд хийсэн зураг авалтын дүнд шүүгч бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэхэд нэг хэрэгт **801.6** минут буюу **13.4** цаг **1.6** хоногт хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж байна гэсэн дүн гарсан байна.

Энэ нь нийт хэргийн хянан шийдвэрлэж буй хугацаатай харьцуулбал 30.1 хувийг эзэлж байна гэж үзэхээр байна.

“ХААИС-ын судалгааны багийн хийсэн дүн шинжилгээгээр Дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхээс 2017-2021 оны хооронд дунджаар хүлээн авсан нэхэмжлэлийн **46.7** хувийг бага үнийн дүнтэй нэхэмжлэл эзэлж байхаас гадна Дүүргийн иргэний хэргийн анхан шатны нэг шүүгч жилд дунджаар **136** бага үнийн дүнтэй нэхэмжлэл хүлээн авсан байх төлөвтэй.

Хүн амын тооны өсөлт нь энэ төрлийн нэхэмжлэлийн тооны өсөлтөд Багануур, Чингэлтэй, Сүхбаатар дүүрэгт урвуу хамааралтай буюу хүн амын тоо

өсөхөд энэ төрлийн нэхэмжлэл өсөхгүй, бусад төрлийн нэхэмжлэлийн тоо илүү өсөх, харин бусад дүүргийн хувьд шууд хамааралтай буюу хүн ам өсөхөд энэ төрлийн нэхэмжлэлийн тоо өсөх зүй тогтолтой байна.

Мөн дүүргийн бага үнийн дүнтэй нэхэмжлэлийн тоонд шүүгчийн ачааллыг прогнозыг илэрхийлэхэд Багахангай дүүргийн хувьд шүүгчийн ачаалалд нөлөө багатай, Налайх дүүргийн хувьд шүүгчийн ачаалалд нөлөөтэй, Багануур дүүргийн хувьд шүүгчийн ачаалалд их нөлөөтэй харин бусад дүүргийн хувьд шүүгчийн ачаалалд маш их нөлөөтэй гэж дүгнэсэн.

Иймд маргааны төрлийн хувьд шүүхийг дагнан байгуулахаас илүүтэй төвийн 6 дүүргийн хэмжээнд **бага үнийн дүнтэй нэхэмжлэлийг шийдвэрлэх шүүхийг байгуулах**, энэ төрлийн **нэхэмжлэлээс үүсэх ачааллыг тусад нь дагнан гаргах нь** нийт хэргийг шийдвэрлэх ачааллаас хөнгөлөх, бага үнийн дүнтэй хэргийг хөнгөн хялбар байдлаар шийдвэрлэх боломжийг олгохоор байна.” гэж дүгнэсэн.

Харин хууль зүйн хэлтсээс бага үнийн дүнтэй нэхэмжлэлийг шийдвэрлэх шүүхийг байгуулах бус иргэний хэргийн шүүх дэх эвлэрүүлэн зуучлалд уг маргааныг хамааруулж болох хууль зүй, практик нөхцөлийг судлах боломжтой байгааг өмнө дүгнэж байсан.

2.2.Иргэний хэргийн анхан шатны шүүхийн эвлэрүүлэн зуучлах ажиллагаа

Хан-Уул дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх болон Багануур дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн эвлэрүүлэн зуучлагчийн ажиллагааны ачааллыг ажиглалтын байдлаар судалсан судалгааны үр дүнг авч үзвэл:

Дүүргийн иргэний хэргийн дэргэдэх Эвлэрүүлэн зуучлагч нь Эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд дунджаар **478** минут буюу **7.9** цаг **1** ажлын өдөр ажиллагаа хийж байна. Өргөдөл /хэрэг/ хүлээн авах шатанд **19.9** хувь буюу **95** минутыг зарцуулж байна. Өргөдөл хүлээн авснаас хойш эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд **35.8** хувь буюу **35.8** минут, Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны уулзалтад бэлтгэх, уулзах үе шатанд **42.5** хувь буюу **203.9** минутыг зарцуулж байна. ЭЗА явагдсаны дараах ажиллагааны үе шатанд **1.8** хувь буюу **7.8** минутыг зарцуулж байгаа нь харагдаж байна.

Энэ нь Иргэний хэргийн шүүгчийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай харьцуулахад ачаалал 4-5 дахин бага байгаа юм.

ХААИС-ийн судалгааны багийн гаргасан судалгаанд дараагийн 2 жилд хүлээн авах бага үнийн дүнтэй нэхэмжлэл нь төвийн 6 дүүргийн шүүхийн ачаалалд их нөлөөлөхөөр харагдаж харагдаж байгааг дурдсан бөгөөд бага үнийн дүнтэй хэрэг гэдэгт нийт дүн 10 саяас доош байх хэргийг тодорхойлсон.

Уг төрлийн хэрэг нь хянан шийдвэрлэгдэх хугацааны хувьд бусад хэрэгтэй ижил хугацаанд шийдвэрлэгддэг бөгөөд энэ төрлийн нэхэмжлэл өндөр байх тусам шүүхэд ачаалал үзүүлж байна.

Иймд Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийг өөрчлөн найруулах төсөл боловсруулагдах явцад бага үнийн дүн бүхий маргааныг эвлэрүүлэн зуучлалд харьяалуулан шийдвэрлэх боломжит хувилбар байгаа эсэхийг судлах боломжтой байна.

Уг хуулийг илүү боловсронгуй болгож хэрэгжүүлснээр иргэний хэрэг хянан шийдвэрлэж буй шүүхийн шүүгчийн ачаалалд маш ихээр нөлөөлөх нь зураг авалтын дүнгээс хийгдсэн судалгаанаас харагдаж байна.

2.3. Шүүгчийн орон тооны хувьд

ХААИС-ын судалгааны багийн дүнгээр Улсын хэмжээнд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж буй Иргэний хэргийн анхан шатны шүүхийн хувьд Төвийн дүүрэгт нийт 41 шүүгч, аймгуудад 20 шүүгч тус тус дутагдалтай, харин захын дүүрэгт 2.1 шүүгч илүү ажиллаж байна гэсэн дүн гарсан нь ажлын байрны зураг авалтад хийсэн судалгааны дүнтэй нийцэхээр байна.

ДИХАШШ-н хувьд дунджаар нэг шүүгчид ногдох иргэний хуулиар шийдвэрлэсэн хэргийн хувьд төвийн дүүрэг их буюу 2560 хэрэг, захын дүүрэг бага буюу 227 хэргийг нэг шүүгч нэг жилд шийдвэрлэсэн байна.

Аймаг, сум дундын шүүхэд нийт хүлээн авсан бага үнийн дүнтэй нэхэмжлэлийн тоо нь дүүргийн шүүхээс 2.1 дахин бага байгаа бөгөөд аймаг, сум дундын иргэний хэргийн анхан шатны нэг шүүгч жилд дунджаар 64 нэхэмжлэл ногдож байна гэсэн судалгааны дүн гарсан.

Иймд судалгааны дүнгээр тодорхойлогдож буй бага үнийн дүнтэй нэхэмжлэлийн тоо өндөр үзүүлэлттэй төвийн дүүргүүд, Дархан-Уул, Орхон, Дорнод гэх мэт их ачаалалтай аймгуудын шүүхэд ачаалал багатай Өмнөговь, Ханбогд, Баян-Өлгий гэх мэт шүүхээс шүүгчдийг тодорхой хугацаанд томилолтоор ажиллуулах, орон тоог нэмэгдүүлэх байдлаар зохион байгуулах боломжтой юм.

2.4. Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх

Ажлын байрны зураг авалтад хийсэн судалгаагаар Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч хэрэг хянан шийдвэрлэхэд нэг хэрэгт дунджаар 466.3 минут буюу 7.8 цаг 1 ажлын өдөр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хийж байна.

Үүнээс хэргийг шүүгч хүлээн авах шатанд дунджаар 8.6 хувь буюу 40 минутыг зарцуулж байна. Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шатны ажиллагаанд 88.7 хувь буюу 413.5 минутыг зарцуулж байна. Хэргийг эцэслэн шийдвэрлэсний дараах ажиллагааны шатанд 2.8 хувь буюу 12.9 минутыг зарцуулж байна.

Ерөнхий шүүгчийн хувьд хийгддэг ажиллагаанд дунджаар 155 минут буюу 2.5 цагийг шүүгчээс илүүгээр зарцуулж байна. Энэ нь анхан шатны шүүхийн ерөнхий шүүгчтэй харьцуулбал 0.9 цагаар бага байна.

Бусад ажиллагаанд дунджаар 300 минут буюу 5 цаг зарцуулж байна.

Ажлын байрны зураг авалт хийгдсэн Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүх болон Дархан-Уул аймаг дахь иргэний хэргийн давж заалдах

шатны шүүхүүдийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зарцуулж буй хугацаанаас харахад орон нутгийн шүүх нь илүү их хугацаа зарцуулж байгаа нь харагдаж байна.

ХААИС-ийн судалгааны багийн дүгнэлтэд улсын дунджаар давж заалдах шатны шүүхийн нэг шүүгч жилд иргэний 103 хэргийг хянан шийдвэрлэсэн ачаалалтай ажилласан байна.

Улсын дундаж: Нийслэлийн болон 19 аймгийн (дагнаагүй), 2 аймгийн (дагнасан) нэг шүүх давж заалдах шатны шүүхэд ажиллаж байгаа нэг шүүгч нэг жилд иргэний 43 хэргийн ачаалалтай байна. Энэ ачаалал нь сүүлийн 5 жилийн динамикийн хувьд нэг шүүгч нэг жилд авч байгаа бодит ачаалал юм. Энэ ачааллыг бодит дундаж гэж нэрлэвэл бодит дунджаас нийслэлийн шүүхийн иргэний хэргийн шүүгч 1.6 дахин их ачаалалтай байгаа бол 21 аймаг дахь шүүхийн шүүгчид бодит дунджид хүрэхээр ачаалал аваагүй байна.

Гурав. Захиргааны хэргийн анхан шатны шүүх

Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгчийн ажиллагааг 4 хэсэгт хуваан үзсэн бөгөөд нийт **3440.4** минут **57.3** цаг, **7.2** ажлын өдөр зарцуулж байна. Үүнээс захиргааны хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэх үе шат дунджаар нийт **174.5** минут, хэрэг үүсгэснээс хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх шийдвэр гаргах хүртэлх хугацааны үе шат дунджаар нийт **2056** минут, хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шат дунджаар нийт **1015.8** минут, хэргийг эцэслэн шийдвэрлэсний дараах үе шат дунджаар нийт **194.1** минутыг тус тус зарцуулж байна.

Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн болон шүүгчийн туслахын ажиллагааг 4 хэсэгт хуваан үзсэн бөгөөд нийт **2621.9** минут **43.7** цаг, **5.5** ажлын өдөр зарцуулж байна. Үүнээс захиргааны хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэх үе шат дунджаар нийт **170.4** минут, хэрэг үүсгэснээс хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх шийдвэр гаргах хүртэлх хугацааны үе шат дунджаар нийт **938.6** минут, хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шат дунджаар нийт **1144.3** минут, хэргийг эцэслэн шийдвэрлэсний дараах үе шат дунджаар нийт **368.6** минутыг тус тус зарцуулж байна.

Маргааны төрлөөр задалж үзвэл Ерөнхий шүүгчийн болон шүүгчийн туслахын хувьд захиргааны 1 хэрэг, маргаан эцэслэн шийдвэрлэх ажиллагаанд туслахад дунджаар 2383.6 минут 39 цаг, ажлын 5 өдөр зарцуулж байна. Хамгийн өндөр хугацаа зарцуулж байгаа хэрэг, маргааны хувьд байгаль орчинтой холбоотой хэрэг, маргаан шийдвэрлэх ажиллагаанд туслахад **3163.5** минут, газрын маргаанд **2559** минут, төрийн хяналт шалгалттай холбоотой маргаанд **2541.5** минут, улсын бүртгэлтэй холбоотой маргаанд **2515.8** минут, барилгын эрх зүйн маргаанд **2510.8** минут, боловсролтой холбоотой маргаанд **2505.3** минут, ашигт малтмалтай холбоотой маргаанд **2501.8** минут тус тус зарцуулж байна.

Ерөнхий шүүгчийн туслахын хувьд захиргааны 1 хэрэг, маргаан эцэслэн шийдвэрлэх ажиллагааг гүйцэтгэхэд дунджаар **2254.5** минут зарцуулж байгаа бөгөөд хамгийн их хугацааг төрийн албаны хэрэг, маргаанд **2699.5** минут, төрийн

хяналт шалгалттай холбоотой хэрэг, маргаанд **2681** минут, тусгай зөвшөөрөлтэй холбоотой хэрэг, маргаанд **2668** минут тус тус зарцуулж байна.

Шүүгчийн туслахын хувьд захиргааны 1 хэрэг, маргаан эцэслэн шийдвэрлэх ажиллагааг гүйцэтгэхэд дунджаар **2512.7** минут зарцуулж байгаа бөгөөд хамгийн их хугацааг байгаль орчинтой холбоотой хэрэг, маргаанд **3708** минут, гаальтай хэрэг, маргаанд **2696** минут тус тус зарцуулж байна.

Захиргааны хэргийн анхан шатны 1 шүүгч жилд дунджаар **23.9** хэрэг, маргаан хянан шийдвэрлэдэг бол 1 хэргийг эцэслэн шийдвэрлэх ажиллагааг гүйцэтгэхэд шүүгчийн туслах ажлын **5** өдөр зарцуулж байна. Өөрөөр хэлбэл захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 1 шүүгчийн туслах жилд **23.9** хэрэг, маргааныг эцэслэн шийдвэрлэх ажиллагааг гүйцэтгэдэг гэвэл жилд **119.5** ажлын өдрийг зарцуулахаар байна.

Нийслэлд Захиргааны хэргийн анхан шатны нэг шүүх үйл ажиллагаа явуулж байгаагаараа онцлог юм.

Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн хувьд 1 жилд **54.1** хэрэг, маргаан хянан шийдвэрлэдэг бол шүүгчийн туслах 1 хэргийг эцэслэн шийдвэрлэх ажиллагааг гүйцэтгэхэд ажлын **5** өдөр зарцуулж байгаа гэж үзвэл жилд **270.5** ажлын өдөр зарцуулахаар байна. Өөрөөр хэлбэл 1 шүүгчийн туслах жилд **52** хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд техник туслалцаа үзүүлэх боломжтой байна. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 1 шүүгч жилд **25** хэрэг, маргаан хянан шийдвэрлэх боломжтой байна.

Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгчийн ажиллагааг 4 хэсэгт хуваан үзсэн бөгөөд нийт **3440.4** минут **57.3** цаг, **7.2** ажлын өдөр зарцуулж байна.

Энэ тоог дээрх ажиглалтын үр дүнгээр гарсан хугацаатай харьцуулж үзвэл захиргааны хэргийн анхан шатны шүүхийн нэг шүүгч 42 хэргийг хянан шийдвэрлэхэд **302.4** ажлын өдөр, ажлын **8** цаг зарцуулна гэсэн тооцоолол гарч байна.

Шүүхийн шүүн таслах ажиллагааны статистик дүн мэдээнээс үзэхэд сүүлийн 5 жилийн хугацаанд улсын дунджаар захиргааны хэргийн анхан шатны шүүхийн нэг шүүгч 23.9 хэрэг хянан шийдвэрлэсэн байх бөгөөд үүнийг ажиглалтын үр дүнгээр гарсан хугацаатай харьцуулж үзвэл 172.1 ажлын өдөр /ажлын 8 цаг/ зарцуулсан гэсэн үр дүн гарч байна.

Харин нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүхийн нэг шүүгчийн дундаж 54.1 хэрэг хянан шийдвэрлэсэн байгаа нь 384.1 ажлын өдөр /ажлын 8 цаг/ зарцуулсан нь харьцангуй өндөр хугацаа зарцуулсан байна. Шүүгч Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу жилд дунджаар ажлын 52 долоо хоног 2080 цаг ажиллах ёстой бөгөөд үүнээс ээлжийн амралтыг дунджаар ажлын дөрвөн долоо хоног амарна гэж тооцвол 48 долоо хоног буюу 1920 цаг ажиллах ёстой байна. Дунджаар 54.1 хэрэг хянан шийдвэрлэж буй Нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүхийн нэг шүүгч жилд дунджаар 3072 цаг ажилласан нь өндөр ачаалалтай ажилласныг харуулж байна.

Маргааны төрлийн хувьд Ерөнхий шүүгч болон шүүгч захиргааны 1 хэрэг, маргаан эцэслэн шийдвэрлэхэд дунджаар 5015.5 минут зарцуулж байна.

2018 онд Шүүхийн ерөнхий зөвлөлийн захиалгаар Хөгжлийн санаачилга, бодлого судалгааны төвийн хийсэн судалгаанд жилд дунджаар эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн нэг шүүгч 75 хэрэг, иргэний хэргийн анхан шатны шүүхийн нэг шүүгч 200, захиргааны хэргийн анхан шатны шүүхийн нэг шүүгч 42 хэрэг шийдэх нь шүүхийн шийдвэр чанартай бөгөөд үндэслэл бүхий шийдвэр гарна” гэж санал асуулгад хариулсан талаар дурдсан байна.

Харин ХААИС-ийн судалгааны багийн гаргасан дүгнэлтээр захиргааны хэргийн шүүгч нь жилд 34 хэрэг хянан шийдвэрлэх нь хэвийн ачаалалтай гэж үзэж болохоор байна гэж үзсэн.

Эдгээр судалгаанаас гарсан дүнгээс ажлын байрны зураг авалтад хийсэн судалгааны дүн нь зөрүүтэй байгаа нь шүүхийн ачаалал өндөр байгааг илэрхийлж байна.

3.1. Шүүгчийн туслах

Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн болон шүүгчийн туслахын ажиллагааг 4 хэсэгт хуваан үзсэн бөгөөд нийт 2621.9 минут /43.7 цаг, 5.5 ажлын өдөр/ зарцуулж байна. Үүнээс захиргааны хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэх үе шат дунджаар нийт 170.4 минут, хэрэг үүсгэснээс хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх шийдвэр гаргах хүртэлх хугацааны үе шат дунджаар нийт 938.6 минут, хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шат дунджаар нийт 1144.3 минут, хэргийг эцэслэн шийдвэрлэсний дараах үе шат дунджаар нийт 368.6 минутыг тус тус зарцуулж байна.

Захиргааны хэргийн давж заалдах шатны 1 шүүгч жилд дунджаар 62.6 хэрэг, маргаан хянан шийдвэрлэдэг бол 1 хэргийг эцэслэн шийдвэрлэх ажиллагааг шүүгчийн туслах гүйцэтгэхэд ажлын 11.4 өдөр зарцуулж байна. Өөрөөр хэлбэл захиргааны хэргийн давж заалдах шатны 1 шүүгчийн туслах жилд 713.6 ажлын өдөр ажиллахаар байгаа нь ачаалал маш өндөр байгааг харуулж байна. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 1 шүүгчийн туслах жилд 22.8 хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг гүйцэтгэхэд техникийн тусламж боломжтой байна.

3.2. Шүүгчийн орон тооны хувьд

ХААИС-ын судалгааны багийн дүнгээр Захиргааны хэргийн анхан шатны шүүх, ялангуяа орон нутгийн шүүхүүдэд нийт 24.1 шүүгч илүү ажиллаж байна. Уг ажиллаж байгаа шүүгч нарыг Нийслэлийн Захиргааны хэргийн анхан шатны шүүх болон Давж заалдах шатны шүүхүүдэд шилжүүлэн ажиллуулах боломжтой гэж дүгнэсэн.

Захиргааны хэргийн шүүгч нарын ажлын ачааллаас үзэхэд шүүгч 1 жилд 34 захиргааны хэргийг хянан шийдвэрлэх нь хэвийн ачаалал гэж үзэхээр байна гэж дүгнэсэн бөгөөд ажлын байрны зураг авалтад хийсэн судалгааны дүнгээс үзэхэд шүүгч нар харьцангуй ачаалалтай ажиллаж байгаа нь харагдаж байна.

3.3. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх

Захиргааны хэргийн давж заалдах шатны 1 шүүгч жилд дунджаар **62.6** хэрэг, маргаан хянан шийдвэрлэдэг бол 1 хэргийг эцэслэн шийдвэрлэхэд ажлын **10.4** өдөр зарцуулж байна. Өөрөөр хэлбэл захиргааны хэргийн анхан шатны 1 шүүгч жилд 62.6 хэрэг, маргааныг эцэслэн шийдвэрлэхэд **651.04** ажлын өдрийг зарцуулахаар байна.

Ажлын байрны зураг авалтад хийсэн судалгааны дүнгээр Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч 1 жилд дунджаар 62.6 хэрэг хянан шийдвэрлэдэг, нэг хэрэг хянан шийдвэрлэхэд нийт 10.4 өдөр зарцуулахаар байна гэсэн дүн гарсан нь ХААИС-ийн судлаачдын багийн гаргасан Захиргааны хэргийн шүүгч 1 жилд дунджаар 34 хэрэг хянан шийдвэрлэнэ гэж дүгнэснээс даруй 1.8 дахин их байна.

Харин уг дүгнэлтэд Захиргааны хэргийн Давж заалдах шатны шүүх 16.4 шүүгчийн орон тоо дутагдалтай ажиллаж байна гэсэн дүгнэсэн нь үндэслэлтэй байна.

--oo0oo--

Гурав. ЭРҮҮ, ИРГЭН, ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШҮҮХЭД ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ ХУГАЦААНЫ АСУУМЖИЙН НЭГДСЭН ТАЙЛАН

АГУУЛГА

НЭГ. УДИРТГАЛ

104

ХОЁР.ЭРҮҮГИЙН ХЭРЭГ

2.1. АНХАН ШАТНЫ ШҮҮХ

2.1.1.Эрүүгийн ердийн хэрэгт

2.1.1.1 Хэргийн материалтай танилцах

2.1.1.2 Хэрэг хүлээн авснаас хойших ажиллагааны үе шат

2.1.1.3.Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шат

2.1.1.4 Шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурах үе шат

2.1.1.5 Хэрэг хянан шийдвэрлэсний дараах ажиллагааны үе шат

2.1.2.Хялбаршуулсан журмаар ирсэн хэрэгт

2.1.2.1 Хэргийн материалтай танилцах

2.1.2.2 Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шат

2.1.2.3. Шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурах үе шат

2.1.2.4 Хэрэг хянан шийдвэрлэсний дараах ажиллагааны үе шат

2.1.3.Зөрчлийн хэрэгт

2.1.3.1 Хэргийн материалтай танилцах

2.1.3.2 Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шат

2.1.3.3. Шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурах үе шат

2.1.3.4 Хэрэг хянан шийдвэрлэсний дараах ажиллагааны үе шат

2.1.4 Бусад ажиллагаа

2.2.ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХ

2.2.1. Хэргийн материалтай танилцах

2.2.3. Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шат

2.2.4. Шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурах үе шат

2.2.5. Хэрэг хянан шийдвэрлэсний дараах ажиллагааны үе шат

2.2.6. Зөрчлийн хэрэг

2.2.6.1. Хэргийн материалтай танилцах

2.2.6.2. Хэрэг хүлээн авснаас хойших ажиллагааны үе шат

2.2.6.3. Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шат

2.2.6.4. Шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурах үе шат

2.2.6.5. Хэрэг хянан шийдвэрлэсний дараах ажиллагааны үе шат

125

ГУРАВ. ИРГЭНИЙ ХЭРЭГ

3.1 АНХАН ШАТНЫ ШҮҮХ

3.1.1.Хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэх шат

3.1.3.Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шат

3.1.4.Хэргийг эцэслэн шийдвэрлэсний дараах ажиллагааны үе шат

3.1.5. Ерөнхий шүүгчийн ажиллагаа

3.1.6.Бусад ажиллагаа

3.2. ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХ

3.2.1. Хэргийг шүүгч хүлээн авах үе шат

3.2.2. Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх ажиллагааны үе шат

3.2.3. Хэргийг эцэслэн шийдвэрлэсний дараах ажиллагааны үе шат

3.2.4. Ерөнхий шүүгчийн ажиллагаа

3.2.5. Бусад ажиллагаа

ДӨРӨВ.ЗАХИРГААНЫ ХЭРЭГ

4.1. АНХАН ШАТНЫ ШҮҮХ

4.1.2. Хэрэг үүсгэснээс хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх шийдвэр гаргах хүртэлх хугацааны ажиллагааны шат

4.1.3.Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шат

4.1.4.Хэргийг эцэслэн шийдвэрлэсний дараах ажиллагааны үе шат

4.2. ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХ

ТАВ. ДҮГНЭЛТ

НЭГ. УДИРТГАЛ

Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын хэсгээс өгсөн чиглэлийн дагуу анхан болон давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгчийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явц дахь ажиллагаа бүрд зарцуулж буй хугацааны өнөөгийн байдлыг бодитоор тогтоох, түүнд үндэслэн шүүн таслах ажиллагааны ачааллыг тооцох, тэнцвэржүүлэх, шүүхийн хүний нөөцийн бодлогын төслийг судалгаанд тулгуурлан бодитой тодорхойлоход энэ судалгааны зорилго оршино.

Зорилгын хүрээнд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явц дахь ажиллагаа бүрд зарцуулж буй дундаж хугацааг гаргалаа.

*Жич: Хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны ачааллын судалгааны хүснэгтийг **минутаар** тооцож хийсэн болно.*

Асуумжийн нэгдсэн тайлан нэгтгэсэн боловсруулсан ажлын хэсэгт дараах албан хаагч нар ажилласан.

Эрүү	Багийн ахлагч:	Б.Батцэцэг
	Гишүүн:	Б.Баатар, З.Баянсүрэн
Иргэн	Багийн ахлагч:	Ч.Ханддулам
	Гишүүн:	П.Ариунбилэг, Т.Энхгэрэл
Захиргаа	Багийн ахлагч:	Т.Түвшинбаяр
	Гишүүн:	Б.Золзаяа
Нэгдсэн дүгнэлт	Багийн ахлагч:	Э.Амарсанаа
	Гишүүн:	П.Ангарагсайхан /иргэн, захиргаа/ Э.Ганцэцэг /эрүү/

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

№	Товчилсон үг	Тайлбар
1	ХХША	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа
2	ИХШХШтХ	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
3	ЭЗТХ	Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль
4	ЭЗА	Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа
5	ТСАХ	Таслах сэргийлэх арга хэмжээ
6	АШШ	Анхан шатны шүүх

ХОЁР.ЭРҮҮГИЙН ХЭРЭГ

2.1. АНХАН ШАТНЫ ШҮҮХ


2.1.1.Эрүүгийн ердийн хэрэгт

Монгол улсын эрүүгийн хэргийн 60 шүүхийн шүүгч нараас асуумж авахаар хүргүүлсэн. Үүнээс 28 шүүхийн шүүгч нараас ирсэн асуумжийг судлахад дараах хугацаатай гарсан байна.

2.1.1.1 Хэргийн материалтай танилцах

Хэргийн материалтай танилцах шатанд уншиж танилцах /1-5, 5-10, 10-с дээш хавтастай/, ХХША-г төлөвлөх, Түүвэр гаргах, Шаардлагатай хууль тогтоомжийг судлах, Шүүхийн практик судлах гэсэн 5 ажиллагаа багтсан байна.

График 63 Ерөнхий шүүгч, шүүгчийн хэргийн материалтай танилцах



Эрүүгийн хэргийн материалтай танилцахдаа хамгийн бага хугацаа зарцуулсан шүүхийн практик судлах нь 7 хувь буюу 305.5 минутыг, хамгийн их хугацаа зарцуулсан хэргийн материалыг уншиж танилцах нь 61 хувь буюу 2627 минутыг эзэлж байна. 1-5 хавтастай хэрэгт 1125.3 минут, 5-10 хавтастай хэрэгт 1912.7 минут, 10-с дээш хавтастай хэрэгт 4581 минутын дундаж хугацаа гарч байна. Үүнийг шүүгчийн асуумжийн зураглал, шүүгч нараас ирүүлсэн асуумжаар нь задалж үзвэл:

Хүснэгт 87 Ерөнхий шүүгч, шүүгчийн хэргийн материалтай танилцах


	Ажиллагаа	Зураглал	Асуумж
Хэргийн материалтай танилцах	Уншиж судлах	412.2	2539.7
	ХХША-г төлөвлөх	27.5	346.1
	Түүвэр гаргах	71.4	658.6
	Шаардлагатай хууль тогтоомжийг судлах	45.9	377.2
	Шүүхийн практик судлах	33.2	305.5
	Нийт /минут/	590.2	4227.2

Хэргийн материал танилцах хугацааны асуумжийн үр дүнгээр 4227.2 минут зарцуулдаг гэж гарсан нь өмнө хийсэн зураглалаас даруй 7.2 дахин их хугацаа зарцуулсан үр дүн гарсан байна.

2.1.1.2 Хэрэг хүлээн авснаас хойших ажиллагааны үе шат

Хэрэг хүлээн авснаас хойших ажиллагааны үе шатанд урьдчилсан хэлэлцүүлэг хийлгэх хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх, ТСАХ-тэй холбоотой хүсэлтийг шийдвэрлэх, Хэргийг түдгэлзүүлэх үндэслэл бий болсон эсэхийг шийдвэрлэсэн шүүгчийн захирамж, Хэргийг харьяалах шүүхэд шилжүүлэх эсэхийг шийдвэрлэх шүүгчийн захирамж гэсэн 4 ажиллагаа багтсан байна.

График 64 Ерөнхий шүүгч, шүүгчийн хэрэг авснаас хойших ажиллагааны үе шат



Эрүүгийн хэргийн хувьд хэрэг хүлээн авснаас хойших ажиллагааны үе шатанд хамгийн бага хугацаа зарцуулсан хэргийг түдгэлзүүлэх үндэслэл бий болсон эсэхийг шийдвэрлэсэн шүүгчийн захирамж боловсруулах ажиллагаа нь 10 хувь буюу 42.3 минутыг, хамгийн их хугацаа зарцуулсан урьдчилсан хэлэлцүүлэг хийлгэх хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх ажиллагаа нь 39 хувь буюу 171.1 минутыг эзэлж байна. Хэрэг хүлээн авснаас хойших ажиллагааны үе шатны шүүгчийн асуумжийн зураглал, шүүгч нараас ирүүлсэн асуумжаар задалж үзвэл:

Хүснэгт 88 Ерөнхий шүүгч, шүүгчийн хэрэг авснаас хойших ажиллагааны үе шат


	Ажиллагаа	Зураглал	Асуумж
Хэрэг хүлээн авснаас хойших ажиллагаа	Урьдчилсан хэлэлцүүлэг хийлгэх хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх	20.1	171.1
	ТСАХ-тэй холбоотой хүсэлтийг шийдвэрлэх	61.7	96.1
	Хэргийг түдгэлзүүлэх үндэслэл бий болсон эсэхийг шийдвэрлэсэн шүүгчийн захирамж	45.5	42.3
	Хэргийг харьяалах шүүхэд шилжүүлэх эсэхийг шийдвэрлэх шүүгчийн захирамж	41.8	128.6
	Нийт /минут/	169.1	438.1

Хэрэг хүлээн авснаас хойших ажиллагаанд зарцуулсан хугацааны хувьд асуумжийн үр дүнгээр 438.1 минут зарцуулдаг гэж дүгнэсэн нь өмнө хийсэн зураглалын үр дүнгээс 2.5 дахин их хугацаа зарцуулдаг гэсэн дүгнэлт гарч байна.

2.1.1.3.Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шат

Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шатанд Хэргийн оролцогчдод шүүх хуралдааны тов мэдэгдэх хуудсанд гарын үсэг зурах, Шүүхийн иргэдийн төлөөлөгчид мэдээлэл өгсөн баримтад гарын үсэг зурах, Нөлөөллийн мэдүүлэг хөтөлдөг талаар мэдээлэл өгсөн баримтыг хянаж, гарын үсэг зурах, Шүүх хуралдаан гэсэн 4 ажиллагаа багтсан байна.

График 65 Ерөнхий шүүгч, шүүгчийн хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шат



Эрүүгийн хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шатанд хамгийн бага хугацаа зарцуулсан Нөлөөллийн мэдүүлэг хөтөлдөг талаар мэдээлэл өгсөн баримтыг хянаж, гарын үсэг зурах ажиллагаа нь 4 хувь буюу 11.4 минутыг, хамгийн их хугацаа зарцуулсан шүүх хуралдаан нь 85 хувь буюу 262.3 минутыг эзэлж байна.

Хүснэгт 89 Ерөнхий шүүгч, шүүгчийн хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шат


	Ажиллагаа	Зураглал	Асуумж
Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шат	Хэргийн оролцогчдод шүүх хуралдааны тов мэдэгдэх хуудсанд гарын үсэг зурах	8.9	21.6
	Шүүхийн иргэдийн төлөөлөгчид мэдээлэл өгсөн баримтад гарын үсэг зурах	6.3	14.3
	Нөлөөллийн мэдүүлэг хөтөлдөг талаар мэдээлэл өгсөн баримтыг хянаж, гарын үсэг зурах	59.9	11.4
	Шүүх хуралдаан	787.4	262.3
Нийт /минут/		862.4	309.6

Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шатад зарцуулсан хугацааны үр өмнө хийсэн зураглалын үр дүнгээс 2.8 дахин бага хугацаа зарцуулсан буюу 309.6 минут зарцуулсан гэж гарсан байна. Энэ нь зураглал хийсэн шүүх болон шүүгчийн тухайн хугацаанд явагдсан хурлын үргэлжлэх хугацаа харьцангуй бага байсан байж болохоор байна.

2.1.1.4 Шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурах үе шат

Эрүүгийн хэргийн шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурах үе шатанд Шүүх хуралдааны тэмдэглэл хянаж, гарын үсэг зурах, Шүүгчийн захирамж, Шүүхийн тогтоол, Шийтгэвэр, Шийтгэх/цагаатгах тогтоол зэргийг боловсруулах, хянах, гарын үсэг зурах гэсэн 5 ажиллагаа багтсан байна.

График 66 Ерөнхий шүүгч, шүүгчийн шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурах ажиллагааны үе шат



Эрүүгийн хэргийн шийдвэр боловсруулах ажиллагааны үе шатанд хамгийн бага хугацаа зарцуулсан нь шүүхийн тогтоол нь 2 хувь буюу 68 минутыг, хамгийн их хугацаа зарцуулсан шийтгэх/цагаатгах тогтоол нь 60 хувь буюу 2363.8 минутыг эзэлж байна.

Эрүүгийн хэргийн шийдвэр хянах, гарын үсэг зурах ажиллагааны үе шатанд хамгийн бага хугацаа зарцуулсан нь Ерөнхий шүүгчийн захирамж хянах, гарын үсэг зурах нь 2 хувь буюу 18 минутыг, хамгийн их хугацаа зарцуулсан шүүх хуралдааны тэмдэглэл хянаж, гарын үсэг зурах ажиллагаа нь 53 хувь буюу 611.6 минутыг эзэлж байна.

Хүснэгт 90 Ерөнхий шүүгч, шүүгчийн шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурах үе шат

		Ажиллагаа	Зураглал	Асуумж	
Шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурах	Ерөнхий шүүгчийн захирамж	Боловсруулсан	30.3	427.8	
		Хянаж, гарын үсэг зурах	18	18	
	Шүүгчийн захирамж	Боловсруулсан	260.9	1073.1	
		Хянаж, гарын үсэг зурах	48.8	249.7	
	Шүүхийн тогтоол	Боловсруулсан	35.7	68	
		Хянаж, гарын үсэг зурах	12.9	35.5	
	Шийтгэх /цагаатгах тогтоол	Боловсруулсан	152.4	2363.8	
		Хянаж, гарын үсэг зурах	22.9	234.8	
	Шүүх хуралдааны тэмдэглэл хянаж, гарын үсэг зурах			58.9	611.6
	Нийт /минут/			640.8	5082.3


Шүүгч шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурахад нийт 5082.3 минут зарцуулсан гэж асуумжийн үр дүнгээр гарсан бөгөөд энэ нь зураглалын үр дүнгээс даруй 7.9 дахин их хугацаа зарцуулсан гэсэн үр дүн гарчээ. Энэ нь тухайн шүүгч энэ үе шатад 84.7 цаг, 10.5 өдрийг зарцуулж буй гэж гарсан нь бодит бус хугацаа гэж дүгнэгдэхээр байна.

2.1.1.5 Хэрэг хянан шийдвэрлэсний дараах ажиллагааны үе шат

Хэрэг хянан шийдвэрлэсний дараах ажиллагааны үе шатанд Гүйцэтгэх хуудас хянаж, гарын үсэг зурах, Эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн хүн, хуулийн этгээдийн тухай тэмдэглэл

хянаж, гарын үсэг зурах, Хэргийг эмхэтгэснийг хянаж баримтад гарын үсэг зурах, Залруулгын шүүгчийн захирамж гэсэн 4 ажиллагаа багтсан байна.

График 67 Ерөнхий шүүгч, шүүгчийн хэрэг авснаас хойших ажиллагааны үе шат



Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэсний дараах ажиллагааны үе шатанд хамгийн бага хугацаа зарцуулсан Эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн хүн, хуулийн этгээдийн тухай тэмдэглэл хянаж, гарын үсэг зурах ажиллагаа нь 11 хувь буюу 23.9 минутыг, хамгийн их хугацаа зарцуулсан залруулгын шүүгчийн захирамж боловсруулж, хянан гарын үсэг зурах ажиллагаа нь 52 хувь буюу 109.4 минутыг эзэлж байна.

Хүснэгт 91 Ерөнхий шүүгч, шүүгчийн хэрэг хянан шийдвэрлэсний дараах ажиллагааны үе шат

	Ажиллагаа	Зураглал	Асуумж
Хэрэг хянан шийдвэрлэсний дараах ажиллагаа	Гүйцэтгэх хуудас хянаж, гарын үсэг зурах	15.8	44.8
	Эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн хүн, хуулийн этгээдийн тухай тэмдэглэл хянаж, гарын үсэг зурах	14.3	23.9
	Хэргийг эмхэтгэснийг хянаж баримтад гарын үсэг зурах	11.8	34.6
	Залруулгын шүүгчийн захирамж	22.9	109.4
Нийт /минут/		64.8	212.7


Хэрэг хянан шийдвэрлэсний дараах ажиллагаанд шүүгч 212.7 минут буюу 3.5 цаг зарцуулж байгаа нь зураглалын үр дүнгээс 3.8 дахин их хугацаа зарцуулж байна гэсэн үр дүн гарсан байна.

2.1.2. Хялбаршуулсан журмаар ирсэн хэрэгт

2.1.2.1 Хэргийн материалтай танилцах

Эрүүгийн хялбаршуулсан журмаар ирсэн хэргийн материалтай танилцах үе шатанд уншиж танилцах, түүвэр гаргах, шаардлагатай хууль тогтоомжийг судлах, шүүхийн практик судлах гэсэн 4 ажиллагаа багтсан байна.

График 68 Ерөнхий шүүгч, шүүгчийн хэргийн материалтай танилцах



Эрүүгийн хялбаршуулсан журмаар ирсэн хэргийн материалтай танилцахдаа хамгийн бага хугацаа зарцуулсан шүүхийн практик судлах ажиллагааг нь 15 хувь буюу 142.1 минутыг, хамгийн их хугацаа зарцуулсан хэргийн материалыг уншиж танилцах нь 45 хувь буюу 427.4 минутыг эзэлж байна. Үүнийг шүүгчийн асуумжийн зураглал, шүүгч нараас ирүүлсэн асуумжаар нь задалж үзвэл:

Хүснэгт 92 Ерөнхий шүүгч, шүүгчийн хэргийн материалтай танилцах


Ажиллагаа		Зураглал	Асуумж
Хэргийн материалтай танилцах	Уншиж судлах	113.4	427.4
	Түүвэр гаргах	13.95	204.6
	Шаардлагатай хууль тогтоомжийг судлах	10.05	183.6
	Шүүхийн практик судлах	9.5	142.1
Нийт /минут/		146.9	957.7

Хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх хэрэгт хэргийн материалтай танилцах хугацаа нь асуумжийн үр дүнгээр 957.7 минут буюу 15.9 цаг, 1.9 өдөр зарцуулж байна гэсэн үр дүн гарсан нь өмнө хийсэн ажлын байрны зураглалын үр дүнгээс 6.5 дахин их хугацаа зарцуулж байгаа гэсэн үр дүн гарсан байна. Ажлын байрны зураглалын үр дүнгээр шүүгч хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлүүлэхээр ирүүлсэн хэргийн материалтай дунджаар 2.5 цаг орчим судалж байсан илүү бодит үр дүн гэж харагдахаар байна.

2.1.2.2 Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шат

Эрүүгийн хялбаршуулсан журмаар ирсэн хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шатанд Хэргийн оролцогчдод шүүх хуралдааны тов мэдэгдэх хуудсанд гарын үсэг зурах, Нөлөөллийн мэдүүлэг хөтөлдөг талаар мэдээлэл өгсөн баримтыг хянаж, гарын үсэг зурах, Шүүх хуралдаан гэсэн 3 ажиллагаа багтсан байна.

График 69 Ерөнхий шүүгч, шүүгчийн хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шат



Эрүүгийн хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шатанд хамгийн бага хугацаа зарцуулсан Нөлөөллийн мэдүүлэг хөтөлдөг талаар мэдээлэл өгсөн баримтыг хянаж, гарын үсэг зурах ажиллагаа нь 17 хувь буюу 13.2 минутыг, хамгийн их хугацаа зарцуулсан шүүх хуралдаан нь 63 хувь буюу 48 минутыг эзэлж байна.

Хүснэгт 93 Ерөнхий шүүгч, шүүгчийн хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шат


	Ажиллагаа	Зураглал	Асуумж
Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шат	Хэргийн оролцогчдод шүүх хуралдааны тов мэдэгдэх хуудсанд гарын үсэг зурах	6.9	15.1
	Нөлөөллийн мэдүүлэг хөтөлдөг талаар мэдээлэл өгсөн баримтыг хянаж, гарын үсэг зурах	5	13.2
	Шүүх хуралдаан	31.3	48
Нийт /минут/		43.2	76.3

Хэргийг хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шатанд 76.3 минут 1.2 өдөр зарцуулж байгаа нь өмнө хийсэн зураглалын үр дүнгээс 76.7 хувиар их хугацаа зарцуулж байна гэсэн үр дүн гарсан байна.

2.1.2.3. Шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурах үе шат

Эрүүгийн хялбаршуулсан журмаар ирсэн хэргийн шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурах үе шатанд Шүүх хуралдааны тэмдэглэл хянаж, гарын үсэг зурах, Ерөнхий шүүгчийн захирамж, Шүүгчийн захирамж, Шийтгэвэр, Шийтгэх/цагаатгах тогтоол зэргийг боловсруулах, хянах, гарын үсэг зурах гэсэн 5 ажиллагаа багтсан байна.

График 70 Ерөнхий шүүгч, шүүгчийн шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурах ажиллагааны үе шат



Эрүүгийн хялбаршуулсан журмаар ирсэн хэргийн шийдвэр боловсруулах ажиллагааны үе шатанд хамгийн бага хугацаа зарцуулсан нь Ерөнхий шүүгчийн захирамж нь 9 хувь буюу 210.5 минутыг, хамгийн их хугацаа зарцуулсан шийтгэх/цагаатгах тогтоол нь 60 хувь буюу 1354.4 минутыг эзэлж байна.

Эрүүгийн хялбаршуулсан журмаар ирсэн хэргийн шийдвэр хянах, гарын үсэг зурах ажиллагааны үе шатанд хамгийн бага хугацаа зарцуулсан нь Ерөнхий шүүгчийн захирамж хянах, гарын үсэг зурах нь 2 хувь буюу 9.6 минутыг, хамгийн их хугацаа зарцуулсан шүүх хуралдааны тэмдэглэл хянаж, гарын үсэг зурах ажиллагаа нь 79 хувь буюу 468.9 минутыг эзэлж байна.

Хүснэгт 94 Ерөнхий шүүгч, шүүгчийн шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурах үе шат

	Ажиллагаа	Зураглал	Асуумж
--	-----------	----------	--------

Шүүх хуралдааны тэмдэглэл хянаж, гарын үсэг зурах			28.7	468.9	
Шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурах	Ерөнхий шүүгчийн захирамж	Боловсруулсан	2.3	210.5	
		Хянасан, гарын үсэг зурах	3.9	9.6	
	Шүүгчийн захирамж	Боловсруулсан	13.4	218.6	
		Хянасан, гарын үсэг зурах	7.4	18.4	
	Шүүхийн шийтгэвэр	Боловсруулсан	0	489.7	
		Хянасан, гарын үсэг зурах	0	21.8	
	Шийтгэх /цагаатгах тогтоол	Боловсруулсан	76	1354.4	
		Хянасан, гарын үсэг зурах	14.6	71.1	
	Нийт /минут/			146.3	2862.8

Шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурахад зарцуулах хугацаа асуумжийн үр дүнгээр 2862.8 минут буюу 47.7 цаг, 5.9 өдөр зарцуулж байна гэсэн үр дүн гарсан байна. Энэ нь ажлын байрны зураглалын үр дүнгээс 19.5 дахин их хугацаа зарцуулж байна гэж гарсан байна.

2.1.2.4 Хэрэг хянан шийдвэрлэсний дараах ажиллагааны үе шат

Хэрэг хянан шийдвэрлэсний дараах ажиллагааны үе шатанд Гүйцэтгэх хуудас хянаж, гарын үсэг зурах, Эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн хүн, хуулийн этгээдийн тухай тэмдэглэл хянаж, гарын үсэг зурах, Хэргийг эмхэтгэснийг хянаж баримтад гарын үсэг зурах, Залруулгын шүүгчийн захирамж гэсэн 4 ажиллагаа багтсан байна.

График 71 Ерөнхий шүүгч, шүүгчийн хэрэг авснаас хойших ажиллагааны үе шат



Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэсний дараах ажиллагааны үе шатанд хамгийн бага хугацаа зарцуулсан Гүйцэтгэх хуудас хянаж, гарын үсэг зурах ажиллагаа нь 3 хувь буюу 16.3 минутыг, хамгийн их хугацаа зарцуулсан Эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн хүн, хуулийн этгээдийн тухай тэмдэглэл хянаж, гарын үсэг зурах ажиллагаа нь 77 хувь буюу 444.6 минутыг эзэлж байна.

Хүснэгт 95 Ерөнхий шүүгч, шүүгчийн хэрэг авснаас хойших ажиллагааны үе шат

	Ажиллагаа	Зураглал	Асуумж
Хэрэг хянаж, гарын үсэг зурах	Гүйцэтгэх хуудас хянаж, гарын үсэг зурах	11.3	16.3

Эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн хүн, хуулийн этгээдийн тухай тэмдэглэл хянаж, гарын үсэг зурах	8	444.6
Хэргийг эмхэтгэснийг хянаж баримтад гарын үсэг зурах	12.1	23.9
Залруулгын шүүгчийн захирамж	17.9	90.9
Нийт /минут/	49.2	575.7


Хэрэг хянан шийдвэрлэсний дараах ажиллагааны үе шатад 575.7 минут зарцуулж байгаа нь ажлын байгаа нь зураглалын үр дүнгээс даруй 11.7 дахин өндөр дүнтэй гарсан байна. Эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн хүн, хуулийн этгээдийн тухай тэмдэглэл хянаж, гарын үсэг зурахад 444.6 минут буюу 7.4 цаг зарцуулж байна гэсэн асуумжийн үр дүн бодит байдлаас хэт дөвийлгөсөн хугацаа болох нь харагдаж байна.

2.1.3. Зөрчлийн хэрэгт

2.1.3.1 Хэргийн материалтай танилцах

Зөрчлийн хэргийн материалтай танилцах үе шатанд уншиж танилцах, шаардлагатай хууль тогтоомжийг судлах, шүүхийн практик судлах гэсэн 3 ажиллагаа багтсан байна.

Ерөнхий шүүгч, шүүгчийн хэргийн материалтай танилцах



Зөрчлийн хэргийн материалтай танилцахдаа хамгийн бага хугацаа зарцуулсан шүүхийн практик судлах ажиллагааг нь 26 хувь буюу 30.1 минутыг, хамгийн их хугацаа зарцуулсан шаардлагатай хууль тогтоомжийг судлах нь 41 хувь буюу 47.5 минутыг эзэлж байна. Үүнийг шүүгчийн асуумжийн зураглал, шүүгч нараас ирүүлсэн асуумжаар нь задалж үзвэл:

Хүснэгт 96 Ерөнхий шүүгч, шүүгчийн хэргийн материалтай танилцах

Ажиллагаа		Зураглал	Асуумж
Хэргийн материалтай танилцах	Уншиж судлах	39.5	38.5
	Шаардлагатай хууль тогтоомжийг судлах	18.2	47.5
	Шүүхийн практик судлах	17.2	30.1
Нийт /минут/		74.9	116.1

Зөрчлийн хэргийн материалтай танилцах ажиллагаанд шүүгчийн зарцуулж буй хугацаа 116.1 минут буюу 55.0 хувиар их хугацаа зарцуулж байгаа үр дүн гарсан байна.

2.1.3.2 Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шат

Зөрчлийн хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шатанд Хэргийн оролцогчдод шүүх хуралдааны тов мэдэгдэх хуудсанд гарын үсэг зурах, Нөлөөллийн мэдүүлэг хөтөлдөг талаар мэдээлэл өгсөн баримтыг хянаж, гарын үсэг зурах, шүүх хуралдаан гэсэн 3 ажиллагаа багтсан байна.

График 72 Ерөнхий шүүгч, шүүгчийн хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шат



Зөрчлийн хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шатанд хамгийн бага хугацаа зарцуулсан Хэргийн оролцогчдод шүүх хуралдааны тов мэдэгдэх хуудсанд гарын үсэг зурах ажиллагаа нь 8 хувь буюу 20.8 минутыг, хамгийн их хугацаа зарцуулсан Нөлөөллийн мэдүүлэг хөтөлдөг талаар мэдээлэл өгсөн баримтыг хянаж, гарын үсэг зурах нь 65 хувь буюу 169.7 минутыг эзэлж байна.

Хүснэгт 97 Ерөнхий шүүгч, шүүгчийн хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шат


Ажиллагаа		Зураглал	Асуумж
Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шат	Хэргийн оролцогчдод шүүх хуралдааны тов мэдэгдэх хуудсанд гарын үсэг зурах	4.4	20.8
	Нөлөөллийн мэдүүлэг хөтөлдөг талаар мэдээлэл өгсөн баримтыг хянаж, гарын үсэг зурах	4.2	169.7
	Шүүх хуралдаан	9.5	68.9
Нийт /минут/		18.1	259.4

Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шатад асуумжийн үр дүнгээр 259.4 минут буюу 4.3 цаг зарцуулж байна гэсэн үр дүн гарсан бол энэ нь ажлын байрны зураглалын хувьд 14.3 дахин их хугацаа зарцуулдаг гэж гарсан байна.

2.1.3.3. Шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурах үе шат

Зөрчлийн хэргийн шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурах үе шатанд Шүүх хуралдааны тэмдэглэл хянаж, гарын үсэг зурах, Ерөнхий шүүгчийн захирамж, Шүүгчийн захирамж, Шийтгэвэр зэргийг боловсруулах, хянах, гарын үсэг зурах гэсэн 4 ажиллагаа багтсан байна.

График 73 Ерөнхий шүүгч, шүүгчийн шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурах ажиллагааны үе шат



Зөрчлийн хэргийн шийдвэр боловсруулах ажиллагааны үе шатанд хамгийн бага хугацаа зарцуулсан нь шийтгэвэр 30 хувь буюу 330.9 минутыг, хамгийн их хугацаа зарцуулсан Ерөнхий шүүгчийн захирамж нь 37 хувь буюу 407.1 минутыг эзэлж байна.

Зөрчлийн хэргийн шийдвэр хянах, гарын үсэг зурах ажиллагааны үе шатанд хамгийн бага хугацаа зарцуулсан нь Ерөнхий шүүгчийн захирамж хянах, гарын үсэг зурах нь 1 хувь буюу 10.6 минутыг, хамгийн их хугацаа зарцуулсан шүүх хуралдааны тэмдэглэл хянаж, гарын үсэг зурах ажиллагаа нь 85 хувь буюу 685.1 минутыг эзэлж байна.

Хүснэгт 98 Ерөнхий шүүгч, шүүгчийн шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурах үе шат

Ажиллагаа		Зураглал	Асуумж
Шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурах	Ерөнхий шүүгчийн захирамж	Боловсруулсан	0
		Хянаж, гарын үсэг зурах	3.8
	Шүүгчийн захирамж	Боловсруулсан	8.9
		Хянаж, гарын үсэг зурах	4.4
	Шийтгэвэр	Боловсруулсан	25.4
		Хянаж, гарын үсэг зурах	4.7
Шүүх хуралдааны тэмдэглэл хянаж, гарын үсэг зурах		24.3	685.1
Нийт /минут/		71.5	1903.7

Зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэж буй шүүгч шийдвэр боловсруулах, хянах гарын үсэг зурахад 1903.7 минут буюу 31.7 цаг, 3.9 өдөр /ажлын 8 цагаар/ зарцуулж байна гэсэн асуумжийн үр дүн гарсан нь ажлын байрны зураглалын үр дүнгээс 26.6 дахин их хугацаа зарцуулна гэсэн үр дүн гарсан байна.

2.1.3.4 Хэрэг хянан шийдвэрлэсний дараах ажиллагааны үе шат

Зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэсний дараах ажиллагааны үе шатанд Гүйцэтгэх хуудас хянаж, гарын үсэг зурах, Хэргийг эмхэтгэснийг хянаж баримтад гарын үсэг зурах, Залруулгын шүүгчийн захирамж гэсэн 3 ажиллагаа багтсан байна.

График 74 Ерөнхий шүүгч, шүүгчийн хэрэг авснаас хойших ажиллагааны үе шат



Зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэсний дараах ажиллагааны үе шатанд хамгийн бага хугацаа зарцуулсан Хэргийг эмхэтгэснийг хянаж баримтад гарын үсэг зурах ажиллагаа нь 6 хувь буюу 18 минутыг, хамгийн их хугацаа зарцуулсан Гүйцэтгэх хуудас хянаж, гарын үсэг зурах ажиллагаа нь 50 хувь буюу 150 минутыг эзэлж байна.

Хүснэгт 99 Ерөнхий шүүгч, шүүгчийн хэрэг авснаас хойших ажиллагааны үе шат

Ажиллагаа		Зураглал	Асуумж
Хэрэг хянан шийдвэрлэсний дараах ажиллагаа	Гүйцэтгэх хуудас хянаж, гарын үсэг зурах	6.6	150
	Хэргийг эмхэтгэснийг хянаж баримтад гарын үсэг зурах	10.9	18
	Залруулгын шүүгчийн захирамж	13.5	133.7
Нийт /минут/		31	301.7

Зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэж буй шүүгч хэрэг хянан шийдвэрлэсний дараах ажиллагаанд 301.7 минут зарцуулж байгаа нь ажлын байрны зураглалын үр дүнгээс 9.7 дахин их хугацаа зарцуулсан үр дүн гарсан байна. Залруулгын захирамжид 133.7 минут зарцуулж байгаа нь энэ ажиллагаанд зарцуулж буй хугацааны 45 хувийг дангаар эзэлж байгаа нь ингэж өндөр хугацаа зарцуулсан гэсэн үр дүн гарч байна.

2.1.4 Бусад ажиллагаа

График 75 Ерөнхий шүүгчийн бусад ажиллагаа



Эрүүгийн хэргийн бүртгэл, хяналтын нэгдсэн системд нэвтэрч ажиллагаа хийх 1111 минут буюу хамгийн их хугацаа зарцуулж байгаа бол Шүүгчдийн зөвлөгөөний тогтоол хянахад хамгийн бага буюу 172.1 минутыг зарцуулж байна.

График 76 Шүүгчийн бусад ажиллагаа



Шүүгч өөр шүүгчийн шүүх бүрэлдэхүүнд 2212.2 минут буюу хамгийн их хугацаа зарцуулж байгаа бол шүүгчдийн зөвлөгөөний тогтоол хянахад хамгийн бага буюу 316.1 минутыг зарцуулж байна.

Явцын дүгнэлт

Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгч нараас авсан асуумжийн хүрээнд ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэхэд нэг хэрэгт дунджаар 10269.7 минут буюу 171 цаг 21.3 хоногт хянан шийдвэрлэх ажиллагаа хийж байна. Хэргийн материалтай танилцах шатанд 41.2 хувь буюу 4227.2 минутыг, Хэрэг хүлээн авснаас хойших ажиллагааны шатанд 4.3 хувь буюу 438.1 минутыг, Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шатанд 3 хувь буюу 309.4 минутыг, Шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурах үе шатанд 49.5 хувь буюу 5082.3 минутыг, Хэрэг хянан шийдвэрлэсний дараах ажиллагаанд 2.1 хувь буюу 212.7 минутыг тус тус зарцуулж байна.

Хүснэгт 100 Ерөнхий шүүгч, шүүгчийн эрүүгийн ердийн хэрэг авснаас хойших ажиллагааны үе шат

Ажиллагаа	Зураглал	Асуумж
Хэргийн материалтай танилцах	590.2	4227.2
Хэрэг хүлээн авснаас хойших ажиллагаа	169.1	438.1
Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шат	862.4	309.4
Шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурах	640.8	5082.3
Хэрэг хянан шийдвэрлэсний дараах ажиллагаа	64.8	212.7
Нийт хугацаа	2327.3	10269.7

Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгч нараас авсан асуумжийн хүрээнд хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэхэд нэг хэрэгт дунджаар 4472.4 минут буюу 74.5 цаг 9.3 хоногт хянан шийдвэрлэх ажиллагаа хийж байна. Хэргийн материалтай танилцах шатанд 21.4 хувь буюу 957.7 минутыг, Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шатанд 1.7 хувь буюу 76.8 минутыг, Шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурах үе шатанд 6.4 хувь буюу 2862.8 минутыг, Хэрэг хянан шийдвэрлэсний дараах ажиллагаанд 12.9 хувь буюу 575.1 минутыг тус тус зарцуулж байна.

Хүснэгт 101 Ерөнхий шүүгч, шүүгчийн эрүүгийн хялбаршуулсан журмаар ирсэн хэргийг авснаас хойших ажиллагааны үе шат

Ажиллагаа	Зураглал	Асуумж
Хэргийн материалтай танилцах	146.8	957.7
Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шат	43.2	76.8
Шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурах	146.3	2862.8
Хэрэг хянан шийдвэрлэсний дараах ажиллагаа	49.2	575.1
Нийт хугацаа	385.5	4472.4

Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгч нараас авсан асуумжийн хүрээнд зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэхэд нэг хэрэгт дунджаар 2580.9 минут буюу 43 цаг 5.3 хоногт хянан шийдвэрлэх ажиллагаа хийж байна. Хэргийн материалтай танилцах шатанд 4.5 хувь буюу 116.1 минутыг, Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шатанд 10.1 хувь буюу 259.4 минутыг, Шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурах үе шатанд 73.8 хувь буюу 1903.7 минутыг, Хэрэг хянан шийдвэрлэсний дараах ажиллагаанд 11.7 хувь буюу 301.7 минутыг тус тус зарцуулж байна.

Хүснэгт 102 Ерөнхий шүүгч, шүүгчийн зөрчлийн хэрэг авснаас хойших ажиллагааны үе шат

Ажиллагаа	Зураглал	Асуумж
Хэргийн материалтай танилцах	74.9	116.1
Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шат	18.1	259.4
Шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурах	71.5	1903.7
Хэрэг хянан шийдвэрлэсний дараах ажиллагаа	31	301.7
Нийт хугацаа	195.5	2580.9

Асуумжийн судалгааны үр дүнгээс үзэхэд Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч нь нэг хэрэгт 14742.1 минут буюу 245.7 цаг буюу 30.7 хоног /ажлын 8 цагаар/-н хугацаа зарцуулж байна.


2.2. ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХ

Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 13 шүүхийн Ерөнхий шүүгч болон шүүгчийн ажиллагааны ачааллыг асуумжийн байдлаар судлахад дараах хугацаатай гарсан байна.

2.2.1. Хэргийн материалтай танилцах

Хэргийн материалтай танилцах шатанд уншиж танилцах, ХХША-г төлөвлөх, Түүвэр гаргах, Шаардлагатай хууль тогтоомжийг судлах, Шүүхийн практик судлах гэсэн 5 ажиллагаа багтсан байна.

График 77 Ерөнхий шүүгч, шүүгчийн хэргийн материалтай танилцах



Эрүүгийн хэргийн материалтай танилцахдаа хамгийн бага хугацаа зарцуулсан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг төлөвлөх нь 4 хувь буюу 173.2 минутыг, хамгийн их хугацаа зарцуулсан хэргийн материалыг уншиж танилцах нь 44 хувь буюу 1879.7 минутыг эзэлж байна. Үүнийг шүүгчийн асуумжийн зураглал, шүүгч нараас ирүүлсэн асуумжаар нь задалж үзвэл:

Хүснэгт 103 Ерөнхий шүүгч, шүүгчийн хэргийн материалтай танилцах


	Ажиллагаа	Зураглал	Асуумж
Хэргийн материалтай танилцах	Уншиж судлах	531.6	1879.7
	ХХША-г төлөвлөх	272.7	173.2
	Түүвэр гаргах	467.6	1139.6
	Шаардлагатай хууль тогтоомжийг судлах	470.7	536.2
	Шүүхийн практик судлах	449.7	559.9
	Нийт /минут/	2192.3	4288.6

Давж заалдах шатны шүүхийн шүүгч хэргийн материалтай танилцахад 4288.6 минут буюу 71.5 цаг, 8.9 хоног /ажлын 8 цагаар/ зарцуулахаар байна. Энэ нь ажлын байрны зураглалын үр дүнгээс даруй 1.9 дахин их хугацаа зарцуулахаар байна.

2.2.2. Хэрэг хүлээн авснаас хойших ажиллагааны үе шат

Хэрэг хүлээн авснаас хойших ажиллагааны үе шатанд ТСАХ-тэй холбоотой хүсэлтийг шийдвэрлэх, Хэргийг түдгэлзүүлэх үндэслэл бий болсон эсэхийг шийдвэрлэсэн шүүгчийн захирамж гэсэн 2 ажиллагаа багтсан байна.

График 78 Ерөнхий шүүгч, шүүгчийн хэрэг авснаас хойших ажиллагааны үе шат



Эрүүгийн хэргийн хувьд хэрэг хүлээн авснаас хойших ажиллагааны үе шатанд бага хугацаа зарцуулсан ТСАХ-тэй холбоотой хүсэлтийг шийдвэрлэсэн шүүгчийн захирамж боловсруулах, хянах, гарын үсэг зурах ажиллагаа нь 37 хувь буюу 72.2 минутыг, их хугацаа зарцуулсан Хэргийг түдгэлзүүлэх үндэслэл бий болсон эсэхийг шийдвэрлэсэн шүүгчийн захирамж боловсруулах, хянах, гарын үсэг зурах ажиллагаа нь 63 хувь буюу 125.3 минутыг эзэлж байна. Хэрэг хүлээн авснаас хойших ажиллагааны үе шатны шүүхээр задалж үзвэл:

Хүснэгт 104 Ерөнхий шүүгч, шүүгчийн хэрэг авснаас хойших ажиллагааны үе шат

	Ажиллагаа	Зураглал	Асуумж
Хэрэг хүлээн авснаас хойших ажиллагаа	ТСАХ-тэй холбоотой хүсэлтийг шийдвэрлэх	29	72.2
	Хэргийг түдгэлзүүлэх үндэслэл бий болсон эсэхийг шийдвэрлэсэн шүүгчийн захирамж	28.8	125.3
	Нийт /минут/	57.8	197.5

Давж заалдах шатны шүүхийн шүүгч хэрэг хүлээн авснаас хойших ажиллагаанд 197.5 минут зарцуулж байгаа нь ажлын байрны зураглалын үр дүнгээс 3.4 дахин их хугацаа зарцуулж байгаа гэж хариулсан байна.

2.2.3. Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шат

Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шатанд ажиллагааны зураглал хийгдэх явцад хэргийн оролцогчдод шүүх хуралдааны тов мэдэгдэх хуудсанд гарын үсэг зурах нь хийгддэггүй ажил учир хасах саналыг гаргасан тул шүүхүүдэд хүргүүлсэн асуумжаас хассан. Шүүх хуралдаан гэсэн 1 ажиллагаатайгаар боловсруулсан байна. Эрүүгийн хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шатанд шүүх хуралдаан нь 526.5 минутыг зарцуулж байна.

Хүснэгт 105 Ерөнхий шүүгч, шүүгчийн хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шат


	Ажиллагаа	Зураглал	Асуумж
Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шат	Шүүх хуралдаан	338	526.5
	Нийт /минут/	338	526.5

Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шатанд 526.5 минут зарцуулсан нь ажлын байрны зураглалын үр дүнгээс 188.5 минутаар буюу 55.7 хувиар их хугацаа зарцуулж байна.

2.2.4. Шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурах үе шат

Эрүүгийн хэргийн шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурах үе шатанд Шүүх хуралдааны тэмдэглэл хянаж, гарын үсэг зурах, Ерөнхий шүүгчийн захирамж, Шүүгчийн захирамж, Шүүхийн тогтоол, Магадлал зэргийг боловсруулах, хянах, гарын үсэг зурах гэсэн 5 ажиллагаа багтсан байна.

График 79 Ерөнхий шүүгч, шүүгчийн шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурах ажиллагааны үе шат



Эрүүгийн хэргийн шийдвэр боловсруулах ажиллагааны үе шатанд хамгийн бага хугацаа зарцуулсан нь Ерөнхий шүүгчийн захирамж нь 2 хувь буюу 43.7 минутыг, хамгийн их хугацаа зарцуулсан магадлал нь 81 хувь буюу 1696 минутыг эзэлж байна.

Эрүүгийн хэргийн шийдвэр хянах, гарын үсэг зурах ажиллагааны үе шатанд хамгийн бага хугацаа зарцуулсан нь Ерөнхий шүүгчийн захирамж хянах, гарын үсэг зурах нь 7 хувь буюу 30 минутыг, хамгийн их хугацаа зарцуулсан шүүх хуралдааны тэмдэглэл хянаж, гарын үсэг зурах ажиллагаа нь 51 хувь буюу 206.5 минутыг эзэлж байна.

Хүснэгт 4. Ерөнхий шүүгч, шүүгчийн шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурах үе шат.

		Ажиллагаа	Зураглал	Асуумж	
Шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурах	Ерөнхий шүүгчийн захирамж	Боловсруулсан	76.9	43.7	
		Хянаж, гарын үсэг зурах	47.5	30	
	Шүүгчийн захирамж	Боловсруулсан	173.5	255.5	
		Хянаж, гарын үсэг зурах	75.1	34.2	
	Шүүхийн тогтоол	Боловсруулсан	20	96.2	
		Хянаж, гарын үсэг зурах	4.4	38.5	
	Магадлал	Боловсруулсан	372.8	1696	
		Хянаж, гарын үсэг зурах	71.7	92.9	
	Шүүх хуралдааны тэмдэглэл хянаж, гарын үсэг зурах			159.9	206.5
	Нийт /минут/			1001.7	2493.5

Шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурах ажиллагаанд 2493.5 минут зарцуулж байгаа нь ажлын байрны зураглалын судалгааны үр дүнгээс 2.5 дахин их хугацаа зарцуулахаар гарсан байна.

2.2.5. Хэрэг хянан шийдвэрлэсний дараах ажиллагааны үе шат

Хэрэг хянан шийдвэрлэсний дараах ажиллагааны үе шатанд Мэдэгдэх хуудас хянаж, гарын үсэг зурах, Залруулгын шүүхийн тогтоол гэсэн 2 ажиллагаа багтсан байна.

График 80 Ерөнхий шүүгч, шүүгчийн хэрэг авснаас хойших ажиллагааны үе шат



Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэсний дараах ажиллагааны үе шатанд бага хугацаа зарцуулсан мэдэгдэх хуудас хянаж, гарын үсэг зурах ажиллагаа нь 34 хувь буюу 37 минутыг, их хугацаа зарцуулсан Залруулгын шүүхийн тогтоол боловсруулах, хянан гарын үсэг зурах ажиллагаа нь 66 хувь буюу 70.7 минутыг эзэлж байна.

Хүснэгт 5. Ерөнхий шүүгч, шүүгчийн хэрэг хянан шийдвэрлэсний дараах ажиллагааны үе шат.

Ажиллагаа		Зураглал	Асуумж
Хэрэг хянан шийдвэрлэсний дараах ажиллагаа	Мэдэгдэх хуудас хянаж, гарын үсэг зурах	22.7	37
	Залруулгын шүүгчийн захирамж	32.6	70.7
Нийт /минут/		55.3	107.7


Хэрэг хянан шийдвэрлэсний дараах ажиллагааны үе шатад 107.7 минут зарцуулж байгаа нь ажлын байрны зураглалын үр дүнгээс 1.9 дахин их хугацаа зарцуулж байна.

2.2.6. Зөрчлийн хэрэг

2.2.6.1. Хэргийн материалтай танилцах

Зөрчлийн хэргийн материалтай танилцах үе шатанд уншиж танилцах, ХХША-г төлөвлөх, Түүвэр гаргах, шаардлагатай хууль тогтоомжийг судлах, шүүхийн практик судлах гэсэн 5 ажиллагаа багтсан байна.

График 81 Ерөнхий шүүгч, шүүгчийн хэргийн материалтай танилцах



Зөрчлийн хэргийн материалтай танилцахдаа хамгийн бага хугацаа зарцуулсан ХХША-г төлөвлөх ажиллагааг нь 9 хувь буюу 30 минутыг, хамгийн их хугацаа зарцуулсан хэргийн материалыг уншиж танилцах нь 27 хувь буюу 93.3 минутыг эзэлж байна. Үүнийг шүүгчийн асуумжийн зураглал, шүүгч нараас ирүүлсэн асуумжаар нь задалж үзвэл:

Хүснэгт 106 Ерөнхий шүүгч, шүүгчийн хэргийн материалтай танилцах


	Ажиллагаа	Зураглал	Асуумж
Хэргийн материалтай танилцах	Уншиж судлах	395.3	93.3
	ХХША-г төлөвлөх	141.3	30
	Түүвэр гаргах	127.2	63.4
	Шаардлагатай хууль тогтоомжийг судлах	114	82.4
	Шүүхийн практик судлах	101.3	74.3
	Нийт /минут/	879.1	343.4

Хэргийн материалтай танилцах ажиллагаанд 343.4 минутыг зарцуулж байна. Ажлын байрны зураглалын үр дүнгээр хэргийн материалтай танилцахад 879.1 минут зарцуулж байгаа нь асуумжийн үр дүнгээс 2.5 дахин их хугацаа зарцуулж байгаа үр дүн гарсан байна. Энэ нь ажиглалтын зураглал хийсэн хугацаанд тухайн шүүх, шүүгч дээр ирсэн танилцаж байсан хэргийн хувьд хугацаа их зарцуулах, ээдрээ төвөгтэй хэрэг байсан байж болохоор байна.

2.2.6.2. Хэрэг хүлээн авснаас хойших ажиллагааны үе шат

Зөрчлийн хэрэг хүлээн авснаас хойших ажиллагааны үе шатанд Хэргийг хэлэлцүүлэхгүй тухай шүүгчийн захирамж, ТСАХ-тэй холбоотой хүсэлтийг шийдвэрлэх, Хэргийг түдгэлзүүлэх үндэслэл бий болсон эсэхийг шийдвэрлэсэн шүүгчийн захирамж гэсэн 3 ажиллагаа багтсан байна.

График 82 Ерөнхий шүүгч, шүүгчийн хэрэг авснаас хойших ажиллагааны үе шат



Зөрчлийн хэргийн хувьд хэрэг хүлээн авснаас хойших ажиллагааны үе шатанд хамгийн бага хугацаа зарцуулсан Хэргийг хэлэлцүүлэхгүй тухай шүүгчийн захирамж боловсруулах, хянаж гарын үсэг зурах ажиллагаа нь 26 хувь буюу 28 минутыг, хамгийн их хугацаа зарцуулсан хэргийг түдгэлзүүлэх үндэслэл бий болсон эсэхийг шийдвэрлэсэн шүүгчийн захирамж боловсруулах, хянаж гарын үсэг зурах ажиллагаа нь 39 хувь буюу 42 минутыг эзэлж байна. Хэрэг хүлээн авснаас хойших ажиллагааны үе шатны шүүхээр задалж үзвэл:

Хүснэгт 107 Ерөнхий шүүгч, шүүгчийн хэрэг авснаас хойших ажиллагааны үе шат.


	Ажиллагаа	Зураглал	Асуумж
Хэрэг хүлээн авснаас хойших ажиллагаа	Хэргийг хэлэлцүүлэхгүй тухай шүүгчийн захирамж	41.1	28
	ТСАХ-тэй холбоотой хүсэлтийг шийдвэрлэх	41	37.5
	Хэргийг түдгэлзүүлэх үндэслэл бий болсон эсэхийг шийдвэрлэсэн шүүгчийн захирамж	36	42
Нийт /минут/		118.1	107.5

Хэрэг хүлээн авснаас хойших хугацаанд хийсэн ажиллагааны хувьд 107.5 минут зарцуулсан бол ажлын байрны зураглалын үр дүнгээр 118.1 минут зарцуулдаг гэж гарсан нь харьцангуй бодит үр дүн гарсан гэж үзэхээр байна.

2.2.6.3. Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шат

Зөрчлийн хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шатанд Хэргийн оролцогчдод шүүх хуралдааны тов мэдэгдэх хуудсанд гарын үсэг зурах, Шүүх хуралдаан гэсэн 2 ажиллагаа багтсан байна.

График 83 Ерөнхий шүүгч, шүүгчийн хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шат



Зөрчлийн хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шатанд бага хугацаа зарцуулсан хэргийн оролцогчдод шүүх хуралдааны тов мэдэгдэх хуудсанд гарын үсэг зурах ажиллагаа нь 8 хувь буюу 13.3 минутыг, их хугацаа зарцуулсан шүүх хуралдаан нь 92 хувь буюу 153.4 минутыг эзэлж байна.

Хүснэгт 108 Ерөнхий шүүгч, шүүгчийн хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шат


Ажиллагаа	Зураглал	Асуумж
Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шат		
Хэргийн оролцогчдод шүүх хуралдааны тов мэдэгдэх хуудсанд гарын үсэг зурах	5	13.3
Шүүх хуралдаан	83.2	153.4
Нийт /минут/	88.2	166.7

Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шатанд 166.7 минут зарцуулдаг гэсэн асуумжийн үр дүн ажлын байрны зураглалын үр дүнгээс 78.2 минутаар буюу 1.8 дахин их хугацаа зарцуулдаг гэж үр дүн гарсан байна.

2.2.6.4. Шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурах үе шат

Зөрчлийн хэргийн шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурах үе шатанд Шүүх хуралдааны тэмдэглэл хянаж, гарын үсэг зурах, Ерөнхий шүүгчийн захирамж, Шүүгчийн захирамж, Шүүхийн тогтоол, Магадлал зэргийг боловсруулах, хянах, гарын үсэг зурах гэсэн 5 ажиллагаа багтсан байна.

График 84 Ерөнхий шүүгч, шүүгчийн шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурах ажиллагааны үе шат.



Зөрчлийн хэргийн шийдвэр боловсруулах ажиллагааны үе шатанд хамгийн бага хугацаа зарцуулсан нь ерөнхий шүүгчийн захирамж нь 4 хувь буюу 27.6 минутыг, хамгийн их хугацаа зарцуулсан магадлал нь 86 хувь буюу 590.6 минутыг эзэлж байна.

Зөрчлийн хэргийн шийдвэр хянах, гарын үсэг зурах ажиллагааны үе шатанд хамгийн бага хугацаа зарцуулсан нь шүүгчийн захирамж хянах, гарын үсэг зурах нь 5 хувь буюу 14.6 минутыг, хамгийн их хугацаа зарцуулсан шүүхийн тогтоол хянаж, гарын үсэг зурах ажиллагаа нь 70 хувь буюу 193.9 минутыг эзэлж байна.

Хүснэгт 109 Ерөнхий шүүгч, шүүгчийн шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурах үе шат


		Ажиллагаа	Зураглал	Асуумж	
Шүүх хуралдааны тэмдэглэл хянаж, гарын үсэг зурах			100.3	28.1	
Шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурах	Ерөнхий шүүгчийн захирамж	Боловсруулсан	16	27.6	
		Хянасан, гарын үсэг зурах	9.8	16.5	
	Шүүгчийн захирамж	Боловсруулсан	33.2	35.0	
		Хянасан, гарын үсэг зурах	13.9	14.6	
	Шүүхийн тогтоол	Боловсруулсан	29.1	35.3	
		Хянасан, гарын үсэг зурах	5.6	193.9	
	Магадлал	Боловсруулсан	389	590.6	
		Хянасан, гарын үсэг зурах	24.4	25.0	
			Нийт /минут/	621	966.6

Шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурах ажиллагаанд 966.6 минут зарцуулж байгаа нь ажлын байрны зураглалын үр дүнгээр гарсан 621 минутаас 345.6 минутаар буюу 55.6 хувиар их хугацаа зарцуулдаг гэсэн үр дүн гарсан байна.

2.2.6.5. Хэрэг хянан шийдвэрлэсний дараах ажиллагааны үе шат

Зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэсний дараах ажиллагааны үе шатанд Мэдэгдэх хуудас хянаж, гарын үсэг зурах, Залруулгын шүүхийн тогтоол гэсэн 2 ажиллагаа багтсан байна.

График 85 Ерөнхий шүүгч, шүүгчийн хэрэг авснаас хойших ажиллагааны үе шат



Хэрэг хянан шийдвэрлэсний дараах ажиллагааны үе шатанд бага хугацаа зарцуулсан мэдэгдэх хуудас хянаж, гарын үсэг зурах ажиллагаа нь 39 хувь буюу 23.3 минутыг, их

хугацаа зарцуулсан Залруулгын шүүхийн тогтоол боловсруулах, хянан гарын үсэг зурах ажиллагаа нь 61 хувь буюу 36 минутыг эзэлж байна.

Хүснэгт 110 Ерөнхий шүүгч, шүүгчийн хэрэг хянан шийдвэрлэсний дараах ажиллагааны үе шат

	Ажиллагаа	Зураглал	Асуумж
Хэрэг хянан шийдвэрлэсний дараах ажиллагаа	Мэдэгдэх хуудас хянаж, гарын үсэг зурах	82.2	23.3
	Залруулгын шүүгчийн захирамж	85.3	36
Нийт /минут/		167.5	59.3

Явцын дүгнэлт

Давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгч нараас авсан асуумжийн хүрээнд хэрэг хянан шийдвэрлэхэд нэг хэрэгт дунджаар 9391.3 минут буюу 156.5 цаг 19.5 хоногт хянан шийдвэрлэх ажиллагаа хийж байна. Хэргийн материалтай танилцах шатанд 45.7 хувь буюу 4288.6 минутыг, Хэрэг хүлээн авснаас хойших ажиллагааны шатанд 21 хувь буюу 1975 минутыг, Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шатанд 5.6 хувь буюу 5265 минутыг, Шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурах үе шатанд 26.6 хувь буюу 2493.5 минутыг, Хэрэг хянан шийдвэрлэсний дараах ажиллагаанд 1.1 хувь буюу 107.7 минутыг тус тус зарцуулж байна.

Хүснэгт 111 Ерөнхий шүүгч, шүүгчийн эрүүгийн ердийн хэрэг авснаас хойших ажиллагааны үе шат

	Ажиллагаа	Зураглал	Асуумж
	Хэргийн материалтай танилцах	2192.3	4288.6
	Хэрэг хүлээн авснаас хойших ажиллагаа	118.1	1975
	Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шат	338	526.5
	Шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурах	1001.7	2493.5
	Хэрэг хянан шийдвэрлэсний дараах ажиллагаа	55.3	107.7
	Нийт хугацаа	3705.3	9391.3

Давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгч зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэхэд нэг хэрэгт дунджаар 1643.5 минут буюу 27.3 цаг 3.4 хоногт хянан шийдвэрлэх ажиллагаа хийж байна. Хэргийн материалтай танилцах шатанд 20.9 хувь буюу 343.4 минутыг, Хэрэг хүлээн авснаас хойших ажиллагааны үе шатанд 6.5 хувь буюу 107.5 минутыг, Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шатанд 10.1 хувь буюу 166.7 минутыг, Шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурах үе шатанд 58.8 хувь буюу 966.6 минутыг, Хэрэг хянан шийдвэрлэсний дараах ажиллагаанд 3.6 хувь буюу 59.3 минутыг тус тус зарцуулж байна.

Хүснэгт 112 Ерөнхий шүүгч, шүүгчийн зөрчлийн хэрэг авснаас хойших ажиллагааны үе шат

	Ажиллагаа	Зураглал	Асуумж
	Хэргийн материалтай танилцах	879.1	343.4
	Хэрэг хүлээн авснаас хойших ажиллагаа	118.1	107.5
	Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шат	128.7	166.7

Шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурах	621	966.6
Хэрэг хянан шийдвэрлэсний дараах ажиллагаа	167.5	59.3
Нийт хугацаа	1914.4	1643.5

Давж заалдах шатны шүүхийн шүүгч асуумжийн үр дүнгээр зөрчлийн хэргийг дунджаар 1643.5 минут зарцуулдаг гэсэн үр дүн гарсан бөгөөд энэ нь ажлын байрны зураглалын үр дүнгээс 270.9 минутаар бага хугацаа зарцуулж байна гэж гарсан байна.

ГУРАВ. ИРГЭНИЙ ХЭРЭГ

3.1 АНХАН ШАТНЫ ШҮҮХ

Иргэний хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч болон шүүгчийн ажиллагааны ачааллын судалгаа

Баянзүрх дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх, Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх, Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх, Багахангай дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх, Налайх дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх болон аймаг дахь Архангай аймаг дахь Сум дундын *Иргэний хэргийн анхан шатны шүүх*, Баян-Өлгий аймаг дахь Сум дундын *Иргэний хэргийн анхан шатны шүүх*, Баянхонгор аймаг дахь Сум дундын *Иргэний хэргийн анхан шатны шүүх*, Говь-Алтай аймаг дахь Сум дундын *Иргэний хэргийн анхан шатны шүүх*, Говьсүмбэр аймаг дахь Сум дундын *Иргэний хэргийн анхан шатны шүүх*, Дархан-Уул аймаг дахь Сум дундын *Иргэний хэргийн анхан шатны шүүх*, Дорноговь аймаг дахь Сум дундын *Иргэний хэргийн анхан шатны шүүх*, Дорнод аймаг дахь Сум дундын *Иргэний хэргийн анхан шатны шүүх*, Дундговь аймаг дахь Сум дундын *Иргэний хэргийн анхан шатны шүүх*, Завхан аймаг дахь Сум дундын *Иргэний хэргийн анхан шатны шүүх*, Өвөрхангай аймаг дахь Сум дундын *Иргэний хэргийн анхан шатны шүүх*, Сүхбаатар аймаг дахь Сум дундын *Иргэний хэргийн анхан шатны шүүх*, Сэлэнгэ аймаг дахь Сум дундын *Иргэний хэргийн анхан шатны шүүх*, Увс аймаг дахь Сум дундын *Иргэний хэргийн анхан шатны шүүх*, Хөвсгөл аймаг дахь Сум дундын *Иргэний хэргийн анхан шатны шүүх*, Ховд аймаг дахь Сум дундын *Иргэний хэргийн анхан шатны шүүх*, Хэнтий аймаг дахь Сум дундын *Иргэний хэргийн анхан шатны шүүх*, Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын шүүх, Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь сум дундын шүүх, Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь сум дундын шүүх, Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь сум дундын шүүх, Ховд аймгийн Булган сум дахь сум дундын шүүхийн Ерөнхий шүүгч болон шүүгчийн ажиллагааны ачааллыг ажиглалтын болон асуумжийн байдлаар судлахад дараах хугацаатай гарсан байна.

3.1.1.Хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэх шат

Хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэх шатанд Нэхэмжлэл, түүнд хавсаргасан баримтыг уншиж танилцах, ИХШХШТХ-ийн 65 дугаар зүйлд заасан татгалзах үндэслэл байгаа эсэхийг шалгасан туслахыг ажиллагааг хянах, Иргэний хэрэг үүсгэх, эсхүл нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах тухай захирамжийн төслийг боловсруулах, хянах гарын үсэг зурах гэсэн 3 ажиллагаа багтсан байна.

Хүснэгт 113 Ерөнхий шүүгч, шүүгчийн хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэх шат

Д/ Д	Ажиллагаа	Ердийн журмаар	Хялбаршуулсан журмаар	Бага үнийн дүнтэй
---------	-----------	----------------	--------------------------	-------------------


		Асуумжаар ирүүлсэн дундаж хугацаа	Ажлын байрны зураглалын дундаж хугацаа	Асуумжаар ирүүлсэн дундаж хугацаа	Ажлын байрны зураглалын дундаж хугацаа	Асуумжаар ирүүлсэн дундаж хугацаа	Ажлын байрны зураглалын дундаж хугацаа
1	Нэхэмжлэл, түүнд хавсаргасан баримтыг уншиж танилцах	14.7	15.5↑	16↑	8	15.4	10
2	ИХШХШТХ-ийн 65 дугаар зүйлд заасан татгалзах үндэслэл байгаа эсэхийг шалгасан туслахыг ажиллагааг хянах	58.7↑	20.6	14.5↑	11	104.9↑	5
3	Иргэний хэрэг үүсгэх, эсхүл нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах тухай захирамжийн төслийг боловсруулах, хянах гарын үсэг зурах	Боловсруулсан		22.1		136.7↑	
		Хянасан, гарын үсэг зурсан	10.8	23.2↑	10.4	25↑	10.8↑
Нийт		84.2↑	59.3	63↑	44	267.8↑	24.9

Ердийн журмаар хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэх шатанд дунджаар 84.2 минутыг зарцуулж байна. Үүнээс хамгийн бага хугацаа зарцуулсан ажиллагаа нь Нэхэмжлэл, түүнд хавсаргасан баримтыг уншиж танилцах 13 хувь буюу 14.7 минутыг, хамгийн их хугацаа зарцуулсан ажиллагаа ИХШХШТХ-ийн 65 дугаар зүйлд заасан татгалзах үндэслэл байгаа эсэхийг шалгасан туслахыг ажиллагааг хянах нь 70 хувь буюу 58.7 минутыг эзэлж байна.

Хялбаршуулсан журмаар хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэх шатанд дунджаар 63.1 минутыг зарцуулж байна. Үүнээс хамгийн бага хугацаа зарцуулсан ажиллагаа нь Нэхэмжлэл, түүнд хавсаргасан баримтыг уншиж танилцах 25 хувь буюу 16 минутыг, хамгийн их хугацаа зарцуулсан ажиллагаа Иргэний хэрэг үүсгэх, эсхүл нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах тухай захирамжийн төслийг боловсруулах, хянаж гарын үсэг зурах нь 52 хувь буюу 32.5 минутыг эзэлж байна.

Бага үнийн дүнтэй хэрэг маргааны хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэх шатанд дунджаар 267.8 минутыг зарцуулж байна. Үүнээс хамгийн бага хугацаа зарцуулсан ажиллагаа нь ИХШХШТХ-ийн 65 дугаар зүйлд заасан татгалзах үндэслэл байгаа эсэхийг шалгасан туслахыг ажиллагааг хянах 4 хувь буюу 15.4 минутыг, хамгийн их хугацаа зарцуулсан ажиллагаа Нэхэмжлэл, түүнд хавсаргасан баримтыг уншиж танилцах нь 69 хувь буюу 147.5 минутыг эзэлж байна.

График 86 Ерөнхий шүүгч, шүүгчийн хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэх шат



Хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэх шатанд Ердийн журмаар ажлын байрны зураглалын дундаж хугацаа 52.4 минут бол асуумжаар ирүүлсэн дундаж хугацаа 84.2 минут буюу 1.6 дахин, Хялбаршуулсан журмаар ажлын байрны зураглалын дундаж хугацаа 44 минут бол асуумжаар ирүүлсэн дундаж хугацаа 63 минут буюу 1.4 дахин, Бага үнийн дүнтэй хэрэг маргааны хувьд ажлын байрны зураглалын дундаж хугацаа 24.9 минут бол асуумжаар ирүүлсэн дундаж хугацаа 267.8 минут буюу 10.7 дахин тус тус их хугацаатай зарцуулсан байна.

3.1.2.Хэрэг үүсгэснээс хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх шийдвэр гаргах хүртэлх хугацааны ажиллагаа

Хэрэг үүсгэснээс хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх шийдвэр гаргах хүртэлх хугацааны ажиллагааны шатанд нийт 8 ажиллагаа багтсан байна.

Хүснэгт 114 Ерөнхий шүүгч, шүүгчийн хэрэг үүсгэснээс хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх шийдвэр гаргах хүртэлх хугацааны ажиллагаа

Д/Д	Ажиллагаа	Ердийн журмаар		Хялбаршуулсан журмаар		Бага үнийн дүнтэй		
		Асуумжаар ирүүлсэн дундаж хугацаа	Ажлын байрны зураглалын дундаж хугацаа	Асуумжаар ирүүлсэн дундаж хугацаа	Ажлын байрны зураглалын дундаж хугацаа	Асуумжаар ирүүлсэн дундаж хугацаа	Ажлын байрны зураглалын дундаж хугацаа	
1	Нэхэмжлэлд дурдсан хариуцагчийн хаягаар хүргүүлэх мэдэгдэх хуудсыг хянаж, гарын үсэг зурах	4.3 ↑	3.1	5.5 ↑	2	4.9 ↑	2.5	
2	Хариуцагчид нэхэмжлэлийн хувь гардуулсан баримтыг хянаж, гарын үсэг зурах	4.4 ↑	3.1	5.3 ↑	3	4.6 ↑	2.5	
3	Хариуцагчид эрх, үүрэг тайлбарласан баримтыг хянаж, гарын үсэг зурах	5.7	16.8 ↑	6.5	13 ↑	6 ↑	2.5	
4	Нөлөөллийн мэдүүлэг хөтөлдөг талаар мэдээлэл өгсөн баримтыг хянаж, гарын үсэг зурах	4.9	11.3 ↑	6.1	13 ↑	4.9 ↑	2.8	
5	Гэрч асуух, үзлэг хийх, хүүхэд асуух	67.9				56.3		
6	Хариу тайлбартай танилцах	19.9	21.4 ↑	22.2 ↑	18	23.7 ↑	15.9	
7	Хэргийн оролцогчоос ХХША-тай холбоотой хүсэлт гаргасан тохиолдолд шийдвэрлэх	Шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ авах	83.2 ↑	35.8	29.3	32 ↑	133.2 ↑	22.2
		ХХША-тай холбоотой	62 ↑	31.2	39.9 ↑	36	94.6 ↑	35.4
		Нотлох баримттай холбоотой	62.4 ↑	37.5	39.3 ↑	28	97.7 ↑	30
		Гуравдагч этгээд оролцуулах тухай	56.7 ↑	27.6	26.4	32 ↑	85.8 ↑	32.5
	Бусад	35.2 ↑	36.5	38.6 ↑	28	38.9 ↑	30	
8	Уншиж судлах	165.4 ↑	28.2	81.9 ↑	30	118.7 ↑	30	


Хэргийн материалтай танилцах	ХХША-г төлөвлөх	40.1 ↑	24.8	38.8 ↑	14	40.1 ↑	7.5
	Түүвэр гаргах	69.9 ↑	38.7	69.4 ↑	23	70 ↑	25
	Шаардлагатай хууль тогтоомжийг судлах	249.8 ↑	67.9		26	233 ↑	5
	Шүүхийн практик судлах	229.4 ↑	56.9	90.6 ↑	23	205.4 ↑	20
9	Шүүх хуралдааныг хэзээ товловол боломжтойг тодруулах, шүүх хуралдааныг товллох талаар шүүгчийн туслахад чиглэл өгөх	18.8	46.4 ↑			20.2 ↑	10
10	Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх тухай захирамжийг хянах, гарын үсэг зурах	Боловсруулсан	12.1 ↑	5.6		12.2	
	Хянасан, гарын үсэг зурсан	7 ↑	4.4			7.9 ↑	4
Нийт		1199.1 ↑	497.3	499.8 ↑	321	1258.1 ↑	277.8

Энэ шатанд **Ердийн журмаар** хэрэг үүсгэснээс хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх шийдвэр гаргах хүртэлх хугацааны шатанд дунджаар 1199.1 минутыг зарцуулж байна. Хамгийн бага хугацаа зарцуулсан ажиллагаа Нэхэмжлэлд дурдсан хариуцагчийн хаягаар хүргүүлэх мэдэгдэх хуудсыг хянаж, гарын үсэг зурах 4.3 минут болон Хариуцагчид нэхэмжлэлийн хувь гардуулсан баримтыг хянаж, гарын үсэг зурах 4.4 минутыг, хамгийн их хугацаа зарцуулсан ажиллагаа Хэргийн материалтай танилцах /Уншиж судлах 165.4 минут, ХХША-г төлөвлөх 40.1 минут, Түүвэр гаргах 69.9, Шаардлагатай хууль тогтоомжийг судлах 67.9 минут, Шүүхийн практик судлах 90.6 минут/ нь 754.5 минутыг эзэлж байна.

2018 онд Шүүхийн ерөнхий зөвлөлийн захиалгаар Хөгжлийн санаачилга, бодлого судалгааны төвийн хийсэн судалгаанд жилд дунджаар эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн нэг шүүгч 75 хэрэг, иргэний хэргийн анхан шатны шүүхийн нэг шүүгч 200, захиргааны хэргийн анхан шатны шүүхийн нэг шүүгч 42 хэрэг шийдэх нь шүүхийн шийдвэр чанартай бөгөөд үндэслэл бүхий шийдвэр гарна” гэж санал асуулгад хариулсан талаар дурдсан байна.⁵

Жилд хөдөлмөрийн тухай хуульд заасан бүх нийтээр амрах болон тэмдэглэлт баярын өдөр, ээлжийн амралтын өдрийг хасаж тооцоход 250 орчим өдөр ажиллах ёстой гэж үзэн ажлын байны зураглал болон асуумжийн үр дүнг тооцон үзэв.

Ажлын байрны зураглалын үр дүнгээр хугацааг тооцвол эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч 52 хэргийг шийдэх боломжит хугацаа гэж гарсан бол энэ асуумжийн үр дүнгээр нэг хэрэгт зарцуулж буй хугацаагаар тооцон үзэхэд шүүгч жилд 11.7 хэрэг хянан шийдвэрлэхээр үр гарсан нь бодит байдлаас хэтийдсэн үр дүн гарч байна.

Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгч зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэхэд нэг хэрэгт дунджаар 2580.2 минут 43.0 цаг, 5.4 хоног /ажлын 8 цагаар/-т хянан шийдвэрлэж байгаа гэсэн үр дүн гарсан байна. Энэ нь ажлын байрны зураглалын үр дүнгээр гарсан 195.4 минутаас 13.2 дахин их хугацаа зарцуулж байна гэсэн үр дүн гарсан байна. Энэ нь эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэж буй шүүгч жилд ажиллах 250 орчим хоног гэж тооцон үзэхэд 46.3 хэрэг хянан шийдвэрлэх боломжтой гэж гарсан байна.

Анхан шатны шүүхийн шүүгч зөрчлийн хэрэгт заруулж буй хугацааг хийж буй ажиллагаагаар задлан үзэхэд Хэргийн материалтай танилцах шатанд 4.5 хувь буюу 116.1 минутыг, Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шатанд 10.1 хувь буюу 259.4 минутыг, Шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурах үе шатанд 73.8 хувь буюу 1903.7 минутыг, Хэрэг хянан шийдвэрлэсний дараах ажиллагаанд 11.6 хувь буюу 301.7 минутыг тус тус зарцуулж байна.

Хөдөө аж ахуйн их сургуулийн багш нараас бүрдсэн судалгааны багийн үр дүнгээр 1 эрүүгийн хэрэгт 2.4 иргэний хэрэг, 10.2 зөрчлийн хэрэг дүйцүүлэн бодох боломжтой бөгөөд захиргааны хэргийг дүйцүүлэн бодох боломжгүй байна гэсэн дүгнэлтийг гаргасан байна.

Энэ асуумжийн судалгааны үр дүнгээр 1 Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэж буй хугацаа нь 1.7-2.0 иргэний хэрэг хянан шийдвэрлэсэн хугацаатай тэнцэж байна. Мөн 1

⁵ Шүүгчийн ажлын ачаалал тодорхойлох судалгааны тайлан. Хөгжлийн санаачилга, бодлого судалгааны төв, Шүүхийн ерөнхий зөвлөл. 2018 он. 68 дахь тал.

эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэж буй хугацаа нь 3.9 зөрчлийн хэрэг шийдвэрлэх хугацаатай тэнцэж байна гэсэн үр дүн гарчээ.

Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгчийн 1 хэргийг хянан шийдвэрлэхэд зарцуулж буй дундаж хугацаа асуумжийн үр дүнгээр **7613.8** минут, **126.8** цаг, **15.8** ажлын өдөр зарцуулж байна.

Давах

Ажиллагаа	Эрүүгийн хэрэг			Зөрчлийн хэрэг		
	Асуумжаар ирүүлсэн дундаж хугацаа	Ажлын байрны зураглалын дундаж хугацаа	Дундаж	Асуумжаар ирүүлсэн дундаж хугацаа	Ажлын байрны зураглалын дундаж хугацаа	Дундаж
Хэргийн материалтай танилцах	4288.6	2192.3	3240.5	343.4	879.1	611.3
Хэрэг хүлээн авснаас хойших ажиллагаа	197.5	57.8	127.7	107.5	118.1	112.8
Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх	526.5	338	432.3	166.7	88.2	127.5
Шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурах	2493.5	1001.7	1747.6	966.6	621	793.8
Хэрэг хянан шийдвэрлэсний дараах ажиллагаа	107.7	55.3	81.5	59.3	167.5	113.4

Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн нэг шүүгч хэргийн материалтай танилцах шатанд 56.3 хувь буюу 4288.6 минутыг, Хэрэг хүлээн авснаас хойших ажиллагааны шатанд 2.6 хувь буюу 197.5 минутыг, Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шатанд 6.9 хувь буюу 526.5 минутыг, Шийдвэр боловсруулах, хянах, гарын үсэг зурах үе шатанд 32.7 хувь буюу 2493.5 минутыг, Хэрэг хянан шийдвэрлэсний дараах ажиллагаанд 1.4 хувь буюу 107.7 минутыг тус тус зарцуулж байна.

Жилд хөдөлмөрийн тухай хуульд заасан бүх нийтээр амрах болон тэмдэглэлт баярын өдөр, ээлжийн амралтын өдрийг хасаж тооцоход 250 орчим өдөр ажиллах ёстой гэж үзвэл эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн нэг шүүгч жилд 15:8 хэргийг хянан шийдвэрлэх боломжтой байна гэсэн үр дүн асуумжаар гарсан байна.

Иргэн: Иргэний хэргийн анхан шатны 29 шүүхээс асуумж бөглөн ирүүлсэн бөгөөд асуумжаар ирүүлсэн дундаж хугацаа 3084.7 минут буюу 51.4 цаг 6.4 ажлын өдөр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хийж байна. Ажлын байрны зураглалын дундаж хугацаа 2.6 ажлын өдөр байсан бол асуумжаар ирүүлсэн дундаж хугацаа 6.4 ажлын өдөр буюу 2.4 дахин их хугацаатай байна.

Хэрэг хянан шийдвэрлэхэд нэг хэрэгт ажлын байрны зураглалын дундаж хугацаа болон асуумжаар ирүүлсэн дундаж хугацааг дундчилж авч үзвэл 2166.5 минут буюу 36.1 цаг 4.5 ажлын өдөр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хийж байна.

Асуумжаар иргэний хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэх шат 6.2 хувь, хэрэг үүсгэснээс хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх шийдвэр гаргах хүртэлх хугацааны ажиллагааны

шат 44.2 хувь, хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шат 46.8 хувь, хэргийг эцэслэн шийдвэрлэсний дараах үе шат 2.8 хувийг тус тус эзэлж байна.

Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэхэд асуумжаар ирүүлсэн дундаж хугацаа 675.7 минут буюу 11.2 цаг 1.4 ажлын өдөр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хийж байна. Ажлын байрны зураглалын дундаж хугацаа 0.8 ажлын өдөр бол асуумжаар ирүүлсэн дундаж хугацаа 1.4 ажлын өдөр буюу 1.7 дахин их хугацаатай байна.

Хэрэг хянан шийдвэрлэхэд нэг хэрэгт ажлын байрны зураглалын дундаж хугацаа болон асуумжаар ирүүлсэн дундаж хугацааг дундчилж авч үзвэл 551.8 минут буюу 9.1 цаг 1.1 ажлын өдөр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хийж байна.

Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн бага үнийн дүнтэй хэрэг маргааны хувьд асуумжаар дундаж хугацаа 2935.1 минут буюу 48.9 цаг 6.1 ажлын өдөр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хийж байна. Ажлын байрны зураглалын дундаж хугацаа 1.6 ажлын өдөр бол асуумжаар ирүүлсэн дундаж хугацаа 1.4 ажлын өдөр буюу 1.7 дахин их хугацаатай байна.

Хэрэг хянан шийдвэрлэхэд нэг хэрэгт ажлын байрны зураглалын дундаж хугацаа болон асуумжаар ирүүлсэн дундаж хугацааг дундчилж авч үзвэл 1865.7 минут буюу 31 цаг 3.8 ажлын өдөр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хийж байна.

Иргэний хэргийн давж заалдах шатны 11 шүүхээс асуумж бөглөн ирүүлсэн бөгөөд нэг шүүгч хэрэг хянан шийдвэрлэхэд нэг хэрэгт дунджаар 3471.4 минут буюу 57.8 цаг 7.2 ажлын өдөр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хийж байна. Ажлын байрны зураглалын дундаж хугацаа 0.8 ажлын өдөр байсан бол асуумжаар ирүүлсэн дундаж хугацаа 7.2 ажлын өдөр буюу 9 дахин их хугацаатай байна. Асуумжаар хэргийг шүүгч хүлээн авах үе шат 17.2 хувь, хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шат 71.6 хувь, хэргийг эцэслэн шийдвэрлэсний дараах үе шат 11.2 хувийг тус тус эзэлж байна.

Иргэний хэргийн хавтаст хэрэгт хийсэн баримт бичгийн судалгааны тайланд Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны 1-р үе шат “Иргэний хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэх шат”-нд 6 хэрэгт 17 ажиллагааг 55 хоногийн туршид, 2-р үе шат “Хэрэг үүсгэснээс хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх шийдвэр гаргах хүртэлх хугацааны ажиллагаа”-нд 86 ажиллагааг 317 хоногийн туршид, 3-р үе шат “Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шат”-нд 83 ажиллагааг 518 хоногт, 4-р үе шат “Хэргийг эцэслэн шийдвэрлэсний дараах ажиллагаа”-нд 51 ажиллагааг 477 хоногт, нийт 237 ажиллагааг хийж гүйцэтгэхэд 1367 хоног зарцуулжээ.

Дээрх үзүүлэлтээс харвал хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны 2, 3-р үе шатанд буюу хэрэг үүсгэснээс хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх шийдвэр гаргах хүртэлх хугацааны ажиллагаа, хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шатуудад хамгийн их буюу 169 ажиллагааг хийж гүйцэтгэхэд 1004 хоног зарцуулсан байна. Нийт 1367 хоногийн 1004 хоног нь дээрх 2 үе шатыг эзэлж байна. Харин 4-р үе шат буюу “Хэргийг эцэслэн шийдвэрлэсний дараах ажиллагаа”-нд 51 ажиллагааг 477 хоног зарцуулсан байгаа нь хамгийн олон хоног зарцуулсан байна.

Маргааны төрлийн хувьд асуумжид хамгийн их хугацааг Иргэний хуулиар буюу гэрээний маргаан, гэрээний бус үүрэгтэй холбоотой хэрэг, маргаан хянан шийдвэрлэхэд зарцуулж байгаа бол хамгийн бага хугацааг Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар буюу онцгой ажиллагааны хэрэг, маргаан хянан шийдвэрлэхэд зарцуулж байна.

Иргэний хэргийн хавтаст хэрэгт хийсэн баримт бичгийн судалгааны тайлангаас үзэхэд хамгийн их хугацааг Иргэний хуулиар буюу гэрээний маргаан, гэрээний бус үүрэгтэй

холбоотой хэрэг хянан шийдвэрлэхэд зарцуулж байгаа бол хамгийн бага хугацааг Гэр бүлийн тухай хуулиар шийдвэрлэсэн хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд зарцуулж байна.

Захиргаа: Захиргааны хэргийн анхан шатны 21 шүүхээс асуумж бөглөн ирүүлсэн бөгөөд асуумжаар ирүүлсэн дундаж хугацаа 28583.5 минут буюу 476.3 цаг 59.5 ажлын өдөр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хийж байна. Ажлын байрны зураглалын дундаж хугацаа 59.5 ажлын өдөр байсан бол асуумжаар ирүүлсэн дундаж хугацаа 7.2 ажлын өдөр буюу 8.3 дахин их хугацаатай байна.

Хэрэг хянан шийдвэрлэхэд нэг хэрэгт ажлын байрны зураглалын дундаж хугацаа болон асуумжаар ирүүлсэн дундаж хугацааг дундчилж авч үзвэл 16011.6 минут буюу 266.9 цаг 33.4 ажлын өдөр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хийж байна.

Асуумжаар захиргааны хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэх шат 7 хувь, хэрэг үүсгэснээс хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх шийдвэр гаргах хүртэлх хугацааны ажиллагааны шат 70.9 хувь, хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шат 15.4 хувь, хэргийг эцэслэн шийдвэрлэсний дараах үе шат 6.7 хувийг тус тус эзэлж байна.

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхээс асуумж бөглөн ирүүлсэн бөгөөд нэг шүүгч хэрэг хянан шийдвэрлэхэд нэг хэрэгт дунджаар 11907.8 минут буюу 198.4 цаг 24.8 ажлын өдөр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хийж байна. Ажлын байрны зураглалын дундаж хугацаа 10.4 ажлын өдөр байсан бол асуумжаар ирүүлсэн дундаж хугацаа 24.8 ажлын өдөр буюу 2.4 дахин их хугацаатай байна.

Захиргааны хэргийн хавтаст хэрэгт хийсэн баримт бичгийн судалгааны тайланд Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны 1-р үе шат “Захиргааны хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэх шат” 26 буюу 10.4 хувь, 2-р үе шат “Хэрэг үүсгэснээс хэрэг шийдвэрлэх хүртэлх үе шат” 191 буюу 76.1 хувь, 3-р шат “Хэргийг эцэслэн шийдвэрлэсний дараах үе шат” 34 буюу 13.5 хувийг тус тус эзэлж байна.

Маргааны төрлийн хувьд анхан шатны Ерөнхий шүүгч, шүүгч захиргааны 1 хэрэг, маргаан эцэслэн шийдвэрлэхэд дунджаар 66 ажлын өдөр зарцуулж байна.

Ерөнхий шүүгчийн хувьд захиргааны 1 хэрэг, маргаан эцэслэн шийдвэрлэхэд дунджаар 70.4 ажлын өдөр зарцуулж байгаа бөгөөд хамгийн их хугацааг газартай холбоотой хэрэг, маргаан 90 ажлын өдөр, төрийн албатай холбоотой хэрэг, маргаан 89.3 ажлын өдөр, төрийн хяналт, шалгалттай холбоотой хэрэг, маргаан 86.3 ажлын өдөр тус тус зарцуулж байна.

Шүүгчийн хувьд захиргааны 1 хэрэг, маргаан эцэслэн шийдвэрлэхэд дунджаар 61.6 ажлын өдөр зарцуулж байгаа бөгөөд хамгийн их хугацааг татвартай холбоотой хэрэг, маргаан 89.4 ажлын өдөр, газартай холбоотой хэрэг, маргаан 83.4 ажлын өдөр, төрийн хяналт, шалгалттай холбоотой хэрэг, маргаан 79.5 ажлын өдөр тус тус зарцуулж байна.

Харин “Захиргааны хэргийн хавтаст хэрэгт хийсэн баримт бичгийн судалгааны тайлан”-д газрын хэрэг, маргаан шийдвэрлэхэд 4050 хоног, татварын хэрэг, маргаан шийдвэрлэхэд 3435 хоног, төрийн албаны маргаан шийдвэрлэхэд 3857 хоног тус тус зарцуулж байгаа нь хамгийн их хугацаатай байна.

Захиргааны хэргийн анхан шатны 1 шүүгч жилд дунджаар 23.9 хэрэг, маргаан хянан шийдвэрлэдэг бол 1 хэргийг эцэслэн шийдвэрлэхэд ажлын 59.5 өдөр зарцуулж байна. Өөрөөр хэлбэл захиргааны хэргийн анхан шатны 1 шүүгч жилд 23.9 хэрэг, маргааныг эцэслэн шийдвэрлэхэд 1422 ажлын өдрийг зарцуулахаар байна.

Харин Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн хувьд 1 жилд 54.1 хэрэг, маргаан хянан шийдвэрлэдэг бол 1 хэргийг эцэслэн шийдвэрлэхэд ажлын 59.5 өдөр зарцуулж байгаа гэж үзвэл жилд 3218.9 ажлын өдөр зарцуулахаар байна.

Гурав. Эрүү, иргэн, захиргааны хэргийн хавтаст хэрэгт хийсэн баримт бичгийн судалгааны тайлан

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ.....

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ЗАХИРГААНЫ ХЭРЭГ.....

НЭГ. ХЯЛБАРШУУЛСАН ЖУРМААР ШИЙДВЭРЛЭСЭН ЗАХИРГААНЫ ХЭРЭГ.....

1. УДИРТГАЛ.....

1.1. Хавтаст хэргийн талаарх ерөнхий мэдээлэл.....

1.2. Нэхэмжлэлийн шаардлагын товч утга.....

1.3. Хавтас хэрэг доторх баримтын задаргаа.....

1.4. Нийт ажиллагаа /шүүн таслах ажиллагааны үе шатаар/.....

2. ҮНДСЭН ХЭСЭГ.....

2.1. 28/2017/0903/з.....

2.2. 128/2017/0270/з.....

2.3. 128/2018/0106/з.....

2.4. 128/2018/0795/з.....

2.5. 28/2018/0575/з.....

2.6. 28/2018/0184/з.....

2.7. 128/2018/0203/з.....

ХОЁР. ЕРДИЙН ЖУРМААР ШИЙДВЭРЛЭСЭН ЗАХИРГААНЫ ХЭРЭГ.....

1. УДИРТГАЛ.....

1.1. Судалгааны түүвэр.....

1.2. Хэрэг хянан шийдвэрлэсэн хугацаа.....

1.3. Хавтаст хэргийн талаарх ерөнхий мэдээлэл.....

1.4. Нэхэмжлэлийн товч утга.....

1.5. Нэхэмжлэлийн төрөл.....

1.6. Хавтаст хэрэг доторх баримтын задаргаа.....

1.7. Хавтаст хэрэг доторх нотлох баримтын эзэлж буй хувь.....

1.8. Түгээмэл төрлийн хэргийн нийт ажиллагаа.....

.....

1.9. Бусад төрлийн хэргийн нийт ажиллагаа.....

2. ҮНДСЭН ХЭСЭГ.....

2.1. Ашигт малтмал.....

2.2. Газар.....

2.3. Тендер.....

2.4. Төрийн алба.....

2.5. Татвар.....

2.6. Тусгай зөвшөөрөл.....

2.7. Шударга өрсөлдөөн.....

2.8. Гааль.....

2.9. Оюуны өмч.....

2.10. Санхүүгийн зохицуулах хороо
2.11. Төрийн хяналт шалгалт
2.12. Боловсрол
2.13. Нийгмийн даатгал
2.14. Улсын бүртгэл
2.15. Байгаль орчин
2.16. Зам тээвэр
2.17. Ажиллагаанд зарцуулсан хоног /шүүхийн шатлалаар/
2.18. Хавтаст хэрэгт хийгдсэн ажиллагаа /шүүхийн шатлалаар/
3. ХАВСРАЛ
ХОЁРДУГААР БҮЛЭГ. ИРГЭНИЙ ХЭРЭГ
НЭГ. БАГА ҮНИЙН ДҮНТЭЙ ИРГЭНИЙ ХЭРЭГ
1. УДИРТГАЛ
1.1. Хэрэг хянан шийдвэрлэсэн хугацаа
1.2. Хавтаст хэргийн талаарх ерөнхий мэдээлэл
1.3. Нэхэмжлэлийн товч утга
1.4. Хавтаст хэрэг доторх баримтын задаргаа
2. ҮНДСЭН ХЭСЭГ
2.1. Нийт ажиллагааны тоо /шүүхийн шатлалаар/
2.2. Нийт ажиллагааны хувь /шүүхийн шатлалаар/
2.3. Хэрэг хянан шийдвэрлэсэн хугацаа /шүүхийн шатлалаар/
2.4. Нийт ажиллагаа /шүүн таслах ажиллагааны үе шатаар/
3. ХАВСРАЛТ
ХОЁР. ХЯЛБАРШУУЛСАН ЖУРМААР ШИЙДВЭРЛЭСЭН ИРГЭНИЙ ХЭРЭГ
1. УДИРТГАЛ
1.1. Хэрэг хянан шийдвэрлэсэн хугацаа
1.2. Хавтаст хэргийн талаарх ерөнхий мэдээлэл
1.3. Нэхэмжлэлийн товч утга
1.4. Хавтаст хэрэг доторх баримтын задаргаа
1.6. Нийт ажиллагаа /шүүхийн шатлалаар/
2. ҮНДСЭН ХЭСЭГ
2.1. Иргэний эрх зүйн 12 маргаан
2.2. Гэр бүлийн 2 маргаан
2.3. Хөдөлмөрийн 2 маргаан
3. ХАВСРАЛТ
ГУРАВ. ЕРДИЙН ЖУРМААР ШИЙДВЭРЛЭСЭН ИРГЭНИЙ ХЭРЭГ
1. УДИРТГАЛ
1.1. Хавтаст хэргийн талаарх ерөнхий мэдээлэл
1.2. Нэхэмжлэлийн шаардлага

1.3. Маргааны төрөл /хувиар/.....
1.4. Иргэний хэрэгт эзэлж байгаа гэрээний төрөл /хувиар/
.....
1.5. Хавтаст хэрэг доторх баримтын задаргаа.....
1.6. Хавтаст хэрэг доторх баримтын задаргаа.....
1.7. Нийт ажиллагаа / хэргийн маргааны төрөл түс бүрээр/.....
<u>2. ҮНДСЭН ХЭСЭГ</u>
2.1. Иргэний эрх зүйн маргаан
2.2. Гэр бүлийн маргаан.....
2.3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэлтэй холбоотой маргаан
2.4. Хөдөлмөрийн маргаан.....
2.5. Цагаатгалын нөхөн олговор.....
<u>3. НЭХЭМЖЛЭЛ, ХАРИУ ТАЙЛБАР, СӨРӨГ НЭХЭМЖЛЭЛ, ХҮСЭЛТ, ГОМДОЛ, ТАЙЛБАРЫН ДАВТАМЖ БОЛОН ТЭДГЭЭРИЙГ ГАРГАСАН СУБЪЕКТИЙН АНГИЛАЛ</u>
.....
3.1. Хэргийн субъектүүдийн шүүхийн ажиллагаанд оролцож байгаа оролцоо
3.2. Иргэний эрх зүйн маргаан
3.2. Гэр бүлийн маргаан
3.3. Хөдөлмөрийн маргаан.....
3.4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэлтэй холбоотой маргаан
<u>4. ХАВСРАЛТ</u>
<u>ГУРАВДУГААР БҮЛЭГ. ЭРҮҮГИЙН ХЭРЭГ</u>
<u>1. УДИРТГАЛ</u>
1.1. Хавтаст хэргийн талаарх ерөнхий мэдээлэл.....
1.2. Хэрэг хянан шийдвэрлэхэд зарцуулсан хугацаа /хэргийн зүйчлэлээр/
1.3. Хэрэг хянан шийдвэрлэхэд зарцуулсан хугацаа
1.4. Шүүхийн шатанд хийгдсэн ажиллагаа /хэргийн зүйчлэлээр/.....
<u>2. ҮНДСЭН ХЭСЭГ</u>
2.1. Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах /11.1-1/.....
2.2. Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах /11.4-1/.....
2.3. Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах /11.6-1/
2.4. Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах
2.5. Хулгайлах /17.1-1/.....
2.6. Хулгайлах /17.1-2/.....
2.7. Залилах /7.3-1/.....
2.8. Алдаатай гүйлгээ, андуурагдсан илгээмж, гээгдэл эд хөрөнгө, алдуул мал завших
.....
2.9. Мал хулгайлах /17.12-1/
2.10. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах /20.7-1/.....

[2.11. Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих /27.10-1/](#).....

[2.12. Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих /27.10-2/](#).....

4. Хавсралт

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. НЭГДСЭН ДҮГНЭЛТ, САНАЛ

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Шүүгч, шүүгчийн туслахын ажиллагааны ачааллыг тооцох, хүний нөөцийн бодлогыг оновчтой тодорхойлох, шүүх байгуулах тухай хуулийн төслийн санал боловсруулах ажлын хүрээнд улсын хэмжээнд эрүү, иргэн, захиргааны хэргийн шүүхийн хянан шийдвэрлэсэн хэргийн 80-аас дээш хувийг эзэлж буй хэрэг, маргааны төрлөөс⁶ тухайн хэрэг маргааныг хянан шийдвэрлэсэн дундаж хугацааг харгалзан түүврийн аргаар захиргааны 48 хэрэг /98 хавтас, 18,576 хуудас/, иргэний 53 хэрэг /77 хавтас, 11,126 хуудас/, эрүүгийн 30 хэрэг /37 хавтас, 5780 хуудас/ нийт 131 хэрэг /212 хавтас, 35,482 хуудас/-ийг сонгон авч, баримт бичгийн судалгааг хийж гүйцэтгэлээ.

Хэргийн хөдөлгөөний удирдлагын хэлтсээс сүүлийн 5 жилийн хугацаанд 3 шатны шүүхээр шийдвэрлэгдсэн эрүү, иргэн, захиргааны хэргийн жагсаалт болон холбогдох бусад мэдээллийг нэгдсэн баазаас татаж өгснийг баталгаат эх сурвалж буюу эх дата хэмээн үзэж, тэрхүү дата-аас хавтаст хэргийн судалгааны түүврийг гаргаж авлаа.

Судалгаанд дараах тооны түүврийг хамруулсан байна. Нийлбэр дүнг дурдвал эрүү, иргэн, захиргааны хэргийн нийт **131** хэргийн, **212** хавтас **35,482 хуудас** бүхий хэргийн материалд дүн шинжилгээ хийсэн.

Хүснэгт 1. Дүн шинжилгээ хийсэн хэргийн задаргаа

Хэргийн төрөл	Хялбаршуулсан журам			Ердийн журам			Бага үнийн дүнтэй иргэний хэрэг			Нийт хэрэг	Нийт хавтас	Нийт хуудас
	Хэрэг	XX-ийн тоо	Хуудасны тоо	Хэрэг	XX-ийн тоо	Хуудасны тоо	Хэрэг	XX-ийн тоо	Хуудасны тоо			
Захиргаа	7	8	1,111	41	90	17,465	-	-	-	48	98	18,576
Иргэн	16	16	631	31	55	9,967	6	6	528	53	77	11,126
Эрүү	-	-	-	30	37	5,780	-	-	-	30	37	5780
Нийлбэр дүн										131	212	35,482

Судалгааны тайлан нь дүгнэлт, зөвлөмжөөс гадна захиргаа, иргэн, эрүү, гэсэн 3 үндсэн бүлгээс бүтсэн бөгөөд захиргааны хэргийн бүлэг нь дотроо 1. Хялбаршуулсан болон

⁶ Монгол Улсын шүүхийн 2021 оны бүтэн жилийн шүүн таслах ажиллагааны нэгдсэн дүн мэдээ

2. Ердийн журмаар шийдвэрлэгдсэн захиргааны хэрэг гэсэн 2 дэд бүлэг, иргэний хэргийн хэргийн бүлэг нь дотроо 1. Бага үнийн дүнтэй иргэний хэрэг, 2. Хялбаршуулсан болон 3. Ердийн журмаар шийдвэрлэгдсэн иргэний хэрэг гэсэн 3 дэд бүлэг, эрүүгийн хэргийн бүлэг нь 1. Удиртгал, 2. Үндсэн хэсэг гэсэн 2 дэд бүлгээс тус тус бүрдэнэ. Ингээд 3 үндсэн бүлэг болон тэдгээрт хамаарах дэд бүлгүүдээс гарсан судалгааны үр дүнг дор нэгтгэн танилцуулъя.

1. Захиргааны хэргийн хавтаст хэргийн судалгааны үр дүн

1.1. Хялбаршуулсан журам

Энэхүү дэд бүлэгт төрийн алба /2/, газар /2/, татвар /3/ гэсэн 3 төрлийн 7 хэргийн 8 хавтас бүхий 1,111 хуудас хэргийн материалд дүн шинжилгээ хийлээ. 1,111 хуудас хэргийн материалын 375 хуудас буюу 33.8 хувийг шүүхээс боловсруулан баримт, үлдсэн 736 хуудас буюу 66.2 хувийг бусад баримт эзэлж байв. Шүүхээс боловсруулсан баримтад бүх төрлийн баримт /хэргийн хөдөлгөөний нэгдсэн аргачлалаар батлагдсан баримт, маягтууд хамаарна/, шүүхийн илгээсэн албан бичиг шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол, утсаар ярьсан, үзлэг хийсэн, гэрч, шинжээч асуусан зэрэг шүүх хуралдааны тэмдэглэлээс бусад бүх төрлийн тэмдэглэлүүд, шүүх хуралдааны тэмдэглэл, шүүхийн шийдвэр, магадлал зэргийг хамруулсан.

Харин үлдсэн баримт болох 736 хуудас буюу 66.2 хувьд нь хэргийн оролцогчдоос гаргасан нэхэмжлэл, хариу тайлбар, сөрөг нэхэмжлэл, хүсэлт, гомдол, тайлбар, тодруулга, нотлох баримт, гэрчийн мэдүүлэг, шинжээчийн дүгнэлт, шүүхээс илгээсэн албан бичгийн хариу болон түүнд хавсаргасан материалуудыг хамруулсан юм.

Эндээс үзэхэд хавтаст хэрэгт авагдсан баримтын 1/3 хувийг шүүхээс боловсруулан гаргадаг бөгөөд үлдсэн хувийг голдуу хэргийн оролцогчдоос гаргасан нотлох баримтын шинжтэй баримт эзэлдэг ба эдгээр баримт материалыг шүүхээс шинжлэн судалж, шийдвэрээ гаргадаг болох нь харагдаж байна.

Дараагийн хэсэгт хавтаст хэрэгт бүртгэгдсэн дээрх нийт ажиллагааг 1. Хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэх үе шат, 2. Хэрэг үүсгэсний дараа шүүх хуралдаанд бэлтгэж, шүүхийн шийдвэр гаргах үе шат, 3. Хэргийг эцэслэн шийдвэрлэсний дараах үе шат гэж 3 ангилан авч үзсэн юм. Ингэхэд хавтаст хэрэгт бүртгэгдсэн нийт ажиллагааны 10.4 хувийг 1-р үе шатанд, 76.1 хувийг 2-р үе шатанд, 13.5 хувийг 3-р үе шатанд хийж гүйцэтгэсэн байв.

Хялбаршуулсан журмаар шийдвэрлэгдсэн хэргүүд нь бүгд анхан шатны шүүх дээр эцэслэн шийдвэрлэгдсэн байв.

1.2. Ердийн журам

Шүүхийн практикт түгээмэл шийдвэрлэгддэг 16 төрлийн 41 хэргийн 90 хавтас бүхий 17,465 хуудас хэргийн материалд дүн шинжилгээ хийлээ. Эдгээр 16 төрлийн хэргээс шүүхийн практикт хамгийн түгээмэл шийдвэрлэгддэг ашигт малтмал, газар, татвар, тендер, төрийн алба гэсэн 5 төрлийн 21 хэрэгт нийт 2788 ажиллагаа хийгдсэн байсан бол бусад 11 төрлийн 20 хэрэгт 1487 ажиллагаа хийгдсэн байв.

Энэ нь тухайн хэргийн онцлог, ээдрээ төвөгтэй байдал зэргээс шалтгаалжээ. Өөрөөр хэлбэл түгээмэл 5 төрлийн хэрэгт шүүхээс харьцангуй их ажиллагаа хийж, хугацаа арай их зарцуулдаг хандлага ажиглагдаж байна.

Мөн түгээмэл 5 төрөл болон бусад 11 төрлийн хэрэг тус бүрд хийгдсэн нийт ажиллагааг 1. Хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэх үе шат, 2. Хэрэг үүсгэсний дараа хэргийг шүүх хуралдаанд бэлтгэх үе шат, 3. Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэж, шүүхийн шийдвэр гаргах үе шат, 4. Хэргийг эцэслэн шийдвэрлэсний дараах үе шат гэж 4 ангилан авч

үзвэл дээрх 16 төрлийн хэрэгт хийгдсэн ажиллагааны 70-85 хувь, маш цөөн тохиолдолд 90 хүртэлх хувийг 2 болон 3 дахь үе шатанд хийгдсэн ажиллагаанууд эзэлж байв.

Түгээмэл 5 төрлийн хэрэгт 1-р үе шат буюу хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэх шатны ажиллагаа 2-4 хувь маш цөөн тохиолдолд 1 хүртэлх хувийг эзэлж байгаа нь энэ төрлийн нэхэмжлэлийг шүүхээс хүлээн авсан даруйдаа хэрэг үүсгэдэг болох нь ажиглагдлаа. Өөрөөр хэлбэл нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангуулах хугацаа тогтоох захирамж гаргах, нэхэмжлэлийг буцаах, хэрэгсэхгүй болгох зэрэг ажиллагаанууд бараг гарахгүй байгаа нь энэ төрлийн нэхэмжлэлүүд дийлэнх тохиолдолд хууль зүйн үндэслэлтэй бөгөөд магадгүй шүүхэд хандахаас өмнө хуулийн зөвлөх үйлчилгээ авах, өмгөөлөгч, итгэмжлэгдсэн төлөөлөгчтэй оролцдог байж болох юм. Харин үүний эсрэгээр бусад 11 төрлийн хэрэгт хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэх үе шатны ажиллагаа нийт ажиллагааны 3-4 хувь, зам тээвэр, нийгмийн даатгал, гааль зэрэг төрлийн хэрэгт 7-14 хувийг эзэлж байсан нь онцлог ялгаатай байв.

16 төрлийн хэрэг тус бүрээр, 1-4 үе шат тус бүрд хийгдсэн нийт ажиллагаанд зарцуулсан нийт хугацааг /хоногоор хэмжсэн/ үндсэн тайланд харуулсан бөгөөд товчоор дүгнэхэд дээр дурдсантай адилаар 2, 3 дахь үе шатанд нийт ажиллагааны дийлэнх олон хувь нь хийж гүйцэтгэгдсэн байв. Мөн хийгдсэн ажиллагааны тооноос хамаарч хугацаа ихсэх зүй ёсны зүй тогтол ажиглагдлаа.

Мөн дээрх 16 төрлийн нийт 41 хэрэгт хийгдсэн 4275 ажиллагаанд зарцуулсан хугацааг шүүхийн шатлалаар нь ангилан авч үзвэл анхан шатны шүүх 75 хувийг, давж заалдах шатны шүүх 15 хувийг, хяналтын шатны шүүх 10 хувийг тус тус эзэлж байна. Эндээс үзэхэд анхан шатны шүүх хамгийн их ажиллагааг хийж гүйцэтгэдэг бөгөөд хамгийн өндөр ачаалалтай ажилладаг байна.

2. Иргэний хэрэг

2.1. Бага үнийн дүнтэй иргэний хэрэг

Нэхэмжлэлийн үнийн дүн нь 10 сая хүртэлх, 6 хэргийн 6 хавтаст хэргийн 528 хуудас бүхий хэргийн материалд дүн шинжилгээ хийлээ. Хавтаст хэргийн 528 хуудсыг дотор нь задалбал 275 хуудас буюу 52 хувь нь шүүхээс боловсруулсан баримт /эрхийн акт болон бүх төрлийн баримтууд/, 228 хуудас буюу 43 хувь нь хэргийн оролцогчдоос гаргасан баримт /үүний 149 хуудас буюу 28 хувь нь нотлох баримт эзэлнэ/, үлдсэн 25 хуудас буюу 5 хувь нь эдгээр ангилалд хамаарахгүй бусад баримтууд эзэлж байв. Иргэний хэргийн шүүх нь захиргааны хэргийн шүүхийн адил мөрдөн шалгах ажиллагааг хэрэгжүүлдэггүй боловч бага үнийн дүнтэй хэрэг нь харьцангуй ажиллагаа багатай, нотлох баримт цөөтэй хэргүүд байсны улмаас шүүхээс гаргасан баримтын хувь нь хэргийн оролцогчдоос гаргасан баримтын хувиас арай өндөр байгаа нь ажиглагдсан юм.

6 хавтаст хэрэгт бүртгэгдсэн нийт 237 ажиллагааг шүүхийн шатлалаар нь авч үзвэл 192 буюу 81 хувь нь анхан шатны шүүхэд, 26 буюу 11 хувь нь давж заалдах шатны шүүхэд, 19 буюу 8 хувь нь хяналтын шатны шүүхэд хийгдсэн ажиллагаа байгаа нь анхан шатны шүүх бусад шатлалын шүүхээс илүү их ажиллагааг хийж, ачаалалтай байдаг болох нь харагдлаа. Мөн 6 хэргийн нийт 237 ажиллагааг 1. Хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэх үе шат, 2. Хэрэг үүсгэсний дараа хэргийг шүүх хуралдаанд бэлтгэх үе шат, 3. Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэж, шүүхийн шийдвэр гаргах үе шат, 4. Хэргийг шийдвэрлэсний дараах үе шат гэсэн 4 үе шатаар ангилан авч үзвэл 2 болон 3 дахь үе шатанд нийт ажиллагааны дийлэнх олон хувь нь ногдож байгааг үндсэн тайлангаас дэлгэрүүлж үзэх боломжтой.

2.2. Хялбаршуулсан журмаар шийдвэрлэгдсэн иргэний хэрэг

Иргэний эрх зүйн /12/, гэр бүлийн /2/, хөдөлмөрийн /2/ маргаан гэсэн 3 төрлийн 16 хэргийн 16 хавтаст хэрэг бүхий 631 хуудас хэргийн материалд дүн шинжилгээ хийлээ. 631 хуудасны 486 хуудас буюу 77 хувь нь шүүхээс боловсруулсан баримт /эрхийн акт болон төрөл бүрийн баримт/, 145 хуудас буюу 23 хувь нь хэргийн оролцогчдоос гаргасан баримт /69 хуудас буюу 10.9 хувь нотлох баримт эзэлнэ/ эзэлж байв.

Дээр дурдсанчлан иргэний хэргийн шүүх нь захиргааны хэргийн шүүхийн адил мөрдөн шалгах ажиллагааг хэрэгжүүлдэггүй боловч хялбаршуулсан журам болон шүүхийн шатан дахь эвлэрлээр шийдэгдсэн хэргүүдийн онцлог нь хэргийн оролцогч талаас гаргасан нотлох баримт болон бусад баримтын тоо хэмжээ харьцангуй бага байдаг тул нийлбэр дүнгээрээ шүүхээс гаргасан баримтын хувь хэмжээ өндөр дүнтэй харагдах үндэслэл боллоо. Гэвч энэхүү журмаар шийдвэрлэгдсэн хэргүүдийн хувьд хэргийн оролцогч дахин тухайн хэрэгтэй холбогдуулж, маргаан үүсгэдэггүй тул шүүх болон хэргийн оролцогч аль аль талдаа ачаалал бага, цаг хугацаа, зардал хэмнэсэн сайн жишиг тул шүүхийн практикт үүнийг дэлгэрүүлэх нь зүйтэй.

16 хэргийн 1 хэрэг нь 3 шатны шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн бөгөөд бусад 15 хэрэг нь анхан шатны шүүхэд шийдвэрлэгджээ. Энэхүү 1 хэрэг нь иргэний эрх зүйн маргаан байв. Мөн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зарцуулсан хугацаа нь 100-аас дээш хоногтой хэрэг 4 байсан бөгөөд бусад 12 хэргийн хувьд 100-аас доош хоногт шийдвэрлэгдсэн байв. 16 хэрэгт хийгдсэн нийт 338 ажиллагааг шүүн таслах ажиллагааны 4 үе шатаар авч үзвэл шүүх хуралдаанд бэлтгэх, шүүх хуралдааныг хийж, шүүхийн шийдвэр гаргах үе шатанд хийгдсэн ажиллагаа нь дийлэнх хувийг эзэлж байв.

2.3. Ердийн журмаар шийдвэрлэгдсэн иргэний хэрэг

Гэр бүл /3/, иргэн /19 хэрэг/, хөдөлмөр /6 хэрэг/, шүүхийн шийдвэр гүйцэтгэл /2/, цагаатгалын нөхөн олговор /1/ гэсэн нийт 5 төрлийн 31 хэргийн 55 хавтаст хэргийн 9967 хуудас бүхий хэргийн материалд дүн шинжилгээ хийлээ. Судалгааны түүврийн 19 хэрэг буюу 61 хувийг иргэний эрх зүйн маргаан эзэлж байсан бөгөөд үүний 3 хэрэг нь гэм хор, бусад 16 хэрэг нь гэрээний эрх зүйн маргаан байв.

55 хавтаст хэргийн 9967 хуудас хэргийн материалын 3659 хуудас буюу 36.7 хувь нь шүүхээс боловсруулсан баримт /эрхийн акт болон бүх төрлийн баримт хамаарна/, 5225 хуудас буюу 52.4 хувь хэргийн оролцогчдоос гаргасан баримт /үүний 4454 хуудас буюу 44.7 хувь нь нотлох баримт/, үлдсэн 1083 хуудас буюу 10.9 хувь нь бусад баримт /иргэдийн төлөөлөгчийн дүгнэлт гэх мэт эдгээр ангиллын альд нь ч хамаарахгүй баримт/ эзэлж байв.

Нийт 31 хэргийн 55 хавтаст хэрэгт хийгдсэн 2893 ажиллагааг шүүн таслах ажиллагааны 4 үе шатаар ангилан авч үзвэл хэрэг үүсгэснээс хойш хэргийг шүүх хуралдаанд бэлтгэх болон хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлж, шүүхийн шийдвэр гаргах гэсэн 2, 3-р үе шатны ажиллагаа нь нийт ажиллагааны ойролцоогоор 80-84 хувийг эзэлж байв. Энэ нь энэхүү 2 үе шатанд шүүгч болон шүүхийн захиргааны ажилчид хамгийн их ачаалалтай ажилладаг болохыг харуулж байна.

Харин хэрэг үүсгэх эсэх шатны ажиллагаа нь нийт ажиллагааны 3-5 хувь буюу тун бага хэмжээг эзэлж байсан бөгөөд цагаатгалын нөхөн олговрын маргааны хувьд 16 орчим хувь байсан нь энэ төрлийн маргаан дээр хэрэг үүсгэх эсэх нь нэлээд эргэлзээтэй байдаг болох нь харагдлаа.

4-р үе шатанд хэргийн оролцогчдод шүүхийн шийдвэрийг танилцуулж, гардуулж, хүргүүлж, хэргийг эмхэтгэж, архивд шилжүүлэх үе шат боловч хэргийн оролцогчдын зүгээс давж заалдах болон хяналтын шатны гомдол гаргах, шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хэргийг дахин хянуулах, хэргийг хүчингүй болгож, дахин хянан хэлэлцүүлэхээр буцаасан тохиолдолд эдгээр төрлийн гомдол, хүсэлтийг анхан шатны шүүх хүлээн авч,

эсрэг талд гомдлыг танилцуулж, дээд шатны шүүхэд хэргийг шилжүүлдэг тул гомдол, хүсэлтийн тооноос хамаарч энэ үе шатанд хийгдэх ажиллагаа харилцан адилгүй байна.

Мөн судалгааны багийн зүгээс хавтаст хэрэгт авагдсан нэхэмжлэл болон сөрөг нэхэмжлэлийн шаардлагыг нэмэгдүүлсэн, багасгасан, өөрчилсөн, тодруулсан, хариу тайлбар гаргасан, хэргийн оролцогчдын зүгээс гаргасан хүсэлт, гомдол, тайлбар, мэдүүлэг зэргийг нэхэмжлэгч тал болон хариуцагч талын аль талаас нь илүүтэй их гаргадаг болох, мөн эдгээрийн давтамжийг гаргаснаар тухайн хэргийн ээдрээ төвөгтэй байдал, өнгийг нь тодорхойлохыг оролдсон юм.

Ингэхэд судалгааны түүвэрт хамруулсан иргэний эрх зүйн 19 маргаанд 153 удаа нэхэмжлэгч талаас, 123 удаа хариуцагч талаас, гэр бүлийн 3 маргааны хувьд 27 удаа нэхэмжлэгч талаас, 20 удаа хариуцагч талаас, 11 удаа гуравдагч этгээд талаас, хөдөлмөрийн 6 маргаанд нэхэмжлэгч талаас 25, хариуцагч талаас 42 удаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэлтэй холбоотой 2 маргаанд нэхэмжлэгч талаас 12, хариуцагч талаас 5 удаа тус тус хүсэлт, гомдол, тайлбар зэрэг гаргасан байв. Эндээс үзэхэд иргэний хэрэгт нэхэмжлэгч талаас хамгийн их хүсэлт, гомдол, тайлбар гаргадаг болох нь харагдаж байна. Харин хөдөлмөрийн маргаанд хариуцагч талаас илүүтэй хүсэлт, гомдол, тайлбар гарсан нь онцлог байв. Мөн гэр бүлийн маргааны хувьд гуравдагч этгээдийн талаас хүсэлт, гомдол, тайлбар их гаргадаг болох нь онцлог байлаа.

Дээрхээс харахад судалгааны түүвэрт хамруулсан 31 хувьд харьцангуй ээдрээ төвөгтэй хэргүүд дийлэнх хувийг эзэлсэн болох нь дээрх тооноос харагдаж байна.

3. Эрүүгийн хэрэг

Шүүхийн практикт хамгийн түгээмэл шийдвэрлэгддэг 12 төрлийн /хүний эрүүл мэндэд хохирол учруулах, хулгайлах, залилах, хөрөнгө завших, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах, авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэх мэт/ 30 хэргийн 37 хавтаст хэрэг бүхий 5780 хуудас хэргийн материалд дүн шинжилгээ хийлээ.

37 хавтаст хэргийг хэрэг бүртгэснээс эхлээд хэрэг эцэслэн шийдвэрлэх хүртэлх хугацаагаар нь тооцвол нийт 6589 хоног зарцуулжээ. Үүний 4295 хоног буюу 65.2 хувь нь шүүхийн өмнөх шат /хэрэг бүртгэл, мөрдөн байцаалт, прокурорын шат/, 2294 хоног буюу 34.8 хувийг шүүхийн шатанд зарцуулжээ. Шүүхийн шатанд хийгдсэн нийт 624 ажиллагааг 1. Хэрэг хүлээн авснаас хойших ажиллагаа, 2. Шүүх хуралд бэлтгэх, шүүхийн шийдвэр гаргах ажиллагаа, 3. Хэргийг эцэслэн шийдвэрлэсний дараах ажиллагаа гэсэн 3 үе шатанд хуваан авч үзсэн бөгөөд 1-р үе шатанд нийт ажиллагааны 23.7 хувийг, 2-р үе шатанд 38.6 хувийг, 3-р үе шатанд 37.7 хувийг тус тус хийж гүйцэтгэсэн байна.

Хэргийн төрөл тус бүрд хийгдсэн ажиллагааны төрлийг 3 үе шатаар тус тусад нь авч үзсэнийг тайлангийн үндсэн хэсгээс дэлгэрүүлэн үзэх боломжтой

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ЗАХИРГААНЫ ХЭРЭГ

НЭГ. ХЯЛБАРШУУЛСАН ЖУРМААР ШИЙДВЭРЛЭСЭН ЗАХИРГААНЫ ХЭРЭГ

1. УДИРТГАЛ

7 хэргийн 8 хавтаст хэргийн хүрээнд баримт бичгийн судалгаа хийж гүйцэтгэлээ. Тайлангийн хувьд тус 8 хавтаст хэргийн талаарх ерөнхий мэдээллийг танилцуулсны дараа хэрэг тус бүрээр тухайн хэргийг хянан шийдвэрлэхэд зарцуулсан хугацаа болон шүүхээс хийсэн ажиллагааг дор дэлгэрүүлэн авч үзье.

1.1. Хавтаст хэргийн талаарх ерөнхий мэдээлэл

№	Хэргийн индекс	Хэргийн оролцогчийн тоо			Маргааны төрөл	Хавтаст хэргийн тоо	Нийт хуудасны тоо
		Нэхэмжлэгчийн тоо	Хариуцагчийн тоо	Гуравдагч этгээдийн тоо			
1	128/2017/0903/з	1	1	1	Төрийн алба	1	204
2	128/2017/0270/з	1	1	-	Төрийн алба	1	28
3	128/2018/0106/з	1	1	2	Газар	2	450
4	128/2018/0795/з	5	1	-	Газар	1	39
5	128/2018/0575/з	1	1	-	Татвар	1	164
6	128/2018/0184/з	1	1	-	Татвар	1	123
7	128/2018/0203/з	1	2	-	Татвар	1	103
3 төрлийн нийт 7 хэрэг						8 хавтас	1,111 хуудас

1.2. Нэхэмжлэлийн шаардлагын товч утга


№	Хэргийн индекс	Нэхэмжлэлийн шаардлагын утга	Захиргааны хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэсэн шүүгчийн захирамжид гомдол гаргасан эсэх
1	128/2017/0903/з	Төрийн албаны албан тушаалын сонгон шалгаруулалтыг хүчингүй болгуулах	Тийм
2	128/2017/0270/з	1. Ажлаас чөлөөлөх захирамжийг хүчингүй болгуулах 2. Ажлаас үндэслэлгүй халагдсаныг тогтоолгох 3. Албан тушаалд эгүүлэн томилох 4. Нөхөн олговор гаргуулах 5. Нийгмийн даатгалын нөхөн бичилт хийлгэх 6. Ажилд томилсон захирамжийг хүчингүй болгуулах	Үгүй
3	128/2018/0106/з	Засаг даргын захирамжийг хууль бус болохыг тогтоолгож, хүчингүй болгуулах	Үгүй
4	128/2018/0795/з	1. Нийслэлийн Засаг даргын захирамжийг хүчингүй болгуулах 2. Нийслэлийн Ерөнхий төлөвлөгөөний газрын мэргэжлийн зөвлөлийн "И.Ө" ХХК-д олгосон Архитектор төлөвлөлтийн даалгаврыг хүчингүй болгуулах	Үгүй
5	128/2018/0575/з	Тендерт шалгаруулсан шийдвэрийг хүчингүй болгож, тендерийн үнэлгээг дахин явуулахыг Тендерийн үнэлгээний хороонд даалгах	Тийм
6	128/2018/0184/з	Татварын улсын байцаагчийн тогтоосон нөхөн татвараас чөлөөлүүлэх	Үгүй
7	128/2018/0203/з	Дүүргийн Татварын хэлтсийн татварын улсын байцаагч нарын актыг илт хууль бус болохыг тогтоолгож, хүчингүй болгуулах	Үгүй

1.3. Хавтас хэрэг доторх баримтын задаргаа

№	Хэргийн индекс	Хэргийн төрөл	Хавтаст хэрэг /хуудас/	Шүүхээс гаргасан эрхийн акт ⁷ /хуудас/		Бусад баримт /хуудас/ ⁸		Ажиллагааны тоо	Нийт зарцуулсан хоног
				Тоо	Хувь	Тоо	Хувь		
1	128/2017/0903/з	Төрийн алба	204	63	31%	141	69%	44	123
2	128/2017/0270/з	Төрийн алба	28	12	43%	16	57%	9	32
3	128/2018/0106/з	Газар	450	167	37%	283	63%	105	355
4	128/2018/0795/з	Газар	39	10	26%	29	74%	7	62
5	128/2018/0575/з	Татвар	164	60	37%	104	63%	38	98
6	128/2018/0184/з	Татвар	123	31	25%	92	75%	25	61
7	128/2018/0203/з	Татвар	103	32	31%	71	69%	23	97
Нийт			1,111	375	33.8%	736	66.2%	251	828

7 хэргийн 8 хавтаст хэрэгт хийгдсэн нийт 251 ажиллагааг шүүн таслах ажиллагааны үе шатаар ангилан харуулбал 26 буюу 10.4% нь захиргааны хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэх үе шат, 191 буюу 76.1% нь хэрэг үүсгэснээс хэрэг шийдвэрлэх хүртэлх үе шат, 34 буюу 13.5% нь хэргийг эцэслэн шийдвэрлэсний дараах үе шатанд хийгдсэн ажиллагаанууд байв.

1.4. Нийт ажиллагаа /шүүн таслах ажиллагааны үе шатаар/




- Хэрэг үүсгэснээс хэргийг шийдвэрлэх хүртэлх үе шатны ажиллагаа
- Хэргийг эцэслэн шийдвэрлэсний дараах үе шатны ажиллагаа
- Захиргааны хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэх үе шатны ажиллагаа

2. ҮНДСЭН ХЭСЭГ

⁷ Шүүхээс гаргасан эрхийн акт гэдэгт шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол, шийдвэр, магадлал, тогтоол, шүүх хуралдааны тэмдэглэл, нотлох баримт, албан бичиг, тэмдэглэлийг хамруулан ойлгоно.

2.1. 28/2017/0903/з

Төрийн албаны маргаан бөгөөд анхан шатны шүүх дээр эцэслэн шийдвэрлэгдсэн. Хэргийг хянан шийдвэрлэхэд 123 хоног зарцуулсан бөгөөд хавтаст хэрэг нийт 44 ажиллагаа бүртгэгдсэн байв.




№	Баримтын нэр	Огноо
1	Нэхэмжлэл	2017.09.08
2	Захирамж-Нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангуулах хугацаа тогтоох	2017.09.15
3	Баримт-гардуулсан	2017.09.15
4	Нэхэмжлэл	2017.09.19
5	Албан бичиг	2017.09.19
6	Захирамж-нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж, хэргийг хэрэгсэхгүй болгох	2017.09.26
7	Баримт-гардуулсан	2017.09.28
8	Албан бичиг	2017.10.05
9	Захирамж-шүүх хуралдааныг товлон зарлах	2017.10.06
10	Ерөнхий шүүгчийн захирамж-шүүх бүрэлдэхүүн болон даргалагчийг томилсон шийдвэрийг албажуулах	2017.10.06
11	Шүүх хуралдааны тэмдэглэл	2017.10.10
12	Шүүхийн тогтоол-нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан захирамжийг хянасан	2017.10.10
13	Баримт-шүүгчийн захирамж, тогтоол танилцуулах	2017.10.10
14	Албан бичиг	2017.11.06
15	Тэмдэглэл-Хэрэг хүлээлцсэн	2017.11.08
16	Захирамж-хэрэг үүсгэх	2017.11.09
17	Баримт-Шүүхэд дуудан ирүүлэх	2017.11.09
18	Баримт-Нэхэмжлэлийн хувийг гардуулсан	2017.11.14
19	Баримт-хэргийн оролцогчид эрх, үүрэг тайлбарласан	2017.11.14
20	Баримт-Нөлөөллийн мэдүүлэг танилцуулсан	2017.11.14
21	Баримт-өмгөөлөгчид эрх, үүрэг тайлбарласан	2017.11.17
22	Баримт-хэргийн материал танилцуулсан	2017.11.24
23	Баримт-хэргийн оролцогчид эрх, үүрэг тайлбарласан	2017.11.24
24	Захирамж- Гуравдагч этгээдээр татан оролцуулах	2017.12.08
25	Баримт-Нэхэмжлэлийн хувийг гардуулсан	2017.12.11
26	Баримт-хэргийн оролцогчид эрх, үүрэг тайлбарласан	2017.12.11
27	Албан бичиг	2017.12.11
28	Баримт-Урьдчилсан хэлэлцүүлгийн тов	2017.12.15
29	Баримт-Нэхэмжлэлийн хувийг гардуулсан	2017.12.17
30	Тэмдэглэл-шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг	2017.12.18
31	Баримт-Шүүх хуралдааны товыг мэдэгдсэн	2017..12.18
32	Албан бичиг	2017.12.21

33	Тэмдэглэл-Утсаар ярьсан	2017.12.25
34	Баримт-Шүүх хуралдааны товыг мэдэгдсэн	2017.12.25
35	Шүүгчдийн зөвлөгөөний тогтоол-ХХШХ-г сунгах	2018.01.02
36	Захирамж-шүүх хуралдааныг хойшлуулах	2018.01.02
37	Баримт-өмгөөлөгчид эрх, үүрэг тайлбарласан	2018.01.03
39	Баримт-хэргийн материал танилцуулсан	2018.01.03
39	Ерөнхий шүүгчийн захирамж-даргалагч шүүгчийг албажуулах	2018.01.04
40	Баримт-Шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолын үр дагаврыг тайлбарласан	2018.01.05
41	Захирамж-Нэхэмжлэгч, хариуцагч нарын эвлэрлийг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгох	2018.01.08
42	Албан бичиг	2018.01.09
43	Албан бичиг	2018.01.09
44	Албан бичиг	2018.01.09

2.2. 128/2017/0270/з

Төрийн албаны маргаан бөгөөд анхан шатны шүүх дээр эцэслэн шийдвэрлэгдсэн. Хэргийн хянан шийдвэрлэхэд 32 хоног зарцуулсан бөгөөд хавтаст хэрэгт 9 ажиллагаа бүртгэгдсэн байв.



№	Баримтын нэр	Огноо
1	Нэхэмжлэл	2017.03.13
2	Захирамж-хэрэг үүсгэх	2017.03.20
3	Баримт-хэргийн оролцогчид эрх, үүрэг тайлбарласан	2017.03.23
4	Баримт-Нэхэмжлэлийн хувийг гардуулсан	2017.03.23
5	Баримт-Нөлөөллийн мэдүүлэг танилцуулсан	2017.03.23
6	Албан бичиг	2017.04.06
7	Захирамж-Нэхэмжлэгч, хариуцагч нарын эвлэрлийг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгох	2017.04.12
8	Баримт-Шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолын үр дагаврыг тайлбарласан	2017.04.13
9	Баримт-гардуулсан	2017.04.14

2.3. 128/2018/0106/з

Газрын маргаан бөгөөд анхан шатны шүүх дээр эцэслэн шийдвэрлэгдсэн. Хэргийг шийдвэрлэхэд 58 хоног зарцуулсан бөгөөд хавтаст хэрэгт 105 ажиллагаа бүртгэгдсэн байв.




№	Баримтын нэр	Огноо
1	Нэхэмжлэл	2017.12.22
2	Захирамж-Нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангуулах хугацаа тогтоох	2017.12.28
3	Баримт-гардуулсан	2018.01.03
4	Нэхэмжлэл	2018.01.09
5	Захирамж-Нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангуулах хугацаа тогтоох	2018.01.17
6	Баримт-гардуулсан	2018.01.19
7	Нэхэмжлэл	2018.01.25
8	Захирамж-хэрэг үүсгэх	2018.02.01
9	Баримт-Шүүхэд дуудан ирүүлэх	2018.02.01
10	Баримт-хэргийн оролцогчид эрх, үүрэг тайлбарласан	2018.02.05
11	Баримт-хэргийн оролцогчид эрх, үүрэг тайлбарласан	2018.02.05
12	Баримт-Нөлөөллийн мэдүүлэг танилцуулсан	2018.02.05
13	Захирамж- Гуравдагч этгээдээр татан оролцуулах	2018.02.26
14	Баримт-хэргийн оролцогчид эрх, үүрэг тайлбарласан	2018.02.28
15	Албан бичиг	2018.03.01
16	Баримт-хэргийн оролцогчид эрх, үүрэг тайлбарласан	2018.03.21
17	Баримт-хэргийн оролцогчид эрх, үүрэг тайлбарласан	2018.03.21
18	Шүүгчдийн зөвлөгөөний тогтоол-ХХШХ-г сунгах	2018.04.02
19	Албан бичиг	2018.04.23
20	Баримт-гардуулсан	2018.04.24
21	Шүүгчдийн зөвлөгөөний тогтоол-ХХШХ-г сунгах	2018.04.30
22	Баримт-Урьдчилсан хэлэлцүүлгийн тов	2018.05.04
23	Тэмдэглэл-Урьдчилсан хэлэлцүүлэг	2018.05.09
24	Захирамж-Шүүх хуралдаан товлон зарлах	2018.05.09
25	Баримт-Шүүх хуралдааны товыг мэдэгдсэн	2018.05.09
26	Захирамж-даргалагч шүүгчийг албажуулах	2018.05.14
27	Захирамж-Шүүх хуралдааныг хойшлуулах	2018.05.23
28	Баримт-Шүүх хуралдааны товыг мэдэгдсэн	2018.05.28
29	Баримт-Хэрэг танилцуулсан	2018.06.06
30	Захирамж-Шүүх хуралдааныг хойшлуулах	2018.06.06
31	Баримт-Шүүх хуралдааны товыг мэдэгдсэн	2018.06.06
32	Албан бичиг	2018.06.07
33	Албан бичиг	2018.06.07
34	Албан бичиг	2018.06.07
35	Шүүх хуралдааны тэмдэглэл	2018.06.13
36	Захирамж-шүүх хуралдааныг хойшлуулах	2018.06.13

37	Баримт-Шүүх хуралдааны товыг мэдэгдсэн	2018.06.13
38	Албан бичиг	2018.06.20
39	Захирамж- Гуравдагч этгээдээр татан оролцуулах	2018.06.26
40	Албан бичиг	2018.06.27
41	Захирамж-Шүүх хуралдааныг хойшлуулах	2018.06.27
42	Баримт-Шүүх хуралдааны товыг мэдэгдсэн	2018.06.27
43	Баримт-хэргийн оролцогчид эрх, үүрэг тайлбарласан	2018.07.03
44	Баримт-Нэхэмжлэлийн хувийг гардуулсан	2018.07.03
45	Захирамж-Шүүх хуралдааныг хойшлуулах	2018.07.17
46	Баримт-Шүүх хуралдааны товыг мэдэгдсэн	2018.07.17
47	Шүүгчдийн зөвлөгөөний тогтоол-Хэрэг, нэхэмжлэл шилжүүлэх	2018.07.30
48	Захирамж-Шүүх хуралдааныг хойшлуулах	2018.07.31
49	Баримт-Шүүх хуралдааны товыг мэдэгдсэн	2018.07.31
50	Баримт-Хэрэг танилцуулсан	2018.08.07
51	Албан бичиг	2018.08.09
52	Захирамж-Шүүх хуралдааныг хойшлуулах	2018.08.13
53	Баримт-Шүүх хуралдааны товыг мэдэгдсэн	2018.08.13
54	Шүүгчдийн зөвлөгөөний тогтоол-Хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдлыг буцаан шилжүүлэх	2018.08.13
55	Албан бичиг	2018.08.22
56	Албан бичиг	2018.08.25
57	Албан бичиг	2018.08.25
58	Баримт-хэргийн материал танилцуулсан	2018.08.27
59	Шүүх хуралдааны тэмдэглэл	2018.08.27
60	Захирамж-Шүүх хуралдааныг хойшлуулах	2018.08.27
61	Баримт-Шүүх хуралдааны товыг мэдэгдсэн	2018.08.27
62	Баримт-Гэрч шинжээч, орчуулагч, хэлмэрчид эрх, үүрэг тайлбарласан	2018.08.31
63	Шүүх хуралдааны тэмдэглэл	2018.08.31
64	Захирамж-Шүүх хуралдааныг хойшлуулах	2018.08.31
65	Баримт-Шүүх хуралдааны товыг мэдэгдсэн	2018.08.31
66	Захирамж-Шүүх хуралдааныг хойшлуулах	2018.09.11
67	Баримт-Шүүх хуралдааны товыг мэдэгдсэн	2018.09.13
68	Баримт-Хэрэг танилцуулсан	2018.09.25
69	Шүүх хуралдааны тэмдэглэл	2018.09.25
70	Захирамж-Шүүх хуралдааныг хойшлуулах	2018.09.25
71	Баримт-Шүүх хуралдааны товыг мэдэгдсэн	2018.09.25
72	Албан бичиг	2018.09.26
73	Баримт-хэргийн оролцогчид эрх, үүрэг тайлбарласан	2018.10.02
74	Баримт-Хэрэг танилцуулсан	2018.10.02
75	Шүүх хуралдааны тэмдэглэл	2018.10.02
76	Захирамж-Шүүх хуралдааныг хойшлуулах	2018.10.02
77	Баримт-Шүүх хуралдааны товыг мэдэгдсэн	2018.10.02
78	Албан бичиг	2018.10.09
79	Албан бичиг	2018.10.09
80	Тэмдэглэл-Утсаар ярьсан	2018.10.10
81	Шүүх хуралдааны тэмдэглэл	2018.10.16
82	Захирамж-Шүүх хуралдааныг хойшлуулах	2018.10.16
83	Баримт-Шүүх хуралдааны товыг мэдэгдсэн	2018.10.16
84	Ерөнхий шүүгчийн захирамж-Шүүгчийг татгалзан гаргах хүсэлтийг хэрэгсэхгүй болгох	2018.10.16
85	Баримт-гардуулсан	2018.10.22
86	Баримт-Шүүх хуралдаанд дуудан ирүүлэх	2018.10.22
87	Шүүх хуралдааны тэмдэглэл	2018.10.22
88	Захирамж-Шүүх хуралдааныг хойшлуулах	2018.10.22
89	Баримт-Шүүх хуралдааны товыг мэдэгдсэн	2018.10.22
90	Албан бичиг	2018.10.24
91	Албан бичиг	2018.10.24
92	Шүүх хуралдааны тэмдэглэл	2018.10.29
93	Захирамж-Шүүх хуралдааныг хойшлуулах	2018.10.29
94	Баримт-Шүүх хуралдааны товыг мэдэгдсэн	2018.10.29

95	Албан бичиг	2018.11.01
96	Тэмдэглэл-Үзлэг хийсэн	2018.11.01
97	Шүүх хуралдааны тэмдэглэл	2018.11.01
98	Захирамж-Шүүх хуралдааныг хойшлуулах	2018.11.01
99	Баримт-Шүүх хуралдааны товыг мэдэгдсэн	2018.11.01
100	Шүүгчдийн зөвлөгөөний тогтоол-Хэрэг, нэхэмжлэл шилжүүлэх	2018.11.12
101	Захирамж-Шүүх хуралдааныг хойшлуулах	2018.11.15
102	Шүүгчдийн зөвлөгөөний тогтоол-Хэрэг, нэхэмжлэл шилжүүлэх	2018.11.27
103	Баримт-Шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолын үр дагаврыг тайлбарласан	2018.11.27
104	Захирамж-Нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсаныг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгох	2018.11.27
105	Баримт-гардуулсан	2018.12.06

2.4. 128/2018/0795/з


Газрын маргаан бөгөөд анхан шатны шүүх дээр эцэслэн шийдвэрлэгдсэн. Хэргийг шийдвэрлэхэд 62 хоног зарцуулсан бөгөөд хавтаст хэрэгт нийт 7 ажиллагаа бүртгэгдсэн байв.



№	Баримтын нэр	Огноо
1	Шүүхэд дуудан ирүүлэх тухай	2018.09.12
2	Шүүгчийн захирамж, Захиргааны хэрэг үүсгэх тухай	2018.09.13
3	Нэхэмжлэлийн хувийг хариуцагч /гуравдагч этгээд/-д гардуулсан баримт	2018.09.17
4	Нэхэмжлэлийн хувийг хариуцагч /гуравдагч этгээд/-д гардуулсан баримт	2018.09.24
5	Шүүгчийн захирамж, Нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсаныг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгох тухай	2018.10.25
6	шүүгчийн захирамжийн үр дагаврыг тайлбарласан баримт	2018.10.25
7	Шүүх тогтоол, шүүгчийн захирамжийг танилцуулж, гардуулсан баримт	2018.11.13

2.5. 28/2018/0575/з


Татварын маргаан бөгөөд анхан шатны шүүх дээр эцэслэн шийдвэрлэгдсэн. Хэргийг хянан шийдвэрлэхэд 98 хоног зарцуулсан бөгөөд хавтаст хэрэгт нийт 38 ажиллагаа бүртгэгдсэн байв.



№	Баримтын нэр	Огноо
1	Нэхэмжлэл	2018.06.08
2	Албан бичиг	2018.06.08
3	Захирамж-Нэхэмжлэл хүлээн авахаас татгалзах	2018.06.15
4	Баримт-гардуулсан	2018.06.18
5	Баримт-нэхэмжлэл, түүнд хавсаргасан материалыг хүлээлгэж өгсөн	2018.06.18
6	Албан бичиг	2018.06.22
7	Захирамж-Гомдол гаргаагүйд тооцох	2018.06.27
8	Албан бичиг	2018.06.28
9	Тэмдэглэл-Хэрэг хүлээлцсэн	2018.06.28
10	Нэхэмжлэл	2018.06.28
11	Захирамж-хэрэг үүсгэх	2018.07.06
12	Баримт-Нэхэмжлэлийн хувийг гардуулсан	2018.07.09
13	Баримт-Хариуцагчид эрх, үүрэг тайлбарласан	2018.07.09
14	Захирамж- Гуравдагч этгээдээр татан оролцуулах	2018.07.09
15	Шүүгчдийн зөвлөгөөний тогтоол-XXШХ-г сунгах	2018.08.06
16	Албан бичиг	2018.08.09
17	Албан бичиг	2018.08.16
18	Албан бичиг	2018.08.16
19	Баримт-Шүүхэд дуудан ирүүлэх	2018.08.16
20	Албан бичиг	2018.08.20
21	Тэмдэглэл-Утсаар ярьсан	2018.08.20
22	Баримт-хэргийн материал танилцуулсан	2018.08.22
23	Баримт-Урьдчилсан хэлэлцүүлгийн тов	2018.08.23
24	Тэмдэглэл-Утсаар ярьсан	2018.08.24
25	Баримт-Шүүхэд дуудан ирүүлэх	2018.08.28
26	Тэмдэглэл-Утсаар ярьсан	2018.08.28
27	Тэмдэглэл-Утсаар ярьсан	2018.08.28
28	Тэмдэглэл-Утсаар ярьсан	2018.08.28
29	Тэмдэглэл-Урьдчилсан хэлэлцүүлэг	2018.08.29
30	Захирамж-Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлж, шүүх хуралдааныг товлон зарлах	2018.08.29
31	Баримт-Шүүх хуралдааны товыг мэдэгдсэн	2018.08.29
32	Ерөнхий шүүгчийн захирамж-даргалагч шүүгчийг албажуулах	2018.08.30
33	Баримт-гардуулсан	2018.09.03
34	Шүүх хуралдааны тэмдэглэл	2018.09.03
35	Захирамж-Шүүх хуралдааныг хойшлуулах	2018.09.03
36	Баримт-Шүүх хуралдааны товыг мэдэгдсэн	2018.09.03
37	Захирамж-Нэхэмжлэгч, хариуцагч нарын эвлэрлийг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгох	2018.09.10
38	Баримт-гардуулсан	2018.09.14

2.6. 28/2018/0184/з


Татварын маргаан бөгөөд анхан шатны шүүх дээр эцэслэн шийдвэрлэгдсэн. Хэргийг шийдвэрлэхэд 61 хоног зарцуулсан бөгөөд хавтаст хэрэгт 25 ажиллагаа бүртгэгдсэн байв.



№	Баримтын нэр	Огноо
1	Нэхэмжлэл	2018.02.01
2	Захирамж-Нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангуулах хугацаа тогтоох	2018.02.08
3	Баримт-гардуулсан	2018.02.08
4	Захирамж-хэрэг үүсгэх	2018.03.01
5	Албан бичиг	2018.03.02
6	Албан бичиг	2018.03.02
7	Баримт-хэргийн оролцогчид эрх, үүрэг тайлбарласан	2018.03.05
8	Баримт-Нөлөөллийн мэдүүлэг танилцуулсан	2018.03.05
9	Баримт-Нэхэмжлэлийн хувийг гардуулсан	2018.03.05
10	Албан бичиг	2018.03.12
11	Баримт-Шүүх хуралдаанд дуудан ирүүлэх	2018.03.14
12	Баримт-Шүүх хуралдаанд дуудан ирүүлэх	2018.03.14
13	Баримт-Шүүх хуралдаанд дуудан ирүүлэх	2018.03.14
14	Баримт-Урьдчилсан хэлэлцүүлгийн тов	2018.03.14
15	Албан бичиг	2018.03.14
16	Баримт-Шүүх хуралдааны товыг мэдэгдсэн	2018.03.19
17	Баримт-хэргийн оролцогчид эрх, үүрэг тайлбарласан	2018.03.19
18	Баримт-хэргийн материал танилцуулсан	2018.03.19
19	Баримт-хэргийн оролцогчид эрх, үүрэг тайлбарласан	2018.03.19
20	Тэмдэглэл-Урьдчилсан хэлэлцүүлэг	2018.03.19
21	Баримт-Нөлөөллийн мэдүүлэг танилцуулсан	2018.03.19
22	Захирамж-шүүх хурал товлон зарлах	2018.03.19
23	Тэмдэглэл-Урьдчилсан хэлэлцүүлэг	2018.03.19
24	Шүүх хуралдааны тэмдэглэл	2018.03.26
25	Баримт-Шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолын үр дагаврыг тайлбарласан	2018.03.26
26	Баримт-гардуулсан	2018.04.03

2.7. 128/2018/0203/з

Татварын маргаан бөгөөд анхан шатны шүүх дээр эцэслэн шийдвэрлэгдсэн. Хэргийг хянан шийдвэрлэхэд 97 хоног зарцуулсан бөгөөд хавтаст хэрэгт 23 ажиллагаа бүртгэгдсэн байв.



№	Баримтын нэр	Огноо
1	Нэхэмжлэл	2018.02.01
2	Захирамж-Нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангуулах хугацаа тогтоох	2018.02.07
3	Баримт-гардуулсан	2018.02.07
4	Захирамж-Нэхэмжлэл хүлээн авахаас татгалзах	2018.02.07
5	Баримт-гардуулсан	2018.02.21
6	Баримт-нэхэмжлэл, түүнд хавсаргасан материалыг хүлээлгэж өгсөн	2018.02.27
7	Нэхэмжлэл	2018.03.05
8	Захирамж-хэрэг үүсгэх	2018.03.07
9	Баримт-Шүүхэд дуудан ирүүлэх	2018.03.09
10	Баримт-Шүүхэд дуудан ирүүлэх	2018.03.09
11	Баримт-Нэхэмжлэлийн хувийг гардуулсан	2018.03.13
12	Баримт-хэргийн оролцогчид эрх, үүрэг тайлбарласан	2018.03.13
13	Баримт-Нөлөөллийн мэдүүлэг танилцуулсан	2018.03.13
14	Баримт-Урьдчилсан хэлэлцүүлгийн тов	2018.03.13
15	Баримт-Урьдчилсан хэлэлцүүлгийн тов	2018.04.27
16	Баримт-Шүүхэд дуудан ирүүлэх	2018.04.30
17	Шүүгчдийн зөвлөгөөний тогтоол-ХХШХ-г сунгах	2018.04.30
18	Баримт-Шүүхэд дуудан ирүүлэх	2018.05.01
19	Шүүгчдийн зөвлөгөөний тогтоол-Хэрэг, нэхэмжлэл шилжүүлэх	2018.05.01
20	Баримт-хэргийн оролцогчид эрх, үүрэг тайлбарласан	2018.05.03
21	Баримт-Шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолын үр дагаврыг тайлбарласан	2018.05.03
22	Захирамж-нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсаныг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгох	2018.05.04
23	Баримт-Шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолын үр дагаврыг тайлбарласан	2018.05.09

ХОЁР. ЕРДИЙН ЖУРМААР ШИЙДВЭРЛЭСЭН ЗАХИРГААНЫ ХЭРЭГ

1. УДИРТГАЛ

Судалгааны түүврийг сонгохдоо 2017.01.01-2018.12.31-ний хоорондох хугацаанд хяналтын шатны шүүхээр шийдвэрлэгдсэн 23 төрлийн нийт 2516 захиргааны хэргээс шүүхийн практикт хамгийн түгээмэл болон харьцангуй цөөн тоогоор шийдвэрлэгддэг 16 төрлийн 41 хэргийг сонгон авч, судалгааны түүвэрт хамрууллаа. Ингэхдээ эдгээр хэргийн шүүхээр хянан шийдвэрлэгдсэн дундаж хугацааг харгалзан үзсэн юм.

1.1. Судалгааны түүвэр

№	Маргааны төрөл	Шийдвэрлэгдсэн нийт хэргийн тоо	Судалгааны түүвэрээр сонгосон хэргийн тоо	Хэрэг хянан шийдвэрлэсэн дундаж хугацаа /хоног/
1	Ашигт малтмал	210	4	380
2	Байгаль орчны асуудалтай холбоотой	16	1	372
3	Боловсролын тухай хууль	4	2	352
4	Гааль	12	2	364
5	Газар	456	4	470
6	Зам тээвэр	6	1	508
7	Нийгмийн даатгал	28	2	389
8	Оюуны өмч	10	2	508
9	Санхүүгийн зохицуулах хороо	-	3	-
10	Татвар	120	5	354
11	Тендер	75	4	256
12	Төрийн алба	593	4	302
13	Төрийн хяналт шалгалт	51	2	307
14	Тусгай зөвшөөрөл	22	2	326
15	Улсын бүртгэл	7	1	360
16	Шударга өрсөлдөөний тухай хууль	5	2	309
Нийт		1,615	41	-

1.2. Хэрэг хянан шийдвэрлэсэн хугацаа⁹

Судалгаанаас үзвэл нотлох баримт цуглуулах, шаардлагатай тохиолдолд үзлэг хийх, шинжээч томилуулах, шинжээч, гэрчээс мэдүүлэг, тайлбар авах зэрэг ажиллагааг хийхийн зэрэгцээ, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотойгоор хэргийн оролцогчдоос гаргасан хүсэлт, гомдол, тайлбарыг хүлээн авч, шийдвэрлэх эсхүл татгалзах захирамж гаргах, хэргийн оролцогчдод эрх, үүрэг тайлбарлах, шүүх хуралдаан товлох захирамж гаргах, хэргийн оролцогчдод тов мэдэгдэх, ерөнхий шүүгч бүрэлдэхүүн томилох захирамж гаргах, шүүх хуралдааныг хийж, шийдвэр гаргах, нотлох баримт цуглуулах, шаардлагатай тохиолдолд үзлэг хийх, шинжээч томилуулах, шинжээч, гэрчээс мэдүүлэг, тайлбар авах зэрэг ажиллагааг хийхийн зэрэгцээ, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотойгоор хэргийн оролцогчдоос гаргасан хүсэлт, гомдол, тайлбарыг хүлээн авч, шийдвэрлэх эсхүл татгалзах захирамж гаргах, хэргийн оролцогчдод эрх, үүрэг тайлбарлах зэрэг ажиллагаа нь хэргийг шийдвэрлэхэд хамгийн их хугацаа зарцуулдаг, ачаалал бүхий ажиллагаа болох нь ажиглагдаж байна.

Судалгаанд нийт 16 төрлийн 41 хэргийг хамруулан дүн шинжилгээ хийжээ.

1.Ашигт малтмалын маргаантай холбоотой хэргийн тухайд: Энэ төрлийн 4 хэрэгт нийт 375 ажиллагаа бүртгэгдсэн байна. Үүнээс 241 ажиллагаа нь 3-р үе шат /Шүүх хуралдааны бэлтгэлийг хангасны дараа шүүх хуралдаан товлох захирамж гаргах, хэргийн оролцогчдод тов мэдэгдэх, ерөнхий шүүгч бүрэлдэхүүн томилох захирамж гаргах, шүүх хуралдааныг хийж, шийдвэр гаргах/-нд хийгдсэн бөгөөд ажиллагаанд нийт 1828 хоног зарцуулсанаас, зөвхөн 3-р үе шатанд хамгийн их буюу 906 хоног зарцуулагджээ.

2.Газрын маргаантай холбоотой хэргийн тухайд: Энэ төрлийн 5 хэрэгт нийт 489 ажиллагаа бүртгэгдсэн байна. Үүнээс 416 ажиллагаа нь 3-р үе шат /Шүүх хуралдааны бэлтгэлийг хангасны дараа шүүх хуралдаан товлох захирамж гаргах, хэргийн оролцогчдод тов мэдэгдэх, ерөнхий шүүгч бүрэлдэхүүн томилох захирамж гаргах, шүүх хуралдааныг хийж, шийдвэр гаргах/-нд хийгдсэн бөгөөд

ажиллагаанд нийт 4050 хоног зарцуулсанаас, зөвхөн 3-р үе шатанд хамгийн их буюу 906 хоног зарцуулагджээ.

3.Тендерийн маргаантай холбоотой хэргийн тухайд: Энэ төрлийн 4 хэрэгт нийт 364 ажиллагаа бүртгэгдсэн байна. Үүнээс 147 ажиллагаа нь 3-р үе шат /Шүүх хуралдааны бэлтгэлийг хангасны дараа шүүх хуралдаан товлох захирамж гаргах, хэргийн оролцогчдод тов мэдэгдэх, ерөнхий шүүгч бүрэлдэхүүн томилох захирамж гаргах, шүүх хуралдааныг хийж, шийдвэр гаргах/-нд хийгдсэн бөгөөд ажиллагаанд нийт 2170 хоног зарцуулсанаас, зөвхөн 3-р үе шатанд 505, 4-р үе шат /шийдвэр боловсруулах, бичгийн хэлбэрээр гарсан шийдвэрийг хэргийн оролцогчдод танилцуулж, гардуулах, хэргийн оролцогчдоос давах, хяналтын шатны гомдол гаргасан тохиолдолд түүнийг хүлээн авч, дээд шатны шүүхэд шилжүүлэх зэрэг ажиллагааг/-нд хамгийн их буюу 1040 хоног зарцуулагджээ.

4.Төрийн албаны маргаантай холбоотой хэргийн тухайд: Энэ төрлийн 4 хэрэгт нийт 692 ажиллагаа бүртгэгдсэн байна. Үүнээс 251 ажиллагаа нь 2-р үе шат /нотлох баримт цуглуулах, шаардлагатай тохиолдолд үзлэг хийх, шинжээч томилуулах, шинжээч, гэрчээс мэдүүлэг, тайлбар авах зэрэг ажиллагааг хийхийн зэрэгцээ, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотойгоор хэргийн оролцогчдоос гаргасан хүсэлт, гомдол, тайлбарыг хүлээн авч, шийдвэрлэх эсхүл татгалзах захирамж гаргах, хэргийн оролцогчдод эрх, үүрэг тайлбарлах/-нд хийгдсэн бөгөөд ажиллагаанд нийт 1913 хоног зарцуулсанаас, зөвхөн 2-р үе шатанд хамгийн их буюу 1020 хоног зарцуулагджээ.

5.Татварын маргаантай холбоотой хэргийн тухайд: Энэ төрлийн 5 хэрэгт нийт 489 ажиллагаа бүртгэгдсэн байна. Үүнээс 236 ажиллагаа нь 3-р үе шат /Шүүх хуралдааны бэлтгэлийг хангасны дараа шүүх хуралдаан товлох захирамж гаргах, хэргийн оролцогчдод тов мэдэгдэх, ерөнхий шүүгч бүрэлдэхүүн томилох захирамж гаргах, шүүх хуралдааныг хийж, шийдвэр гаргах/-нд хийгдсэн бөгөөд ажиллагаанд нийт 3435 хоног зарцуулсанаас 3-р үе шатанд 899, 2-р үе шат /нотлох баримт цуглуулах, шаардлагатай тохиолдолд үзлэг хийх, шинжээч томилуулах, шинжээч, гэрчээс мэдүүлэг, тайлбар авах зэрэг ажиллагааг хийхийн зэрэгцээ, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотойгоор хэргийн оролцогчдоос гаргасан хүсэлт, гомдол, тайлбарыг хүлээн авч, шийдвэрлэх эсхүл татгалзах захирамж гаргах, хэргийн оролцогчдод эрх, үүрэг тайлбарлах/-нд хамгийн их буюу 1020 хоног зарцуулагджээ.

6.Тусгай зөвшөөрлийн маргаантай холбоотой хэргийн тухайд: Энэ төрлийн 2 хэрэгт нийт 210 ажиллагаа бүртгэгдсэн байна. Үүнээс 81 ажиллагаа нь 2-р үе шат /нотлох баримт цуглуулах, шаардлагатай тохиолдолд үзлэг хийх, шинжээч томилуулах, шинжээч, гэрчээс мэдүүлэг, тайлбар авах зэрэг ажиллагааг хийхийн зэрэгцээ, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотойгоор хэргийн оролцогчдоос гаргасан хүсэлт, гомдол, тайлбарыг хүлээн авч, шийдвэрлэх эсхүл татгалзах захирамж гаргах, хэргийн оролцогчдод эрх, үүрэг тайлбарлах/-нд

хийгдсэн бөгөөд ажиллагаанд нийт 1060 хоног зарцуулсанаас 2-р үе шатанд хамгийн их буюу 339 хоног зарцуулагджээ.

7.Шударга өрсөлдөөний тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой хэргийн тухайд: Энэ төрлийн 2 хэрэгт нийт 67 ажиллагаа бүртгэгдсэн байна. Үүнээс 30 ажиллагаа нь 2-р үе шат /*нотлох баримт цуглуулах, шаардлагатай тохиолдолд үзлэг хийх, шинжээч томилуулах, шинжээч, гэрчээс мэдүүлэг, тайлбар авах зэрэг ажиллагааг хийхийн зэрэгцээ, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотойгоор хэргийн оролцогчдоос гаргасан хүсэлт, гомдол, тайлбарыг хүлээн авч, шийдвэрлэх эсхүл татгалзах захирамж гаргах, хэргийн оролцогчдод эрх, үүрэг тайлбарлах/-* нд хийгдсэн бөгөөд ажиллагаанд нийт 644 хоног зарцуулсанаас 2-р үе шатанд хамгийн их буюу 207 хоног зарцуулагджээ.

8.Гаалийн маргаантай холбоотой хэргийн тухайд: Энэ төрлийн 2 хэрэгт нийт 119 ажиллагаа бүртгэгдсэн байна. Үүнээс 41 ажиллагаа нь 2-р үе шат /*нотлох баримт цуглуулах, шаардлагатай тохиолдолд үзлэг хийх, шинжээч томилуулах, шинжээч, гэрчээс мэдүүлэг, тайлбар авах зэрэг ажиллагааг хийхийн зэрэгцээ, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотойгоор хэргийн оролцогчдоос гаргасан хүсэлт, гомдол, тайлбарыг хүлээн авч, шийдвэрлэх эсхүл татгалзах захирамж гаргах, хэргийн оролцогчдод эрх, үүрэг тайлбарлах/-* нд хийгдсэн бөгөөд ажиллагаанд нийт 737 хоног зарцуулсанаас 2-р үе шатанд хамгийн их буюу 238 хоног зарцуулагджээ.

9.Оюуны өмчийн маргаантай холбоотой хэргийн тухайд: Энэ төрлийн 2 хэрэгт нийт 195 ажиллагаа бүртгэгдсэн байна. Үүнээс 95 ажиллагаа нь 3-р үе шат /*Шүүх хуралдааны бэлтгэлийг хангасны дараа шүүх хуралдаан товлох захирамж гаргах, хэргийн оролцогчдод тов мэдэгдэх, ерөнхий шүүгч бүрэлдэхүүн томилох захирамж гаргах, шүүх хуралдааныг хийж, шийдвэр гаргах/-*нд хийгдсэн бөгөөд ажиллагаанд нийт 1181 хоног зарцуулсанаас 3-р үе шатанд хамгийн их буюу 387 хоног зарцуулагджээ.

10.Санхүүгийн зохицуулах хороотой холбоотой хэргийн тухайд: Энэ төрлийн 3 хэрэгт нийт 195 ажиллагаа бүртгэгдсэн байна. Үүнээс 95 ажиллагаа нь 3-р үе шат /*Шүүх хуралдааны бэлтгэлийг хангасны дараа шүүх хуралдаан товлох захирамж гаргах, хэргийн оролцогчдод тов мэдэгдэх, ерөнхий шүүгч бүрэлдэхүүн томилох захирамж гаргах, шүүх хуралдааныг хийж, шийдвэр гаргах/-*нд хийгдсэн бөгөөд ажиллагаанд нийт 1114 хоног зарцуулсанаас 3-р үе шатанд хамгийн их буюу 398 хоног зарцуулагджээ.

11.Төрийн хяналт шалгалттай холбоотой хэргийн тухайд: Энэ төрлийн 2 хэрэгт нийт 194 ажиллагаа бүртгэгдсэн байна. Үүнээс 83 ажиллагаа нь 2-р үе шат /*нотлох баримт цуглуулах, шаардлагатай тохиолдолд үзлэг хийх, шинжээч томилуулах, шинжээч, гэрчээс мэдүүлэг, тайлбар авах зэрэг ажиллагааг хийхийн зэрэгцээ, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотойгоор хэргийн оролцогчдоос гаргасан хүсэлт, гомдол, тайлбарыг хүлээн авч, шийдвэрлэх эсхүл*

татгалзах захирамж гаргах, хэргийн оролцогчдод эрх, үүрэг тайлбарлах/-нд хийгдсэн бөгөөд ажиллагаанд нийт 906 хоног зарцуулсанаас 2-р үе шатанд хамгийн их буюу 270 хоног зарцуулагджээ.

*12.Боловсролын салбартай холбоотой хэргийн тухайд: Энэ төрлийн 2 хэрэгт нийт 137 ажиллагаа бүртгэгдсэн байна. Үүнээс 57 ажиллагаа нь 2-р үе шат /*нотлох баримт цуглуулах, шаардлагатай тохиолдолд үзлэг хийх, шинжээч томилуулах, шинжээч, гэрчээс мэдүүлэг, тайлбар авах зэрэг ажиллагааг хийхийн зэрэгцээ, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотойгоор хэргийн оролцогчдоос гаргасан хүсэлт, гомдол, тайлбарыг хүлээн авч, шийдвэрлэх эсхүл татгалзах захирамж гаргах, хэргийн оролцогчдод эрх, үүрэг тайлбарлах/-нд хийгдсэн бөгөөд ажиллагаанд нийт 658 хоног зарцуулсанаас 2-р үе шатанд хамгийн их буюу 286 хоног зарцуулагджээ.**

*13.Нийгмийн даатгалын салбартай холбоотой хэргийн тухайд: Энэ төрлийн 2 хэрэгт нийт 112 ажиллагаа бүртгэгдсэн байна. Үүнээс 42 ажиллагаа нь 2-р үе шат /*нотлох баримт цуглуулах, шаардлагатай тохиолдолд үзлэг хийх, шинжээч томилуулах, шинжээч, гэрчээс мэдүүлэг, тайлбар авах зэрэг ажиллагааг хийхийн зэрэгцээ, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотойгоор хэргийн оролцогчдоос гаргасан хүсэлт, гомдол, тайлбарыг хүлээн авч, шийдвэрлэх эсхүл татгалзах захирамж гаргах, хэргийн оролцогчдод эрх, үүрэг тайлбарлах/-нд хийгдсэн бөгөөд ажиллагаанд нийт 502 хоног зарцуулсанаас 2-р үе шатанд хамгийн их буюу 172 хоног зарцуулагджээ.**

*14.Улсын бүртгэлтэй холбоотой хэргийн тухайд: Энэ төрлийн 1 хэрэгт нийт 69 ажиллагаа бүртгэгдсэн байна. Үүнээс 39 ажиллагаа нь 3-р үе шат /*Шүүх хуралдааны бэлтгэлийг хангасны дараа шүүх хуралдаан товлох захирамж гаргах, хэргийн оролцогчдод тов мэдэгдэх, ерөнхий шүүгч бүрэлдэхүүн томилох захирамж гаргах, шүүх хуралдааныг хийж, шийдвэр гаргах/-нд хийгдсэн бөгөөд ажиллагаанд нийт 893 хоног зарцуулсанаас 3-р үе шатанд хамгийн их буюу 592 хоног зарцуулагджээ.**

*15.Байгаль орчны салбартай холбоотой хэргийн тухайд: Энэ төрлийн 1 хэрэгт нийт 123 ажиллагаа бүртгэгдсэн байна. Үүнээс 54 ажиллагаа нь 2-р үе шат /*нотлох баримт цуглуулах, шаардлагатай тохиолдолд үзлэг хийх, шинжээч томилуулах, шинжээч, гэрчээс мэдүүлэг, тайлбар авах зэрэг ажиллагааг хийхийн зэрэгцээ, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотойгоор хэргийн оролцогчдоос гаргасан хүсэлт, гомдол, тайлбарыг хүлээн авч, шийдвэрлэх эсхүл татгалзах захирамж гаргах, хэргийн оролцогчдод эрх, үүрэг тайлбарлах/-нд хийгдсэн бөгөөд ажиллагаанд нийт 789 хоног зарцуулсанаас 2-р үе шатанд хамгийн их буюу 229 хоног зарцуулагджээ.**

*16.Зам тээврийн салбартай холбоотой хэргийн тухайд: Энэ төрлийн 1 хэрэгт нийт 43 ажиллагаа бүртгэгдсэн байна. Үүнээс 20 ажиллагаа нь 2-р үе шат /*нотлох баримт цуглуулах, шаардлагатай тохиолдолд үзлэг хийх, шинжээч**

томилуулах, шинжээч, гэрчээс мэдүүлэг, тайлбар авах зэрэг ажиллагааг хийхийн зэрэгцээ, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотойгоор хэргийн оролцогчдоос гаргасан хүсэлт, гомдол, тайлбарыг хүлээн авч, шийдвэрлэх эсхүл татгалзах захирамж гаргах, хэргийн оролцогчдод эрх, үүрэг тайлбарлах/-нд хийгдсэн бөгөөд ажиллагаанд нийт 651 хоног зарцуулсанаас 1-р үе шат /хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэх/-нд хамгийн их буюу 490 хоног зарцуулагджээ.

Хялбаршуулсан журмаар шийдвэрлэгдсэн захиргааны хэргийн хавтаст хэргийн судалгааны хувьд

Хавтаст хэргийн судалгаанд хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэгдсэн 7 хэргийн 8 хавтаст хэрэгт хийгдсэн нийт 251 ажиллагааг шүүн таслах ажиллагааны үе шатаар ангилан харуулбал 26 буюу 10.4% нь захиргааны хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэх үе шат, 191 буюу 76.1% нь хэрэг үүсгэснээс хойш хэрэг шийдвэрлэх хүртэлх үе шат, 34 буюу 13.5% нь хэргийг эцэслэн шийдвэрлэсний дараах үе шатанд хийгдсэн ажиллагаанууд байна.

Мөн хавтаст хэргийн судалгаанд захиргааны хэргийн шүүхийн нэг онцлог шинж харагдаж байгаа бөгөөд тухайлбал Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1. дэх хэсэгт “Захиргааны хэргийн шүүх хэргийн нөхцөл байдлыг тодруулах, хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нотлох баримт цуглуулах, үнэлэх ажиллагааг хэрэгжүүлэх үүрэгтэй бөгөөд хэргийн оролцогчийг татан оролцуулна.”, “32.1.Хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нотлох баримтыг цуглуулах үүргийг захиргааны хэргийн шүүх гүйцэтгэнэ.” гэж тус тус заасны дагуу нотлох баримтыг шүүх өөрөө цуглуулдаг нь хянан шийдвэрлэх хугацаандаа хэргийг шийдэж чадахгүй байх гол хүчин зүйл болж байгаа нь ажиглагдаж байна.

Хавтаст хэргийн судалгаанаас үзвэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаанд нөлөөлж байгаа томоохон нэг шалтгаан нь Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.2.-т”Нотлох баримт цуглуулах зайлшгүй шаардлагатай, эсхүл хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч хүндэтгэн үзэх шалтгаанаар шүүх хуралдаанд оролцох боломжгүй нь шүүх хуралдаанаас өмнө тогтоогдсон тохиолдолд уг нөхцөлийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхгүйгээр товлосон хуралдааныг 14 хүртэл хоногоор хойшлуулж болно.” гэж заасны дагуу шүүх хуралдаан хойшлох, түүнтэй холбогдсон ажиллагаа хийгдэх зэрэг юм.

Хавтаст хэргийн судалгаанд дурдсан 7 хэргийг маргааны төрлөөр нь шинжлэн үзвэл:

Төрийн албаны маргаантай холбогдсон хэрэг

Төрийн албаны сонгон шалгаруулалтыг хүчингүй болгуулах нэхэмжлэлтэй, 128/2017/0903/з индексийн дугаартай хэргийн хувьд Төрийн албаны тухай хуулийн

76 дугаар зүйлийн 76.3 дэх хэсэгт “Төрийн албаны төв байгууллагын шийдвэрийг эс зөвшөөрсөн тал уг шийдвэрийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор шүүхэд гомдол гаргаж болно.” гэж заасны дагуу гомдол гаргаж, анхан шатны шүүх Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1 дэх хэсэгт “Хуульд өөрөөр заагаагүй бол хэрэг үүсгэснээс хойш 60 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ.” мөн хуулийн 63 дугаар зүйлийн 63.3 дахь хэсэгт “Энэ хуулийн 63.1, 63.2-т заасан хугацааг шаардлагатай тохиолдолд тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс эхний удаа 30 хүртэл хоногоор, хоёр дахь удаагаа 15 хүртэл хоногоор сунгаж болно” гэж тус тус заасны дагуу хэргийг хянан шийдвэрлэсэн байна.

Хавтаст хэргийн судалгааны дүнгээс үзвэл дээрх хэргийн хувьд нийт 44 ажиллагаа бүртгэгдсэн байна. Үүнээс 19 ажиллагаа захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны баримт, түүнд холбогдсон ажиллагаа байгаа бөгөөд захиргааны хэрэг үүсгэснээс хэрэг хянан шийдвэрлэх хүртэлх үе шатанд нийт ажиллагааны 61% нь хийгджээ.

Эдгээрийн хамгийн их хугацаа зарцуулсан ажиллагаа нь Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 59 дүгээр зүйлд зааснаар хэргийн оролцогчдыг шүүхэд дуудан ирүүлэх, мөн хуулийн 17 дугаар зүйлд заасан хэргийн оролцогчдод эрх, үүрэг тайлбарлах, мөн хуулийн 32 дугаар зүйлд зааснаар нотлох баримтыг эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас авах зэрэг ажиллагаа байна.

Ажлаас чөлөөлөх захирамжийг хүчингүй болгох нэхэмжлэлтэй, 128/2017/0270/з индексийн дугаартай хэргийн хувьд Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.9 дэх хэсэгт “Төрийн жинхэнэ албан хаагч сахилгын шийтгэл ногдуулсан тухай шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл энэ тухай гомдлоо тухайн шийдвэрийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор төрийн албаны төв байгууллагад, эсхүл шүүхэд гаргаж болно.” гэж заасны дагуу гомдол гаргаж, шүүх Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1 дэх хэсэгт “Хуульд өөрөөр заагаагүй бол хэрэг үүсгэснээс хойш 60 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ.” гэж заасны дагуу шийдвэрлэсэн байна.

128/2017/0270/з индексийн дугаартай хэргийн хувьд хэрэг хянан шийдвэрлэх явцад хийгдсэн ажиллагааны хувьд нийт 9 ажиллагаа бүртгэгдсэн байна. Үүнээс 5 ажиллагаа нь дангаараа захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны баримт, түүнд холбогдсон ажиллагаа байна.

Эдгээрийн хамгийн их хугацаа зарцуулсан ажиллагаа нь дээр дурдсан төрийн албаны маргааны ажиллагаатай ижил бөгөөд Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 59 дүгээр зүйлд зааснаар хэргийн оролцогчдыг шүүхэд дуудан ирүүлэх, мөн хуулийн 17 дугаар зүйлд заасан хэргийн оролцогчдод эрх, үүрэг тайлбарлах, мөн хуулийн 32 дугаар зүйлд зааснаар нотлох баримтыг эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас авах зэрэг ажиллагаа байна.

Газрын маргаантай холбогдсон хэрэг

Засаг даргын захирамжийг хууль бус болохыг тогтоолгож, хүчингүй болгуулах нэхэмжлэлтэй 128/2018/0106/з, 128/2018/0795/з индексийн дугаартай хэргүүдийн хувьд Газрын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2 дэх хэсэгт “Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага газартай холбогдон үүссэн маргааны талаар энэ хуулийн 60.1.1, 60.1.2, 60.1.3-т заасан байгууллага, албан тушаалтны гаргасан шийдвэрийг эс зөвшөөрвөл уг маргааныг тэдгээрийн дээд шатны албан тушаалтан, байгууллага, эсхүл шүүхээр шийдвэрлүүлнэ.”, гэж заасны дагуу гомдол гаргаж, анхан шатны шүүх Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1 дэх хэсэгт “Хуульд өөрөөр заагаагүй бол хэрэг үүсгэснээс хойш 60 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ.” гэж заасны дагуу шийдвэрлэсэн байна.

Хавтаст хэргийн судалгааны дүнгээс үзвэл 128/2018/0106/з индексийн дугаартай хэргийн хувьд нийт 105 ажиллагаа бүртгэгдсэн байна. Үүнээс 39 ажиллагаа захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны баримт, түүнд холбогдсон ажиллагаа байгаа бөгөөд захиргааны хэрэг үүсгэснээс хэрэг хянан шийдвэрлэх хүртэлх үе шатанд нийт ажиллагааны 89.5% нь хийгджээ.

Эдгээрийн хамгийн их хугацаа зарцуулсан ажиллагаа нь Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 17 дугаар зүйлд заасан хэргийн оролцогчдод эрх, үүрэг тайлбарлах, мөн хуулийн 32 дугаар зүйлд зааснаар нотлох баримтыг эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас авах, нөлөөллийн мэдүүлэг танилцуулах, мөн хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-т зааснаар гуравдагч этгээдээр татан оролцуулах, албан бичиг явуулах, хариу авах зэрэг ажиллагаа байна.

Хавтаст хэргийн судалгааны дүнгээс үзвэл 128/2018/0106/з индексийн дугаартай хэргийн хувьд нийт 7 ажиллагаа бүртгэгдсэн байна. Үүнээс 5 ажиллагаа нь захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны баримт, түүнд холбогдсон ажиллагаа байгаа бөгөөд захиргааны хэрэг үүсгэснээс хэрэг хянан шийдвэрлэх хүртэлх үе шатанд нийт ажиллагааны 42% нь хийгджээ.

Эдгээрээс Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 57 дугаар зүйлд зааснаар нэхэмжлэлийг гардуулах, түүнтэй холбогдсон ажиллагаанд хамгийн их хугацаа зарцуулагдсан байна.

Татварын маргаантай холбогдсон хэрэг

Тендерт шалгаруулсан шийдвэрийг хүчингүй болгох, тендерийн үнэлгээг дахин явуулах, татварын улсын байцаагч нарын актыг илт хууль бус болохыг тогтоолгож, хүчингүй болгуулах агуулага бүхий нэхэмжлэлтэй, 128/2018/0184/з, 128/2018/0203/з, 128/2018/0575/з индексийн дугаартай хэргүүдийн хувьд:

Татварын ерөнхий 12 дугаар зүйлийн 12.1.6 дэх хэсэгт “татварын албанаас гаргасан татварын акт, бусад баримт бичигтэй танилцах, үндэслэлгүй буюу хуульд нийцээгүй гэж үзвэл уг шийдвэрийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор

захиргааны болон шүүхийн журмаар гомдол гаргах;" мөн хуулийн 12.1.9 дэх хэсэгт "татварын алба, татварын улсын байцаагчийн хууль бус ажиллагаа болон шийдвэрт холбогдох гомдлыг түүнийг шууд захирдаг болон дээд шатны албан тушаалтанд, түүнчлэн шүүхэд гаргах. Ийнхүү гомдол гаргасан нь ногдуулсан татвар, торгууль, алдангийг төлөхийг зогсоох үндэслэл болохгүй;" гэж тус тус заасны дагуу гомдол гаргах эрхээ эдлэж, анхан шатны шүүх Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1 дэх хэсэгт "Хуульд өөрөөр заагаагүй бол хэрэг үүсгэснээс хойш 60 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ.", мөн хуулийн 63 дугаар зүйлийн 63.3 дахь хэсэгт "Энэ хуулийн 63.1, 63.2-т заасан хугацааг шаардлагатай тохиолдолд тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс эхний удаа 30 хүртэл хоногоор, хоёр дахь удаагаа 15 хүртэл хоногоор сунгаж болно" гэж тус тус заасны дагуу хэргийг хянан шийдвэрлэсэн байна.

Эдгээр захиргааны хэргийг шүүхээр хянан шийдвэрлэхэд хамгийн их хугацаа зарцуулсан ажиллагаа нь дээр дурдсан төрийн албатай холбогдсон маргаан, газрын маргаантай нийтлэг буюу Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 17 дугаар зүйлд заасан хэргийн оролцогчдод эрх, үүрэг тайлбарлах, мөн хуулийн 32 дугаар зүйлд зааснаар нотлох баримтыг эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас авах, нөлөөллийн мэдүүлэг танилцуулах, мөн хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-т зааснаар гуравдагч этгээдээр татан оролцуулах, албан бичиг явуулах, хариу авах зэрэг ажиллагаа байна.

Дүгнэлт

Хавтаст хэргийн судалгаанаас үзвэл захиргааны хэргийн шүүх нь өөрийн онцлог чиг үүрэг болох мөрдөн шалгах зарчмын дагуу талуудаас нотлох баримт цуглуулах чиг үүргийн дагуу төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас нотлох баримтыг гаргуулан авах ажиллагааг гүйцэтгэж байгаа нь шүүгчийн ажиллагааны ачаалалд нөлөөлж байна. Үүнээс гадна зарим тохиолдолд нотлох баримтыг гаргаж өгөхгүй байх, нотлох баримт гаргуулах тухай олон удаа бичиг хүргүүлж байгаа нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удаашруулах, хугацаа хэтрүүлэх зэргээр шүүн таслах ажиллагаанд хүндрэл учруулж байна.

Дээрх болон бусад хүчин зүйлээс шалтгаалан захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэхэд хийгддэг ажиллагааны тоо эрүү, иргэний хэргийн шүүхтэй харьцуулахад илүү өндөр байгаа нь ажиглагдаж байна.

Тухайлбал хавтаст хэргийн судалгаанд "нийт 17,465 хуудас баримтын 47 хувь буюу 8,240 хуудас шүүхээс гаргасан эрхийн акт байсан бол үлдсэн 53 хувийг бусад баримт эзэлж байна", "шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой асуудлыг шийдвэрлэх захирамж гаргах, шүүх тогтоол гаргах, нотлох баримт шаардсан албан бичгийн дагуу цугларсан нотлох баримтад дүн шинжилгээ хийх, шүүх хуралдааныг даргалж, шийдвэр гаргах, шийдвэрээ боловсруулах зэрэг ажиллагаа нь шүүгчээс хамгийн их цаг хугацаа, оюун дүгнэлт шаардсан ажиллагаа гэж дүгнэж болох юм" гэжээ.

Энэ нь захиргааны хэргийн бас нэгэн онцлог шинж болох хэрэг маргааны ээдрээ төвөгтэй байдал, үүнтэй холбогдон цуглуулсан нотлох баримтад дүн шинжилгээ хийх, нягтлан шалгах ажиллагаанд ихээхэн хугацаа зарцуулж байгааг илэрхийлж байна.

Захиргааны хэргийг шүүхээр хянан шийдвэрлэх үе шат, түүний дундаас шүүгчийн ачаалал, хэрэг хянан шийдвэрлэх хугацаанд хамгийн их нөлөөлж буй ажиллагааг хуульчилсан байдлыг дурдвал Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт “Захиргааны хэргийн шүүх хэргийн нөхцөл байдлыг тодруулах, хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нотлох баримт цуглуулах, үнэлэх ажиллагааг хэрэгжүүлэх үүрэгтэй бөгөөд хэргийн оролцогчийг татан оролцуулна”, мөн хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсэгт “Хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нотлох баримтыг цуглуулах үүргийг захиргааны хэргийн шүүх гүйцэтгэнэ”, мөн хуулийн 80 дугаар зүйлийн 80.2 дахь хэсэгт “Нотлох баримт цуглуулах зайлшгүй шаардлагатай, эсхүл хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч хүндэтгэн үзэх шалтгаанаар шүүх хуралдаанд оролцох боломжгүй нь шүүх хуралдаанаас өмнө тогтоогдсон тохиолдолд уг нөхцөлийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхгүйгээр товлосон хуралдааныг 14 хүртэл хоногоор хойшлуулж болно.” гэж тус тус заасан.

Монгол Улсын Үндсэн Хуулийн нэгдүгээр зүйлийн 2-т “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “Хууль дээдлэх нь шүүхийн зохион байгуулалт, үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”, 6.2 дахь хэсэгт “Шүүхээр хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбогдсон харилцааг тухайлсан хуулиар зохицуулна” гэж тус тус заасан байна.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэхэд хийгдэж буй ажиллагааны зохицуулалт дээрх байдлаар хуульчлагдсан байх боловч эдгээр зохицуулалтын үйлчлэл болон бусад хүчин зүйлээс шалтгаалан ачаалал нэмэгдэж байгаа нь хавтаст хэргийн судалгаанаас харагдаж байгаагаар холбогдуулан дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

1. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрлэж буй хэргийн тоо бага байгаа боловч тухайн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хийгдэж буй ажиллагааны тоо их байгааг харгалзан үзэх нь зүйтэй. */График 3-ыг харна уу/*

2. Шүүх байгуулах эсэх тухай саналд захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны энэ онцлогийг харгалзан үзэх нь зүйтэй.

3. Хавтаст хэргийн судалгаанд хамруулсан маргааны төрлүүдээс Газар, Тендер, Татварын маргаантай хэргийг хянан шийдвэрлэхэд хамгийн олон тооны нотлох баримтыг гаргуулсан байгаа нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаанд нөлөөлсөн байна.

4. Шүүх хуралдаан олон удаа хойшилж байгаа нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа, шүүгчийн ажиллагааны ачаалалд нөлөөлж байна.

4.1.3. ИРГЭНИЙ ХЭРГИЙН ХАВТАСТ ХЭРЭГТ ХИЙСЭН БАРИМТ БИЧГИЙН СУДАЛГААНЫ ТАЙЛАНД ҮНДЭСЛЭСЭН ХУУЛЬ ЗҮЙН ДҮГНЭЛТ

НЭГ. БАГА ҮНИЙН ДҮНТЭЙ ИРГЭНИЙ ХЭРГИЙН ХАВТАСТ ХЭРЭГТ ХИЙСЭН БАРИМТ БИЧГИЙН СУДАЛГААНЫ ТАЙЛАНД ҮНДЭСЛЭСЭН ХУУЛЬ ЗҮЙН ДҮГНЭЛТ

1.1. Бага үнийн дүнтэй иргэний хэрэг 1. Удиртгалд 2004-2022 оны хооронд хяналтын шатны шүүхийн шийдвэрлэсэн 71 төрлийн нийт 7,706 хэргээс 10 сая хүртэлх нэхэмжлэлийн үнийн дүнтэй хэргийг бага үнийн дүнтэй гэж үзэж, нийт 6 хэргийг судалгааны түүврээр сонгож, дүн шинжилгээ хийлээ. Нийт 7706 хэргийн 65-аас дээш хувь нь 100-аас 500 хүртэлх хоногт шийдвэрлэгдсэн бол 30 орчим хувь нь 500-аас 1000 хүртэлх хоногт шийдвэрлэгдсэн байна. Харин 1000-аас дээш хоногт шийдвэрлэгдсэн хэрэг тун бага хувийг эзэлж байна” гэсэн судалгааны тайлан гарчээ.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1-т “Шүүгч энэ хуулийн 65.1-д заасан үндэслэл байхгүй гэж үзвэл нэхэмжлэлийг хүлээн авсан өдрөөс хойш **7 хоногийн** дотор хэрэг үүсгэх тухай захирамж гаргана, 71.1. Хуулиар өөр хугацаа тогтоогоогүй бол хэрэг үүсгэсэн өдрөөс хойш **60 хоног**, давж заалдах болон хяналтын шатны шүүхээс хэргийг дахин хэлэлцүүлэхээр ирүүлсэн бол шүүгч хэргийг хүлээж авснаас хойш 30 хоногийн дотор тус тус шийдвэрлэнэ. 71.2. Энэ хуулийн 71.1-д заасан хугацааг тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс нэг удаа **30 хүртэл хоногоор** сунгаж болно”, 166 дугаар зүйлийн 166.2-т “Давж заалдах гомдол гарсан хэргийг шүүх хүлээн авсан өдрөөс хойш **30 хоногт** багтаан хянан шийдвэрлэнэ”, 173.5. Хяналтын шатны шүүх гомдлыг хүлээн авснаас хойш **21 хоногийн** дотор танхимын нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцэж дөрөв, түүнээс дээш шүүгч хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх талаар санал гаргавал энэ тухай тогтоол гаргана. 174.1. Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх тогтоол гарснаас хойш **30 хоногийн** дотор хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэнэ” гэж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацааг шүүхийн шат бүрээр зохицуулжээ.

Тодруулбал: Анхан шатны шүүхэд 97 хоног, давж заалдах шатанд 30 хоног, хяналтын шатны шүүхэд хугацаа 30 хоног, хуралдаанаар хэлэлцэх эсэхийг шийдвэрлэхэд 21 хоногийн дотор шийдвэрлэхээр байна.

Дээрх хуулийн зохицуулалтаас 3 шатны шүүхээр хянагдсан нэг хэргийн хуулийн хугацаа 178 хоног гэж үзнэ. График 1-т үзүүлснээр хяналтын шатны шүүхийн шийдвэрлэсэн 7706 хэргийн 65-аас дээш хувь нь 100-500 хүртэлх хоногт шийдвэрлэгдсэн байгаа нь хуульд заасан хугацаандаа шийдвэрлэгдсэн гэж үзэхээр байна. Хуулийн хугацаанд шийдвэрлэгдэхгүй байх тусмаа шүүгчийн ажлын ачааллыг тодорхой хэмжээгээр нэмэгдүүлж байдаг.

Шийдвэрлэгдсэн хэргийн 30 орчим хувь нь 500-аас 1000 хүртэлх хоногт шийдвэрлэсэн байгаа үзүүлэлт нь иргэний хэргийн өөрийнх нь онцлогоос шалтгаалж байх магадлал өндөр юм. Учир нь зохигч Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1-т зааснаар “Зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч нь өөрийн шаардлага ба татгалзлын үндэс болж байгаа байдлын талаарх нотлох баримтаа өөрөө гаргаж өгөх, цуглуулах

үүрэгтэй” байдаг. Нотлох баримт гаргаж өгөх хуулийн хугацааны талаар зохицуулалт байхгүйтэй холбоотой хэргийн хугацаа сунжирдаг. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.1-т “хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдолтой нотлох баримт хангалттай бүрдсэн гэж шүүгч үзсэн, эсхүл энэ хуулийн 71.1-д заасан хугацаа дууссан” бол хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээр захирамж гаргадаг. Өөрөөр хэлбэл зохигч хэзээ нотлох баримтаа авчирч өгнө, тэдний гаргаж, бүрдүүлж өгсний дараа л хэрэг шийдэгдэнэ.

Мөн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-т “Хэргийн оролцогч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад дараах эрх эдэлнэ: 25 дугаар зүйлийн 25.1.3-т “... шүүх хуралдааныг хуульд заасан үндэслэлээр хойшлуулах тухай хүсэлт гаргах” хэмээн шүүх хуралдааныг хойшлуулах хязгааргүй эрхийг хуулиар олгосонтой холбоотой байж болох юм. Иймд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгад шүүх хуралдаан хойшлуулах зохигчийн эрхийг хязгаарласан заалт оруулж өгөх нь зүйтэй гэж үзэж байна.

Судалгааны тайланд 4 төрлийн 6 хэргийг сонгон авч, дүн шинжилгээг хэрэг тус бүрээр Хүснэгт 3-6-д байгаа 3 үзүүлэлтээр гаргажээ.

Хүснэгт 1.Хавтаст хэргийн талаарх ерөнхий мэдээлэлд “сонгон авсан 6 хэргийн индекс, зохигчийн тоо, хавтаст хэргийн тоо, хуудасны тоог” харуулжээ.

Хүснэгт 2.Нэхэмжлэлийн товч утгад “сонгон авсан 6 хэргийн индекс, нэхэмжлэлийн товч утга, нэхэмжилсэн үнийн дүн” зэрэг ерөнхий мэдээллүүдийг тусгасан байх тул хүснэгт 1, 2-т дүгнэлт хийх шаардлагагүй болно.

1.2.Хүснэгт 3.Хавтаст хэрэгт авагдсан баримтын тайлбарт “Дээрх 6 хэргийн хавтаст хэрэг дотор эзэлж буй баримтыг дотор нь нарийвчлан авч үзвэл шүүхээс гаргасан эрхийн акт дийлэнх хувийг эзэлж байсан бөгөөд үлдсэн хувийг хэргийн оролцогчдоос гаргасан баримт материал түүний дотор нотлох баримтын шинжтэй баримт материал цөөн хувьтай байсан нь онцлог байв” гэж судалгааны тайланд дурджээ.

Өөрөөр хэлбэл 6 хэргийн 528 хуудасны 176 хуудас буюу 33 хувь нь шүүхээс гарч буй эрхийн акт, 99 хуудас буюу 19 хувь нь баримт буюу шүүхээс хэргийн оролцогчдод эрх, үүрэг тайлбарласан, хэрэг танилцуулсан, мэдэгдэх хуудас, нэхэмжлэлийн хувь гардуулсан гэх мэт баримт байна. Шүүхээс гаргасан эрхийн акт, баримтын нийлбэр нь 275 хуудас буюу **52 хувь нь** шүүхээс гарч буй эрхийн акт, үлдсэн 252 хуудас буюу **48 хувь нь** зохигчийн нэхэмжлэл, тайлбар, нотлох баримт байна гэсэн үзүүлэлт гарчээ. 6 хэргийн 528 хуудсанд 237 ажиллагаа хийгдсэн байх ба 1367 хоногийг зарцуулжээ.

Дээрх тоон үзүүлэлтийн хуулийн үндэслэлийг гаргах гэж оролдвол:

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.1-т “Хэрэг хянан шийдвэрлэж энэ хуулийн 115, 116 дугаар зүйлд зааснаар шийдвэр гаргаснаас бусад тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулах, хэргийг хэрэгсэхгүй болгохтой холбогдуулан шүүх тогтоол, шүүгч захирамж гаргана” гэж заасантай холбоотойгоор зохигчийн гаргасан хүсэлт бүрийг шүүх эрхийн акт гаргаж шийдвэрлэдэгтэй холбоотой байж болох юм.

Шүүхээс гарч буй эрхийн актууд хамгийн их буюу ажиллагааны дийлэнх хувийг эзэлсэн байна. Түүнээс дутахааргүй баримт гэх шүүхээс хэргийн оролцогчдод эрх, үүрэг тайлбарласан, хэрэг танилцуулсан, мэдэгдэх хуудас, нэхэмжлэлийн хувь гардуулсан гэх бусад баримтууд дараагийн байрыг эзэлжээ. Шүүхээс гарах эрхийн акт, баримт их байх тусмаа шүүхийн ачааллыг их гэж харуулж байна. Эндээс шүүх, шүүгч, шүүгчийн туслахын ажлын ачаалал харагдана. Эрхийн акт их гаргах тусам ажлын ачаалал тодорхой хэмжээгээр нэмэгддэг.

Нотлох баримтын хувьд 6 хэргийн 528 хуудасны 25 хуудас буюу 5 хувь нь нэхэмжлэл, тайлбар, гомдол, хүсэлт байна. Харин 79 хуудас буюу 15 хувийг зохигчид өөрсдөө бүрдүүлж өгсөн бол 149 хуудас буюу 28 хувийг шүүгч захирамж гарган бүрдүүлж байгаа нь шүүх, шүүгчийн ажлын ачааллыг нэмэгдүүлж байна гэж харагдахаар байна. /ИХШХШТХ-ийн 38 дугаар зүйлийн 38.3, 38.9/

1.3.Хүснэгт 4.Хийгдсэн ажиллагаанд “Судалгаанд хамруулсан 6 хэргийн индекс, анхан, давах, хяналтын шатанд хийгдсэн ажиллагаа тус бүрийг тоон үзүүлэлтээр гаргаж, хэрэгт бүртгэгдсэн нийт ажиллагааны 80 орчим хувийг анхан шатны шүүх хийж гүйцэтгэсэн бол үлдэх хувийг давах болон хяналтын шатны шүүхэд хийгдсэн ажиллагаанууд тус тус эзэлж байна” гэж дүгнэжээ.

Дээрх үзүүлэлтээс харахад 6 хэрэгт нийт 237 ажиллагаа бүртгэгдсэн байх бөгөөд анхан шатанд 193 буюу 79 хувь, давах шатанд 28 буюу 12 хувь, хяналтын шатанд 22 буюу 9 хувийн ажиллагаа хийгджээ.

Анхан шатны шүүх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 6-11 дүгээр бүлэг “Нэхэмжлэл гаргах, түүнийг хүлээн авах”-аас эхлээд “Шийдвэр, түүнийг гаргах” хүртэл нийт 6 бүлэг буюу 61-124 дүгээр зүйл хүртэлх хуульд заасан ажиллагааг хийж гүйцэтгэдэгтэй холбоотой юм.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 161 дүгээр зүйлийн 161.4-т “Энэ хуулийн 161.1-д заасан этгээд давж заалдах гомдлын үндэслэлд анхан шатны шүүхээр хэлэлцэгдээгүй шинэ нотлох баримтыг заах эрхгүй” гэж заасантай холбоотойгоор зохигч анхан шатны шүүхэд бүхий л нотлох баримтыг гаргаж, цуглуулж өгөх үүрэгтэй. Уг хуулийн заалтаар зохигч давж заалдах болон хяналтын шатны шүүхэд нотлох баримт гаргахгүй учраас давж заалдах болон хяналтын шатны шүүхэд хийгдэж байгаа ажиллагаа бага үзүүлэлттэй гарсан байна.

Судалгаанд хамруулсан 6 хэргийн 2 хэрэг анхан шатны шүүхээр, 1 хэрэг нь давж заалдах шатны шүүхээр, 3 хэрэг нь буюу 50 хувь нь хяналтын шатны шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн байна. Эндээс шүүхэд итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх шаардлагатай гэж дүгнэж болохоор байна.

1.4.Хүснэгт 5.Хэрэг хянан шийдвэрлэсэн хугацаанд “6 хэргийг анхан, давах, хяналтын шатны шүүх хэд хоногийн дотор шийдвэрлэснийг тоон үзүүлэлтээр гаргажээ.”

Үзүүлэлтээс харахад 6 хэргийг анхан шатны шүүх 687 хоногт буюу 50 хувь, давж заалдах шатны шүүх 207 хоног буюу 15 хувь, хяналтын шатны шүүх 473 буюу 35 хувь, нийт 1367 хоногт шийдвэрлэжээ. Хуульд заасан хугацаанд шийдвэрлэсэн эсэхийг тооцож үзье.

Анхан шатны шүүхийн хувьд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1-т “Шүүгч энэ хуулийн 65.1-д заасан үндэслэл байхгүй гэж үзвэл нэхэмжлэлийг хүлээн авсан өдрөөс хойш **7 хоногийн** дотор хэрэг үүсгэх тухай захирамж гаргана, 71.1.Хуулиар өөр хугацаа тогтоогоогүй бол хэрэг үүсгэсэн өдрөөс хойш **60 хоног**, давж заалдах болон хяналтын шатны шүүхээс хэргийг дахин хэлэлцүүлэхээр ирүүлсэн бол шүүгч хэргийг хүлээж авснаас хойш 30 хоногийн дотор тус тус шийдвэрлэнэ. 71.2.Энэ хуулийн 71.1-д заасан хугацааг тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс нэг удаа **30 хүртэл хоногоор** сунгаж болно” гэж заасны дагуу нийт нэг хэргийг 97 хоногийн дотор шийдвэрлэх хуулийн хугацаатай. 6 хэргээ 97 хоногоор үржүүлбэл 582 хоногт шийдвэрлэх тооцоолол гарч байна. Хүснэгтээс харахад 6 хэргийг 582 хоногт шийдвэрлэх ёстой гэж үзвэл 687 хоногт шийдвэрлэж, 105 хоногоор хуулийн хугацаа хэтэрчээ.

Давж заалдах шатны шүүхийн хувьд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 166 дугаар зүйлийн 166.2-т “Давж заалдах гомдол гарсан хэргийг шүүх хүлээн авсан өдрөөс хойш **30 хоногт** багтаан хянан шийдвэрлэнэ” гэж заасны дагуу нэг хэргийг 30 хоногийн хугацаанд шийдвэрлэх хуультай байна. Хүснэгтээс үзэхэд 6 хэрэг 30 хоногт шийдвэрлэнэ гэж үзвэл 180 хоног байхаар байна. Гэтэл тайланд 207 гэж тусгагдсан байгаагаас харахад мөн л 27 хоног хэтэрчээ.

Харин хяналтын шатны шүүхийн хувьд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 173 дугаар зүйлийн 173.5-т зааснаар “Хяналтын шатны шүүх гомдлыг хүлээн авснаас хойш **21 хоногийн** дотор танхимын нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцэж дөрөв, түүнээс дээш шүүгч хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх талаар санал гаргавал энэ тухай тогтоол гаргана”, 174 дүгээр зүйлийн 174.1-т “Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх тогтоол гарснаас хойш **30 хоногийн** дотор хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэнэ” гэж тус тус заажээ. Хяналтын шатны шүүх 51 хоногийн дотор шийдвэрлэх ёстой гэж үзвэл 51х6 гэхээр 306 хоног шийдвэрлэх тооцоолол гарч байна. Судалгааны тайланд 473 хоногт шийдвэрлэсэн бол 167 хоног хэтрүүлсэн гэж үзэхээр байна.

Судалгааны тайлангаас 3 шатны шүүхийн хувьд хэргийг хуулийн хугацаандаа шийдвэрлэдэггүй болох нь харагдаж байна. Энэ нь давж заалдах болон хяналтын шатны шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийн хугацаа бага, хугацааг сунгах эрх зүйн зохицуулалт байхгүй байгаатай холбоотой гэж үзэж байна. Иймд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгад давж заалдах болон хяналтын шатны шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацааг хэрхэн сунгах талаар зохицуулалт нэмж оруулах нь зүйтэй байна.

1.5.Хүснэгт 6.Шүүн таслах ажиллагааны үе шат (үүнийг иргэний хэргийн хувьд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе хэмээн нэрлэдэг тул цаашид “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шат” гэх)-нд хийгдсэн ажиллагааны төрөл, үе шат бүрд хийгдсэн ажиллагааны тоо, ажиллагааг хийж гүйцэтгэхэд зарцуулсан нийт хугацааг үзүүлжээ.

Тодруулбал: Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны 1-р үе шат “Иргэний хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэх шат”-нд 6 хэрэгт 17 ажиллагааг 55 хоногийн туршид, 2-р үе шат “Хэрэг үүсгэснээс хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх шийдвэр гаргах хүртэлх хугацааны ажиллагаа”-нд 86 ажиллагааг 317 хоногийн туршид, 3-р үе шат “Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шат”-нд 83

ажиллагааг 518 хоногт, 4-р үе шат “Хэргийг эцэслэн шийдвэрлэсний дараах ажиллагаа”-нд 51 ажиллагааг 477 хоногт, нийт 237 ажиллагааг хийж гүйцэтгэхэд 1367 хоног зарцуулжээ.

Дээрх үзүүлэлтээс харвал хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны 2, 3-р үе шатанд буюу хэрэг үүсгэснээс хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх шийдвэр гаргах хүртэлх хугацааны ажиллагаа, хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шатуудад хамгийн их буюу 169 ажиллагааг хийж гүйцэтгэхэд 1004 хоног зарцуулсан байна. Нийт 1367 хоногийн 1004 хоног нь дээрх 2 үе шатыг эзэлж байна. Харин 4-р үе шат буюу “Хэргийг эцэслэн шийдвэрлэсний дараах ажиллагаа”-нд 51 ажиллагааг 477 хоног зарцуулсан байгаа нь хамгийн олон хоног зарцуулжээ.

1.6. Судалгааны тайланд хамруулсан хэрэг тус бүрээр бүртгэгдсэн ажиллагаа болон зарцуулсан хоногийг дэлгэрүүлье.

1.Барааны үлдэгдэл төлбөр 1396957 төгрөг гаруулах хэргийн тухайд: Уг хэрэг нь зөвхөн анхан шатны шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн, 1 хавтас 56 хуудастай, 33 ажиллагааг шүүхээс хийж гүйцэтгэсэн байх ба 115 хоног зарцуулагджээ.

2.Байрны түрээсийн төлбөр болох 4200000 төгрөг гаруулах хэргийн тухайд: Уг хэрэг нь зөвхөн анхан шатны шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн, 1 хавтас 20 хуудастай, 14 ажиллагааг шүүхээс хийж гүйцэтгэсэн байх ба 104 хоног зарцуулагджээ.

3.Цалингийн зөрүү гаргуулах хэргийн тухайд: Уг хэрэг нь давж заалдах шатны шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн, 1 хавтас 168 хуудастай, 50 ажиллагааг шүүхээс хийж гүйцэтгэсэн байх ба 188 хоног зарцуулагджээ.

4.Банкнаас зээлийн гэрээний үүргийн биелэлт шаардсан хэргийн тухайд: Уг хэрэг нь хяналтын шатны шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн, 1 хавтас 66 хуудастай, 37 ажиллагааг шүүхээс хийж гүйцэтгэсэн байх ба 289 хоног зарцуулагджээ.

Хугацааны хувьд анхан шатанд 85 хоног 29 хувь, давж заалдах шатанд 45 хоног буюу 16 хувь, хяналтын шатанд 159 хоног буюу 55 хувийг зарцуулжээ.

5.Түрээсийн гэрээний үүргийн биелэлт шаардсан хэргийн тухайд: Уг хэрэг нь хяналтын шатны шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн, 1 хавтас 124 хуудастай, 47 ажиллагааг шүүхээс хийж гүйцэтгэсэн байх ба 363 хоног зарцуулагджээ. Хугацааны хувьд анхан шатанд 146 хоног, давж заалдах шатанд 50 хоног, хяналтын шатанд 167 хоног зарцуулжээ.

6.Банкнаас зээлийн гэрээний үүргийн биелэлт шаардсан хэргийн тухайд: Уг хэрэг нь хяналтын шатны шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн, 1 хавтас 94 хуудастай, 56 ажиллагааг шүүхээс хийж гүйцэтгэсэн байх ба 308 хоног зарцуулагджээ.

Хугацааны хувьд анхан шатанд 112 хоног, давж заалдах шатанд 49 хоног, хяналтын шатанд 147 хоног зарцуулжээ.

Сүүлийн 4-6 дугаарт дугаарлагдсан 3 хэрэг нь 3-уулаа хяналтын шатны шүүхээр хянагдсан хэрэг байх бөгөөд зөвхөн хяналтын шатны шүүхэд 100-ээс дээш хоногийг зарцуулсан нь хяналтын шатны шүүх нэг хэсэг хугацаанд хэрэг

шийдвэрлэх бүрэлдэхүүний асуудалтай байсан цаг хугацаатай холбоотой байж болох юм.

ХОЁР.ХЯЛБАРШУУЛСАН ЖУРМААР ШИЙДВЭРЛЭСЭН ИРГЭНИЙ ХЭРГИЙН ХАВТАСТ ХЭРЭГТ ХИЙСЭН БАРИМТ БИЧГИЙН СУДАЛГААНЫ ТАЙЛАНД ҮНДЭСЛЭСЭН ХУУЛЬ ЗҮЙН ДҮГНЭЛТ

2.1.2004-2022 оны хооронд хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн 71 төрлийн нийт 7,706 хэргийн 65,7 хувийг эзэлж буй нь 100-аас 500 хүртэлх хоногт шийдвэрлэгдсэн хэргүүдээс 4 төрлийн 16 хэргийг судалж түүвэр хийжээ.

График 1.Хэрэг хянан шийдвэрлэсэн хугацааны хувьд: Судалгааны тайланд 7706 хэргийн 65,7 хувь нь 100-499 хоногийн дотор буюу хуульд заасан хугацаандаа шийдвэрлэгдсэн бол 30,2 хувь нь 500-999 хоног буюу хуулийн хугацаа хэтэрч шийдвэрлэгджээ. /Хугацааны хувьд бага үнийн дүнтэй хэрэгт өгсөн дүгнэлттэй адилхан/

Судалгааны тайланд 4 төрлийн 16 хэргийг сонгон авч, дүн шинжилгээг хэрэг тус бүрээр Хүснэгт 3-7-д заасан үзүүлэлтээр гаргасан байна.

Хүснэгт 1.Хавтаст хэргийн талаарх ерөнхий мэдээлэлд “сонгон авсан 16 хэргийн индекс, зохигчийн тоо, хавтаст хэргийн тоо, хуудасны тоог” харуулжээ.

Хүснэгт 2.Нэхэмжлэлийн товч утгад “сонгон авсан 16 хэргийн индекс, нэхэмжлэлийн товч утга, нэхэмжилсэн үнийн дүн” зэрэг ерөнхий мэдээллүүдийг тусгасан байх тул хүснэгт 1, 2-т дүгнэлт хийх шаардлагагүй болно.

2.2.Хүснэгт 3.Хавтаст хэрэг доторх баримтын задаргааг дүгнэж “Хялбаршуулсан журмаар шийдвэрлэгдсэн хэргийн хавтас хэрэгт шүүхээс гаргасан эрхийн актууд дийлэнх хувийг эзэлж байсан бөгөөд үлдсэн цөөн хувийг хэргийн оролцогчдоос гаргасан нотлох баримт болон бусад баримт бичгүүд эзэлж байна. Эдгээр төрлийн хэргийн хавтаст хэрэгт бүртгэгдсэн ажиллагаа нь цөөн тоотой байгаа нь бусад төрлийн хэргээс нь онцлог байв” гэжээ.

Судалгааны тайлангаас харахад 16 хэргийн 631 хуудасны 339 хуудас буюу **53,7 хувь** нь шүүхээс гарч буй эрхийн акт, 147 хуудас буюу **23,3 хувь** нь шүүхийн баримт байна. Шүүхээс гаргасан эрхийн акт, баримтын нийлбэр 486 хуудас буюу **77 хувь** нь шүүхээс гарч буй эрхийн акт, үлдсэн 145 хуудас буюу **23 хувь** нь нэхэмжлэл, тайлбар, нотлох баримт байна гэсэн үзүүлэлт гарчээ.

16 хэргийн 631 хуудсанд 338 ажиллагаа хийгдсэн байх ба 1703 хоногийг зарцуулжээ.

Нотлох баримтын хувьд 16 хэргийн 631 хуудасны 69 хуудас буюу 10,9 хувь нь шүүхээр гаргуулсан нотлох баримт, 76 хуудас буюу 12 хувь нь зохигчид өөрсдөө бүрдүүлж өгсөн нотлох баримт байгаа учраас шүүхээс гарч буй эрхийн акт өндөр үзүүлэлттэй байгаа нь бага үнийн дүнтэй хэрэгт өгсөн дүгнэлттэй адилхан.

Судалгааны тайланд бүртгэгдсэн ажиллагаа цөөн байгаа нь бусад хэргийнхээс онцлог гэж онцолжээ. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.1-т “Хэрэг үүсгэснээс хойш шүүх хуралдаан хүртэлх хугацаанд нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсан, хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөн, эсхүл зохигч эвлэрсэн, нэхэмжлэлийн шаардлагыг хариуцагч биелүүлсэн бол хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэнэ” гэж заасан. Хуульд заасан эдгээр нөхцөлд хялбаршуулсан журмаар шийдвэрлэж байгаа учир цөөн төрлийн ажиллагаа хийгддэгтэй холбоотой.

2.3.Хүснэгт 4.Хийгдсэн ажиллагаанд “Судалгаанд хамруулсан 16 хэргийг анхан, давах, хяналтын шатанд хянагдсан үзүүлэлтийг гаргасан байна. Иргэний хуулиар хялбаршуулсан журмаар шийдвэрлэгдсэн хэргийн 95 хувь нь анхан шатны шүүх дээр, 2 хувь нь давах, 3 хувь нь хяналтын шатанд шийдвэрлэгдсэн байна. Харин Гэр бүл, Хөдөлмөрийн хуулиар шийдвэрлэгдсэн хэргүүд анхан шатандаа хялбаршуулсан журмаар шийдвэрлэгдсэн байна.

2.4.Хүснэгт 5.”Иргэний хуулиар шийдвэрлэгдсэн хэрэгт хийгдсэн нийт ажиллагаа”-нд 18 төрлийн 240 ажиллагааг хийж гүйцэтгэхэд 1391 хоног зарцуулсан байна. Үүнийг задалбал: хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны 1-р үе шат “Иргэний хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэх шат”-нд 10 хэрэгт 33 ажиллагааг 91 хоног, 2-р үе шат “Хэрэг үүсгэснээс хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх шийдвэр гаргах хүртэлх хугацааны ажиллагаа”-нд 105 ажиллагааг 317 хоног, 3-р үе шат “Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шат”-нд 55 ажиллагааг 230 хоног, 4-р үе шат “Хэргийг эцэслэн шийдвэрлэсний дараах ажиллагаа”-нд 47 ажиллагааг 753 хоног зарцуулжээ.

Дээрх үзүүлэлтээс харвал хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны 2, 3-р үе шатанд буюу хэрэг үүсгэснээс хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх шийдвэр гаргах хүртэлх хугацааны ажиллагаа, хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шатуудад хамгийн их буюу 160 ажиллагааг хийж гүйцэтгэхэд 547 хоног зарцуулсан байна. 240 ажиллагааны 160 ажиллагаа нь 2, 3-р шатанд хийгддэг хамгийн их ажиллагаа хийгддэг үе шат гэж тодорхойлж болох юм. Мөн бага үнийн дүнтэй хэрэг дээр ажиглагдсантай адилхан 4-р үе шат буюу “Хэргийг эцэслэн шийдвэрлэсний дараах ажиллагаа”-нд 47 ажиллагааг хийж гүйцэтгэхэд 753 хоног зарцуулсан байна. 47 ажиллагаа нь 2, 3-р шатанд хийгдсэн ажиллагаанаас хэдий бага боловч зарцуулсан хоног нь хамгийн их байна. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эхний 1-3 үе шатны нийлбэр хоног 638 хоног байхад түүнээс ч илүү буюу 753 хоног зарцуулж байгаа нь 4-р үе шат хамгийн их хугацааг эзэлж байна.

Хүснэгт 6.”Гэр бүлийн хуулиар шийдвэрлэгдсэн хэрэгт хийгдсэн нийт ажиллагаа”-нд 7 төрлийн 32 ажиллагааг хийж гүйцэтгэхэд нийт 134 хоног зарцуулсан байна. Үүнийг задалбал хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны 1-р үе шат “Иргэний хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэх шат”-нд 5 ажиллагааг 7 хоног, 2-р үе шат “Хэрэг үүсгэснээс хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх шийдвэр гаргах хүртэлх хугацааны ажиллагаа”-нд 20 ажиллагааг 67 хоног, 3-р үе шат “Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шат”-нд 5 ажиллагааг 36 хоног, 4-р үе шат “Хэргийг эцэслэн шийдвэрлэсний дараах ажиллагаа”-нд 2 ажиллагааг 24 хоног, нийт 32 ажиллагааг хийж гүйцэтгэхэд 134 хоног зарцуулжээ.

Дээрх үзүүлэлтээс харвал хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны 2, 3-р үе шатанд буюу хэрэг үүсгэснээс хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх шийдвэр гаргах хүртэлх хугацааны ажиллагаа, хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шатуудад хамгийн их буюу 25 ажиллагааг хийж гүйцэтгэхэд 103 хоног зарцуулсан байна. Гэр бүлийн хэрэг дээр нийт 134 хоногоос 103 хоног нь 2, 3-р үе шатанд зарцуулсан нь хамгийн их хугацаа шаардсан үеүд байна.

Хүснэгт 7."Хөдөлмөрийн хуулиар шийдвэрлэгдсэн хэрэгт хийгдсэн нийт ажиллагаа"-нд 10 төрлийн 57 ажиллагааг хийж гүйцэтгэхэд 178 хоног зарцуулсан байна. Үүнийг задалбал хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны 1-р үе шат "Иргэний хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэх шат"-нд 6 ажиллагааг 30 хоног, 2-р үе шат "Хэрэг үүсгэснээс хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх шийдвэр гаргах хүртэлх хугацааны ажиллагаа"-нд 29 ажиллагааг 81 хоног, 3-р үе шат "Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шат"-нд 17 ажиллагааг 18 хоног, 4-р үе шат "Хэргийг эцэслэн шийдвэрлэсний дараах ажиллагаа"-нд 5 ажиллагааг 49 хоног зарцуулжээ.

Дээрх үзүүлэлтээс харвал хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны 2, 3-р үе шатанд буюу хэрэг үүсгэснээс хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх шийдвэр гаргах хүртэлх хугацааны ажиллагаа, хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шатуудад хамгийн их буюу 46 ажиллагааг хийж гүйцэтгэхэд 99 хоног зарцуулсан байна. Хөдөлмөрийн хуулиар шийдвэрлэсэн хэрэг дээр нийт 178 хоногоос 99 хоног нь 2, 3-р үе шатанд зарцуулсан хугацаа хамгийн их байна.

Хүснэгт 4-7 буюу Иргэн, Гэр бүл, Хөдөлмөрийн хуулиудаар шийдвэрлэсэн хэрэгт хийгдсэн ажиллагааны төрлийг харьцуулж харвал Иргэний хуулиар шийдвэрлэгдсэн хэрэгт 18 төрлийн, Гэр бүлийн хуулиар 7 төрлийн, Хөдөлмөрийн хуулиар 10 төрлийн ажиллагаа хийгджээ. Үүнээс Иргэний хуулиар шийдвэрлэгдсэн хэрэгт хийгдсэн ажиллагаа хамгийн их байна. Харин Гэр бүл, Хөдөлмөрийн хуулиар шийдвэрлэгдсэн хэргийн ажиллагааны төрөл Иргэний хуулиар шийдвэрлэгдсэн хэргийнхээс арай цөөн байна. Энэ нь маргааны өөрийнх нь онцлогтой холбоотой байж болох юм.

2.5.Судалгааны тайланд хамруулсан хэрэг тус бүрээр бүртгэгдсэн ажиллагаа болон зарцуулсан хоногийг дэлгэрүүлэе.

Иргэний хэрэг:

1. 10,000,000 төгрөг гаруулах хэргийн тухайд: Уг хэрэг нь анхан, давах, хяналтын шатны шүүхээр хянагдаж, хяналтын шатны шүүхэд хялбаршуулсан журмаар шийдвэрлэгдсэн, 1 хавтас 156 хуудастай, шүүхээс 82 ажиллагааг хийж гүйцэтгэсэн байх ба 399 хоног зарцуулагджээ.

Уг хэрэг хяналтын шатны шүүх хүртэл хянагдаж хялбаршуулсан журмаар шийдвэрлэгдсэн байх бөгөөд хамгийн олон ажиллагаа хийгдсэн, хамгийн олон хоног зарцуулсан хэрэг байна.

2.Засвар үйлчилгээний хөлс болох 162,500 төгрөг гаргуулах хэргийн тухайд: Уг хэрэг нь зөвхөн анхан шатны шүүхэд хялбаршуулсанаар шийдвэрлэгдсэн, 1 хавтас 22 хуудастай, шүүхээс 15 ажиллагааг хийж гүйцэтгэсэн байх ба 102 хоног зарцуулагджээ.

3. Хууль бус эзэмшлээс чөлөөлүүлэх хэргийн тухайд: Уг хэрэг нь анхан шатны шүүхэд хялбаршуулсан журмаар шийдвэрлэгдсэн, 1 хавтас 41 хуудастай, шүүхээс 25 ажиллагааг хийж гүйцэтгэсэн байх ба 93 хоног зарцуулагджээ.

4. Үйлчилгээний зардал гаргуулах хэргийн тухайд: Уг хэрэг нь анхан шатны шүүхэд хялбаршуулсан журмаар шийдвэрлэгдсэн, 1 хавтас 22 хуудастай, шүүхээс 14 ажиллагааг хийж гүйцэтгэсэн байх ба 257 хоног зарцуулагджээ.

5. Зээлийн гэрээний үүргийн биелэлт шаардсан хэргийн тухайд: Уг хэрэг нь анхан шатны шүүхэд хялбаршуулсан журмаар шийдвэрлэгдсэн, 1 хавтас 31 хуудастай, шүүхээс 14 ажиллагааг хийж гүйцэтгэсэн байх ба 75 хоног зарцуулагджээ.

6. Төлбөр гаргуулах хэргийн тухайд: Уг хэрэг нь анхан шатны шүүхэд хялбаршуулсан журмаар шийдвэрлэгдсэн, 1 хавтас 19 хуудастай, шүүхээс 13 ажиллагааг хийж гүйцэтгэсэн байх ба 21 хоног зарцуулагджээ.

7. Зээлийн гэрээний үүргийн биелэлтэд 5700000 төгрөг гаргуулах хэргийн тухайд: Уг хэрэг нь анхан шатны шүүхэд хялбаршуулсан журмаар шийдвэрлэгдсэн, 1 хавтас 25 хуудастай, шүүхээс 15 ажиллагааг хийж гүйцэтгэсэн байх ба 77 хоног зарцуулагджээ.

8. Худалдах худалдан авах гэрээний үүргийн биелэлтэд 1,000,000 төгрөг гаргуулах хэргийн тухайд: Уг хэрэг нь анхан шатны шүүхэд хялбаршуулсан журмаар шийдвэрлэгдсэн, 1 хавтас 18 хуудастай, шүүхээс 13 ажиллагааг хийж гүйцэтгэсэн байх ба 29 хоног зарцуулагджээ.

Уг хэргийн хувьд шүүхээс гаргасан эрхийн акт 5 буюу 27,8 хувь хамгийн бага үзүүлэлттэй байна.

9. Үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ гаргуулах хэргийн тухайд: Уг хэрэг нь анхан шатны шүүхэд хялбаршуулсан журмаар шийдвэрлэгдсэн, 1 хавтас 27 хуудастай, шүүхээс 16 ажиллагааг хийж гүйцэтгэсэн байх ба 48 хоног зарцуулагджээ.

10. Засвар үйлчилгээний төлбөр 271,300 төгрөг гаргуулах хэргийн тухайд: Уг хэрэг нь анхан шатны шүүхэд хялбаршуулсан журмаар шийдвэрлэгдсэн, 1 хавтас 23 хуудастай, шүүхээс 12 ажиллагааг хийж гүйцэтгэсэн байх ба 60 хоног зарцуулагджээ.

11. Зээлийн гэрээний үүргийн биелэлт шаардсан хэргийн тухайд: Уг хэрэг нь анхан шатны шүүхэд хялбаршуулсан журмаар шийдвэрлэгдсэн, 1 хавтас 24 хуудастай, шүүхээс 12 ажиллагааг хийж гүйцэтгэсэн байх ба 138 хоног зарцуулагджээ.

12. Төлбөр гаргуулах хэргийн тухайд: Уг хэрэг нь анхан шатны шүүхэд хялбаршуулсан журмаар шийдвэрлэгдсэн, 1 хавтас 37 хуудастай, шүүхээс 17 ажиллагааг хийж гүйцэтгэсэн байх ба 92 хоног зарцуулагджээ.

Гэр бүлийн хуулиар шийдвэрлэсэн хэрэг:

13.Гэрлэлт цуцлуулах хэргийн тухайд: Уг хэрэг нь анхан шатны шүүхэд хялбаршуулсан журмаар шийдвэрлэгдсэн, 1 хавтас 58 хуудастай, шүүхээс 20 ажиллагааг хийж гүйцэтгэсэн байх ба 88 хоног зарцуулагджээ.

14.Хүүхдийн асрамж тогтоолох, тэтгэлэг гаргуулах хэргийн тухайд: Уг хэрэг нь анхан шатны шүүхэд хялбаршуулсан журмаар шийдвэрлэгдсэн, 1 хавтас 27 хуудастай, шүүхээс 12 ажиллагааг хийж гүйцэтгэсэн байх ба 46 хоног зарцуулагджээ.

Хөдөлмөрийн хуулиар шийдвэрлэсэн хэрэг:

15.Ажлаас үндэслэлгүй халагдсан болохыг тогтоолох хэргийн тухайд: Уг хэрэг нь анхан шатны шүүхэд хялбаршуулсан журмаар шийдвэрлэгдсэн, 1 хавтас 65 хуудастай, шүүхээс 34 ажиллагааг хийж гүйцэтгэсэн байх ба 85 хоног зарцуулагджээ.

16.Ажилд эргүүлэн тогтоолох, ажилгүй байсан хугацааны цалин 1,099,835 төгрөг гаргуулах хэргийн тухайд: Уг хэрэг нь анхан шатны шүүхэд хялбаршуулсан журмаар шийдвэрлэгдсэн, 1 хавтас 36 хуудастай, шүүхээс 24 ажиллагааг хийж гүйцэтгэсэн байх ба 93 хоног зарцуулагджээ.

Хялбаршуулсан журмаар шийдвэрлэгдсэн хэргээс харахад 16 хэргийн зөвхөн 2 хэрэг нь зохигчид хоорондоо эвлэрсэн, үлдэгдэл 14 нь хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөн, биелүүлсэн, нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсан хэргүүд байна.

ГУРАВ.ЕРДИЙН ЖУРМААР ШИЙДВЭРЛЭСЭН ИРГЭНИЙ ХЭРГИЙН ХАВТАСТ ХЭРЭГТ ХИЙСЭН БАРИМТ БИЧГИЙН СУДАЛГААНЫ ТАЙЛАНД ҮНДЭСЛЭСЭН ХУУЛЬ ЗҮЙН ДҮГНЭЛТ

3.1.Судалгааны тайланд гэр бүл, иргэн, хөдөлмөр, шүүхийн шийдвэр гүйцэтгэл, цагаатгалын нөхөн олговор гэх мэт 5 төрлийн 31 хэргийн 55 хавтас, 9967 хуудас бүхий баримт бичигт дүн шинжилгээ хийжээ.

Хүснэгт 1.Хавтаст хэргийн талаарх ерөнхий мэдээлэлд “сонгон авсан 31 хэргийн индекс, зохигчийн тоо, хавтаст хэргийн тоо, хуудасны тоог” харуулжээ.

Хүснэгт 2.Нэхэмжлэлийн товч утгад “сонгон авсан 31 хэргийн индекс, нэхэмжлэлийн товч утга, нэхэмжилсэн үнийн дүн” зэрэг ерөнхий мэдээллүүдийг тусгасан байх тул хүснэгт 1, 2-т дүгнэлт хийх шаардлагагүй болно.

График 1.-т Хэргийн төрлийг хувиар харуулсан байна. 31 хэргийн 61 хувийг иргэн, 19 хувийг хөдөлмөрийн, 10 хувийг гэрлэлт, 7 хувийг шүүхийн шийдвэр гүйцэтгэл, 3 хувийг цагаатгалын нөхөн олговрын хэрэг тус тус эзэлсэн байна.

Эндээс харахад иргэн болон хөдөлмөрийн хуулиар шийдвэрлэгдсэн хэрэг дийлэнх хувийг, шүүхийн шийдвэр гүйцэтгэл болон цагаатгалын нөхөн олговор бага хувийг эзэлсэн байна.

3.2.График 2.-т Иргэний хэрэгт эзэлж байгаа гэрээний төрлөөр хувийг харуулсан байна. 37 хувь нь ажил гүйцэтгэх гэрээ, 26 хувь нь зээлийн гэрээ, 16 хувь

гэм хор, 11 хувь нь хамтран ажиллах гэрээ, 5 хувь нь түрээсийн гэрээ, 5 хувь нь худалдах худалдан авах гэрээ тус тус эзэлжээ.

Үүнээс харах ажил гүйцэтгэх болон зээлийн гэрээ дийлэнх хувийг, түрээсийн болон худалдах худалдан авах гэрээ бага хувийг эзэлж байна.

3.3.Хүснэгт 3.Хавтаст хэрэг доторх баримтын задаргааг тоон үзүүлэлтээр харуулсан байна.

Судалгааны тайлангаас харахад 31 хэргийн 9967 хуудасны 2563 хуудас буюу **25,7 хувь** нь шүүхээс гарч буй эрхийн акт, 1096 хуудас буюу **11 хувь** нь шүүхийн баримт байна. Шүүхээс гаргасан эрхийн акт, баримтын нийлбэр 3659 хуудас буюу **36 хувь** нь шүүхээс гарч буй эрхийн акт, 4454 хуудас буюу **44,7 хувь** нь шүүгчийн захирамжаар гаргуулсан нотлох баримт, 771 буюу **7,7 хувь** нь зохигчоос ирсэн баримт, 1083 хуудас буюу **10,9 хувь** нь нэхэмжлэл, тайлбар, дүгнэлт тус тус эзэлж байна. 31 хэргийн 9967 хуудсанд 2893 ажиллагаа хийгдсэн байх ба 15256 хоногийг зарцуулжээ.

Дээрх үзүүлэлтээс харахад 4454 хуудас буюу 44,7 хувь нь шүүгчийн захирамжаар гаргуулсан нотлох баримт хавтаст хэрэг доторх баримтын дийлэнх хувийг эзэлжээ.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.3-т “Шүүх зохигч аль нэг талын хүсэлтээр эсрэг талаас нотлох баримтыг албадан гаргуулж болно”, 38.9-т “Шүүх хуралдааны явцад шинээр нотлох баримт шаардагдвал шүүх хуралдааныг нэг удаа хойшлуулах, хэрэгт хамааралгүй, нотолгооны ач холбогдолгүй, хуулиар зөвшөөрөгдөөгүй баримтыг хэргийн нотлох баримтаас хасах буюу шаардан авахаас татгалзах эрхийг шүүх эдлэх бөгөөд эдгээр тохиолдолд шүүх тогтоол, шүүгч захирамж гаргана”, 39 дүгээр зүйлийн 39.1-д “Хилийн чанадад нотлох баримт бүрдүүлэх шаардлагатай бол зохигчийн хүсэлтээр шүүх өөрөө, эсхүл эрх бүхий байгууллагаар дамжуулан тухайн улсын зохих байгууллагад хандаж болно” гэж тус тус заасантай холбоотойгоор зохигч шүүхээр нотлох баримт бүрдүүлэх ажиллагааг ихэвчлэн хийлгэж байгаа дүр зураг харагдаж байна. Энэ нь шүүхийн ачааллыг нэмэгдүүлж байна.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2.2-т “шүүхэд гаргасан нэхэмжлэлийн шаардлага, түүнийг үгүйсгэх, татгалзах үндэслэл, тайлбар түүнтэй холбоотой баримтыг өөрөө нотлох, нотлох баримтыг цуглуулах, гаргаж өгөх” үүрэгтэй хэмээн зохигчийн үүргийг хуульчилсан. Хуульд ийнхүү заасаар байхад үүргээ огт биелүүлдэггүй, шүүхээр албадан гаргуулдаг. Зохигч өөрсдөө нотлох баримтаа бүрдүүлж өгдөггүй, шүүхээр бүрдүүлдэг нь шүүхийн ачааллыг улам бүр нэмэгдүүлсээр байна.

Шүүхээр бүрдүүлсэн нотлох баримт 4454 хуудас буюу 44,7 хувь бол зохигчоос гаргаж өгсөн нотлох баримт 771 хуудас буюу 7,7 хувийг эзэлж байгаа нь харьцангуй юм. Өөрөөр хэлбэл 3683 хуудас буюу 37 хувиар зөрөөтэй харагдаж байна. Зохигчоос гаргаж өгсөн баримт шүүхээр бүрдүүлсэн нотлох баримтаас 5 дахин бага байна. Үүнээс Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1-т “Зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу

өмгөөлөгч нь өөрийн шаардлага ба татгалзлын үндэс болж байгаа байдлын талаархи нотлох баримтаа өөрөө гаргаж өгөх, цуглуулах үүрэгтэй” гэсэн заалт хэрэгждэггүй мэт харагдаж байна. Уг заалт жинхэнэ утгаараа хэрэгждэг бол дээрх үзүүлэлт эсрэгээрээ гарах байлаа. Зохигчийн өөрсдийн бүрдүүлж өгсөн нотлох баримт дийлэнх хувийг эзэлж байвал иргэний хэргийн өөрийнх нь онцлогийг харуулна.

Иймд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.3-т “Шүүх зохигч аль нэг талын хүсэлтээр эсрэг талаас нотлох баримтыг албадан гаргуулж болно” гэж заасны дагуу гаргуулсан бол нотлох баримтаа гаргаж өгөхгүй байгаа этгээдэд хариуцлага хүлээлгэх заалт Зөрчлийн хуульд нэмж оруулж болох юм.

3.4.График 1.-т Хавтаст хэрэг доторх баримтын задаргааг харуулжээ. Үүнд: Шүүгчийн захирамжаар гаргуулсан нотлох баримт 45 хувь, шүүхээс гаргасан эрхийн акт 25 хувь, нэхэмжлэл тайлбар 11 хувь, шүүхийн баримт 11 хувь, зохигчоос ирсэн баримт 8 хувийг тус тус эзэлж байна.

Судалгааны тайланд “Хавтаст хэрэгт авагдсан баримт материалын нарийвчлан үзвэл 83 хувь нь шүүхээс гаргасан эрхийн акт, үлдсэн цөөн хувийг нотлох баримт болон бусад холбогдох баримт эзэлж байсан” гэж тусгасан нь шүүхийн ачаалал их байгааг харуулж байна.

3.5.График 2.Хавтаст хэрэгт хийгдсэн нийт ажиллагааг шатлал тус бүрээр харуулжээ.

Иргэний хуулиар 1-р үе шат “Иргэний хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэх шат”-нд 15,8 хувийг, 2-р үе шат “Хэрэг үүсгэснээс хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх шийдвэр гаргах хүртэлх хугацааны ажиллагаа”-нд 52,6 хувийг, 3-р үе шат “Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шат”-нд 26,3 хувийг, 4-р үе шат “Хэргийг эцэслэн шийдвэрлэсний дараах ажиллагаа”-нд 3 хувийг зарцуулсан байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар 1-р үе шат “Иргэний хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэх шат”-нд 5,6 хувийг, 2-р үе шат “Хэрэг үүсгэснээс хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх шийдвэр гаргах хүртэлх хугацааны ажиллагаа”-нд 33,1 хувийг, 3-р үе шат “Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шат”-нд 46,8 хувийг 4-р үе шат “Хэргийг эцэслэн шийдвэрлэсний дараах ажиллагаа”-нд 14,5 хувийг зарцуулсан байна.

Хөдөлмөрийн хуулиар 1-р үе шат “Иргэний хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэх шат”-нд 4 хувийг, 2-р үе шат “Хэрэг үүсгэснээс хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх шийдвэр гаргах хүртэлх хугацааны ажиллагаа”-нд 45,5 хувийг, 3-р үе шат “Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шат”-нд 39,3 хувийг, 4-р үе шат “Хэргийг эцэслэн шийдвэрлэсний дараах ажиллагаа”-нд 11,2 хувийг тус тус зарцуулсан байна.

Гэр бүлийн хуулиар 1-р үе шат “Иргэний хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэх шат”-нд 8,2 хувийг, 2-р үе шат “Хэрэг үүсгэснээс хэргийг шүүх хуралдаанаар

хэлэлцүүлэх шийдвэр гаргах хүртэлх хугацааны ажиллагаа"-нд 55,9 хувийг, 3-р үе шат "Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шат"-нд 32,4 хувийг, 4-р үе шат "Хэргийг эцэслэн шийдвэрлэсний дараах ажиллагаа"-нд 8,5 хувийг тус тус зарцуулсан байна.

Цагаатгалын нөхөх олговрын хуулиар 1-р үе шат "Иргэний хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэх шат"-нд 2,5 хувийг, 2-р үе шат "Хэрэг үүсгэснээс хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх шийдвэр гаргах хүртэлх хугацааны ажиллагаа"-нд 48,3 хувийг, 3-р үе шат "Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шат"-нд 34,1 хувийг, 4-р үе шат "Хэргийг эцэслэн шийдвэрлэсний дараах ажиллагаа"-нд 15 хувийг тус тус зарцуулсан байна.

График 2-ыг дүгнэвэл: Хэргийн төрлөөс үл хамааран бүх хэрэгт адилхан 2, 3-р үе шатанд л хамгийн их хугацаа зарцуулагддаг байна.

3.6.Хүснэгт 4.Иргэний хуулиар шийдвэрлэгдсэн 19 хэрэг судалгаанд хамрагдсан байна. Үүнд: 25 төрлийн ажиллагааг хийж гүйцэтгэхэд 10,120 хоног зарцуулсан байна. Үүнийг задалбал хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны 1-р үе шат "Иргэний хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэх шат"-нд 627 хоног, 2-р үе шат "Хэрэг үүсгэснээс хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх шийдвэр гаргах хүртэлх хугацааны ажиллагаа"-нд 3974 хоног, 3-р үе шат "Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шат"-нд 2953 хоног, 4-р үе шат "Хэргийг эцэслэн шийдвэрлэсний дараах ажиллагаа"-нд 2566 хоногийг тус тус зарцуулжээ.

Дээрх үзүүлэлтээс харвал хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны 2, 3, 4-р үе шатанд буюу хэрэг үүсгэснээс хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх шийдвэр гаргах хүртэлх хугацааны ажиллагаа, хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шат, хэргийг эцэслэн шийдвэрлэсний дараах ажиллагааны үе шатуудад хамгийн их буюу 9493 хоногийг зарцуулсан байна. 2,3,4-р үе шатанд хамгийн их ажиллагаа хийгддэг байна.

1-р үе шатанд 21 нэхэмжлэл, захирамж, 2-р үе шатанд баримт 394, 3-р үе шатанд 201, баримт, нотлох баримт шаардсан захирамж 152, 4-р үе шатанд баримт 148, албан бичиг 77 дийлэнх хувийг эзэлж байна.

Хүснэгт 5.Гэр бүлийн хуулиар шийдвэрлэгдсэн 3 хэрэг судалгаанд хамрагдсан байна. Үүнд: 25 төрлийн ажиллагааг хийж гүйцэтгэхэд 1852 хоног зарцуулсан байна. Үүнийг задалбал хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны 1-р үе шат "Иргэний хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэх шат"-нд 17 хоног, 2-р үе шат "Хэрэг үүсгэснээс хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх шийдвэр гаргах хүртэлх хугацааны ажиллагаа"-нд 1002 хоног, 3-р үе шат "Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шат"-нд 500 хоног, 4-р үе шат "Хэргийг эцэслэн шийдвэрлэсний дараах ажиллагаа"-нд 333 хоногийг тус тус зарцуулжээ.

Дээрх үзүүлэлтээс харвал хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны 2, 3-р үе шатанд буюу хэрэг үүсгэснээс хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх шийдвэр гаргах хүртэлх хугацааны ажиллагаа, хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шатуудад хамгийн их буюу 1502 хоног зарцуулсан байна. 2,3-р шатанд хамгийн их ажиллагаа хийгдсэн байна. Харин 4-р үе шат буюу "Хэргийг эцэслэн шийдвэрлэсний дараах ажиллагаа"-нд 333 хоног зарцуулсан байна.

2-р үе шатанд баримт 67, 3-р үе шатанд баримт 26, 4-р үе шатанд баримт 10 дийлэнх хувийг эзэлж байна.

Хүснэгт 6.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар шийдвэрлэгдсэн 2 хэрэг судалгаанд хамрагдсан байна. Үүнд: 24 төрлийн ажиллагааг хийж гүйцэтгэхэд 663 хоног зарцуулсан байна. Үүнийг задалбал хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны 1-р үе шат “Иргэний хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэх шат”-нд 76 хоног, 2-р үе шат “Хэрэг үүсгэснээс хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх шийдвэр гаргах хүртэлх хугацааны ажиллагаа”-нд 172 хоног, 3-р үе шат “Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шат”-нд 264 хоног, 4-р үе шат “Хэргийг эцэслэн шийдвэрлэсний дараах ажиллагаа”-нд 151 хоногийг тус тус зарцуулжээ.

Дээрх үзүүлэлтээс харвал хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны 2, 3, 4-р үе шатанд буюу хэрэг үүсгэснээс хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх шийдвэр гаргах хүртэлх хугацааны ажиллагаа, хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шат, хэргийг эцэслэн шийдвэрлэсний дараах ажиллагааны үе шатуудад хамгийн их буюу 587 хоногийг зарцуулсан байна. 2,3,4-р үе шатанд хамгийн их ажиллагаа хийгдсэн байна.

2-р үе шатанд баримт 19, 3-р үе шатанд баримт 12, 4-р үе шатанд баримт 11 дийлэнх хувийг эзэлж байна.

Хүснэгт 7.Хөдөлмөрийн тухай хуулиар шийдвэрлэгдсэн 6 хэрэг судалгаанд хамрагдсан байна. Үүнд: 21 төрлийн ажиллагааг хийж гүйцэтгэхэд 2518 хоног зарцуулсан байна. Үүнийг задалбал хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны 1-р үе шат “Иргэний хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэх шат”-нд 45 хоног, 2-р үе шат “Хэрэг үүсгэснээс хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх шийдвэр гаргах хүртэлх хугацааны ажиллагаа”-нд 739 хоног, 3-р үе шат “Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шат”-нд 1168 хоног, 4-р үе шат “Хэргийг эцэслэн шийдвэрлэсний дараах ажиллагаа”-нд 566 хоногийг тус тус зарцуулжээ.

Дээрх үзүүлэлтээс харвал хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны 2, 3, 4-р үе шатанд буюу хэрэг үүсгэснээс хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх шийдвэр гаргах хүртэлх хугацааны ажиллагаа, хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шат, хэргийг эцэслэн шийдвэрлэсний дараах ажиллагааны үе шатуудад хамгийн их буюу 2473 хоногийг зарцуулсан байна. 2,3,4-р үе шатанд хамгийн их ажиллагаа хийгдсэн байна.

2-р үе шатанд баримт 82, 3-р үе шатанд баримт 45, 4-р үе шатанд баримт 25 дийлэнх хувийг эзэлж байна.

Хүснэгт 8.Цагаатгалын нөхөн олговроор шийдвэрлэгдсэн 1 хэрэг судалгаанд хамрагдсан байна. Үүнд: 10 төрлийн ажиллагааг хийж гүйцэтгэхэд 103 хоног зарцуулсан байна. Үүнийг задалбал хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны 1-р үе шат “Иргэний хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэх шат”-нд 7 хоног, 2-р үе шат “Хэрэг үүсгэснээс хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх шийдвэр гаргах хүртэлх хугацааны ажиллагаа”-нд 84 хоног, 3-р үе шат “Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шат”-нд 1 хоног, 4-р үе шат “Хэргийг эцэслэн шийдвэрлэсний дараах ажиллагаа”-нд 11 хоногийг тус тус зарцуулжээ.

Дээрх үзүүлэлтээс харвал хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны 2 үе шатанд буюу хэрэг үүсгэснээс хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх шийдвэр гаргах хүртэлх хугацаанд хамгийн их буюу 84 хоногийг зарцуулсан байна.

3.7."Нэхэмжлэл, хариу тайлбар, сөрөг нэхэмжлэлийн тоо, нэхэмжлэлийн шаардлага нэмэгдүүлсэн, багасгасан, өөрчилсөн тохиолдлын тоо, нотлох баримт шаардсан тал, хүсэлт, гомдол, тайлбар гаргасан тал болон давтамж, давах, хяналтын гомдол гаргасан тал болон давтамж зэргийг маргааны төрөл болон субъектээр нь ангилан харууллаа. Ингэснээр энэхүү боловсруулалтаас нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдийн алинаас нь илүүтэй хүсэлт, гомдол, тайлбар, давж заалдах болон хяналтын шатны шүүхэд гомдол гаргадаг болох, мөн доорх үзүүлэлтүүдээс тухайн хэргийн хөнгөн болон ээдрээ төвөгтэй байдал, хэргийн өнгийг нь таних боломжтой юм" гэж судалгааны тайланд тусгажээ.

Хүснэгт 9.Иргэний эрх зүйн маргааны хүснэгтээс харахад нэхэмжлэгчээс 99, хариуцагчаас 63, хариуцагчийн өмгөөлөгчөөс 22, нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс 34, хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс 38, гуравдагч этгээдээс 0, нэхэмжлэгчийн өмгөөлөгч 14, нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн өмгөөлөгчөөс 6, нийт 276 нэхэмжлэл, тайлбар, хүсэлт, гомдлыг гаргажээ.

Үүнээс харахад зохигч, тэдгээрийн итгэмжлэгдсэн төлөөлөгч, өмгөөлөгчид хамгийн ихээр буюу 135 хүсэлт, шүүгчийн захирамжаар нотлох баримт гаргуулах 56 хүсэлт гаргажээ.

Хүснэгт 10.Гэр бүлийн маргааны хүснэгтээс харахад нэхэмжлэгчээс 21, хариуцагчаас 15, хариуцагчийн өмгөөлөгчөөс 5, нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс 3, хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс 0, гуравдагч этгээдээс 11, нэхэмжлэгчийн өмгөөлөгчөөс 3, нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн өмгөөлөгчөөс 0, нийт 58 нэхэмжлэл, тайлбар, хүсэлт, гомдлыг гаргажээ.

Үүнээс харахад зохигч, тэдгээрийн итгэмжлэгдсэн төлөөлөгч, өмгөөлөгчид хамгийн ихээр буюу 24 хүсэлт, шүүгчийн захирамжаар нотлох баримт гаргуулах 10 хүсэлт гаргажээ.

Хүснэгт 11.Хөдөлмөрийн маргаан хүснэгтээс харахад нэхэмжлэгчээс 17, хариуцагчаас 9, хариуцагчийн өмгөөлөгчөөс 3, нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс 8, хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс 30, гуравдагч этгээдээс 0, нэхэмжлэгчийн өмгөөлөгчөөс 11, нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн өмгөөлөгчөөс 0, нийт 78 нэхэмжлэл, тайлбар, хүсэлт, гомдлыг гаргажээ.

Үүнээс харахад зохигч, тэдгээрийн итгэмжлэгдсэн төлөөлөгч, өмгөөлөгчид хамгийн ихээр буюу 28 хүсэлт, шүүгчийн захирамжаар нотлох баримт гаргуулах 23 хүсэлт гаргажээ.

Хүснэгт 12.Шүүхийн шийдвэр гүйцэтгэлтэй холбоотой маргаан хүснэгтээс харахад нэхэмжлэгчээс 6, хариуцагчаас 5, хариуцагчийн өмгөөлөгчөөс 0, нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс 4, хариуцагчийн итгэмжлэгдсэн

төлөөлөгчөөс 0, гуравдагч этгээдээс 0, нэхэмжлэгчийн өмгөөлөгчөөс 2, нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн өмгөөлөгчөөс 0, нийт 17 нэхэмжлэл, тайлбар, хүсэлт, гомдлыг гаргажээ.

Үүнээс харахад зохигч, тэдгээрийн итгэмжлэгдсэн төлөөлөгч, өмгөөлөгчид хамгийн ихээр буюу 5 хүсэлт, шүүгчийн захирамжаар нотлох баримт гаргуулах 4 хүсэлт гаргажээ.

Хүснэгт 13. Шүүхийн шийдвэр гүйцэтгэлтэй холбоотой маргаан хүснэгтээс харахад нэхэмжлэгчээс 6, хариуцагчаас 5, хариуцагчийн өмгөөлөгчөөс 0, нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс 4, хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс 0, гуравдагч этгээдээс 0, нэхэмжлэгчийн өмгөөлөгчөөс 2, нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн өмгөөлөгчөөс 0, нийт 17 нэхэмжлэл, тайлбар, хүсэлт, гомдлыг гаргажээ.

Үүнээс харахад зохигч, тэдгээрийн итгэмжлэгдсэн төлөөлөгч, өмгөөлөгчид хамгийн ихээр буюу 5 хүсэлт, шүүгчийн захирамжаар нотлох баримт гаргуулах 4 хүсэлт гаргажээ.

Хүснэгт 9-13-ыг дүгнэвэл зохигчоос хүсэлт гаргах, шүүгчийн захирамжаар нотлох баримт гаргуулах ажиллагаа хамгийн их хийгддэг байна.

3.8. Судалгааны тайланд хамруулсан хэрэг тус бүрээр бүртгэгдсэн ажиллагаа болон зарцуулсан хоногийг дэлгэрүүлье.

Гэр бүлийн хэрэг:

1. Гэрлэлт шүүхийн журмаар цуцлах, хүүхдийн асрамж, хүүхдийн тэтгэмж тогтоох, гэр бүлийн дундын эд хөрөнгийн ногдох хэсгийг гаргуулах хэргийн тухайд: Уг хэрэг нь 1 хавтас 191 хуудастай, шүүхээс 61 ажиллагааг хийж гүйцэтгэсэн байх ба 345 хоног зарцуулагджээ.

2. Гэрлэлт цуцлах, хүүхдийн тэтгэмж тогтоолгох хэргийн тухайд: Уг хэрэг нь 1 хавтас 172 хуудастай, шүүхээс 59 ажиллагааг хийж гүйцэтгэсэн байх ба 549 хоног зарцуулагджээ.

3. Гэрлэлт цуцлуулах, хүүхдийн асрамж, тэтгэлэг тогтоолгох хэргийн тухайд: Уг хэрэг нь 2 хавтас 321 хуудастай, шүүхээс 161 ажиллагааг хийж гүйцэтгэсэн байх ба 958 хоног зарцуулагджээ.

Гэрлэлтийн 3 хэрэг 3-уулаа олон хоног зарцуулагдсан хэргүүд байна.

Иргэний хэрэг:

1. Ажил гүйцэтгэх гэрээний үүргийн биелэлтэд үл хөдлөх хөрөнгө захиалгаар барих гэрээний төлбөрийн үлдэгдэл болон алдагдал гаргуулах хэргийн тухайд: Уг хэрэг нь 1 хавтас 124 хуудастай, шүүхээс 53 ажиллагааг хийж гүйцэтгэсэн байх ба 427 хоног зарцуулагджээ.

2.Ажил гүйцэтгэх гэрээний үүргийн биелэлтэд гэрээний төлбөр гаргуулах гаргуулах хэргийн тухайд: Уг хэрэг нь 1 хавтас 109 хуудастай, шүүхээс 42 ажиллагааг хийж гүйцэтгэсэн байх ба 274 хоног зарцуулагджээ.

3.Ажил гүйцэтгэх гэрээний үүргийн биелэлтэд барилга барихад зарцуулсан барилгын материалын зардлыг гаргуулах хэргийн тухайд: Уг хэрэг нь 6 хавтас 1446 хуудастай, шүүхээс 387 ажиллагааг хийж гүйцэтгэсэн байх ба 1489 хоног зарцуулагджээ.

Уг хэрэг хамгийн олон ажиллагаа хийгдсэн, хамгийн олон хоног зарцуулсан хэрэг байна.

4.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны улмаас үчирсан хохиролд 1,797,103,396 төгрөг гаргуулах хэргийн тухайд: Уг хэрэг нь 2 хавтас 307 хуудастай, шүүхээс 45 ажиллагааг хийж гүйцэтгэсэн байх ба 118 хоног зарцуулагджээ.

5.Зээлийн гэрээний үүргийн биелэлтэд төлбөр гаргуулах, үүргийн гүйцэтгэлийн барьцаа хөрөнгөөс төлбөр гаргуулах хэргийн тухайд: Уг хэрэг нь 2 хавтас 347 хуудастай, шүүхээс 110 ажиллагааг хийж гүйцэтгэсэн байх ба 826 хоног зарцуулагджээ.

6.Зээлийн гэрээний үүргийн биелэлтэд 95,438,325/91 төгрөг гаргуулах хэргийн тухайд: Уг хэрэг нь 1 хавтас 114 хуудастай, шүүхээс 59 ажиллагааг хийж гүйцэтгэсэн байх ба 238 хоног зарцуулагджээ.

7.Ажил гүйцэтгэх гэрээний үүргийн биелэлтэд 30,000,000 төгрөг гаргуулах хэргийн тухайд: Уг хэрэг нь 3 хавтас 530 хуудастай, шүүхээс 162 ажиллагааг хийж гүйцэтгэсэн байх ба 1504 хоног зарцуулагджээ.

Уг хэрэг хяналтын шатны шүүх хүртэл хянагдаж хялбаршуулсан журмаар шийдвэрлэгдсэн байх бөгөөд хамгийн олон ажиллагаа хийгдсэн, хамгийн олон хоног зарцуулсан хэрэг байна.

8.Хамтран ажиллах гэрээний үүргийн биелэлтэд 11,109,060 төгрөг, хэтэрсэн хугацааны хүү 5,554,530 төгрөг, нийт 16,663,590 төгрөгийг гаргуулах хэргийн тухайд: Уг хэрэг нь 1 хавтас 157 хуудастай, шүүхээс 91 ажиллагааг хийж гүйцэтгэсэн байх ба 441 хоног зарцуулагджээ.

Уг хэргийн хувьд шүүхээс гаргасан эрхийн акт 5 буюу 27,8 хувь хамгийн бага үзүүлэлттэй байна.

9.Зээлийн гэрээний үүргийн биелэлтэд 20,680,000 төгрөгийг гаргуулах хэргийн тухайд: Уг хэрэг нь 1 хавтас 217 хуудастай, шүүхээс 68 ажиллагааг хийж гүйцэтгэсэн байх ба 441 хоног зарцуулагджээ.

10. Хамтран ажиллах гэрээний үүргийн биелэлтэд 100,000,000 төгрөг гаргуулах хэргийн тухайд: Уг хэрэг нь 2 хавтас 359 хуудастай, шүүхээс 143 ажиллагааг хийж гүйцэтгэсэн байх ба 708 хоног зарцуулагджээ.

11.Эрүүл мэндэд үчирсан хохирол болох 13,455,482 төгрөг гаргуулах хэргийн тухайд: Уг хэрэг нь 2 хавтас 516 хуудастай, шүүхээс 174 ажиллагааг хийж гүйцэтгэсэн байх ба 648 хоног зарцуулагджээ.

12. Ажил гүйцэтгэх гэрээний үүргийн биелэлтэд алданги 263,330,000 төгрөг гаргуулах хэргийн тухайд: Уг хэрэг нь 1 хавтас 209 хуудастай, шүүхээс 79 ажиллагааг хийж гүйцэтгэсэн байх ба 431 хоног зарцуулагджээ.

13. Зээлийн гэрээний үүргийн биелэлтэд 32,979,743/99 төгрөг гаргуулах хэргийн тухайд: Уг хэрэг нь 1 хавтас 119 хуудастай, шүүхээс 50 ажиллагааг хийж гүйцэтгэсэн байх ба 295 хоног зарцуулагджээ.

14. Гэрээний үүргээ биелүүлж, барилгын ажил эхлүүлэх зөвшөөрөл гаргуулахыг даалгах хэргийн тухайд: Уг хэрэг нь 1 хавтас 199 хуудастай, шүүхээс 70 ажиллагааг хийж гүйцэтгэсэн байх ба 310 хоног зарцуулагджээ.

15. Зээлийн гэрээний үүргийн биелэлтэд нөхөн төлбөр гаргуулах хэргийн тухайд: Уг хэрэг нь 3 хавтас 520 хуудастай, шүүхээс 186 ажиллагааг хийж гүйцэтгэсэн байх ба 643 хоног зарцуулагджээ.

16. Ажил гүйцэтгэх гэрээний үүргийн биелэлтэд төлбөр гаргуулах хэргийн тухайд: Уг хэрэг нь 3 хавтас 548 хуудастай, шүүхээс 71 ажиллагааг хийж гүйцэтгэсэн байх ба 359 хоног зарцуулагджээ.

17. Хохирол, нөхөн олговрыг олгуулах хэргийн тухайд: Уг хэрэг нь 1 хавтас 59 хуудастай, шүүхээс 20 ажиллагааг хийж гүйцэтгэсэн байх ба 91 хоног зарцуулагджээ.

18. Түрээсийн гэрээг цуцлан түрээсийн эд хөрөнгийг албадан чөлөөлүүлэх, гүйцэтгээгүй үүрэг болох 25.999.541 төгрөгийг хариуцагчаас гаргуулах хэргийн тухайд: Уг хэрэг нь 3 хавтас 855 хуудастай, шүүхээс 162 ажиллагааг хийж гүйцэтгэсэн байх ба 448 хоног зарцуулагджээ.

19. Төлбөр гаргуулах хэргийн тухайд: Уг хэрэг нь 1 хавтас 220 хуудастай, шүүхээс 93 ажиллагааг хийж гүйцэтгэсэн байх ба 429 хоног зарцуулагджээ.

Хөдөлмөрийн хуулиар шийдвэрлэсэн хэрэг:

1. Албан тушаалд эгүүлэн томилуулах, учирсан хохирол болон цалингийн зөрүүг нөхөн төлүүлэх хэргийн тухайд: Уг хэрэг нь 1 хавтас 307 хуудастай, шүүхээс 78 ажиллагааг хийж гүйцэтгэсэн байх ба 371 хоног зарцуулагджээ.

2. Ажлаас үндэслэлгүй халагдсан болохыг тогтоолгож, нөхөн олговор гаргуулах хэргийн тухайд: Уг хэрэг нь 1 хавтас 211 хуудастай, шүүхээс 56 ажиллагааг хийж гүйцэтгэсэн байх ба 346 хоног зарцуулагджээ.

3. Ажлаас үндэслэлгүй халагдсан болохыг тогтоолгох хэргийн тухайд: Уг хэрэг нь 3 хавтас 519 хуудастай, шүүхээс 92 ажиллагааг хийж гүйцэтгэсэн байх ба 617 хоног зарцуулагджээ.

4. Ажилд эргүүлэн тогтоолгох хэргийн тухайд: Уг хэрэг нь 2 хавтас 302 хуудастай, шүүхээс 37 ажиллагааг хийж гүйцэтгэсэн байх ба 96 хоног зарцуулагджээ.

5. Ажилд эргүүлэн тогтоолгох хэргийн тухайд: Уг хэрэг нь 2 хавтас 320 хуудастай, шүүхээс 93 ажиллагааг хийж гүйцэтгэсэн байх ба 887 хоног зарцуулагджээ.

6. Ажилд эргүүлэн тогтоолгох хэргийн тухайд: Уг хэрэг нь анхан шатны шүүхэд хялбаршуулсан журмаар шийдвэрлэгдсэн, 1 хавтас 208 хуудастай, шүүхээс 48 ажиллагааг хийж гүйцэтгэсэн байх ба 201 хоног зарцуулагджээ.

Шийдвэр гүйцэтгэлийн хуулиар шийдвэрлэсэн хэрэг:

1. Үнэлгээ хүчингүй болгуулах хэргийн тухайд: Уг хэрэг нь анхан шатны шүүхэд хялбаршуулсан журмаар шийдвэрлэгдсэн, 1 хавтас 169 хуудастай, шүүхээс 65 ажиллагааг хийж гүйцэтгэсэн байх ба 398 хоног зарцуулагджээ.

2. Үнэлгээ хүчингүй болгуулах хэргийн тухайд: Уг хэрэг нь анхан шатны шүүхэд хялбаршуулсан журмаар шийдвэрлэгдсэн, 1 хавтас 233 хуудастай, шүүхээс 65 ажиллагааг хийж гүйцэтгэсэн байх ба 398 хоног зарцуулагджээ.

Цагаатгалын нөхөн олговрын хуулиар шийдвэрлэсэн хэрэг:

1. Нэр төр сэргээлгэх, хэлмэгдсэнд тооцуулан цагаатгах хэргийн тухайд: Уг хэрэг нь анхан шатны шүүхэд хялбаршуулсан журмаар шийдвэрлэгдсэн, 1 хавтас 59 хуудастай, шүүхээс 19 ажиллагааг хийж гүйцэтгэсэн байх ба 103 хоног зарцуулагджээ.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

4.1. Бага үнийн дүнтэй, хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн, ердийн журмаар шийдвэрлэсэн иргэний хэргийн хавтаст хэрэгт хийсэн баримт бичгийн судалгааны тайланг уншиж судаллаа.

Бага үнийн дүнтэй хэрэг дээр 6 буюу цөөн хэрэг, хялбаршуулсан журмаар шийдвэрлэгдсэн 16 хэрэг, ердийн журмаар шийдвэрлэсэн 31 хэрэг судалгаанд хамрагджээ.

Бага үнийн дүнтэй иргэний хэргийг шийдвэрлэсэн судалгааны тайлангийн бүтэц нь хэргийн ерөнхий мэдээлэл, нэхэмжлэлийн товч утга, хавтаст хэрэгт авагдсан баримт, хийгдсэн ажиллагаа шатлал тус бүрээр, хэрэг хянан шийдвэрлэсэн хугацаа, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны төрөл, нийт хийгдсэн ажиллагаа, ажиллагаанд зарцуулсан нийт хугацаа гэсэн үзүүлэлтээр гаргажээ.

Хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн судалгааны тайлангийн бүтэц нь хэрэг хянан шийдвэрлэсэн хугацаа, хэргийн ерөнхий мэдээлэл, нэхэмжлэлийн товч утга, хавтаст хэрэг доторх баримтын задаргаа, хийгдсэн ажиллагаа шатлал тус бүрээр, хэргийн төрлөөр хэрэг хянан шийдвэрлэсэн хугацаа, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны төрөл, нийт хийгдсэн ажиллагаа, ажиллагаанд зарцуулсан нийт хугацаа гэсэн үзүүлэлтээр гаргажээ.

Ердийн журмаар шийдвэрлэсэн иргэний хэргийн хавтаст хэрэгт хийсэн баримт бичгийн судалгааг хэргийн ерөнхий мэдээлэл, нэхэмжлэлийн товч утга, хэргийн төрөл, иргэний хэрэгт эзэлж байгаа гэрээний төрлийг хувиар, хавтаст хэрэг доторх баримтын задаргаа, хавтаст хэрэгт хийгдсэн ажиллагаа шүүхийн шатлал тус

бүрээр, хэргийн төрлөөр хэрэг хянан шийдвэрлэсэн хугацаа, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны төрөл, нийт хийгдсэн ажиллагаа, ажиллагаанд зарцуулсан нийт хугацаа, зохигч /субъект/-оос гаргасан хүсэлт, тайлбар, гомдлын тоо гэсэн үзүүлэлтээр гаргажээ.

Бага үнийн дүнтэй хэрэг, хялбаршуулсан журмаар шийдвэрлэгдсэн хэрэг, ердийн журмаар шийдвэрлэгдсэн хэрэг дээр гаргасан үзүүлэлт тус бүрийн дор судалгааны тоон үзүүлэлтийг үгээр илэрхийлж, дүгнэлтийг бичих гэж хичээсэн болно.

Иймд зөвхөн энэхүү дүгнэлтээр хязгаарлагдахгүйгээр хууль зүйн дүгнэлтийг бүхэлд нь уншихыг зөвлөө.

Эдгээр 3 судалгааны тайлангийн хэргийн дотор харагдаж буй дүр зураг ижилхэн байна. Өөрөөр хэлбэл хавтаст хэрэг доторх баримтын задаргаанд зохигчийн гаргаж өгсөн нэхэмжлэл, тайлбар, хүсэлт, гомдол хамгийн бага хувийг эзэлсэн. Түүний дараа зохигчоос гаргасан нотлох баримт орж байна. Шүүхээс гаргасан эрхийн акт, баримт, шүүхийн шаардсанаар гаргасан нотлох баримт зэрэг нь хамгийн их хувийг эзэлсэн байна.

Хавтаст хэргийн тоо их байх тусмаа шүүхээс гарч буй эрхийн акт олон, хийгдсэн ажиллагаа болон зарцуулсан хоног их байна.

Судалгаанд хамруулсан хэргийн дийлэнх хувь нь анхан шатны шүүхээр шийдвэрлэгдэж дууссан, хийгдсэн ажиллагааны хувьд анхан шатны шүүх дээр ихэнх ажиллагаа хийгдсэн байна.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны 1-р үе шат “Иргэний хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэх шат”-нд хамгийн бага хугацаа зарцуулдаг бол 2-р үе шат “Хэрэг үүсгэснээс хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх шийдвэр гаргах хүртэлх хугацааны ажиллагаа”, 3-р үе шат “Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд бэлтгэх, хэлэлцэх үе шат”-нд, 4-р үе шат “Хэргийг эцэслэн шийдвэрлэсний дараах ажиллагаа”-нд хамгийн олон хоногийг зарцуулсан байна.

Иймд дараах дүгнэлтийг дэвшүүлж байна.

1. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 25 дугаар зүйл. Зохигчийн эрх үүрэг, 38 дугаар зүйл. Нотлох баримт гаргах ба цуглуулах, бүрдүүлэх заалтуудыг шинэчилсэн найруулгын төсөлд зохигчоор өөрсдөөр нь нотлох баримт гаргуулах илүү оновчтой хувилбарыг оруулж өгөх, эсвэл нотлох баримт гаргаж өгөхгүй байгаа зохигчид хариуцлага хүлээлгэх хуулийн заалт Зөрчлийн хуульд нэмж оруулах.

2. Шүүхээс гарч буй хүсэлтийн дийлэнх хэсэг нь шүүх хуралдаан хойшлуулах байсантай холбогдулан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд шүүх хуралдаан хойшлуулах зохигчийн эрхийг хязгаарласан заалт оруулж өгөх.

3. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд давж заалдах болон хяналтын шатны шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацааг хэрхэн сунгах талаар зохицуулалт нэмж оруулах.

4.Иргэний хэргийн хувьд анхан шатны шүүх дээр ихэнх хэрэг шийдвэрлэгдсэн байх тул Монгол улсын шүүхийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3-т “Шүүхийг шүүн таслах ажиллагааны төрлөөр дагнан байгуулж болох бөгөөд ...” гэж заасны дагуу бага үнийн дүнтэй хэргийн, гэр бүл, хөдөлмөрийн гэх мэт дагнасан төрлөөр шүүх байгуулах.

5.Шүүхэд итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх, иргэдийн эрх зүйн боловсролыг нэмэгдүүлэх.

6.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны 2-4-р үе шатуудад хамгийн их ажиллагаа хийгдэж, хамгийн олон хоногийг зарцуулж байгаа тул иргэний хэргийн анхан шатны шүүгчийн орон тоог нэмэгдүүлэх.

7.Ердийн журмаар шийдвэрлэсэн хэргийн 4-р үе шатанд хамгийн их хугацаа зарцуулсантай холбоотойгоор Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай шинэчилсэн найруулгын төсөлд хугацааны талаар нарийвчилсан зохицуулалт оруулах.

8.Хэрэгт хавсаргаж буй баримт /хэргийн хөдөлгөөний аргачлалаар батлагдсан/ хавтаст хэрэг дотор тодорхой хэмжээгээр эзлэх хувь өндөр байгаа тул гадаад орнуудын туршлагыг судалж, нэвтрүүлэх.

9.Мэдээлэл технологи асар хурдтай хөгжиж байгаа цаг үетэй хөл нийлүүлэн шүүх хуралдааны тэмдэглэлийг дуу болон дүрс бичлэгийн монгол яриаг бичвэрт буулгах “Чимэгэ” систем-ийг нийт шүүхэд нэвтрүүлэх.

Шүүхэд “Чимэгэ” систем нэвтэрвэл шүүгчийн шийдвэр бичихэд зарцуулдаг хугацаа ч багасаж, шүүхийн ачаалал тодорхой хэмжээгээр буурах магадлалтай гэж үзэж байна.

-000-

**Тав. АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН ХЯНАН ШИЙДВЭРЛЭСЭН ХЭРГИЙН
ТООНД НӨЛӨӨЛЖ БУЙ ХҮЧИН ЗҮЙЛИЙН ШИНЖИЛГЭЭ**

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 58 дугаар тогтоолоор батлагдсан шалгуур үзүүлэлтэд хамаарах өгөгдөлд хийсэн суурь судалгаа /цаашид Үндсэн тайлан гэх/-ны Гуравдугаар бүлэг “Шүүхэд шийдвэрлэсэн хэргийн тогтолцооны шинжилгээ”, Дөрөвдүгээр бүлэг “Шаардлагатай шүүгчийн тооны тооцоо”-р шүүхэд хянан шийдвэрлэж байгаа хэргийн тоо жилд нэмэгдэж байгаа хэмжээ болон ажиллах шаардлагатай шүүгчийн тооны тооцоонд хамаарах дараах үр дүн гарсан байна.

Нэг. 1 шүүгч 1 жилд хянан шийдвэрлэсэн хэргийн тооны өөрчлөлт

1.1. Анхан шатны шүүх

№	Хэргийн төрөл	Нийслэл, дүүрэг		Аймаг	Сум дунд
		Төвийн дүүрэг	Захын дүүрэг		
1	Эрүү	0.5	0.1	1	0.03
2	Зөрчил	9	0.5	2	0.4
3	Иргэн	0.3	1	2	1
4	Захиргаа	0.07		-0.13	-

Хүснэгт 212 Үндсэн тайлангийн бүлэг 3-т дурдсан гол хэсгийн шинжилгээгээр тодорхойлогдсон нэг шүүгчийн нэг жилд хянан шийдвэрлэсэн хэргийн тооны өөрчлөлт, анхан шатны шүүхээр

Хүснэгтээс харвал хамгийн ихдээ зөрчлийн хэрэг шүүгчид нэг жил тутамд 9 хэргээр нэмэгдэж байгаа бол аймаг дахь захиргааны хэргийн анхан шатны шүүхэд шийдвэрлэсэн хэргийн тоо буурсан дүнтэй байна.

№	Хэргийн төрөл	2024 онд			
		Төвийн дүүрэг	Захын дүүрэг	Аймаг	Сум дунд
1	Эрүү	1-2 хэрэг	0.3 хэрэг	3 хэрэг	0.09
2	Зөрчил	27 хэрэг	1-2 хэрэг	6 хэрэг	1.2 хэрэг
3	Иргэн	1 хэрэг	3 хэрэг	6 хэрэг	3 хэрэг
4	Захиргаа	0.21 хэрэг		-0.39	-

Хүснэгт 213 Үндсэн тайлангийн бүлэг 3-т дурдсан гол хэсгийн шинжилгээгээр тодорхойлогдсон үр дүнг ашиглаж тооцсон хандлагын тооцоо, анхан шатны шүүх, 3 жилээр

2017-2021 оны хоорондох 5 жилийн динамикийн хувьд нэг шүүгч нэг жилд шийдвэрлэсэн хэргийн өөрчлөлтийн дүнгээр 2022-2024 оны дүнг тодорхойлон гаргавал шүүгч нэмэх шаардлага үүсэхээргүй байна. Үндсэн тайлангийн шинжилгээний үр дүн нь 2-3 жилдээ хадгалагдах мэдээлэл агуулах боломжтой, харин түүнээс хойших жилүүдэд тооцооллыг дахин хийх шаардлага үүсэхээр байна.

1.2. Давж заалдах шатны шүүх

№	Хэргийн төрөл	Нийслэл	Орхон, Дархан-Уул	
			Орхон,	Бусад аймаг
1	Эрүү	0.7	0.7	0.7
2	Зөрчил	0.01	0.2	0.1
3	Иргэн	0.04	-0.7	-0.7
4	Захиргаа	-0.7	-	-

Хүснэгт 214 Үндсэн тайлангийн бүлэг 3-т дурдсан гол хэсгийн шинжилгээгээр тодорхойлогдсон нэг шүүгчийн нэг жилд хянан шийдвэрлэсэн хэргийн тооны өөрчлөлт, давж заалдах шатны шүүхээр

Давж заалдах шатны шүүх нь хамгийн ихдээ 1 шүүгчид 1 жилд шийдвэрлэсэн эрүүгийн 1 хэрэг нэмэгдэх, харин захиргааны хэрэг мөн аймаг дахь шүүхийн иргэний хэрэг тус тус буурахаар байна.

№	Хэргийн төрөл	2024 онд		
1	Эрүү	2 хэрэг	2 хэрэг	2.1 хэрэг
2	Зөрчил	0.03 хэрэг	0.6 хэрэг	0.3 хэрэг
3	Иргэн	0.12 хэрэг	-2 хэрэг	-2 хэрэг
4	Захиргаа	-2 хэрэг	-	-

Хүснэгт 215 Үндсэн тайлангийн бүлэг 3-т дурдсан гол хэсгийн шинжилгээгээр тодорхойлогдсон үр дүнг ашиглаж тооцсон хандлагын тооцоо, давж заалдах шатны шүүх, 3 жилээр

2017-2021 оны хоорондох 5 жилийн динамикийн хувьд нэг шүүгч нэг жилд шийдвэрлэсэн хэргийн өөрчлөлтийн дүнгээр 2022-2024 оны дүнг тодорхойлон гаргавал шийдвэрлэсэн дундаж хэрэг буюу Нийслэлийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн эрүүгийн 39, зөрчлийн 7, иргэн 103, захиргааны 62 хэрэг нэмэгдэх үр дагавар үүсэхээргүй байна. Үндсэн тайлангийн шинжилгээний үр дүн нь 3 жилдээ хадгалагдах мэдээлэл агуулах боломжтой, харин түүнээс хойших жилүүдэд тооцооллыг дахин хийх шаардлага үүсэхээр байна.

Хоёр. Шүүх бүрд шаардлагатай шүүгчийн орон тооны тооцоо

2.1. Төвийн 6 дүүргийн шүүх

№	Шүүхийн нэр	анхан шат					
		эрүү		Иргэн			
		ажиллаж байгаа	шаардлагатай	зөрүү	ажиллаж байгаа	шаардлагатай	зөрүү
1	Баянзүрх	10.6	22.2	11.6	16.4	24.6	8.2
2	Чингэлтэй	7.2	10.9	3.7	11.8	15.3	3.5
3	Сүхбаатар	7.5	11.6	4.1	11.5	16.1	4.6
4	Баянгол	8.6	11.9	3.3	14.4	18.7	4.3
5	Хан-Уул	7	9.8	2.8	11	17.6	6.6
6	Сонгинохайрхан	9.2	14.8	5.6	12	16.8	4.8
	Дүн	50.1	81.3	31.2	77.1	109.2	32.1

Хүснэгт 216 Үндсэн тайлангийн бүлэг 4-т дурдсан ажиллах шаардлагатай шүүгчийн тооны тооцоо, төвийн 6 дүүргээр


Үндсэн тайлангийн бүлэг 3 болон 4-ийн үр дүнг нэгтгэн дүгнэвэл төвийн 6 дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд шаардлагатай болох 31 шүүгчийн тоо нь ирэх 3 жилд нэмэгдэх эсэх хандлагыг судалгааг гүйцэтгэсэн талаас тодруулахад “төвийн дүүргийн 1 шүүгчид нэг жилд эрүүгийн 1-2 хэрэг л нэмэгдэх тул ирэх 3 жилдээ энэ тооцоо хадгалагдана гэсэн” тайлбарыг өгч байна. Тухайлбал, Баянзүрх дүүрэгт өнгөрсөн 5 жилийн динамикийн хувьд 10.6 шүүгч /чөлөө авсан, өвдсөн гэх мэт шалтгаанаар ажиллаагүй шүүгчийн тоо хасагдсан дүн/ ажилласан гэж үзвэл нэмээд 11.6 шүүгч шаардлагатай байна. Нийтдээ 22-23 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр 2022-2024 онд ажиллахад орон тооны дутагдал үүсэхээргүй байна.

Энэ мэтчилэн бусад дүүрэг, аймаг, сум дунд, давж заалдах шатны шүүхэд шаардлагатай шүүгчийн тоо ирэх 3 жилд хангалттай гэж үзээд орон тоог тогтоохдоо Үндсэн тайлангийн бүлэг 2 дахь шүүх бүрээр ажиллавал зохих шүүгчийн тооны тооцоог ашиглах боломжтой байна.

Гурав. Анхан шатны шүүхүүдэд шийдвэрлэсэн хэргийн тооны хугацаанаас хамаарсан хандлага


3.1. Нийслэл

Эрүү болон иргэний хэргийн хувьд шүүхийн бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтөөс шалтгаан 18 жилийн динамик өгөгдөл шүүх бүрээр гарахгүй байгаатай холбоотойгоор хугацааны цуваанд шинжилгээ хийж, хандлагыг тодорхойлох боломжгүй байна. Харин Нийслэл дэх нийт хэмжээгээр 2004-2021 оны өгөгдөлд шинжилгээ хийж эрүү, иргэн, захиргааны хэргийн анхан шатны шүүхийн хувьд загварыг тооцох боломжтой байна.




Зураг 1 ДЭХАШШ-ийн шийдвэрлэсэн хэргийн тооны хугацаанаас хамаарсан загвар

Нийт 9 дүүргийн хэмжээнд жил тутам 274 эрүүгийн хэрэг нэмэгдэх хугацааны нөлөөлөл 63 хувьтай тодорхойлогдсон байна. Бусад хүчин зүйлийн нөлөө 37 хувьтай байгаа тул энэ загвараар тооцогдсон хугацаанаас хамаарсан шийдвэрлэсэн хэргийн тооны өсөлтийг бодлого шийдвэрт ашиглахдаа анхаарч бусад нөлөөллийг анхаарч үзэх шаардлагатай байна.



Зураг 2 ДИХАШШ-ийн шийдвэрлэсэн хэргийн тооны хугацаанаас хамаарсан загвар

Нийт 9 дүүргийн хэмжээнд жил тутам 1302 иргэний хэрэг нэмэгдэх хугацааны нөлөөлөл 91 хувьтай тодорхойлогдсон байна. Бусад хүчин зүйлийн нөлөө 9 хувьтай байгаа тул энэ загвараар тооцогдсон хугацаанаас хамаарсан шийдвэрлэсэн хэргийн тооны өсөлтийг бодлого шийдвэрт ашиглах боломжтой байна.



Зураг 3 НДЗХАШШ-ийн шийдвэрлэсэн хэргийн тооны хугацаанаас хамаарсан загвар

Нийслэл дэх ЗХАШШ-ийн шийдвэрлэсэн хэргийн тоон нь хугацаанаас хамаарсан нөлөөлөл хүчтэй буюу 91 хувьтай гарсан байна. Энэ нь тус шүүхийн шийдвэрлэсэн хэрэг жилээс жилд нэмэгдэж, өсөх хандлагатай байгаа мэдээллийг өгч байна. Загварын утгаас харвал жил тутамд 61 хэрэг нэмэгдэх тооцоолол гарсан байна. Үндсэн тайланд дурдсанаар захиргааны хэргийн 1 шүүгч 1 жилд Улсын дунджаар 34 хэрэг шийдвэрлэж байгаа бөгөөд энэ тоог баримтлан Нийслэл дэх ЗХАШШ-д шаардлагатай шүүгчийн тоо тооцоход одоо ажиллаж байгаа шүүгч 18.5, шаардлагатай шүүгч 9.3 гэж гарсан. Нийт $18.5+9.3=27.8$ буюу 28 шүүгчийн орон тоо нь 2021 оны байдлаар шаардлагатай болсон шүүгчийн тоо юм. Иймд 2022-2026 онд шаардагдах тоог тооцож үзвэл жил тутамд 61 хэрэг нэмэгдэх зураг 3-р харуулсан тооцооллын дагуу ирэх 5 жилд $61*5=305$ хэрэг нэмэгдэж, $305/34=8.9$ буюу 5 жилийн дараа энэ шүүхэд дахин 9 шүүгч томилох шаардлага үүсэж, 2026 оны байдлаар энэ шүүхэд 37 шүүгч ажиллах хэрэгцээ, шаардлага үүсэхээр тооцоо гарч байна.

3.2. Аймаг


Аймаг дахь эрүү болон иргэний хэргийн АШШ-ийн шийдвэрлэсэн хэргийн тоонд хугацаанаас хамаарсан хандлагыг тооцохдоо хугацааны цувааны шинжилгээнд дата анализ ашиглан шугаман загвараар тодорхойлж үзэхэд дараах үр дүн гарлаа.

№	Шүүхийн нэр	эрүү			иргэн		
		нөлөөлөл хүчтэй	нөлөөлөл дунд	нөлөөлөл сул	нөлөөлөл хүчтэй	нөлөөлөл дунд	нөлөөлөл сул
1	Баян-Өлгий		0.4799				0.3341
2	Говь-алтай			0.1354			0.0648
3	Завхан			0.2152			0.0622
4	Увс			0.0003			0.1495
5	Ховд			0.2001			0.1533
6	Архангай			0.3294			0.3177
7	Баянхонгор	0.7463					0.3178
8	Булган			0.3394			0.1084
9	Орхон		0.5089			0.5852	
10	Хөвсгөл		0.5438				0.1664
11	Өвөрхангай			0.251			0.0778
12	Говь-сүмбэр		0.4374				0.0003
13	Дархан-Уул			0.0919			0.0338
14	Дорноговь		0.3753				0.0845
15	Дундговь			0.016			0.1621
16	Өмнөговь	0.7882					0.3397
17	Сэлэнгэ			0.0172		0.3727	
18	Төв		0.6883				0.3009
19	Дорнод		0.3901				0.24
20	Хэнтий			0.1936			0.0173
21	Сүхбаатар		0.6253				

Хүснэгт 217 Шийдвэрлэсэн хэрэгт нөлөөлөл хугацааны нөлөөлөл, аймаг дахь ЭХАШШ, ИХАШШ-ээр


Сум дундын 8 шүүх байрлаж байгаа 7 аймгийн шүүхийн хугацаанаас хамаарсан загварыг гаргахдаа тухайн аймагт нь багтааж тооцсон. Сум дундын шүүх нь 2014 оноос хойш статистик мэдээлэл бүртгэж эхэлсэн байна. Иймд энэ хугацаанаас хойших мэдээллийг аймгийн хэмжээн дэх мэдээллээс салгахад аймгийн төв дээр байрлаж байгаа шүүхийн 2014 оноос хойших үзүүлэлт бүгд огцом бууралттай, уналттай байгаа тул дата анализ ашиглан тооцоолол хийж байгаа 18 жилийн динамикийн хувьд сум дундын шүүхийн мэдээллийг салгах боломжгүй байна.

Хугацаанаас хамаарсан загварын утгыг тайлбарлахдаа детерминацийн коэффициент 70 дээш хувьтай бол нөлөөлөл хүчтэй, 35-70-ын хооронд дунд зэрэг, 30-аас доош бол сул гэж үзнэ. Иймд аймаг дахь ЭХАШШ-ийн хувьд нөлөөлөл хүчтэй гарсан Баянхонгор, Өмнөговь аймгуудын хувьд шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн тооны хандлагыг загварын утгын дагуу үр дүн болгон ашиглах боломжтой. Харин дунд болон сул хамааралтай шүүхүүдийн хувьд бусад шалтгаан, нөхцөлийг агуулсан хүчин зүйлсийг тодорхойлох нь чухал байна.



Зураг 4 Баянхонгор аймаг дахь СДЭХАШШ-ийн шийдвэрлэсэн хэргийн тооны хугацаанаас хамаарсан загвар

Энэ аймагт жил тутамд шийдвэрлэх эрүүгийн хэрэг 14 хэргээр нэмэгдэх тооцоолол гарсан байна. Үндсэн тайлангийн бүлэг 4-т дурдсан ажиллах шаардлагатай шүүгчийн тоог харвал 4.1 байна. Иймд жил тутамд дунджаар 14 хэрэг өсөхөд 5 жилийн дараа 2021 онд шийдвэрлэсэн 331 хэрэг хугацаанаас хамаарсан хандлагын дагуу 75 хувийн нөлөөтэйгөөр 401 орчим хэрэг болох тооцоо гарч байна. Үндсэн тайлангийн бүлэг 2-т дурдсанаар аймаг дахь СДЭХАШШ-ийн нэг шүүгч нэг жилд Улсын дунджаар 89 хэрэг шийдвэрлэж байгаа тооцоо гарсан тул энэ аймгийн хувьд ирэх 5 жилийн хугацаанд 4 шүүгч ажиллахаас гадна мөн 1 шүүгч тодорхой хугацаагаар томилолтоор ажиллах шаардлага үүсэхээр байна. Шийдвэрлэсэн хэрэг 445-д хүрснээр 5 дахь шүүгчийн орон тоог зарлан ажиллуулах хэмжээнд хүрэхээр байна.



Зураг 5 Өмнөговь аймаг дахь СДЭХАШШ-ийн шийдвэрлэсэн хэргийн тооны хугацаанаас хамаарсан загвар

Энэ аймагт жил тутамд шийдвэрлэх эрүүгийн хэрэг 14 хэргээр нэмэгдэх тооцоолол гарсан байна. Үндсэн тайлангийн бүлэг 4-т дурдсан ажиллах шаардлагатай шүүгчийн тоог харвал 2.1 байна. Иймд жил тутамд дунджаар 14 хэрэг өсөхөд 5 жилийн дараа 2021 онд шийдвэрлэсэн 284 хэрэг хугацаанаас хамаарсан хандлагын дагуу 79 хувийн нөлөөтэйгөөр 354 орчим хэрэг болох тооцоо гарч байна. Энэ аймгийн хувьд ирэх 5 жилийн хугацаанд 3 шүүгч ажиллахад хангалттай байна.

Энэ мэтчилэн иргэний болон захиргааны хэргийн загварыг тооцож үзвэл энэ загвараар шийдвэрлэх хэргийн тооны тооцоолол үр дүн, ач холбогдол багатай байх шүүхүүд олон тоогоор гарч байгаа тул зөвхөн хугацаанаас хамаарсан загвар тодорхойлох, түүний үр дүнгээр шийдвэрлэсэн хэргийн тооны цаашдын хандлагыг


эрүү, иргэн, захиргааны хэргийн анхан болон завж заалдах шатны шүүхэд тооцох боломжгүй гэдэг нь тодорхой байна. Аймаг дахь иргэний хэргийн шүүхэд хугацааны нөлөөлөл дунд болон сул байгаа тул шалтгаан, нөхцөлийг сайтар судлах шаардлагатай байна.

Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн хугацаанаас хамаарсан загварын үр дүнг хүснэгтээр харуулбал:

№	Шүүхийн нэр	захиргаа		
		нөлөөлөл хүчтэй	нөлөөлөл дунд	нөлөөлөл сул
1	Баян-Өлгий		0.6007	
2	Говь-алтай		0.6663	
3	Завхан			0.3129
4	Увс		0.5748	
5	Ховд		0.5342	
6	Архангай		0.5627	
7	Баянхонгор	0.7678		
8	Булган		0.4489	
9	Орхон			0.0679
10	Хөвсгөл			0.1583
11	Өвөрхангай			0.0402
12	Говь-сүмбэр			0.2424
13	Дархан-Уул			0.3044
14	Дорноговь		0.5082	
15	Дундговь		0.5112	
16	Өмнөговь		0.5389	
17	Сэлэнгэ		0.3546	
18	Төв	0.7214		
19	Дорнод			0.3162
20	Хэнтий			0.217
21	Сүхбаатар			0.2433


Хүснэгт 218 Шийдвэрлэсэн хэрэгт нөлөөлөл хугацааны нөлөөлөл, аймаг дахь ЗХАШШ-ээр

Загварын үр дүнг тайлбарлавал Баянхонгор болон Төв аймаг дахь ЗХАШШ-ийн шийдвэрлэсэн хэргийн тоонд хугацаанаас хамаарсан нөлөөлөл хүчтэй байна. Иймд эдгээр шүүхэд жил ирэх тутам шийдвэрлэсэн хэргийн тоо өсөх хандлагатай бөгөөд загварын утгыг дараах зургаар харуулбал:



Зураг 6 Баянхонгор аймаг дахь ЗХАШШ-ийн шийдвэрлэсэн хэргийн тооны хугацаанаас хамаарсан загвар

Энэ аймагт жил тутамд шийдвэрлэх захиргааны хэрэг 2 хэргээр нэмэгдэх тооцоолол гарсан байна. Үндсэн тайлангийн бүлэг 4-т дурдсан ажиллах шаардлагатай шүүгчийн тоог харвал 0.9 байна. Иймд жил тутамд дунджаар 2 хэрэг өсөхөд 5 жилийн дараа 2021 онд шийдвэрлэсэн 35 хэрэг хугацаанаас хамаарсан хандлагын дагуу 76 хувийн нөлөөтэйгөөр 45 орчим хэрэг болох тооцоо гарч байна. Үндсэн тайлангийн бүлэг 2-т дурдсанаар ЗХАШШ-ийн нэг шүүгч нэг жилд Улсын дунджаар 34 хэрэг шийдвэрлэж байгаа тооцоо гарсан тул энэ аймгийн хувьд ирэх жилүүдэд 1 шүүгч ажиллахаас гадна мөн 1 шүүгч тодорхой хугацаагаар томилолтоор ажиллах шаардлага үүсэхээр байна.



Зураг 7 Баянхонгор аймаг дахь ЗХАШШ-ийн шийдвэрлэсэн хэргийн тооны хугацаанаас хамаарсан загвар

Энэ аймагт жил тутамд шийдвэрлэх захиргааны хэрэг 2.2 хэргээр нэмэгдэх тооцоолол гарсан байна. Үндсэн тайлангийн бүлэг 4-т дурдсан ажиллах шаардлагатай шүүгчийн тоог харвал 1.2 байна. Иймд жил тутамд дунджаар 2.2 хэрэг өсөхөд 5 жилийн дараа 2021 онд шийдвэрлэсэн 46 хэрэг хугацаанаас хамаарсан хандлагын дагуу 72 хувийн нөлөөтэйгөөр 57 орчим хэрэг болох тооцоо гарч байна. Үндсэн тайлангийн бүлэг 2-т дурдсанаар ЗХАШШ-ийн нэг шүүгч нэг жилд Улсын дунджаар 34 хэрэг шийдвэрлэж байгаа тооцоо гарсан тул энэ аймгийн хувьд ирэх жилүүдэд 2 шүүгч ажиллахаар төлөвлөх эсвэл 1 шүүгч дээр мөн нэг шүүгчийг 3 улирлын хугацаатай томилолтоор ажиллуулах бодлого баримтлах нь зохимжтой байна.

Явцын дүгнэлт

Шинжилгээнд өгсөн 18 жилийн динамиктай өгөгдлөөс аймаг дахь шүүхүүдийн өгөгдөлд хугацаанаас хамаарсан загварыг тооцох боломжтой байсан. Харин нийслэлийн хэмжээнд Нийслэл дэх ЗХАШШ-ийн тооцоолол мөн дүүргийн шүүхийн хэмжээнд нэгтгэн тооцооллыг хийх боломжтой байна.

№	Шүүх	нөлөөлөл хүчтэй байгаа шүүх /70-100%/	нөлөөлөл дунд зэрэг байгаа шүүх /35-69%/	нөлөөлөл сул байгаа шүүх /0-34%/
---	------	---------------------------------------	--	----------------------------------

1	Аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн АШШ	Баянхонгор, Өмнөговь	Баян-Өлгий, Орхон, Хөвсгөл, Говьсүмбэр, Дорноговь, Төв, Дорнод, Сүхбаатар	Говь-алтай, Завхан, Увс, Ховд, Архангай, Булган, Өвөрхангай, Дархан-Уул, Дундговь, Сэлэнгэ, Хэнтий
2	Аймаг дахь Сум дундын иргэний хэргийн АШШ	-	Орхон, Сэлэнгэ	Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Увс, Ховд, Архангай, Баянхонгор, Булган, Хөвсгөл, Өвөрхангай, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Төв, Дорнод, Хэнтий, Сүхбаатар
3	Аймаг дахь Захиргааны хэргийн АШШ	Баянхонгор, Төв	Баян-Өлгий, Алтай, Увс, Ховд, Архангай, Булган, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Сэлэнгэ	Завхан, Орхон, Хөвсгөл, Өвөрхангай, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорнод, Хэнтий, Сүхбаатар
4	Нийслэл	Нийслэл дэх ЗХАШШ	-	-

Хүснэгт 219 АШШ-ийн шийдвэрлэсэн хэргийн тоонд хугацаанаас хамаарсан нөлөөллийн хүч

Шинжилгээнээс харахад шийдвэрлэсэн хэргийн тоо нь Улсын дүнгээр тооцсон тооцоонд хугацаанаас хамаарсан нөлөөлөл хүчтэй байна. Харин орон нутгийн хэмжээн дэх дүнг салгаж, шүүх бүрээр тооцоход нөлөөлөл хүчтэй шүүхүүд цөөхөн байна. Энэ нь **нийслэлийн хувьд эрүү, иргэн, захиргааны хэргийн дүн өндөр, жилээс жилд өсөх хандлагатай болохыг илэрхийлж байгаа бол эсрэгээрээ орон нутгийн шүүхүүдэд шийдвэрлэсэн хэргийн тоо хугацаанаас хамаарч өснө эсвэл буурна гэсэн тооцооллыг шууд гаргах боломжгүй гэдгийг харуулж байна.**

Хугацаанаас хамаарсан нөлөөлөл хүчтэй байгаа шүүхүүдийн хувьд загварын үр дүнгээр шийдвэрлэсэн хэргийн тооны хандлагыг тооцож, судалгааг ашиглах боломжтой байгаа бол **нөлөөлөл дунд болон сул хамааралтай шүүхүүдийн хувьд хугацаанаас хамаарсан загвараас гарсан үр дүнг ашиглах боломж хязгаарлагдмал байна.** Эрүүгийн мөн захиргааны хэргийн хувьд Баянхонгор аймаг дахь шүүхийн шийдвэрлэсэн хэргийн тооны хугацаанаас хамаарсан загварын хамаарал 70 дээш хувийн буюу хүчтэй нөлөөтэй байна. Эндээс дүгнэхэд энэ аймгийн эрүү болон захиргааны хэргийн шүүхийн шийдвэрлэсэн хэргийн тоог прогноз хийж тооцоход бидэнд байгаа хугацааны мэдээлэл дангаараа 70 хүртэлх хувийг тайлбарлах боломжтой, өөрөөр хэлбэр жилээс жил гэсэн хугацаа нь өөрөө шийдвэрлэсэн хэргийн тоогоо тодорхойлох боломжийг 70 хүртэл хувьтай өгч чадаж байна.

Шүүхийн статистикаас харахад эрүү, иргэн, захиргааны аль ч хэрэгт хугацааны нөлөө бага, ихэнхдээ байхгүй шахам болох нь харагдаж байна. Иймд хэрэг, маргааны гаралт, шалтгаан нөхцөлийг судалдаг криминологи болон хууль зүйн салбарын бусад судалгаа, ялангуяа эрх зүйн орчны өөрчлөлт, хөгжил, хуулийн бусад байгууллагын бүтэц, үйл ажиллагаа, гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх бодлого, хүн амын шилжилт хөдөлгөөн, ял шийтгүүлэгчийн онцлог, хууль, эрх зүйн үр дагавар бүхий нийгэм, олон нийтийг хамарсан үзэгдэл гэх

мэтээс хамаарч шийдвэрлэсэн хэргийн тоо жилээс жилд огцом хэлбэлздэг гэсэн дүгнэлтийг хийхэд хүргэж байна. **Өөрөөр хэлбэл хэрэг, маргааны гаралт үүний улмаас шүүхийн үйл ажиллагаа, шийдвэрлэсэн хэргийн тоо зэрэг нь өөрийн хэвийн зүй тогтлоороо явагддаг үзэгдэл биш болох нь тодорхой байна.**

Иймд шийдвэрлэсэн хэргийн тоо зэрэг шүүхийн статистикийн тулгуур үзүүлэлтүүдийг яв цав хэд хэчнээн болохыг урьдчилан тооцож, таамаглах боломж манай үндэсний онцлог болон нийгмийн бусад үзэгдлээс шалтгаан хязгаарлагдмал байдалтай байна.

Цаашид шийдвэрлэсэн хэргийн тооны хандлагыг тодорхойлох ажилд шүүх бүрийн үйл ажиллагааны онцлог, энэ нь шүүхийн тамгын газар, ажилтнууд, шүүгчдээс хамаарсан, мөн шүүхээр үйлчлүүлж байгаа талаас хамаарсан, бусад хүчин зүйлээс хамаарсан гэж үзвэл энэ бүрийг тухайн шүүх нутаг дэвсгэрийн нэгжийн онцлогт тулгуурлан судлах, тодорхойлох, энэ төрлийн мэдээллийг ШЕЗ шүүхүүдээс тайлан болон бусад хэлбэрээр хүлээн авч дүгнэх, нэгтгэх, **мэдээ тайланг гаргахдаа тухайн жилийн шүүхийн үйл ажиллагааны онцлог, шалтгаан, нөхцөлийн талаарх мэдээллийг хамтад нь авч үзэж, статистик үзүүлэлтэд дүн шинжилгээгээ хийхдээ эдгээрийг ашиглах нь мэдээллийг тодорхой, ойлгомжтой, учир шалтгаантай, үнэн зөв өгөхөөр байна.**

Мөн түүнчлэн маргааны төрөл нь статистик үзүүлэлт болдог иргэн, захиргааны хэргийн хувьд маргааны төрөл тус бүрд ямар тохиолдлуудыг ойлгох талаар тодорхой зааварчилгаа тогтмол өгөх, нэг нэхэмжлэлд хэд хэдэн шаардлага агуулагдаж, түүнд нь хэд хэдэн маргаан хамаарч байгаа нөхцөлд шийдвэрлэсэн хэргийн маргааны төрлийг нэг л үзүүлэлт болгон хэргийн хөдөлгөөний систем, цахим сан, бусад санд мэдээллийг тоолж бүртгэж, ангилах эсэхийг захиргааны ажилтанд нэгдсэн ойлголт давтамжтайгаар өгөхгүй бол шинэ тутам ажилтан байх, эсвэл ойлголт, заавар дутагдалтай байдлаас шалтгаалан маргааны төрлийг андуурч бүртгэх зэрэг шалтгаанаар жил бүрийн дүн хооронд хэлбэлзэл үүсэхийг ч үгүйсгэхгүй юм.

Өмнө нь батлагдсан Шүүх байгуулах тухай хуулиудаас шалтгаалан шийдвэрлэсэн хэргийн тоо шүүх бүрийн тоогоор, засаг захиргааны нэгж тус бүрийн хэмжээнд гарах эсвэл тойргийн журмаар байгуулагдсан шүүхүүдийн мэдээлэл нэгтгэгдэж нэг гаргах гэх мэтээр харилцан адилгүй тоолж бүртгэх арга зүйтэй байжээ. Үүнээс шалтгаалан зарим шүүхийн хувьд шинжилгээ хийгдэх боломжгүй нөхцөлд хүрч байна. **Гэтэл статистик аливаа мэдээлэл нь засаг захиргааны нэгж, бүтцээр бүртгэгдэж, тоологдож ирсэн байна. Иймд цаашид шүүхийн бүтэц, тогтолцоо өөрчлөгдсөн ч засаг захиргааны нэгж бүрээр, шүүх бүрээр мэдээлэл гарах, эдгээр мэдээллээс дахин боловсруулалт хийж хэд хэдэн нэгжийг дараагийн шатанд нэгтгэх зэргээр анхдагч мэдээллээ заавал задгай нэгжээр авч байх, дараа нь баазаа бүрдүүлэхдээ нэгж бүр, мөн шүүхийн үйл ажиллагааны онцлогоос шалтгаалан шүүх байгууллагын бүтэц рүү шилжүүлж нэгтгэх ажлыг шүүхийн захиргааны бодлогын хүрээнд анхаарч хэвшүүлэх шаардлага байгаа нь ажиглагдлаа.**

Шүүх бүрийн шийдвэрлэсэн хэргийн тоо харилцан адилгүй, дараалсан жилүүдэд хэлбэлзэл ихтэй, загвар тооцоход хүндрэлтэй, хуулийн болон магадгүй тоолох бүртгэх арга ажиллагаанд нөлөөлөл ихтэй байгаа байдал ажиглагдаж байна. Энэ тохиолдолд зөвхөн хугацаанаас хамаарсан хандлагыг тодорхойлох нь төдийлөн ач холбогдол багатай байна. Харин 2021 онд гаргах бодлого, шийдвэрийн хувьд сүүлийн 5 жилийн хувьд судалсан үндсэн тайлангийн 3-р бүлэг “Гол хэсгийн шинжилгээ”-гээр дүүрэг, аймаг, сум дунд, давж заалдах шатны шүүхэд ажилладаг 1 шүүгчид ногдох эрүү, зөрчил, иргэн, захиргааны хэрэг нэг жилд хэдээр нэмэгдэж байгаа үр дүн, мөн 4-р бүлгийн “шаардлагатай шүүгчийн тооны тооцоог”-г ашиглах боломжтой байна. Мөн түүнчлэн шийдвэрлэсэн хэргийн тооны өөрчлөлтийн шалтгаан, нөхцөлийг тодруулах шаардлага үүсэж байна.

Дөрөв. Шийдвэрлэсэн хэргийн тооны өөрчлөлтийн шалтгаан, нөхцөл

- **Эрүүгийн хэрэг**

Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүд сүүлийн 18 жилийн хугацаанд **138761** хэргийг хянан шийдвэрлэсэн байна.

Огноо	Шийдвэрлэсэн хэрэг	Өсөлт, бууралт	Хувь	Ерөнхий шалтгаан нөхцөл
2004 он	6272	398	6.8	Тухайн тайлант хугацаанд хүлээн авсан хэргийн тоо өмнөх оноос 7.8 хувиар өссөн нь нөлөөлсөн байна.
2005 он	6966	694	11.1	Тухайн тайлант хугацаанд хүлээн авсан хэргийн тоо өмнөх оноос 11.1 хувиар өссөн нь нөлөөлсөн байна.
2006 он	5558	-1408	-20.2	Өршөөл үзүүлэх тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор 393 хэргийг өршөөн хэрэгсэхгүй болгож, 102 хэргийг цагаатгах тогтоолоор тус шийдвэрлэсэн нь хянан шийдвэрлэсэн хэргийн тоо буурахад нөлөөлсөн байж болох юм. Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн байгууллага дээр ажлын хэсэг гарч шууд тогтоолоор шийдвэрлэдэг байсан ба энэ нь хянан шийдвэрлэсэн хэрэгт орж тооцогдохгүй тусдаа мэдээлдэг байсан байна. Энэ 20.2 хувиар буурахад нөлөөлсөн байна. Таслан шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг Хэнтий, Говь-Алтай, Сүхбаатар, Дорнод, Орхон, Дорноговь, Өвөрхангай, Өмнөговь, Дундговь, Завхан, Дархан-Уул, Булган, Төв, Нийслэл, Увс, Сэлэнгэ, Архангай, Хөвсгөл аймагт 0.39-38.6 хувиар буурч, Баянхонгор, Баян-Өлгий, Говьсүмбэр, Ховд аймагт 0.8-24.07 хувиар нэмэгджээ.
2007 он	5831	273	4.9	Бүртгэгдсэн болон илрүүлсэн хэргийн тоо өмнөх оноос 16.5 хувиар өссөн бөгөөд хүлээн авсан хэргийн тоо мөн 1.4 хувиар өссөн нь нөлөөлсөн байна.
2008 он	5812	-19	-0.3	Дэлхийн санхүүгийн хямрал оны сүүлээс эхэлсэн.
2009 он	5407	-405	-7.0	Татварын өршөөлийн тухай хууль өмнөх онд хэрэгжсэнтэй холбоотойгоор буурсан. Оюу толгойн гэрээ оны сүүлээр зурагдсан нь эдийн засгийн ерөнхий байдал сэргэсэн ч өмнөх онд 8.9 байснаас 1.9 хувиар буурсан байна ¹³ . Бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо буурсан ¹⁴ . Боловсруулах салбарын хөдөлмөр эрхлэлт буурч, уул уурхай, олборлох салбарын хөдөлмөр эрхлэлт өсөх хандлагатай болж ирсэн ¹⁵ . Төсвийн алдагдал сайжирч, орлогын бүрдүүлэлт муу. Анод банкны хадгаламж эзэмшигчдэд Монгол Банк

¹³ <https://www.mongolbank.mn/documents/moneypolicy/worldbank/2009-12.pdf>

¹⁴ Эх сурвалж Үндэсний статистикийн хороо

¹⁵ Эх сурвалж Үндэсний статистикийн хороо

				127 тэрбум төгрөг төлж барагдуулсан, Зоос банкны бүтцийн өөрчлөлт зориулж Засгийн газраас 100 тэрбум төгрөгийн бонд гаргах шийдвэрийг УИХ-аас баталсан. 2008 оны сүүл, 2009 он бүхэлдээ ашигт малтмалын үнэ бууж, эдийн засгийн өсөлт 1993 оноос хойш анх удаа хасахтай гарсан.
2010 он	5460	53	1.0	Гэмт хэргийн илрүүлэлт 59.9 хувь болж өмнөх оноос 5.0 хувиар өссөн нь нөлөөлсөн байна.
2011 он	5877	417	7.6	Гэмт хэргийн илрүүлэлт 61.5 хувь болж 1.6 хувиар өссөн, мөн хүлээн авсан хэргийн тоо 404 хэргээр өссөн нь нөлөөлсөн байна. байна.
2012 он	6161	284	4.8	Гэмт хэргийн илрүүлэлт 56.3 хувь болж өмнөх оноос 5.2 хувиар буурсан ч хүлээн авсан хэргийн тоо 289 хэргээр мөн адил өссөн байна.
2013 он	6169	8	0.1	Шүүхийн тухай багц хууль батлагдан мөрдөгдсөн.
2014 он	6375	206	3.3	Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд зааснаас өөрөөр буюу жишээлбэл Төв аймгийн зарим сумд өөр шүүхийн харьяанд очиж хэрэг маргаан шийдсэнтэй холбоотой зарим шүүхүүдийн хянан шийдвэрлэсэн хэрэг маргаан өссөн, зарим нь буурсан байна.
2015 он	6756	381	6.0	Баянзүрх, Чингэлтэй, Баянгол дүүргүүдэд гэмт хэргийн илрүүлэлт 3.3-28.6 хувиар өссөн нь хянан шийдвэрлэсэн хэрэг өсөхөд нөлөөлсөн гэж үзэж үзэж болох юм ¹⁶ .
2016 он	5762	-994	-14.7	2015 оны Өршөөл үзүүлэх тухай хуультай холбоотойгоор хянан шийдвэрлэлт өмнөх онд 3.3 хувиар өссөн ба хуулийн үр нөлөөгөөр гэмт хэргийн гаралт, шийдвэрлэлт буурсан дүнтэй гарсан гэж үзэхээр байна.
2017 он	8839	3077	53.4	Эрүүгийн хууль /2015 он/-ийн шинэчилсэн найруулга 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн бөгөөд энэ хуулийн гол зохицуулалт эрүүгийн хэрэг үүсгэсэн бол хэргийг зөвхөн шүүх эцэслэн шийдвэрлэнэ гэсэн зохицуулалт орж ирснээр хэрэг шийдвэрлэлт огцом өссөн.
2018 он	12551	3712	42.0	
2019 он	13427	876	7.0	Дээрх хуулийн үйлчлэл тогтворжиж хэргийн өсөлт тогтворжсон гэж үзэхээр байна.
2020 он	13470	43	0.3	
2021 он	12068	-1402	-10.4	Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахалтай холбоотой хүлээн авсан хэрэг 9 хувиар, хянан шийдвэрлэсэн хэрэг 10.4 хувиар тус тус буурсан байна.
Нийт	138761	126693		

Хүснэгт 220 Хянан шийдвэрлэсэн хэргийн тоо, оноор

1. Эрх зүйн орчны хувьд

А. Эрүүгийн хуульд 2004-2021 оны хугацаанд:

- 2004 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн нэмэлт өөрчлөлт,
- 2007 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн өөрчлөлт,
- 2008 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн нэмэлт, өөрчлөлт,
- 2008 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн нэмэлт, өөрчлөлт,
- 2011 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн нэмэлт, өөрчлөлт,
- 2012 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн нэмэлт, өөрчлөлт,
- 2014 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн нэмэлт, өөрчлөлт,
- 2015 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн нэмэлт өөрчлөлт,
- 2016 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн нэмэлт, өөрчлөлт,

¹⁶ Үндэсний статистикийн хороо. Гэмт хэрэг -2015. 16-р хуудас.

Эх сурвалж: https://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=crime_2015.pdf&ln=Mn

- 2017 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн нэмэлт, өөрчлөлт,

- 2017 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн нэмэлт өөрчлөлт,

Нийт 11 удаагийн нэмэлт өөрчлөлт орсноос хамгийн олон, хамгийн том нэмэлт өөрчлөлт 2008 онд орсон байна.


2002 оны Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2008 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн хуулиар Эрүүгийн хуулийн 163 дугаар зүйл /Хууль бусаар олж авсан эд хөрөнгө, мөнгийг ашиглах/, 167 дугаар зүйл /Татвар ногдуулалт, төлөлтөд хяналт тавих, татвар хураах тухай хууль тогтоомж зөрчих/, 239 дүгээр зүйл /Төрийн дайчилгаанаас зайлсхийх/, 267 дугаар зүйл /Албан тушаалтны нэр барих/, 272 дугаар зүйл /Албан тушаалтан албан үүрэгтээ хайнга хандах/, 103 дугаар зүйл /Бэлгийн замын халдварт өвчин халдаах/-ийн 1 дэх хэсэг, 155 дугаар зүйл /Гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгийг авах, борлуулах/-ийн 2 дахь хэсэг, 230 дугаар зүйл /Төрийн албан хаагч, хэв журам хамгаалах олон нийтийн байцаагчийг эсэргүүцэх/-ийн 1 дэх хэсгийг тус тус гэмт хэрэгт тооцохгүй болсон тул эдгээр зүйлд заасан гэмт хэрэг үйлдэн шүүхээр ял шийтгүүлж, ял эдэлж байгаа хүмүүсийг эдлээгүй үлдсэн үндсэн болон нэмэгдэл ялаас чөлөөлнө гэсэн заалтын хүрээнд 8 зүйл заалтад заасан гэмт хэргийг гэмт хэрэгт тооцохгүй болсонтой холбоотойгоор ял эдэлж байгаа, эдлээгүй үлдсэн ял, нэмэгдэл ялаас чөлөөлөхөөр болсон. Ингэхдээ яллагдагчийг шүүхэд шилжүүлсэн бол шүүх хуралдаанаар хэрэгсэхгүй болгох, үүнээс өмнөх шатанд шалгаж байгаа бол харьяалах прокурорын тогтоолоор болон шүүгчийн захирамжаар тус тус хэрэгсэхгүй болгож шийдвэрлэхээр зохицуулсан байна¹⁷.

Мөн 2008 оны 2 дугаар сарын 1-ний өдөр нэмэлт, өөрчлөлт оруулсан Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 55¹ дугаар зүйлийн 55¹.1-д заасан "...хорих ялын доод хэмжээний гуравны хоёроос хэтрэхгүй байна", 62¹ дугаар зүйлийн 62¹.1-д заасан "...хорих ялын доод хэмжээний хоёрны нэгээс хэтрэхгүй байна" гэснийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн тухайн зүйл, хэсэгт хорих ялын доод хэмжээг заасан тохиолдолд л хэрэглэнэ" гэсэн зохицуулалт оруулж өгсөн нь 2002 оны эрүүгийн хуульд заасан хорих ялын доод хэмжээг шүүгч хэргийн онцлог шүүгдэгчийн хувийн байдлаас шалтгаалан хорих ялын хугацааг доош нь татаж, хөнгөрүүлэх боломж хуулиар хязгаарлагдсан байсныг өөрчилсөн онцлог зохицуулалт болсон байна.

Мөн 2015 онд батлагдсан ч хэрэгжиж эхлээгүй байсан Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад 2017 онд өөрчлөлт оруулж 2017 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн байна. Энэ хуулиар зарим төрлийн гэмт хэргийг зөрчлийн хэрэгт тооцон, Зөрчлийн тухай болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиар шийдвэрлэхээр хэргийн харьяаллыг салгаж тогтоож өгсөн. Мөн үйлдэл тус бүрт нь хариуцлага тооцох зарим энэ хуулиар хэрэгжиж эхэлсэн бөгөөд нэг хүнд 2 ба түүнээс дээш төрлийн ял оногдуулж эдлүүлж болохоор хуульчилсан. Мөн хуулийн этгээдийн хариуцлагын асуудлыг тодорхойлж хуульчилж өгсөн.

¹⁷ Улсын дээд шүүхийн 2008 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 10 дугаар тогтоол /http://www.supremecourt.mn/files/20220/0_1641284222.pdf/

Түүнчлэн энэ хуулийн бас нэг онцлог гол зохицуулалт нь Эрүүгийн хэрэг үүсгэсэн бол бүх хэрэг шүүх эцэслэн шийдвэрлэхээр зааж өгсөн нь Эрүүгийн хэргийн шүүхүүдэд тэр хэрээр ачаалал нэмж өгсөн байна. Энэ нь жил бүр хянан шийдвэрлэсэн хэргийн тоо огцом өсөлттэй буюу 2004-2016 оны хооронд дунджаар эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 6031¹⁸ хэрэг байсан бол 2017-2021 оны 5 жилийн дундаж хэрэг нь 12071¹⁹ хэрэг болж даруй 2 дахин өссөн дүнтэй гарсан байна. Шинжилгээ хийж үзэхэд хугацааны хувьд хянан шийдвэрлэсэн хэрэгт 58 хувийн хүчин зүйлийн хамааралтай байна гэж гарч байна.




Зураг 8. Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрлэсэн хэрэг

Б. Шүүх байгуулах тухай хуульд 2013, 2015, 2016, 2018, 2021 онуудад нэмэлт өөрчлөлт болон шинэчилсэн найруулга хийгдэж байсан. 2013 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс хэрэгжиж эхэлсэн Шүүх байгуулах тухай хуульд анхан шатны шүүхийн нутаг дэвсгэрийн харьяаллыг засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд зааснаас өөрөөр буюу тухайлбал сум дундын 6-р шүүхийн нутаг дэвсгэрийн харьяалалд Говьсүмбэр аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж, Дорноговь аймгийн Айраг, Даланжаргалан сумд болон Дундговь аймгийн Баянжаргалан, Цагаандэлгэр сумдыг хамааруулсан нь энэ шүүхийн хянан шийдвэрлэсэн хэргийн тоо өсөх нөхцөлийг бүрдүүлжээ. 2004-2013 оныг хүртэлх хугацаанд Говьсүмбэр аймгийн эрүүгийн хэргийн шүүх жилд дунджаар 49.7 хэрэг хянан шийдвэрлэж байсан бол 2014-2016 оны хугацаанд дээрх хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэнтэй холбоотой жилд дунджаар 65.6 хэрэг хянан шийдвэрлэсэн байна. Харин 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хянан шийдвэрлэсэн хэрэг 2017-2021 оны хугацаанд хуулийн үр нөлөөгөөр жилд дунджаар 99.2 хэрэг хянан шийдвэрлэсэн байна.


¹⁸ 2004-2016 оны хугацаанд Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүдийн шүүн таслах ажиллагааны мэдээ, хянан шийдвэрлэсэн хэргийн дундаж

¹⁹ 2017-2021 оны хугацаанд Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүдийн шүүн таслах ажиллагааны мэдээ, хянан шийдвэрлэсэн хэргийн дундаж



Зураг 9 Төв аймгийн СДЭХАШШ-ийн шийдвэрлэсэн хэргийн тоо

В. Өршөөл үзүүлэх тухай хууль 2004-2021 оны бүтэн жилийн хугацаанд хууль 2006, 2009, 2015, 2021 онуудад батлагдсан ба 2008 онд Татварын өршөөл үзүүлэх тухай хууль нийтдээ сүүлийн 18 жилийн хугацаанд 5 удаагийн Өршөөлийн тухай хууль батлагдан хэрэгжсэн байна. Өршөөл үзүүлэх тухай гарсан жилдээ шүүхийн ажиллагааны болон хэргийн ачаалал нэмэгдэж шүүн таслах ажиллагааны мэдээ өсөлттэй гардаг ч дараа жилд нь хэргийн шийдвэрлэлт буурдаг ерөнхий зураглалыг гарч байна.



Зураг 10 Өршөөл үзүүлэх тухай хуулийн үзүүлэх нөлөөлөл

2015 оны Өршөөлийн хуулиас өмнө Өршөөл үзүүлэх тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хэсэг Шийдвэр гүйцэтгэх байгууллага дээр байгуулагдаж ажилладаг байсантай холбоотойгоор зарим жилд хэрэгжсэн Өршөөл үзүүлэх тухай хуульд хамрагдсан талаарх шийдвэрлэлт шүүхийн хянан шийдвэрлэсэн хэрэгт тооцогддоггүй байсан байна. Энэ нь өмнөх жилүүдэд хянан шийдвэрлэсэн Өршөөлийн хуультай хэрэгжсэн зарим жилүүдэд эсрэгээрээ бууралттай гарч байгаа тохиолдол байна.

3. Цагдаагийн байгууллагаас авч хэрэгжүүлсэн аян, арга хэмжээний үр дүн нөлөөлөл

Цагдаагийн ерөнхий газраас болон цагдаагийн 2017-2021 оны бүтэн жилд 33 удаагийн аян, арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байна²⁰. Жишээлбэл:



- Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх “Хайрла, хамгаал” аян, “Хайр өвтгөдөггүй” соён гэгээрүүлэх арга хэмжээ;



Цахим орчин дахь гэмт хэрэгт өртөхөөс сэргийлэн “Unfriend” хөдөлгөөн; Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх “Нэг хором” аян;



Хүүхдийн эсрэг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх “Зөв тусгал” аян;

-Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг зөрчлийн шалтгаан нөхцөл, урьдчилан сэргийлэх хүрээнд “Яараад яахав дээ”, “Дураараа бишээ дүрмээрээ” аяныг тус тус хэрэгжүүлсэн нь хамгийн их үр дүнтэй олон нийтэд хүрсэн аян; “Орон нутгийн зам-Хөдөлгөөний соёл” нэгдсэн арга хэмжээ;



Залилах гэмт хэргийн шалтгаан нөхцөл арилгах, урьдчилан сэргийлэх чиглэлээр “Ятгах тусам нягтал”, “Нягтлах тусам аюулгүй” нөлөөллийн аян 3 удаа,


- Хулгайн гэмт хэргийн гаралт ихэсдэгтэй холбоотой “Сар шинэ-2020”, Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан

сэргийлэх арга хэмжээ, “Мал мах 2021” арга хэмжээ, “Байна уу байна” аян, арга хэмжээ;

- Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Байгалиа хамгаалъя” нэгдсэн арга хэмжээ жил бүр, “Угаарын хийгээс урьдчилан сэргийлье” “Алдвал галдана” арга хэмжээ, “Хогоор бүү хорло” хэсэгчилсэн арга хэмжээ; “Ирлээ, Явлаа Цэвэр” арга хэмжээ;
- Өсвөр насны хүүхдийн гэмт хэрэг зөрчилд холбогдон, эсхүл хохирогч болж буй шалтгаан нөхцөлийг арилгах чиглэлээр “Сүүдэр бүү тусга” соён гэгээрүүлэх арга хэмжээ;
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр – Аюулгүй ажиллагаа-Амьдралын баталгаа” арга хэмжээ, “Бид нэг амьтай шүү” хэсэгчилсэн арга хэмжээ;
- Хүн худалдаалах гэмт хэргийн эсрэг “Мөрөөдлийн шүхэр” мэдээллийн аян;
- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэргийн эсрэг “Цахим хяналт” хэсэгчилсэн арга хэмжээ, “Цахим нөлөөлөл” хэсэгчилсэн арга хэмжээ гэх мэт аян арга хэмжээнүүдийг сүүлийн жилүүдэд маш эрчимтэй авч хэрэгжүүлсэн байна.

²⁰ Эх сурвалж Цагдаагийн ерөнхий газрын тайлан

Дээрх аян, арга хэмжээ нь зарим төрлийн гэмт хэргийн гаралт, бүртгэлтэд тодорхой хэмжээгээр нөлөөлсөн гэж үзэж болохоор байна. Жишээлбэл сүүлийн жилүүдэд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн хүлээн авч, хянан шийдвэрлэсэн хэрэг тогтмол өсөлттэй гарч байна. Мөн дээрх аяны хүрээнд илрүүлэлт шийдвэрлэлт нэмэгдэхийн хэрээр эргээд зарим тодорхой төрийн гэмт хэргийн гаралт буурч байгаа эерэг нөлөөлөл харагдаж байна. Тухайлбал замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг авч хэрэгжүүлсэн арга хэмжээний хүрээнд энэ төрлийн гэмт хэрэг жил ирэх бүр буурах хандлагатай байна.



Зураг 11 Зарим төрлийн гэмт хэргийг шийдвэрлэсэн тоо

4. Нийгэм эдийн засгийн нөлөөлөл

Эдийн засгийн таатай нөхцөл байдлаас шалтгаалан гэмт хэргийн төрөл өөрчлөгдөх тохиолдол байна. Мөн дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын үр нөлөөгөөр сүүлийн 2 жилийн хугацаанд хилийн дэглэм зөрчих, хилээр хууль бусаар барааг нэвтрүүлэх гэмт хэргийн гаралт шийдвэрлэлт огцом буурсан байна. Мөн хөл хорионы дэглэм тавьсан байсантай холбоотойгоор хулгайлах, дээрэмдэх гэмт хэргийн гаралт, шийдвэрлэлт буурсан бол эсрэгээр хүний бэлгийн эрх чөлөөнд халдах гэмт хэрэг тэр дундаа хүчиндэх гэмт хэрэг, хүний эрүүл мэндийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг үүн дотроо гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн бүртгэгдсэн, шийдвэрлэгдсэн тоо өсөлттэй гарсан байна. Хүлээн авсан хэрэг болон шийдвэрлэсэн хэрэг буурч, харин үлдэгдэл хэрэг өссөн зураглалд Ковид-19 цар тахалтай холбоотойгоор хөл хориотой байх үеийн нөлөөлөл орсон гэж үзэж болохоор байна.

5. Бүс нутгийн онцлог, гэмт хэргийн төрөл, шалтгаан

Хүний амь бие эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг гаралтыг авч үзвэл 2012-2015 оны хугацаанд Баруун бүсэд /Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Увс, Ховд/ дунджаар жилд 636.2 хэрэг бүртгэгдэн шийдвэрлэгдэж байгаа бол Төвийн бүсэд /Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Сэлэнгэ, Төв/ 1367 хэрэг бүртгэгдэн шийдвэрлэгдэж байна.²¹ Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг баруун бүсэд жилд дунджаар 583.5 хэрэг бүртгэгдэж байгаа бол Хангайн бүсэд /Архангай, Баянхонгор, Булган, Орхон, Өвөрхангай, Хөвсгөл/ 1274.2 хэрэг бүртгэгдэж байна. Харин Төвийн бүсэд 1395 хэрэг бүртгэгдэн шалгагдсан байна.

2012-2020 оны байдлаар Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийг бүртгэгдсэн тоогоор авч үзвэл жилд дунджаар 14502 хэрэг бүртгэгдэж байна. Үүнээс баруун

²¹ Монгол Улсын статистикийн эмхэтгэл 2015 /<https://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=Yearbook2015.pdf&ln=Mn/>

бүсийн бүртгэгдсэн өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн тоо 617.1 байгаа бол хангайн бүсийн бүртгэгдсэн гэмт хэргийн тоо 1472.2, төвийн бүсийн бүртгэгдсэн өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн тоо 1451.5, зүүн бүсийн өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн тоо 737.4 байна.

Огноо	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он
Улсын дүн	9023	11118	12551	13445	13336	18176	22468	18341	12061
Баруун бүс	589	555	573	617	561	625	668	786	580
Баян-Өлгий	137	70	80	104	71	101	131	139	135
Говь-Алтай	74	60	71	84	69	89	125	119	79
Завхан	131	110	144	91	118	96	106	108	118
Увс	138	141	143	145	136	138	136	143	62
Ховд	109	174	135	193	167	201	170	277	186
Хангайн бүс	1048	1279	1315	1455	1358	1720	1904	1994	1177
Архангай	182	192	216	278	290	262	244	316	193
Баянхонгор	120	186	157	148	145	234	315	326	192
Булган	147	197	167	113	108	157	144	240	140
Орхон	211	262	220	210	216	461	438	405	253
Өвөрхангай	207	181	166	287	234	247	307	324	180
Хөвсгөл	181	261	389	419	365	359	456	383	219
Төвийн бүс	1177	1376	1510	1520	1333	1548	1606	1738	1256
Говьсүмбэр	40	40	72	74	73	56	52	61	54
Дархан-Уул	231	288	366	341	299	385	408	444	285
Дорноговь	184	172	166	203	263	281	219	215	140
Дундговь	95	130	104	114	84	65	144	111	89
Өмнөговь	98	139	122	123	102	148	134	169	178
Сэлэнгэ	209	205	255	271	215	240	285	330	204
Төв	320	402	425	394	297	373	364	408	306
Зүүн бүс	725	726	704	615	541	652	809	1175	690
Дорнод	276	387	267	211	203	245	280	294	193
Сүхбаатар	93	132	128	140	128	143	165	314	233
Хэнтий	356	207	309	264	210	264	364	567	264
Улаанбаатар	5419	7105	8442	9215	9539	13616	17465	12626	8355
Бусад	65	77	7	23	4	15	16	22	3

Хүснэгт 221 Бүртгэгдсэн гэмт хэрэг /Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг/

Мөн цэргийн анги, нэгтгэл, отрядтай аймгуудад цэргийн албаны эсрэг гэмт хэргийн гаралт өндөр, хилийн зурвастай аймгуудад улсын хилээр барааг хууль бусаар хил нэвтрүүлэх гэмт хэргүүд өсөлттэй гардаг байна. Тухайлбал Увс, Дорноговь аймгуудад жил бүр цэргийн албаны эсрэг гэмт хэрэг бүртгэгдэн, шүүхээр хянан шийдвэрлэгддэг байна.

Гэмт хэргийн төрлийг сүүлийн 4 жилийн байдлаар төвийн 6 дүүргийг Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан бүлгээр авч үзвэл Баянзүрх дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн хянан шийдвэрлэсэн хэргийн 59.0 хувийг, Чингэлтэй дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 50.6 хувийг, Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 49.6 хувийг, Баянгол дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 57.7 хувийг, Хан-Уул дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны

шүүхийн 51.3 хувийг, Сонгинохайрхан дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 57.7 хувийг тус тус Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг дангаараа эзэлж байна.


Гэмт хэргийн төрөл	Баянзүрх	Чингэлтэй	Сүхбаатар	Баянгол	Хан-Уул	Сонгинохайрхан
10-р бүлэг Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	1.8	1.6	1.3	1.8	2.5	2.6
11-р бүлэг Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	59.0	50.6	49.6	57.7	51.3	57.7
12-р бүлэг Хүний бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	2.6	2.0	1.8	1.6	1.8	3.0
13-р бүлэг Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	0.3	0.2	0.3	0.3	0.2	0.2
14-р бүлэг Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
15-р бүлэг. Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	0.1	0.0	0.0	0.1	0.1	0.0
16-р бүлэг. Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	0.1	0.1	0.1	0.3	0.0	0.1
17-р бүлэг. Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	26.4	34.6	34.2	26.8	27.7	25.6
18-р бүлэг. Эдийн засгийн гэмт хэрэг	0.3	0.3	0.2	0.2	0.3	0.1
19-р бүлэг. Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	0.0	0.1	0.1	0.0	1.3	0.0
20-р бүлэг. Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	2.4	2.7	3.4	3.3	3.0	1.5
21-р бүлэг. Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	0.3	0.1	0.4	0.1	0.2	0.0
22-р бүлэг. Авлигын гэмт хэрэг	0.5	1.0	1.1	0.5	0.5	0.3
23-р бүлэг. Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	0.6	0.8	1.1	0.8	1.0	0.4
24-р бүлэг. Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	0.4	0.6	0.5	0.3	0.2	0.3
25-р бүлэг. Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
26-р бүлэг. Кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	0.1	0.1	0.2	0.1	0.1	0.0
27-р бүлэг. Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	5.2	5.1	5.7	6.3	9.6	8.0
28-р бүлэг. Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
29-р бүлэг. Хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэг	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Шийдсэн хэргийн дундаж	1778.0	890.0	992.8	977.3	719.5	1242.0

Хүснэгт 222 Шийдвэрлэсэн хэрэг /гэмт хэргийн төрлөөр, 6 дүүргээр/

Мөн Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн дундаж хэрэг 1778 хэрэг, Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн хянан шийдвэрлэсэн хэргийн дундаж 1242 хэрэг байна.


Доорх төвийн 6 дүүргийн шийдвэрлэсэн хэргийн төрлөөр авч үзвэл төрлийн хувьд онцгой өөр төрлийн гэмт хэрэг шийдвэрлээгүй байх бөгөөд Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг, өмчлөх эрхийн эсрэг болон хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг гэсэн 3

төрлийн хэрэг голлон эзэлж байгаа нь харагдаж байна. Сонгинохайрхан дүүрэгт хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг хамгийн их үйлдэгдэж




байгаа бол Хан-Уул дүүрэгт хамгийн бага шийдвэрлэгдэж байна. Харин өмчийн эсрэг гэмт хэрэг Чингэлтэй дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд хянан шийдвэрлэсэн хэргийн 34.6 хувийг, Сүхбаатар дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн хянан шийдвэрлэсэн хэргийн 34.2 хувийг тус тус эзэлж байгаа нь хамгийн өндөр байгаа бол Сонгинохайрхан дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн хянан шийдвэрлэсэн хэргийн 25.6 хувийг эзэлж байгаа нь хамгийн бага нь байна. Баянзүрх дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн хянан шийдвэрлэсэн хэргийн 59.0 хувийг хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг


Зураг 12 Гэмт хэргийн төрлөөр/бүсээр, эзлэх хувиар гэмт хэрэг эзэлж байгаа нь хамгийн их байгаа бол Сүхбаатар дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн хянан шийдвэрлэсэн хэргийн 49.6 хувийг эзэлж байгаа нь хамгийн бага байна.



Зураг 13 Гэмт хэргийн төрлөөр/ орон нутаг, бүсээр, эзлэх хувиар/




Зураг 14 Хянан шийдвэрлэсэн хэрэг/гэмт хэргийн төрлөөр, 6 дүүргээр/





Зураг 15 Баянзүрх дүүргийн шийдвэрлэсэн хэрэг/гэмт шийдвэрлэсэн хэрэг/гэмт хэргийн төрлөөр, бүлгээр/

Зураг 16 Баянгол дүүргийн хэргийн төрлөөр, бүлгээр/



Зураг 17 Чингэлтэй дүүргийн шийдвэрлэсэн хэрэг/гэмт шийдвэрлэсэн гэмт хэргийн төрлөөр, бүлгээр/

Зураг 18 Сүхбаатар дүүргийн хэргийн төрлөөр, бүлгээр/



Зураг 19 Хан-Уул дүүргийн шийдвэрлэсэн хэрэг/
Гэмт хэрэг/гэмт хэргийн төрлөөр, бүлгээр/
Зураг 20 Сонгинохайрхан дүүргийн шийдвэрлэсэн
хэргийн төрлөөр, бүлгээр/

Улсын хэмжээнд хянан шийдвэрлэсэн хэргийн 49.5 хувийг дангаараа Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг эзэлж байна. Баруун бүсийн хувьд бусад бүсүүдийг бодоход Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 42.9 хувь буюу хамгийн бага хувийг эзэлж байгаа бол Улаанбаатар хотод хянан шийдвэрлэсэн хэргийн 58.4 хувийг энэ төрлийн гэмт хэрэг эзэлж байна. Хүний бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг Хангайн бүсэд хянан шийдвэрлэсэн хэргийн 4.3 хувийг, Төвийн болон Зүүн бүсэд хянан шийдвэрлэсэн хэргийн 4.2 хувийг эзэлж байгаа нь хамгийн өндөр байгаа бол Улаанбаатар хотод хянан шийдвэрлэсэн хэргийн 2.2 хувийг эзэлж байгаа нь хамгийн бага байна. Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг Төвийн бүсэд хянан шийдвэрлэсэн хэргийн 21.0 хувийг эзэлж байгаа нь хамгийн бага байгаа бол Зүүн бүсэд хянан шийдвэрлэсэн хэргийн 29.8 хувийг эзэлж байгаа нь хамгийн өндөр байна. Эдийн засгийн гэмт хэрэг Төвийн бүсэд хамгийн өндөр хувьтай шийдвэрлэгдэж байгаа бол Хангайн бүсэд хамгийн бага шийдвэрлэгдэж байна. Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг төвийн бүсэд өндөр шийдвэрлэгдэж байгаа бол хангайн бүсэд хамгийн бага шийдвэрлэгдэж байна. Нийтийн албаны эсрэг гэмт хэрэг баруун бүсэд өндөр шийдвэрлэгдэж байгаа бол Улаанбаатар хотод хамгийн бага шийдвэрлэгдэж байна. Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг Баруун бүсэд хянан шийдвэрлэгдсэн хэргийн 10.1 хувийг эзэлж байгаа нь хамгийн өндөр байгаа бол Улаанбаатар хотод шийдвэрлэгдсэн хэргийн 0.4 хувийг эзэлж байгаа нь хамгийн бага хувьтай байна. Төвийн бүсэд хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг болон цэргийн албаны эсрэг гэмт хэрэг өндөр шийдвэрлэгдэж байна.


Гэмт хэргийн төрөл /Бүлгээр/	Баруун	Хангайн	Төвийн	Зүүн	Улаанбаатар	Дундаж
Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	1.6	1.9	2.6	2.7	1.9	2.1
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	42.9	47.8	48.8	49.7	58.4	49.5
Хүний бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	2.9	4.3	4.2	4.2	2.2	3.6

Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	0.5	0.2	0.6	0.3	0.2	0.4
Хүний хувийн, улс төрийн эрх, эрхч чөлөөний эсрэг гэмт хэрэг	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	0.1	0.0	0.1	0.0	0.1	0.1
Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	0.1	0.0	0.0	0.0	0.1	0.0
Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	27.6	25.1	21.0	29.8	25.5	25.8
Эдийн засгийн гэмт хэрэг	0.2	0.1	2.4	0.4	0.3	0.7
Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	0.4	0.1	0.9	0.2	0.2	0.3
Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	1.0	1.3	1.7	0.4	2.2	1.3
Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	0.5	0.6	0.4	0.1	0.3	0.4
Авлигын гэмт хэрэг	1.4	0.5	0.8	0.7	0.5	0.8
Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	2.1	0.8	1.2	1.0	0.7	1.2
Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	10.1	8.9	4.4	2.8	0.4	5.3
Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг	0.0	0.0	0.1	0.0	0.0	0.0
Кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	0.0	0.0	0.0	0.0	0.1	0.0
Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	8.7	8.2	10.6	7.6	6.8	8.4
Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг	0.1	0.0	0.2	0.1	0.1	0.1
Хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэг	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Шийдсэн хэрэг /дундаж/	136.8	270.0	170.8	228.4	770.2	315.2

Хүснэгт 223 Хянан шийдвэрлэсэн хэрэг /бүсээр, эзлэх хувиар/

Шилжилт хөдөлгөөн 2013 оноос харьцангуй тогтворжиж эхэлсэн байна²².

2018 оны жилийн эцэст засаг захиргааны нэг нэгжээс нөгөөд шилжин ирэгчдийн тоо 31429, шилжин явагчдын тоо 29810 болсон байна. Шилжих хөдөлгөөнд оролцогчдыг аймаг, нийслэлээр авч үзвэл төвийн бүсийн аймгуудад шилжих хөдөлгөөнд оролцогчид бусад бүсүүдтэй харьцуулахад хамгийн өндөр байжээ. 2020-2021 онуудад шилжилт хөдөлгөөн эргэж өсөх хандлага ажиглагдаж байна. Үндэсний статистикийн хорооны 1212.mn цахим хуудаст шилжин явсан иргэдийн тоо сүүлийн 2 жилийн мэдээлэл байхгүй байна.



²² https://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=population_mn_2018.pdf&ln=Mn /44-р хуудас/

Зураг 21. Хүн амын шилжилт хөдөлгөөн /2009-2021²³/

Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүд сүүлийн 18 жилийн хугацаанд дунджаар хүлээн авсан хэргийн 84.9 хувийг хянан шийдвэрлэж, 6.5 хувь нь тухайн тайлант хугацааны үлдэгдэл хэрэг болон үлдэж байна. Хамгийн өндөр хувийн үлдэгдэлтэй хэрэг 2008 онд хүлээн авсан хэргийн 7.9 хувийг, 2013 онд 7.8 хувийг, 2016 онд 7.3 хувийг, 2021 8.2 хувийг тус тус эзэлж байна.

Хүлээн авсан хэрэг, шийдвэрлэсэн хэрэг өсөхөд үлдэгдэл хэрэг дагаж өсөх, хүлээн авсан хэрэг буурахад шийдвэрлэсэн хэрэг буурч, үлдэгдэл мөн дагаж буурч буй динамик харагдаж байна. Харин хүлээн авсан, шийдвэрлэсэн хэрэг буурсан байхад үлдэгдэл хэрэг өссөн зүй тогтол мөн ажиглагдаж байна. Тухайлбал 2016 онд хүлээн авсан хэрэг өмнөх оноос 12.2 хувиар, хянан шийдвэрлэсэн хэргийн тоо 14.7 хувиар тус тус буурсан бол үлдэгдэл хэргийн тоо 5.8 хувиар өссөн дүн гарсан байна. Цаг хугацааны хувьд үлдэгдэл хэргийн тоо өссөн огноог шүүж үзвэл 2008, 2013, 2017-2020 онуудад өндөр өсөлттэй байна. Энэ нь эргээд эрх зүйн орчин буюу 2008 оны Эрүүгийн хуулийн нэмэлт өөрчлөлт оруулсан, Шүүх байгуулах тухай хууль батлагдсан, Эрүүгийн хууль /2015 он/-ийн шинэчилсэн найруулга хэрэгжиж эхэлсэн, үйлчилж буй цаг хугацаатай давхцаж байна.

Огноо	Хүлээн авсан	Өсөлт, бууралт	Шийдсэн	Өсөлт, бууралт	Үлдэгдэл	Өсөлт, бууралт
2004	7477		6272		456	
2005	8307	11.1	6966	11.1	500	9.6
2006	6784	-18.3	5558	-20.2	343	-31.4
2007	6876	1.4	5831	4.9	369	7.6
2008	6878	0.0	5812	-0.3	544	47.4
2009	6668	-3.1	5407	-7.0	412	-24.3
2010	6372	-4.4	5460	1.0	386	-6.3
2011	6776	6.3	5877	7.6	438	13.5
2012	7065	4.3	6161	4.8	420	-4.1
2013	7248	2.6	6169	0.1	562	33.8
2014	7603	4.9	6375	3.3	493	-12.3
2015	7998	5.2	6756	6.0	483	-2.0
2016	7025	-12.2	5762	-14.7	511	5.8
2017	10412	48.2	8839	53.4	741	45.0
2018	14207	36.4	12551	42.0	802	8.2
2019	15216	7.1	13427	7.0	887	10.6
2020	15583	2.4	13470	0.3	1139	28.4
2021	14182	-9.0	12068	-10.4	1156	1.5

Хүснэгт 224 Хүлээн авсан, шийдсэн, үлдэгдэл хэргийн харьцаа

Дүгнэлт

Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүдийн хэргийн өсөлт, бууралтад эрх зүйн орчин буюу Эрүүгийн хууль, түүний нэмэлт, өөрчлөлт, шинэчилсэн найруулга, Өршөөл үзүүлэх тухай хууль маш их нөлөөлж байна.

²³ Эх сурвалж. Үндэсний статистикийн хороо <https://www.1212.mn/>

Шүүх байгуулах тухай хуулийн үйлчлэлээр зарим шүүхийн хэрэг хянан шийдвэрлэлт нэмэгдэж, зарим шүүхүүдийн шийдсэн хэргийн тоо буурсан байдал ажиглагдаж байна.

Эдийн засгийн хямрал болсон 2008-2010 онуудад, дэлхий нийтийг хамарсан цар тахалтай холбоотойгоор сүүлийн 2 жилийн хугацаанд гэмт хэргийн гаралт, илрүүлэлт, шүүхэд хүлээн авсан хэрэг, хянан шийдвэрлэсэн хэрэг бүхэлдээ хамааралтайгаар буурсан байна.

Цагдаагийн байгууллагаас, прокурорын байгууллагаас гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн аян, арга хэмжээний үр дүнд зарим онуудад гэмт хэргийн илрүүлэлт, шүүхэд хүлээн авсан хэрэг өссөн дүнтэй гарсан боловч эргээд дараа жилүүдээс зарим төрлийн гэмт хэргийн гаралт буурч байгаа эерэг нөлөөлөл ажиглагдаж байна. Харин зарим төрлийн гэмт хэргийн илрүүлэлт нэмэгдэж, үүнийгээ дагаад шийдвэрлэлт өсөж байгаа зураглал мөн харагдаж байна.

Нийгмийн цахим сүлжээ хөгжихийн хэрээр гэмт хэргийн илрүүлэлт нэмэгдэж байгаа, олны анхаарлын төвд оруулж хянан шийдвэрлэлтэд олон нийтийн хяналт тавигдаж буй дүр зураг ажиглагдаж байна.

№	Нөлөө үзүүлсэн шалтгаан, нөхцөл	Хугацаанаас бусад шалтгаан, нөхцөлийн утга
1	Хугацааны нөлөө	Шийдвэрлэсэн хэргийн тооны өгөгдлийн 2004-2021 оны хоорондох хугацаа нь Баянхонгор, Өмнөговь аймгийн шүүхэд хүчтэй, бусад аймгийн шүүхэд дунд болон сул нөлөөтэй байна. Харин дүүргийн ЭХАШШ-ийн хэмжээнд 63 хувийн нөлөөтэй байна.
2	Эрх зүйн орчин	Эрүүгийн хуулийн нэмэлт өөрчлөлт, шинэчилсэн найруулга хамгийн өндөр нөлөө үзүүлж байна. Мөн Зөрчлийн хуулийн үйлчлэлээр Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүдэд ачаалал эрс нэмэгдсэн. Өршөөлийн хууль батлагдан хэрэгжсэн онуудад хүлээн авсан, шийдвэрлэсэн хэргийн тоо өсөх, дараа жил буурах хандлагатай байна. Хүлээн авсан хэрэг, шийдсэн хэрэг, үлдэгдэл хэргийн харьцаанд эрх зүйн орчин мөн л нөлөөлөл үзүүлж байна.
3	Цагдаа, Прокурорын байгууллагаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, хяналт шалгалт	Шүүхийн өмнөх шатанд ажиллагаа явуулж буй байгууллагын тухайн тайлант жилүүдэд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн хамааралтай байна.
4	Бүс нутгийн онцлог болон гэмт хэргийн төрөл	Бүс нутгийн онцлогоос хамааран цэргийн анги нэгтгэлтэй, мөн хилийн дагуух аймгуудад тодорхой төрлийн гэмт хэрэг тогтмол үйлдэгдэж байгаа зураглал ажиглагдаж байна. Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг баруун бүсэд улсын дунджаас 2 дахин их шийдэгдэж байна. Улаанбаатар хотод хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг бусад бүсүүдээс хэрэгт эзлэх хувиар бага шийдэгдсэн байгаа бол төвийн бүсэд энэ төрлийн гэмт хэрэг хамгийн их шийдвэрлэгдэж байна.
5	Нийгэм эдийн засгийн хүчин зүйл	Дэлхий нийтийг хамарсан цар тахалтай холбоотойгоор шүүхүүдийн хүлээн авсан болон хянан шийдвэрлэсэн хэргийн тоо буурсан хандлага ажиглагдаж байгаа ч 2022 оноос эргээд өсөх хандлагатай байна.

Хүснэгт 225 Эрүүгийн хэргийн шүүхэд нөлөөлж буй хүчин зүйлс

- **Иргэний хэрэг**

Монгол Улсын шүүхээр 2004-2021 онд 656631 иргэний хэрэг, маргаан хянан шийдвэрлэсэн байна.

№	Огноо	Шийдвэрлэсэн хэрэг	Өсөлт, бууралт тоо	Өсөлт, бууралт хувь	Ерөнхий шалтгаан нөхцөл
1	2004	23269	-138	-	Тухайн тайлант хугацаанд хянан шийдвэрлэсэн хэрэг, маргаан өмнөх оноос буурсан.
2	2005	24492	1223	5.3	Тухайн тайлант хугацаанд хүлээн авсан хэрэг 3.4 хувиар, шийдвэрлэсэн хэрэг 5.3 хувиар өссөн.
3	2006	27469	2977	12.2	Худалдах худалдан авах гэрээтэй холбоотой маргаан 583 хэргээр буюу 42.5 хувиар, нэхэмжлэгчээс гаргасан хүсэлтийн дагуу хариуцагчийг эрэн сурвалжлах маргаан 819 хэргээр буюу 2.5 дахин, ажилласан жил тогтоосон маргаан 1925 хэргээр буюу 73.3 хувиар тус тус өссөн нь иргэний хэрэг маргаан өсөхөд гол нөлөөлсөн байна.
4	2007	30699	3230	11.8	Иргэний хэрэг 12.2 хувиар өссөн бөгөөд энэ онд худалдах худалдан авах гэрээтэй холбоотой маргаан 583 хэргээр буюу 42.5 хувиар, ажилласан жил тогтоосон маргаан 1925 хэргээр буюу 73.3 хувиар тус тус өссөн.
5	2008	28464	-2235	-7.3	Дэлхийн эдийн засгийн хямрал эхэлсэн бөгөөд шийдвэрлэсэн иргэний хэрэг маргааны тоо харьцангуй тогтвортой байсан.
6	2009	35822	7358	25.9	Дэлхийн эдийн засгийн хямрал, “Анод”, “Зоос” банкнуудын дампуурал болон 2008 оны Сонгууль зэргээс шалтгаалан шийдвэрлэсэн хэрэг 25.9 хувиар өссөн байна.
7	2010	35787	-35	-0.1	Банкны дампууралтай холбоотойгоор банкнаас олгох зээлтэй холбоотой маргаан зарим аймгуудад огцом өссөн. Тухайлбал, Ховд, Өвөрхангай аймаг
8	2011	30368	-5419	-15.1	Өмнөх оны Сонгуулийн нөлөө, Банкны дампуурал, Дэлхийн эдийн засгийн хямрал зэрэг нөлөөл харьцангуй багасаж тайлант хугацаанд хүлээн авсан хэрэг 11.7 хувиар буурсан нь шийдвэрлэсэн хэрэг 15.1 хувиар буурахад голлон нөлөөлсөн байна.
9	2012	27792	-2576	-8.5	Тухайн тайлант хугацаанд хүлээн авсан хэрэг 6.7 хувиар, шийдвэрлэсэн хэрэг 8.5 хувиар буурсан.
10	2013	35314	7522	27.1	Шүүх байгуулах багц хууль батлагдан мөрдөгдсөн. Мөн энэ онд ажилласан жил тогтоосон маргаан 5841 хэргээр буюу 2.2 дахин нэмэгдсэн нь НДСОТТХ-д нэмэлт өөрчлөлт орсон
11	2014	33996	-1318	-3.7	Тайлант хугацаанд хүлээн авсан хэрэг 2.3 хувиар, хянан шийдвэрлэсэн хэрэг 3.7 хувиар тус тус буурсан.
12	2015	40674	6678	19.6	2015-2017 онуудад иргэд хоорондын зээлтэй холбоотой хэрэг маргаан өссөн нь хадгаламжийн хүүгээс татвар авдаг тогтолцоонд шилжсэнтэй холбоотойгоор иргэд хадгаламжаа өөр эх үүсвэр рүү байршуулснаар иргэд хоорондын чанаргүй зээлийн хэмжээ нэмэгдэж, энэ төрлийн хэрэг маргаан өсөх нэг гол шалтгаан нөхцөл болсон байна.
13	2016	46578	5904	14.5	Тайлант хугацаанд хүлээн авсан хэрэг 13.1 хувиар, хянан шийдвэрлэсэн хэрэг 14.5 хувиар тус тус өссөн байна. Энэхүү өсөлтөд худалдах худалдан авах арилжаатай холбоотой маргаан 32.1 хувиар, зээлийн гэрээний маргаан 19.1 хувиар, банкнаас олгох зээлтэй холбоотой маргаан 30.7 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.
14	2017	45233	-1345	-2.9	НДСОТТХ-д нэмэлт өөрчлөлт орсонтой холбоотойгоор ажилласан жил тогтоосон маргаан өсч, бусад маргаан бага хэмжээгээр буурсан.

15	2018	48155	2922	6.5	Тухайн тайлант хугацаанд хүлээн авсан хэрэг 2.1 хувиар, шийдвэрлэсэн хэрэг 6.5 хувиар өссөн.
16	2019	43397	-4758	-9.9	Тухайн тайлант хугацаанд хянан шийдвэрлэсэн хэрэг, маргаан өмнөх оноос буурсан.
17	2020	53678	10281	23.7	Тайлант хугацаанд хүлээн авсан хэрэг 20.4 хувиар, хянан шийдвэрлэсэн хэрэг 23.7 хувиар тус тус өссөн байна. Дэлхийн нийтийг хамарсан цар тахлын нөхцөл байдалтай холбоотой зээл, худалдах худалдан авах, түрээс, банк, банк бус санхүүгийн байгууллагаас олгох зээлтэй холбоотой маргаанууд өссөн байна.
18	2021	45444	-8234	-15.3	Тухайн тайлант хугацаанд хүлээн авсан хэрэг, маргаан 9.2 хувиар, хянан шийдвэрлэсэн хэрэг, маргаан 15.3 хувиар өмнөх оноос буурсан.
19	Дундаж	36480	-	4.60%	-

Хүснэгт 226 Шийдвэрлэсэн иргэний хэрэг /2004-2021 он/

Иргэний хэрэг 2004-2005 онуудад харьцангуй тогтвортой байсан бөгөөд 2006-2007 онуудад өссөн байна. Харин 2008 онд бага зэрэг буураад 2009, 2010 онуудад дэлхийн эдийн засгийн хямрал, сонгууль, банкны дампууралтай холбоотойгоор огцом өсч, 2011-2012 онуудад харьцангуй тогтворжиж, 2013 оноос дахин өссөн байна.

2015 онд хянан шийдвэрлэсэн хэрэг, маргаан өмнөх оноос 19.6 хувиар өссөн бөгөөд 2015-2017 онуудад хадгаламжийн хүүгээс татвар авдаг тогтолцоонд шилжсэнтэй холбоотойгоор иргэд хадгаламжаа өөр эх үүсвэр рүү байршуулснаар иргэд хоорондын чанаргүй зээлийн хэмжээ нэмэгдэж, энэ төрлийн хэрэг, маргаан өссөн байна. 2020 онд шийдвэрлэсэн хэрэг, маргаан өмнөх оноос 23.7 хувиар өссөн нь дэлхийн нийтийг хамарсан цар тахлын нөхцөл байдалтай холбоотой байна.



Зураг 22 Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрлэсэн хэрэг

Иргэний хэргийн анхан шатны шүүхийн хэмжээнд жил тутам 1530 иргэний хэрэг нэмэгдэх хугацааны нөлөөлөл 83 хувьтай тодорхойлогдсон байна. Бусад хүчин зүйлийн нөлөө 17 хувьтай байгаа бөгөөд эдгээр хүчин зүйлд нэгдүгээрт эрх зүйн орчин хоёрдугаарт бүсийн, шүүхийн онцлог болон хэрэг, маргааны төрөл гуравдугаарт нийгмийн бусад хүчин зүйл буюу хүн амын өсөлт, улс төрийн бодлого,

шилжилт хөдөлгөөн, цар тахлын нөхцөл байдал зэрэг нөлөөлж байна гэж үзэж байна.

1. Эрх зүйн орчин

Иргэний хэргийн өсөлт, бууралтад эрх зүйн орчны өөрчлөлт тодорхой хэмжээгээр нөлөөлж байна. Тухайлбал, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль 2002 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр батлагдаж тус оны 09 дүгээр сарын 01-ны өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн бөгөөд 20 жилийн хугацаанд нийт 28 удаагийн нэмэлт өөрчлөлт орсон бөгөөд хэрэг маргааны тоонд нөлөөлөхүйц нэмэлт өөрчлөлт нь 2014 онд орсон байна.

Тус хуулийн 117 дугаар зүйлийн 117.1 дэх хэсэгт “хариуцагчийн хаяг тодорхойгүй” гэсэн үндэслэл иргэний хэрэг үүсгэснээс хойш, 65.1.1, 65.1.3-65.1.8, 65.1.10-д заасан үндэслэл хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэх үед тогтоогдвол хэргийг хэрэгсэхгүй болгоно гэж заасны дагуу энэ үндэслэлээр нэхэмжлэгчийн гаргасан хүсэлтийн дагуу хариуцагчийг эрэн сурвалжлах хэрэг, маргаан 2015 оноос нэмэгдсэн байна.

Мөн Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай хуулийн 2012 оны 05 дугаар сарын 01-ны өдрийн нэмэлт өөрчлөлтөөр “Нийгмийн даатгалын тухай хууль хүчин төгөлдөр болохоос өмнөх болон мөн үеийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр тогтоолгосон иргэдийн тэтгэврийг бодоход баримталсан хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогыг шимтгэл төлсөн хугацаа, эрхэлж байсан ажил, албан тушаал, хөдөлмөрийн нөхцөл нь ижил 1995 оноос хойш тэтгэврээ тогтоолгосон иргэний тэтгэврийг бодоход баримталсан хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын хэмжээтэй дүйцүүлэн тооцно.” гэсэн заалт орсонтой холбоотойгоор ажилласан жил тогтоосон хэрэг, маргаан 2013 оноос өссөн. Мөн хуульд 2017 оны 02 дугаар сарын 02-ны өдөр нэмэлт өөрчлөлт орсонтой холбоотой малчнаар ажиллаж тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн тохиолдолд эрэгтэй 55 настай, эмэгтэй 50 настай тэтгэвэрт гарах боломжтой болсонтой холбоотойгоор хөдөө орон нутагт ажилласан жил тогтоосон хэрэг, маргаан мөн өссөн байна.

Шүүх байгуулах тухай хуульд 2013, 2015, 2016, 2018, 2021 онуудад нэмэлт өөрчлөлт болон шинэчилсэн найруулга хийгдсэн бөгөөд 2013 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс хэрэгжиж эхэлсэн Шүүх байгуулах тухай хуульд анхан шатны шүүхийн нутаг дэвсгэрийн харьяаллыг засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд зааснаас өөрөөр буюу тухайлбал сум дундын 23-р шүүхийн нутаг дэвсгэрийн харьяалалд Төв аймгийн Зуунмод, Алтанбулаг, Баян-Өнжүүл, Баянцогт, Баянцагаан, Баянхангай, Бүрэн, Дэлгэрхаан, Сэргэлэн, Лүн, Өндөрширээт, Архуст, Аргалант, Цээл, Баянчандмань, Заамар, Угтаалцайдам сумд дүүргийн Иргэний хэргийн анхан шатны 4 дүгээр шүүхэд Нийслэлийн Налайх, Багахангай дүүрэг болон Төв аймгийн Баян, Баянжаргалан, Эрдэнэ сумыг хамруулсан нь эдгээр шүүхийн хянан шийдвэрлэсэн хэргийн тоо өсөх, буурах нөхцөлийг бүрдүүлж байсан.

Улс төрийн төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулийн 2018 оны өөрчлөлтөөр “улс төрийн хилс хэрэгт холбогдуулан цаазаар авах ялаар шийтгүүлсэн хэлмэгдэгчийн эхнэр /нөхөр/, эсхүл хэлмэгдэгчийн төрсөн болон үрчилж авсан хүүхэд, хэлмэгдэгчийг нас барснаас

хойш 10 сараас илүүгүй хугацааны дотор төрсөн хүүхдэд 80 сая төгрөг”, “улс төрийн хилс хэрэгт холбогдуулан хорих ялаар шийтгүүлсэн хэлмэгдэгч, хэлмэгдэгч нас барсан бол түүний эхнэр /нөхөр/, эсхүл хэлмэгдэгчийн төрсөн болон үрчилж авсан хүүхэд, хэлмэгдэгчийг нас барснаас хойш 10 сараас илүүгүй хугацааны дотор төрсөн хүүхдэд 40 сая төгрөг”-ийн нөхөн олговрыг олгохоор болсон.

Мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-т цагаатгуулах тухай гомдлыг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор гаргаж болох бөгөөд энэ хугацаанаас хойш гаргасан гомдлыг хүлээж авахгүй гэсэн заалтын дагуу 2019 онд 624 хэрэг, 2020 онд 919 хэрэг тус тус хянан шийдвэрлэж өмнөх онуудаас энэ төрлийн хэрэг, маргаан огцом өссөн байна.

Хэрэг, маргааны төрөл

Иргэний хэргийн анхан шатны шүүхийн нийт шийдвэрлэж буй маргааны 25 орчим хувийг ажилласан жил тогтоосон маргаан, 20 орчим хувийг худалдах худалдан авах гэрээтэй холбоотой маргаан, 14 хувийг иргэд хоорондын зээлтэй холбоотой маргаан, 11 орчим хувийг нэхэмжлэгчийн гаргасан хүсэлтийн дагуу хариуцагчийг эрэн сурвалжлах маргаан, 9 орчим хувийг банкны зээлтэй холбоотой маргаан, 8 орчим хувийг гэрлэлт цуцалсан маргаан, 4 орчим хувийг хүүхдийн тэтгэлэг гаргуулах маргаан, 3 орчим хувийг согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх тухай хуулиар 3 орчим хувийг гэрлэлт цуцалсан маргаан, 2 орчим хувийг ажилласан жил тогтоосон маргаан тус тус эзэлж байна.



Зураг 23 Өндөр дүнтэй шийдвэрлэгдсэн 10-н төрлийн хэрэг маргаан

Дээрх маргаануудын өсөлт иргэний хэргийн өсөлтөд голлон нөлөөлж байгаа бөгөөд хугацааны дагуу судлан үзэхэд дараах тайлбар өгөгдөхөөр байна.

2006 онд худалдах худалдан авах гэрээтэй холбоотой маргаан 583 хэргээр буюу 42.5 хувиар, нэхэмжлэгчээс гаргасан хүсэлтийн дагуу хариуцагчийг эрэн сурвалжлах маргаан 819 хэргээр буюу 2.5 дахин, ажилласан жил тогтоосон маргаан

1925 хэргээр буюу 73.3 хувиар тус тус өссөн нь иргэний хэрэг энэ онд өсөхөд голлон нөлөөлсөн байна.

2007 онд иргэний хэрэг 12.2 хувиар өссөн бөгөөд энэ онд худалдах худалдан авах гэрээтэй холбоотой маргаан 583 хэргээр буюу 42.5 хувиар, ажилласан жил тогтоосон маргаан 1925 хэргээр буюу 73.3 хувиар тус тус өссөн нь иргэний хэрэг өсөхөд гол нөлөөлсөн байна.

2009 онд иргэний хэрэг өмнөх оноос 25.9 хувиар өссөн бөгөөд худалдах худалдан авах болон арилжаатай холбоотой маргаан 927 хэргээр буюу 92.6 хувиар, зээлийн гэрээтэй холбоотой маргаан 334 хэргээр буюу 17.2 хувиар, ажил гүйцэтгэх гэрээтэй холбоотой маргаан 14 хэргээр буюу 41.3 хувиар, Банкнаас олгох зээлтэй холбоотой маргаан 2296 хэргээр буюу 3 дахин, банк бус санхүүгийн байгууллагаас олгох зээлтэй холбоотой маргаан 244 хэргээр буюу 3.7 дахин, банк зээлийн бусад үйл ажиллагаа эрхэлдэг эрх бүхий этгээдээс олгох зээлтэй холбоотой маргаан 408 хэргээр буюу 2.3 дахин тус тус өссөн байна. Энэ нь 2008-2009 онд “Зоос”, “Анод” банкнууд төлбөрийн чадваргүй болж, дампуурлаа зарласантай холбоотой байж болох бөгөөд мөн дэлхийн эдийн засгийн хямрал, УИХ-ын сонгуулийн нөлөөнөөс хамааралтай байж болохоор байна. Эдгээр банкнуудын хадгаламж эзэмшигчдэд “Банкны мөнгөн хадгаламж баталгаа гаргах тухай” хууль батлагдсантай холбогдуулан тухайн үед 225 тэрбум төгрөгийн зардал гарган хохирлыг барагдуулсан байна. Ямартай ч энэ үед ДНБ өмнөх оноос 1.6 хувиар буурч, арилжааны банкнуудын чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хэмжээ 17.4 хувьд хүрч байжээ.

Шүүхүүд	2008 он шийдвэр лэсэн хэрэг	2009 он шийдвэрлэсэн хэрэг	2010 он шийдвэрлэсэн хэрэг	Өссөн, буурсан хэргийн тоо 2009 он/	Өссөн, буурсан хэргийн тоо 2010 он/	Банкнаас олгох зээлтэй холбоотой маргааны өсөлт /2009/	Банкнаас олгох зээлтэй холбоотой маргааны өсөлт /2010/
Улсын дүн	28464	35822	35787	7358	-35	2296	
Баруун бүс	3509	4509	4822	1000	313	688	
Баян-Өлгий	704	1048	935	344	-113	239	
Говь-Алтай	519	782	678	263	-104	195	
Завхан	874	954	924	80	-30	142	27
Увс	541	672	686	131	14	62	
Ховд	871	1053	1599	182	546	50	652
Хангайн бүс	6049	7599	7539	1550	-60	526	
Архангай	626	949	843	323	-106	25	
Баянхонгор	833	1052	853	219	-199	65	
Булган	616	846	731	230	-115	137	
Орхон	956	1470	1419	514	-51	97	49
Өвөрхангай	1635	1565	1768	-70	203	91	281
Хөвсгөл	1383	1717	1925	334	208	111	67
Төвийн бүс	5715	7642	7284	1927	-358	461	
Говьсүмбэр	311	496	292	185	-204	100	
Дархан-Уул	1341	1958	2062	617	104	113	
Дорноговь	691	1082	887	391	-195	46	23
Дундговь	560	529	566	-31	37	-14	
Өмнөговь	483	594	553	111	-41	34	14
Сэлэнгэ	1289	1676	1520	387	-156	109	

Төв	1040	1307	1404	267	97	73
Зүүн бүс	2318	3808	2719	1490	-1089	264
Дорнод	1163	1134	1056	-29	-78	-6
Сүхбаатар	483	848	689	365	-159	89
Хэнтий	672	1826	974	1154	-852	181
Улаанбаатар	10873	12264	13423	1391	1159	357

Хүснэгт 227 Банкнаас олгох зээлтэй холбоотой хэрэг маргааны өсөлт, аймгаар 2008-2010 он

Дээрх хүснэгтийн дүгнэвэл **2009 онд** банкнаас олгох зээлтэй холбоотой маргаан 2296 хэргээр өссөн бөгөөд Тухайлбал Завхан аймгийн шүүхийн шийдвэрлэсэн хэрэг 2009 онд 80 хэргээр өссөн бөгөөд тус шүүхийн шийдвэрлэсэн банкнаас олгох зээлтэй холбоотой маргаан 142 хэргээр өссөн нь шүүхийн нийт шийдвэрлэсэн хэрэг өсөхөд банкнаас олгох зээлтэй холбоотой маргаан голлон нөлөөлсөн байна гэж дүгнэхээр байна.


Харин **2010 онд** улсын хэмжээнд шийдвэрлэсэн хэрэг харьцангуй тогтвортой байсан ч Ховд аймгийн шийдвэрлэсэн банкнаас олгох зээлтэй холбоотой маргаан 652 хэргээр өссөн нь энэ аймгийн хэрэг 546 хэргээр өсөхөд голлон нөлөөлсөн байна. Мөн үүнтэй адилхан Өвөрхангай аймгийн банкнаас олгох зээлтэй холбоотой шийдвэрлэсэн хэрэг 281 хэргээр өссөн бөгөөд тус аймгийн нийт шийдвэрлэсэн иргэний хэрэг 203 хэргээр өсөхөд мөн голлон нөлөөлсөн байна гэж дүгнэж болохоор байна.

Банкнаас олгох зээлтэй холбоотой маргаан 2009 онд дийлэнх аймагт их байсан бол 2010 онд тодорхой хэдэн аймгуудад өсч, тухай шүүхийн шийдвэрлэсэн хэрэг, маргааны тоо нэмэгдэхэд энэ төрлийн маргаан голлон нөлөөлсөн байна. Энэ нь “Зоос”, “Анод” банкнуудын салбаруудын дампуурлаа зарласан хугацаанаас хамаарч байна.

Мөн дээрх онуудад АНУ-аас эхэлсэн дэлхийн санхүүгийн хямрал Монголын эдийн засагт нөлөөлж, 2008 оны сүүл, 2009 он бүхэлдээ хүнд байсан. Үүнтэй холбоотойгоор 2009-2010 онуудад шүүхээр шийдвэрлэсэн иргэний хэрэг, маргаан өссөн байна.

2013 онд иргэний хэрэг өмнөх оноос 27.3 хувиар өссөн бөгөөд хэрэг маргааны төрлөөр өсөлтийг авч үзвэл худалдах худалдан авах болон арилжаатай холбоотой маргаан 1161 хэргээр буюу 55.4 хувиар, зээлийн гэрээний маргаан 530 хэргээр буюу 23.1 хувиар, нэхэмжлэгчийн хүсэлтийн дагуу хариуцагчийг эрэн сурвалжлах маргаан 345 хэргээр буюу 40 хувиар, ажилласан жил тогтоосон маргаан 5841 хэргээр буюу 2.2 дахин, гэрлэлт цуцалсан маргаан 282 хэргээр буюу 9.2 хувиар, ажлаас үндэслэлгүй халсан маргаан 266 хэргээр буюу 58 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна. Өөрөөр хэлбэл ажилласан жил тогтоосон маргаан 5841 хэргээр өссөн нь Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай хуульд 2012 оны 05 дугаар сарын 01-ны өдрөөс нэмэлт өөрчлөлт орж "Нийгмийн даатгалын тухай хууль хүчин төгөлдөр болохоос өмнөх болон мөн үеийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр тогтоолгосон иргэдийн тэтгэврийг бодоход баримталсан хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогыг шимтгэл төлсөн хугацаа, эрхэлж байсан ажил, албан тушаал, хөдөлмөрийн

нөхцөл нь ижил 1995 оноос хойш тэтгэврээ тогтоолгосон иргэний тэтгэврийг бодоход баримталсан хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын хэмжээтэй дүйцүүлэн тооцно." гэсэн заалтай холбоотой байж болохоор байна.




Зураг 24 Ажилласан жил тогтоосон маргаан 2004-2021 он

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврээ, тэтгэмжийн тухай хуулийн 2017 оны 02 дугаар сарын 02-ны өдөр нэмэлт өөрчлөлт орсонтой холбоотой малчнаар ажиллаж тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн тохиолдолд эрэгтэй 55 настай, эмэгтэй 50 настай тэтгэвэрт гарах боломжтой болсон учраас ажилласан жил тогтоосон хэрэг, маргаан 2018 онд огцом өсч шийдвэрлэгдсэн байна.

Шийдвэрлэсэн хэргээс ажилласан жил тогтоосон маргаан хамгийн өндөр хувийг эзэлдэг бөгөөд хугацааны нөлөөлөл 55 хувьтай байна. Харин бусад хүчин зүйлийн нөлөөлөл 45 хувьтай байгаа тул энд хуулийн өөрчлөлт голлон нөлөөлж байна гэж үзэж байна.


Мөн 2013 онд ажлаас үндэслэлгүй халагдсан маргаан 58 хувиар өссөн нь УИХ, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн дараагийн жил энэ төрлийн маргаан өсөх хандлагатай байдагтай холбоотой байна.

2015 онд иргэний хэрэг өмнөх оноос 19.3 хувиар өссөн бөгөөд зээлийн гэрээний маргаан 3284 хэргээр буюу 2.1 хувиар, худалдах худалдан авах арилжаатай холбоотой маргаан 1317 хэргээр буюу 30.4 хувиар, түрээсийн гэрээтэй холбоотой маргаан 455 хэргээр буюу 3.1 дахин, банкнаас олгох зээлтэй холбоотой маргаан 693 хэргээр буюу 62.4 хувиар, банк бус санхүүгийн байгууллагаас олгох зээлтэй холбоотой маргаан 291 хэргээр буюу 51 хувиар, албадан эмчлэх албадан хөдөлмөр хийлгэхтэй холбоотой маргаан 336 хэргээр буюу 43.7 хувиар, Татварын ерөнхий хуультай холбоотой маргаан 316 хэргээр буюу 2 дахин тус тус өссөн байна.



Зураг 25 Худалдах худалдан авах арилжаатай холбоотой маргаан /2004-2021 он/

2016 онд худалдах худалдан авах арилжаатай холбоотой маргаан 1810 хэргээр буюу 32.1 хувиар өссөн бөгөөд 2015-2017 онд энэ төрийн маргаан харьцангуй өндөр байсан байна. Худалдах худалдан авах гэрээ, арилжаатай холбоотой маргаан жил тутам 435 хэрэг нэмэгдэх хугацааны нөлөөлөл 84 хувьтай байна. Бусад хүчин зүйлийн нөлөө 16 хувьтай байна.




Зураг 26 Зээлийн гэрээний маргаан/2004-2021 он/

Зээлийн гэрээний маргаан жил тутам 118 хэрэг нэмэгдэх хугацааны нөлөөлөл 74 хувьтай байна. Бусад хүчин зүйлийн нөлөө 26 хувьтай байна. Худалдах, худалдан авах арилжаатай холбоотой маргаан болон зээлийн гэрээний маргаанууд нь хугацааны нөлөөлөл харьцангуй өндөр байна. Бусад хүчин зүйлийн хувьд 2015-2017 онуудад иргэд хоорондын зээлтэй холбоотой хэрэг маргаан өссөн нь хадгаламжийн хүүгээс татвар авдаг тогтолцоонд шилжсэнтэй холбоотойгоор иргэд хадгаламжаа өөр эх үүсвэр рүү байршуулснаар иргэд хоорондын чанаргүй зээлийн хэмжээ нэмэгдэж, энэ төрлийн хэрэг маргаан өсөх нэг гол шалтгаан нөхцөл болсон байна.

Татварын багц хуулийг 2010 онд УИХ-аар хэлэлцэж, батлахад хадгаламжийн хүүгээс орлогын татвар авах асуудал анх яригдсан. Гэхдээ 2008 оны хямралтай холбоотойгоор хадгаламжийн хүүгээс татвар авах хуулийг хэрэгжүүлэх хугацааг хойшлуулсан. Харин 2015 онд Төсвийн тухай хуулиар хадгаламжийн хүүгийн

орлогоос татвар авахгүй, харин 100 сая төгрөгөөс дээш хадгаламжтай иргэдийн хүүгийн орлогоос татвар авч байхаар зохицуулсан. Харин 2016 оны нэгдүгээр сарын 1-нээс бүх иргэдийн хадгаламжийн хүүгийн орлогоос 10 хувийн татвар авахаар хууль хэрэгжиж эхэлсэн байна.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 2014 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн нэмэлт өөрчлөлтөөр 117 зүйл 117.1-т “хариуцагчийн хаяг тодорхойгүй” гэсэн үндэслэлээр иргэний хэрэг үүсгэснээс хойш хэргийг хэрэгсэхгүй болгохоор заасан байна. Энэхүү хуулийн өөрчлөлттэй холбоотойгоор 2015 оноос нэхэмжлэгчийн гаргасан хүсэлтийн дагуу хариуцагчийг эрэн сурвалжлах маргаан өсч байна.



Зураг 27 Зээлийн гэрээний маргаан/2004-2021 он/

Нэхэмжлэгчийн гаргасан хүсэлтийн дагуу хариуцагчийг эрэн сурвалжлах маргаан жил тутам 196 хэрэг нэмэгдэх хугацааны нөлөөлөл 75 хувьтай байна. Бусад хүчин зүйлийн нөлөө 15 хувьтай байна.

2020 онд иргэний хэрэг өмнөх оноос 23.7 хувиар өссөн бөгөөд шүүхээр шийдвэрлэсэн хэргээс худалдах, худалдан авах гэрээтэй холбоотой маргаан 1633 хэргээр буюу 27.5 хувиар, банк бус санхүүгийн байгууллагаас олгох зээлтэй холбоотой маргаан 1471 хэргээр буюу 2.3 дахин, банкнаас олгох зээлтэй холбоотой маргаан 1196 хэргээр буюу 69.5 хувиар, түрээсийн гэрээтэй холбоотой маргаан 142 хэргээр буюу 28.2 хувиар, зээлийн гэрээтэй холбоотой маргаан 108 хэргээр буюу 1.9 хувиар, хадгаламж зээлийн хоршооноос олгох зээлтэй холбоотой маргаан 105 хэргээр буюу 61.4 хувиар тус тус өссөн. Энэ нь Коронавируст цар тахлын нөхцөл байдалтай холбоотой зээл, худалдах худалдан авах, түрээс, банк, банк бус санхүүгийн байгууллагаас олгох зээлтэй холбоотой маргаанууд өссөн байна.

2. Бүсийн болон шүүхийн онцлог

Бүсийн болон шүүхийн онцлогоос шалтгаалан маргааны төрөл өөр өөр байна. Тухайлбал,

- Баянзүрх, Сонгинохайрхан дүүргийн хувьд хүн ам, шилжилт хөдөлгөөн, ажилгүйдэл, амьжиргааны түвшин зэргээс шалтгаалан шийдвэрлэсэн хэрэг маргааны тоо өндөр бөгөөд тогтмол өсч байна. Эдгээр шүүхүүдэд **бага үнийн дүнтэй гэрээний маргаанууд, иргэд хоорондын зээлийн маргаанууд**

ихээр шийдвэрлэгдэж байна. Мөн Сонгинохайрхан, Баянзүрх, Баянгол, Багануур, Налайх дүүргийн хувьд гэрлэлт цуцалсан маргаан, хүүхдийн тэтгэлэг тогтоолгох маргаан, эцэг тогтоохтой холбоотой маргаанууд харьцангуй өндөр байна.

- Харин Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн шүүхийн хувьд гэрээний маргаан бусад шүүхээс харьцангуй цөөн, **харин онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэгдэж байгаа нэхэмжлэгчийн гаргасан хүсэлтийн дагуу хариуцагчийг эрэн сурвалжлахтай холбоотой маргаан** бусад дүүргийн шүүхүүдээс харьцангуй өндөр байна. Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн хувьд гэр бүлийн маргаан харьцангуй бага байна.
- Сүхбаатар дүүрэгт **хөдөлмөрийн маргаан** харьцангуй өндөр, Сонгинохайрхан дүүрэгт бага байгаа нь тус дүүрэг байрлах аж нэгж болон төрийн байгууллагын тооноос хамааралтай байна.
- Баруун бүсэд гэрээтэй холбоотой маргаан харьцангуй цөөн, **харин ажилласан жил тогтоохтой холбоотой маргаан** харьцангуй өндөр байна. Мөн гэрлэлт цуцлах маргаан баруун бүсэд бага, **хөдөлмөрийн маргаан буюу ажлаас үндэслэлгүй халсан, цалин хөлсний маргаан** бусад бүсийг бодвол харьцангуй өндөр байна.
- Хангайн бүсийн Архангай, Баянхонгор, Өвөрхангайн шүүх **ажилласан жил тогтоосон** хэрэг харьцангуй өндөр шийдвэрлэдэг бол бусад төрлийн маргааныг дундаж хэмжээнд шийдвэрлэж байна.
- Төвийн бүсийн хувьд Өмнөговь, Дорноговь, Говьсүмбэр аймгуудад **гэрлэлт цуцлах маргаан, хүүхдийн тэтгэлэг гаргуулах маргаан, эцэг тогтоохтой холбоотой маргаан** их байна. Учир нь уул уурхайг түшиглэсэн ажлын байр бий болсноос хариуцагчийн хаягаар хэрэг маргаан шийдвэрлэгдэж байгаатай холбоотой байж болох юм. Мөн төвийн бүсийн аймагт шинэ суурьшлын бүсүүд нэмэгдэж байгаа тул хэргийн тоо өсөж байна.
- Зүүн бүсийн Дорнод, Хэнтий аймагт гэрээний маргаан нийт шийдвэрлэсэн хэргийн 40 хувьд шийдвэрлэгддэг бол Сүхбаатар аймгийн шүүхийн хувьд 20 гаран хувийг эзэлж байна. Харин онцгой ажиллагааны хэрэг маргаан Сүхбаатар аймгийн шүүхийн нийт шийдвэрлэсэн хэргийн 50-аас дээш хувийг эзэлж байна.

Шалгуур үзүүлэлт	Гэрээтэй холбоотой, гэрээний бус үүрэгтэй холбоотой хэрэг маргаан /Их 60%-иас дээш, Бага 20%-иас доош/	Онцгой ажиллагааны маргаан /Их 60%-иас дээш, Бага 20%-иас доош/	Гэрлэлт цуцлалт, хүүхдийн тэтгэлэг гаргуулах, эцэг тогтоох /Их 13%-иас дээш, 6%-иас доош/	Ажлаас үндэслэлгүй халагдсан, цалин хөлс, буруу шилжүүлсэн, сахилгын шийтгэл /Их 4%-иас дээш, 1%-иас доош/
Их		✓ Завхан аймгийн Тосонцэнгэл		✓ Говь-Алтай
	✓ Баянзүрх	✓ Завхан	✓ Дорноговь	✓ Баян-Өлгий
	✓ Налайх	✓ Ховд аймгийн Булган	✓ Говьсүмбэр	✓ Чингэлтэй
	✓ Сонгинохайрхан	✓ Архангай	✓ Өмнөговь	✓ Увс
	✓ Хан-Уул	✓ Говь-Алтай	✓ Орхон	✓ Сүхбаатар
	✓ Баянгол	✓ Баянхонгор	✓ Налайх	дүүрэг
	✓ Багануур	✓ Төв	✓ Дархан-уул	✓ Ховд
		✓ Өвөрхангай		
		✓ Дундговь		

Бага	✓ Говь-Алтай	✓ Баянзүрх	✓ Баян-Өлгий	✓ Сонгинохайрхан
	✓ Завхан	✓ Говьсүмбэр	✓ Говь-Алтай	✓ Багахангай
	✓ Завхан аймгийн Тосонцэнгэл	✓ Багахангай	✓ Завхан	✓ Налайх
		✓ Налайх	✓ Ховд	✓ Өвөрхангай
	✓ Сонгинохайрхан	✓ Чингэлтэй	✓ Хэнтий	
	✓ Хан-Уул	дүүрэг		

Хүснэгт 228 Маргааны төрөл, эзлэх хувиар

Цаг үеийн нөхцөл байдал болон шүүхийн онцлогоос шалтгаалан тухайн шүүхийн хэрэг маргааны өсөлт бууралт харилцан адилгүй байгааг Хэнтий болон Төв аймгийн шүүхүүдийн жишээн дээр танилцуулъя.

- **Хэнтий аймаг 2009 онд 1826 хэрэг шийдвэрлэсэн бөгөөд өмнөх оноос 1154 хэргээр буюу 2.7 дахин өссөн** байна. Үүний 700-800 орчим шийдвэр нь Хэнтий Цахилгааны түгээх сүлжээний ХК-ны “Цахилгааны төлбөр гаргуулах тухай” нэхэмжлэлийг шийдвэрлэсэн шийдвэр байна. Эдгээр нэхэмжлэлийн дийлэнх нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74 дүгээр зүйлд зааснаар хялбаршуулсан журмаар шийдвэрлэгдсэн байна.
- **Төв аймгийн шүүхийн хувьд согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэхтэй холбоотой маргаан нийт хэргийн 40-45 орчим хувийг эзэлж байна.** 2000 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн Согтуурах Мансуурах Донтой Өвчтөнийг Албадан Эмчлэх Албадан Хөдөлмөр Хийлгэх тухай хуулийн дагуу өвчтөнүүдийг шүүгчийн захирамжаар албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх хугацааг дуусгавар болгодог байсныг Улсын Дээд Шүүхийн 2007 оны 3 сарын 18-ны өдрийн 15 дугаартай “Согтуурах мансуурах донтой өвчтэй этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай” тайлбарт зааснаар шүүхийн шийдвэрээр шийдвэрлэдэг болсон учир шийдвэрлэсэн хэргийн тоо 2007 онд 243-аар нэмэгдсэн бөгөөд 2007 оноос хойш тухайн шүүхийн иргэний хэрэг маргаан дээрх шалтгааны улмаас өсч байна.

3. Нийгэм эдийн засгийн бусад хүчин зүйлс

Иргэний хэргийн өсөлт, бууралтад нийгэм эдийн засгийн бусад хүчин зүйлс буюу хүн амын өсөлт, шилжилт хөдөлгөөн, улс төрийн бодлого, ажилгүйдэл, инфляци зэрэг хүчин зүйлс тодорхой хэмжээгээр нөлөөлж байна гэж үзэж байна. Тухайлбал, Монгол Улс²⁴ 2004 онд 2,521,733 амтай байсан бол 2021 он 3,409,939 хүн амтай болж 18 жилийн хугацаанд 888206 хүнээр буюу 35.2 хувиар өссөн байна. Нийслэлийн хүн амын хувьд 1109764 хүнээр буюу 72.6 хувиар харин орон нутгийн хүн амын хувьд 48442 хүнээр буюу 4.8 хувиар тус тус өссөн байна.

²⁴ Статистикийн мэдээллийн нэгдсэн сан 1212.mn



Зураг 28 Хүн амын тоо /2004, 2021 он/

Дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрлэсэн хэрэг, маргааны тоо жил тутам өсч байгаа нь хүн амын өсөлттэй тодорхой хэмжээгээр холбоотой байна гэж үзэж байна.

4. Иргэний хэргийн хүлээн авсан, шийдвэрлэсэн, үлдэгдэл хэргийн харьцаа

Иргэний хэргийн анхан шатны шүүхүүд сүүлийн 18 жилийн хугацаанд дунджаар хүлээн авсан хэргийн 72.7 хувийг хянан шийдвэрлэж, 9.5 хувь нь тухайн тайлант хугацааны үлдэгдэл хэрэг болон үлдэж байна. Хамгийн өндөр хувийн үлдэгдэлтэй хэрэг, 2021 онд хүлээн авсан хэргийн 13.2 хувийг, 2016 онд 12.4 хувийг, 2015 онд 11.7 хувийг, 2019 онд 11.5 хувийг тус тус эзэлж байна.

Хүлээн авсан хэрэг, шийдвэрлэсэн хэрэг өсөхөд үлдэгдэл хэрэг дагаж өсөх, хүлээн авсан хэрэг буурахад шийдвэрлэсэн хэрэг буурч, үлдэгдэл мөн дагаж буурч буй ерөнхий динамик харагдаж байна. Харин хүлээн авсан, шийдвэрлэсэн хэрэг буурсан байхад үлдэгдэл хэрэг өссөн зүй тогтол цөөхөн ажиглагдаж байна. Тухайлбал 2021 онд хүлээн авсан хэрэг өмнөх оноос 9.2 хувиар, хянан шийдвэрлэсэн хэргийн тоо 15.3 хувиар тус тус буурсан боловч үлдэгдэл хэргийн тоо 14.5 хувиар өссөн дүн гарсан байна. Энэ нь дэлхий нийтийг хамарсан цар тахлын нөхцөл байдалтай холбоотойгоор хорио цээрийн дэглэмд шилжин ажиллаж байсантай холбоотой байж болохоор байна.

Харин 2020 онд шүүхүүдийн хүлээн авсан хэрэг, маргаан 20.9 хувиар, хянан шийдвэрлэсэн хэрэг 19.2 хувиар өссөн бөгөөд үлдэгдэл хэрэг 10.5 хувиар өсөлттэй байгаа нь тухайн онд иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч ачаалалтай ажилласан байгааг харуулж байна.

Огноо	Хүлээн авсан хэрэг	Өсөлт, бууралт	Шийдвэрлэсэн хэрэг	Өсөлт, бууралт	Үлдэгдэл хэрэг	Өсөлт, бууралт
2004	35250		23269	-	2540	-
2005	36440	3.4	24492	5.3	2937	15.6
2006	39455	8.3	27469	12.2	2891	-1.6
2007	41878	6.1	30699	11.8	2667	-7.7
2008	38120	-9.0	28464	-7.3	2924	9.6
2009	48204	26.5	35822	25.9	4058	38.8
2010	48170	-0.1	35787	-0.1	4080	0.5
2011	42538	-11.7	30368	-15.1	3520	-13.7
2012	39690	-6.7	27792	-8.5	3767	7.0
2013	49581	24.9	35314	27.1	4628	22.9

2014	48431	-2.3	33996	-3.7	5680	22.7
2015	56607	16.9	40674	19.6	7018	23.6
2016	64030	13.1	46578	14.5	6632	-5.5
2017	63220	-1.3	45233	-2.9	6656	0.4
2018	64518	2.1	48155	6.5	5966	-10.4
2019	62010	-3.9	43397	-9.9	7107	19.1
2020	74684	20.4	53678	23.7	7812	9.9
2021	67805	-9.2	45444	-15.3	8947	14.5

Хүснэгт 229 Хүлээн авсан, шийдсэн, үлдэгдэл хэргийн харьцаа

Явцын дүгнэлт

Иргэний хэргийн анхан шатны шүүхийн хянан шийдвэрлэсэн хэргийн өсөлт бууралтад дараах хүчин зүйлс нөлөөлж байна. Үүнд

1. Эрх зүйн орчин
2. Цаг үеийн нөхцөл байдал
3. Бүсийн болон шүүхийн онцлог
4. Нийгэм эдийн засгийн бусад хүчин зүйлс

№	Нөлөө үзүүлсэн шалтгаан, нөхцөл	Нөлөө үзүүлж буй шалтгаан нөхцөлийн утга
1	Хугацааны нөлөө	Шийдвэрлэсэн хэргийн тооны өгөгдлийн 2004-2021 оны хоорондох хугацаа нь аймгийн шүүхэд дунд болон сул нөлөөтэй байна. Харин дүүргийн ИХАШШ-ийн хувьд 93 хувийн нөлөөтэй байна.
2	Эрх зүйн орчин	Шийдвэрлэсэн хэргийн тооны өгөгдлийн 2004-2021 оны хоорондох хугацааны өсөлт бууралтад Иргэний хууль, ИХШХШТХ-ийн өөрчлөлт, Шүүх байгуулах тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн өөрчлөлт зэрэг нь тодорхой хэмжээнд нөлөөлж байна гэж үзэж байна. Тухайлбал Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай хуулийн 2012, 2017 онуудын нэмэлт өөрчлөлтөөр ажилласан жил тогтоосон маргаан 3000-6000 хэргээр өссөн нь иргэний хэрэг маргаан өсөж буурахад нөлөөлж байна.
3	Цаг үеийн нөхцөл байдлын онцлог	Дэлхийн эдийн засгийн хямрал, дэлхий нийтийг хамарсан цар тахал, сонгууль, банк, банк зээлийн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн төлбөрийн чадваргүй байдал, дампуурал, бодлого шийдвэртэй холбоотойгоор иргэний хэрэг маргаан өсч, буурч байна. Тухайлбал, 2008-2009 онд “Зоос”, “Анод” банкнууд төлбөрийн чадваргүй болж, дампуурлаа зарласантай холбоотой банкнаас олгох зээлтэй холбоотой маргаан 2-3 дахин өссөн бөгөөд тухайн жилүүдэд иргэний хэрэг өсөх гол шалтгаан болсон гэж үзэж болохоор байна. 2015-2017 онуудад иргэд хоорондын зээлтэй холбоотой хэрэг маргаан 1500-3500 хэргээр өссөн нь хадгаламжийн хүүгээс татвар авдаг тогтолцоонд шилжсэнтэй холбоотойгоор иргэд хадгаламжаа өөр эх үүсвэр рүү байршуулснаар иргэд хоорондын чанаргүй зээлийн хэмжээ нэмэгдэж, энэ төрлийн хэрэг маргаан өсөх нэг гол шалтгаан нөхцөл болсон байна. Мөн дэлхий нийтийг хамарсан цар тахалтай холбоотойгоор 2020 онд шүүхүүдийн хүлээн авсан хэрэг, маргаан 20.9 хувиар, хянан шийдвэрлэсэн хэрэг 19.2 хувиар өссөн бөгөөд 2021 оноос буурах төлөв ажиглагдаж байна. Харин үлдэгдэл хэрэг харьцангуй бага хувиар өсөлттэй байгаа нь тухайн онд иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч ачаалалтай ажилласан байгааг харуулж байна.
4	Бүс, шүүхийн онцлог болон тухай орон нутгийн онцлог	Орон нутгийн болон нийслэлийн 9 дүүргийн шүүхийн хувьд шийдвэрлэсэн хэрэг, маргааны төрлөөр өөр өөр байна. Тухайлбал, Дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн хувьд гэрээний маргаан өндөр шийдвэрлэлттэй байгаа бол орон нутгийн шүүхийн хувьд онцгой ажиллагааны маргаан буюу ажилласан жил тогтоосон маргаан өндөр шийдвэрлэлттэй байна. Орон нутгийн шүүхүүдээс ажилласан жил тогтоохтой холбоотой маргаан баруун бүсийн шүүхэд илүү өндөр мөн хөдөлмөрийн маргаан буюу ажлаас

		үндэслэлгүй халсан, цалин хөлсний маргаан бусад бүсийг бодвол мөн баруун бүсэд харьцангуй өндөр байна. Төвийн бүсийн хувьд Өмнөговь, Дорноговь, Говьсүмбэр аймгуудад гэрлэлт цуцлах маргаан, хүүхдийн тэтгэлэг гаргуулах маргаан, эцэг тогтоохтой холбоотой маргаан их байна. Учир нь уул уурхайг түшиглэсэн ажлын байр бий болсноос хариуцагчийн хаягаар хэрэг маргаан шийдвэрлэгдэж байгаатай холбоотой байж болох юм. Мөн төвийн бүсийн аймагт шинэ суурьшлын бүсүүд нэмэгдэж байгаа тул хэргийн тоо өсөх хандлагатай байна. Төв аймгийн шүүхийн хувьд согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэхтэй холбоотой маргаан нийт хэргийн 40-45 орчим хувийг эзэлж байна.
5	Нийгэм эдийн засгийн хүчин зүйл	Нийгэм эдийн засгийн бусад хүчин зүйлс буюу хүн амын өсөлт, шилжилт хөдөлгөөн, улс төрийн бодлого ажилгүйдэл, инфляци зэрэг хүчин зүйлс хэрэг, маргааны өсөлтөд нөлөө үзүүлж байна. Тухайлбал, Монгол Улс 2004 онд 2,521,733 амтай байсан бол 2021 он 3,409,939 хүн амтай болж 18 жилийн хугацаанд 888206 хүнээр буюу 35.2 хувиар өссөн байна. Нийслэлийн хүн амын хувьд 1109764 хүнээр буюу 72.6 хувиар харин орон нутгийн хүн амын хувьд 48442 хүнээр буюу 4.8 хувиар тус тус өссөн байна.

Хүснэгт 230 Иргэний хэргийн шүүхэд нөлөөлж буй хүчин зүйлс

• Захиргааны хэрэг

Монгол Улсын шүүхээр 2004-2021 онд 20420 иргэний хэрэг, маргаан хянан шийдвэрлэгдсэн байна.

№	Огноо	Шийдвэрлэсэн хэрэг	Өсөлт, бууралт тоо	Өсөлт, бууралт хувь
1	2004	134	-	-
2	2005	388	254	2.9 дахин
3	2006	431	43	11.1
4	2007	591	160	37.1
5	2008	826	235	39.8
6	2009	1074	248	30.0
7	2010	1031	-43	-4.0
8	2011	961	-70	-6.8
9	2012	891	-70	-7.3
10	2013	1106	215	24.1
11	2014	1187	81	7.3
12	2015	1439	252	21.2
13	2016	1780	341	23.7
14	2017	1908	128	7.2
15	2018	1638	-270	-14.2
16	2019	1747	109	6.7
17	2020	1524	-223	-12.8
18	2021	1764	240	15.7
19	Дундаж	20420	-	21.7


Хүснэгт 231 Нийт хэрэгт эзэлж байгаа хувиар

2004 оны 6 сард Захиргааны хэргийн дагнасан шүүх анх байгуулагдсанаар захиргааны шүүхэд хандах иргэн, албан тушаалтан олширч, жил ирэх тусам захиргааны хэргийн тоо өссөн үзүүлэлттэй байна. Тухайлбал, 2005 онд 254 хэргээр буюу 2.9 дахин, 2006 онд 43 хэргээр буюу 11.1 хувиар, 2007 онд 160 хэргээр буюу 37.1 хувиар, 2008 онд 235 хэргээр буюу 39.8 хувиар, 2009 онд 248 хэргээр буюу 30 хувиар тус тус өссөн бөгөөд энэ үе нь захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа тогтворжих үе байна.

Харин 2010 онд 43 хэргээр буюу 4 хувиар, 2011 онд 70 хэргээр буюу 6.8 хувиар, 2012 онд 70 хэргээр буюу 7.3 хувиар тус тус буурсан байна. Харин 2013 оноос хэрэг, маргаан өссөн байна. Захиргааны хэрэг, маргааны өсч, буурч байгаа гол шалтгаан бол УИХ, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуультай холбоотойгоор сонгуулийн маргаан, төрийн албаны маргаан, цаашлаад газрын маргаан өсөх хандлагатай холбоотой байна.


1. Хэрэг, маргааны төрөл

Захиргааны хэрэг маргааны 25 орчим хувийг газрын маргаан, 20 орчим хувийг төрийн албаны маргаан, 7 орчим хувийг ашигт малтмалтай холбоотой маргаан, 6 орчим хувийг татварын маргаан, 5 орчим хувийг эд хөрөнгийн улсын бүртгэлтэй холбоотой маргаан, мөн 5 орчим хувийг төрийн хяналт шалгалттай холбоотой бусад маргаан, 4 орчим хувийг сонгуулийн маргаан, мөн 4 орчим хувийг тендерийн маргаан, 2 орчим хувийг нийгмийн даатгалтай холбоотой маргаан эзэлж байна.



Зураг 29 Захиргааны хэргийн маргааны төрөл, эзлэх хувиар

Газрын маргаан: Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль 2003 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор газрын маргаан жил бүр нэмэгдэж байна.




Зураг 30 Газрын маргаан /2004-2021 он/

Газрын маргаанд газар эзэмших, ашиглах эрхийг цуцалсан, дуусгавар болгохтой холбоотой, газрын давхцал, орц гарц хаасантай холбоотой, газар эзэмших, ашиглах, өмчлөх хүсэлтийг шийдвэрлээгүй, газар эзэмших, ашиглах эрхийг сунгаагүй, газрыг тусгай хэрэгцээнд авсан, нөхөн олговортой холбоотой, бусад газрын маргаанууд хамаардаг.

Газрын маргаантай хэргийн 65 орчим хувь нь нийслэлд байдаг бол орон нутгаас Төв аймаг, Баян-Өлгий аймаг, Дархан-уул аймаг, Сэлэнгэ аймгуудад энэ төрлийн маргаан их байдаг байна.

Төрийн албаны маргаан: Сүүлийн 18 жилд аймаг, Нийслэлийн Захиргааны хэргийн шүүхүүд төрийн албан хаагчийг төрийн албанаас үндэслэлгүйгээр халсан, чөлөөлсөн, цалин хөлсний маргаан, өөр ажилд шилжүүлсэн, сахилгын шийтгэлийг хууль бусаар ногдуулсан, сонгон шалгаруулалтыг буруу явуулсан тухай маргаантай холбоотой 3934 хэргийг Төрийн албаны тухай хуулийн холбогдох зүйл, заалтыг баримтлан шийдвэрлэсэн байна.²⁵

Энэ нь захиргааны хэргийн шүүхийн нэг жилд шийдвэрлэсэн хэргийн 20 орчим хувийг эзэлж байгаа бөгөөд төрийн албан хаагчийн хөдөлмөрийн маргаантай холбоотой хэрэг 2013 оноос 2017 он хүртэл огцом өссөн бол, 2018 оноос буурсан төлөв байдалтай байна.



Зураг 31 Төрийн албаны маргаан /2004-2021 он/

²⁵ Монгол Улсын шүүхийн шүүн таслах ажиллагааны 2004-2021 оны статистик мэдээ, тайлан.

Төрийн албаны маргаан буюу ажлаас үндэслэлгүй халагдсан маргаан нь УИХ, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн дараагийн жилд өсөх хандлагатай байгаа нь дээрх судалгаануудаас харагдаж байна. Энэ нь Засгийн газар шинэчлэгдэн байгуулагдах, яам, агентлагийн бүтэц, зохион байгуулалт, төрийн албан хаагчдын орон тоо, ажлын байрны чиг үүрэг өөрчлөгдөх зэрэг шалтгаануудтай холбоотой байж болох юм. Тухайлбал, 2008 онд Захиргааны хэргийн шүүхэд төрийн албаны 100 хэрэг, маргаан хянан шийдвэрлэж байсан бол тухайн сонгуулийн дараагийн жил буюу 2009 онд 197 хэрэг хянан шийдвэрлэж энэ төрлийн хэрэг, маргаан 2 дахин өссөн. Мөн 2012 оны сонгуулийн жил төрийн албаны 133 хэрэг, маргаан хянан шийдвэрлэж байсан бол 2013 онд энэ төрлийн хэрэг, маргаан 203 болж 52 хувиар, 2016 онд төрийн албаны 417 хэрэг, маргаан хянан шийдвэрлэж байсан бол 2017 онд 660 болж 58 хувиар тус тус өссөн байна. Харин 2020 онд төрийн албаны 199 хэрэг, маргаан хянан шийдвэрлэсэн бол 2021 онд төрийн албаны 305 хэрэг маргаан, хянан шийдвэрлэсэн бөгөөд мөн өмнөх оноос 53.3 хувиар өссөн байна.

Сонгуулийн маргаан: Сонгуулийн маргаанд нэр дэвшигчээр бүртгэх, хассантай холбоотой, сонгуулийн сурталчилгаатай холбоотой, сонгогчийн нэрсийн жагсаалттай холбоотой, санал хураалт, дүнтэй холбоотой, ИНХурлын сонгуультай холбоотой /МУЗЗНДНТУТХ/, сонгуультай холбоотой бусад маргаанууд хамаардаг.



Зураг 32 Сонгуулийн маргаан /2004-2021 он/

Сонгуулийн жилүүдэд захиргааны хэрэг, маргаан өсч байгаа гол шалтгаан бол сонгуультай холбоотой хэрэг маргаанаас шууд хамааралтай байна.

2. **Бүсийн болон шүүхийн онцлог**

Маргааны төрлөөр хамгийн өндөр хувийг эзэлдэг аймгуудыг доор хүснэгтэд харуулбал:

№	Бүлгийн үзүүлэлт	Шийдвэрлэсэн хэрэгт эзлэх хувиар
1	Газрын /25% хүртэл/	Төв, Баян-Өлгий, Дархан-Уул, Сэлэнгэ, Орхон
2	Иргэний бүртгэлтэй холбоотой	Өвөрхангай, Сүхбаатар, Хөвсгөл
3	Нийгмийн даатгалын	Архангай, Баян-Өлгий, Ховд, Сүхбаатар, Хөвсгөл
4	Сонгуулийн	Орхон, Баян-Өлгий, Завхан, Сүхбаатар, Увс
5	Татварын	Орхон, Өмнөговь, Хөвсгөл, Говьсүмбэр, Дорноговь, Төв
6	Төрийн албаны /20% хүртэл/	Архангай, Баян-Өлгий, Говь-Алтай, завхан, Ховд, Булган
7	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил	Дорноговь, Баян-Өлгий, Орхон

	үйлчилгээ худалдан авахтай холбоотой /тендер/	
8	Төрийн хяналт шалгалтын	Баян-Өлгий, Дорноговь, Баянхонгор, Дундговь, Дорноговь, Дорнод, Сэлэнгэ, Хөвсгөл, Ховд
9	Хуулийн этгээдийн бүртгэлийн	Ховд, Булган, Хөвсгөл
10	Эд хөрөнгийн эрхийн бүртгэлтэй холбоотой	Дархан-Уул, Орхон, Сэлэнгэ, Увс, Хөвсгөл

Хүснэгт 232 Шийдвэрлэсэн хэрэгт эзлэх хувиар

2004-2021 онуудад аймгуудын шүүхийн өссөн буурсан хэргийн, шалтгаан нөхцөлийг аймаг тус бүрээр нь судалж үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

- Баян-Өлгий аймгийн хувьд 2009 онд 69 хэрэг, маргаан шийдвэрлэсэн бөгөөд өмнөх оноос 22 хэргээр буюу 46.8 хувиар өссөн. Хэрэг маргаан өссөн гол шалтгаан бол 2008 онд төрийн албаны 12 хэрэг шийдвэрлэсэн бол 2009 онд 31 хэрэг шийдвэрлэж 19 хэргээр өссөн байгаатай холбоотой бөгөөд төрийн албаны маргаан тэр дундаа ажлаас үндэслэлгүй халахтай холбоотой маргаан сонгуулийн дараагийн жилүүдэд өсдөг. Мөн 2017 онд Баян-Өлгий аймгийн шүүх 74 хэрэг хянан шийдвэрлэсэн бөгөөд өмнөх оноос 24 хэргээр буюу 48 хувиар өссөн байна. Мөн л төрийн албаны 50 хэрэг маргаан хянан шийдвэрлэсэн бөгөөд өмнөх оноос 34 хэргээр нэмэгдсэн тул 2017 онд хэрэг маргаан өсөхөд төрийн албан маргаан өссөн нь нөлөөлсөн байна.
- Говь-Алтай аймгийн хувьд 2021 онд 52 хэрэг маргаан хянан шийдвэрлэсэн бөгөөд өмнөх оноос 26 хэргээр буюу 2 дахин өссөн. Үүний дийлэнх хувь нь 2021 онд төрийн албаны хэрэг, маргаан 18 хэргээр өссөн байгаатай холбоотой байна.
- Завхан аймгийн хувьд 2008 онд 3 хэрэг шийдвэрлэсэн бол 2009 онд 37 хэрэг хянан шийдвэрлэсэн бөгөөд төрийн албаны маргаан 2008 онд 1 хэрэг хянан шийдвэрлэгдсэн бол 2009 онд 26 хэрэг хянан шийдвэрлэгдсэн байна. Мөн энэ онд сонгуулийн хэрэг, маргаан 5 хэрэг шийдвэрлэгдсэн нь хэрэг маргаан өсөх шалтгаан нөхцөл болсон байна.
Мөн 2017 онд төрийн албаны маргаан 30 хэргээр, 2021 онд 12 хэргээр тус тус өссөн байна.
- Увс аймгийн хувьд 2021 онд 83 хэрэг шийдвэрлэж өмнөх оноос 57 хэргээр 3.2 дахин өссөн байна. Энэ нь 2021 оны орон нутгийн сонгуульд нэр дэвшигчдийг сонгуулийн дансны дугаар банкны нэрийг Увс аймгийн Төрийн аудитын газарт бүртгүүлээгүй зөрчил гаргасан гэж үзэж татварын улсын байцаагч торгох шийтгэл оногдуулсан байна. Иймд шүүхэд 2021 онд актыг хүчингүй болгуулах маргаан 27 шүүхээр шийдвэрлэгдсэн байсан нь хэрэг маргаан өсөх гол шалтгаан болсон байна. Мөн төрийн албаны маргаан 13 хэргээр өссөн.
- Ховд аймгийн хувьд 2007 онд шийдвэрлэсэн хэрэг 23 хэргээр буюу 54.8 хувиар өссөн бөгөөд үүнд төрийн албаны маргаан 10 хэргээр, сонгуулийн маргаан 6 хэргээр, төрийн хяналт шалгалттай холбоотой маргаан 4 хэргээр нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.
- Архангай аймгийн хувьд 2017 онд 23 хэргээр буюу 69.7 хувиар өссөн бөгөөд энэ онд төрийн албаны 38 хэрэг хянан шийдвэрлэсэн нь өмнөх оноос 22 хэргээр өссөн байна. 2021 онд шийдвэрлэсэн хэрэг 19 хэргээр өссөн бөгөөд нийгмийн даатгалтай холбоотой маргаан 18 хэргээр нэмэгдсэн байна. Энэ нь

Нийгмийн даатгалын ерөнхий газраас 2020 оны 11 дүгээр сард Архангай аймгийн Нийгмийн даатгалын хэлтэст дотоод хяналт, шалгалт хийж, улмаар 2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн “Нэр бүхий иргэдийн тэтгэврийн олголт зогсоох тухай” 32/05 дугаар актаар хуурамч баримт бүрдүүлэн хөнгөлөлттэй нөхцөлөөр тэтгэвэр тогтоолгосон нэр бүхий 51 иргэдийн мэдээллийг аймгийн Нийгмийн даатгалын хэлтэст хүргүүлж, уг иргэдийн мэдээллийг тэтгэврийн программд зогсоох хөдөлгөөнөөр бүртгэхийг даалгаж, холбогдох байцаагч нарт танилцуулсан акт гарсан байна.

- Орхон аймаг 2009 онд 65 хэрэг маргаан хянан шийдвэрлэсэн бөгөөд газрын маргаан 5 хэргээр, сонгуулийн маргаан 5 хэрэг, төрийн албаны маргаан 6 хэрэг, үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлтэй холбоотой маргаан 8 хэргээр тус тус нэмэгдсэн байна. Энэ онд үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлтэй холбоотой 18 хэрэг хянан шийдвэрлэгдсэн нь нийт шийдвэрлэсэн хэргийн өсгөх нэг шалтгаан болсон байна.
- Хөвсгөл аймгийн хувьд 2007 онд 50 хэрэг, маргаан хянан шийдвэрлэсэн бөгөөд өмнөх оноос 22 хэргээр өссөн байна. Энэ нь онд хянан шийдвэрлэсэн 50 хэрэг маргааны 41 хэрэг нь улсын байцаагчийн актыг түдгэлзүүлэхтэй холбоотой хэрэг байна. Харин 2015 онд мөн 50 хэрэг маргаан хянан шийдвэрлэсэн бөгөөд өмнөх оноос 21 хэргээр өссөн байна. Энэ өсөлтийн шалтгаан нь 2015 онд төрийн албаны маргаан 19 хэргээр өссөнтэй холбоотой байна. Өөрөөр хэлбэл төрийн албан хаагчийг төрийн албанаас үндэслэлгүйгээр халсан, чөлөөлсөн, цалин хөлсний маргаан, өөр ажилд шилжүүлсэн, сахилгын шийтгэлийг хууль бусаар ногдуулсан, сонгон шалгаруулалтыг буруу явуулсан тухай маргаантай холбоотой юм.
- Дархан-Уул аймгийн хувьд 2016 онд 96 хэрэг маргаан хянан шийдвэрлэсэн бөгөөд өмнөх оноос 2.1 дахин өссөн бөгөөд энэ онд газрын маргаан, 18 хэргээр, сонгуулийн маргаан 20 хэргээр, төрийн албаны маргаан 11 хэргээр тус тус өссөн байна.
Энэ онд Дархан-Уул аймгийн засаг даргад холбогдох газар өмчлөх эрхийг хүчингүй болгуулах тухай нэхэмжлэлтэй хэрэг маргаан их шийдвэрлэгдсэн бөгөөд сонгуулийн санал, хураалттай холбоотой маргаан, сонгуулийн нэр дэвшигчээр бүртгүүлэхийг даалгахтай холбоотой маргаанууд, төрийн албаны маргаан буюу төрийн албан хаагчийн ажлаас үндэслэлгүй халагдсантай холбоотой маргаануудын тоо өссөн нь хэрэг маргаан өсөх гол шалтгаан болсон байна.
- Өмнөговь аймгийн хувьд 2019 онд татварын хяналт шалгалттай холбоотой татварын байцаагчийн актыг хүчингүй болгуулах маргаан 10 шийдвэрлэгдсэн байна.
- Дундговь аймгийн хувьд 2021 онд 63 хэрэг маргаан хянан шийдвэрлэсэн бөгөөд энэ нь өмнөх оноос 46 хэргээр буюу 3.7 дахин өссөн байна.
Дундговь аймгийн Ерөнхий прокурорын дэргэдэх зөвлөлийн хуралдаанаас гаргасан шийдвэрийн дагуу Мэргэжлийн хяналтын улсын байцаагч нарын Зөрчлийн тухай болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль зөрчиж шийтгэл оногдуулсан шийтгэлийн хуудсыг хүчингүй болгуулах шаардлага

- бүхий 49 нэхэмжлэл шүүхэд ирсэн. Тус нэхэмжлэлүүдэд захиргааны хэрэг үүсгэж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулсан болно.
- Сэлэнгэ аймгийн хувьд 2019 онд 44 хэрэг хянан шийдвэрлэсэн бөгөөд энэ өмнөх оноос 16 хэргээр өссөн байна. Захиргааны хэрэг, маргаан өсөхөд байгаль орчны, гааль, татварын байцаагчийн актыг хүчингүй болгуулахтай холбоотой маргаан 23 шийдвэрлэгдсэн нь нөлөөлсөн байна.
 - Төв аймгийн хувьд 2016 онд 41 хэрэг хянан шийдвэрлэсэн бөгөөд энэ нь өмнөх оноос 17 хэргээр өссөн байна. Хэрэг маргаан өсөхөд ашигт малтмалтай холбоотой маргаан 7 хэргээр энэ онд өссөн бол 2016 оны сонгуультай холбоотой 10 маргаан шийдвэрлэгдсэн байна. Ашигт малтмалын маргааны хувьд Төв аймгийн Иргэдийн төлөөлөгчийн хурал болон Сүмбэр, Баян, Алтан булаг сумдын Иргэдийн төлөөлөгчийн хурлын шийдвэрийг хүчингүй болгуулах нэхэмжлэлтэй маргаанууд байна. Сонгуулийн маргааны хувьд нэр дэвшигчийг бүртгэлээс хасах, нэр дэвшигчийг бүртгэхийг даалгах тухай нэхэмжлэлтэй сонгуулийн хэргүүдийг шийдвэрлэсэн байна.
 - Сүхбаатар аймгийн хувьд 2017 онд 45 хэрэг маргаан хянан шийдвэрлэсэн бөгөөд өмнөх оноос 24 хэргээр буюу 2.1 дахин өссөн бөгөөд энэ онд төрийн албаны маргаан 22 хэргээр өссөн нь хянан шийдвэрлэж байгаа хэрэг маргаан өсөх гол шалтгаан болсон байна.
 - Нийслэлийн шүүхийн хувьд газрын маргаан хамгийн өндөр буюу нийт шийдвэрлэж байгаа хэргийн 25 орчим хувь, төрийн албаны маргаан 16.1 хувь, Ашигт малтмалын маргаан 11 хувь, татварын маргаан 5.3 хувь, тендерийн маргаан 5 орчим хувь, эд хөрөнгийн эрхийн бүртгэлтэй холбоотой маргаан 5 орчим хувь, төрийн хяналт шалгалттай холбоотой маргаан 3 хувь, нийгмийн даатгалын маргаан 2 хувь, хуулийн этгээдийн бүртгэлтэй холбоотой маргаан 2 орчим хувь, тусгай зөвшөөрөлтэй холбоотой маргаан 1.7 орчим хувийг тус тус эзэлж байна. 2015 онд 292 хэргээр өссөн бөгөөд энэхүү өсөлтөд төрийн албаны маргаан 87 хэргээр ашигт малтмалын маргаан 39 хэргээр, татварын маргаан 48 хэргээр, эд хөрөнгө, хуулийн этгээдийн бүртгэлтэй холбоотой маргаан 46 хэргээр, тендерийн маргаан 21 хэргээр тус тус өссөн байна.

3. Захиргааны хэргийн хүлээн авсан, шийдвэрлэсэн, үлдэгдэл хэргийн харьцаа

Захиргааны хэргийн анхан шатны шүүхүүд сүүлийн 18 жилийн хугацаанд дунджаар хүлээн авсан хэргийн 59.8 хувийг хянан шийдвэрлэж, 21.5 хувь нь тухайн тайлант хугацааны үлдэгдэл хэрэг болон үлдэж байна. Шийдвэрлэсэн хэргийн хүлээн авсан хэрэгт эзлэх хувиар хамгийн өндөр 2017 онд 77.6 хувь, 2019 онд 70.9 хувь, 2021 онд 68.5 хувь тус тус байна.

Хамгийн өндөр хувийн үлдэгдэлтэй 2020 онд хүлээн авсан хэргийн 33.7 хувийг, 2018 онд 33.3 хувийг, 2021 онд 31.5 хувийг, 2019 онд 29.1 хувийг тус тус эзэлж байна.

2004-2019 онуудад хүлээн авсан хэрэг, шийдвэрлэсэн хэрэг өсөхөд үлдэгдэл хэрэг дагаж өсөх, хүлээн авсан хэрэг буурахад шийдвэрлэсэн хэрэг буурч, үлдэгдэл мөн дагаж буурч буй ерөнхий динамик харагдаж байгаа бөгөөд 2020 онд хүлээн авсан хэрэг 667 хувиар, шийдвэрлэсэн хэрэг 12.8 хувиар буурч харин үлдэгдэл хэрэг

8.1 хувиар өссөн байна. Энэ нь дэлхий нийтийг хамарсан цар тахлын нөхцөл байдалтай холбоотойгоор хорио цээрийн дэглэмд шилжүүлэн ажиллуулж байсантай холбоотой байж болох юм.

Огноо	Хүлээн авсан хэрэг	Өсөлт, бууралт	Шийдвэрлэсэн хэрэг	Өсөлт, бууралт	Үлдэгдэл хэрэг	Өсөлт, бууралт
2004	174		134		40	
2005	745	328.2	388	189.6	73	82.5
2006	765	2.7	431	11.1	112	53.4
2007	998	30.5	591	37.1	120	7.1
2008	1455	45.8	826	39.8	202	68.3
2009	1739	19.5	1074	30.0	243	20.3
2010	1690	-2.8	1031	-4.0	250	2.9
2011	1740	3.0	961	-6.8	341	36.4
2012	1556	-10.6	891	-7.3	262	-23.2
2013	2170	39.5	1106	24.1	531	102.7
2014	2437	12.3	1187	7.3	602	13.4
2015	2775	13.9	1439	21.2	695	15.4
2016	3234	16.5	1780	23.7	644	-7.3
2017	2458	-24.0	1908	7.2	550	-14.6
2018	2534	3.1	1689	-11.5	845	53.6
2019	2464	-2.8	1747	3.4	717	-15.1
2020	2299	-6.7	1524	-12.8	775	8.1
2021	2574	12.0	1764	15.7	810	4.5

Хүснэгт 233 Хүлээн авсан, шийдсэн, үлдэгдэл хэргийн харьцаа

Явцын дүгнэлт

1. Захиргааны хэрэг, маргааны өсч, буурч байгаа гол шалтгаан, нөхцөлд УИХ, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль нөлөөлж байгаа нь статистик мэдээнээс харагдаж байна. Сонгуулийн жилүүдэд сонгуулийн маргаан огцом өсч, сонгуулийн дараагийн 1-2 жилд төрийн албаны маргаан, улмаар ажлаас үндэслэлгүй халагдсан хэрэг, маргаан өсч байна.
2. Эрх зүйн орчны нөлөөллөөс захиргааны хэрэг маргаан өсч байна. Тухайлбал, Газрын тухай хуулийн өөрчлөлт, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль, хуулийн өөрчлөлттэй холбоотой газрын маргаан жил бүр нэмэгдэж байгаа бөгөөд захиргааны хэргийн шүүхийн шийдвэрлэж байгаа хэргийн хамгийн их хувь буюу 25 орчим хувийг эзэлж байна.
3. Улсын байцаагчийн актыг хүчингүй болгуулахтай холбоотой маргаанууд сүүлийн жилүүдэд өсч байна. Тухайлбал, Дундговь аймгийн хувьд 2021 онд 63 хэрэг маргаан хянан шийдвэрлэсэн бөгөөд энэ нь өмнөх оноос 46 хэргээр буюу 3.7 дахин өссөн байна. Дундговь аймгийн Ерөнхий прокурорын дэргэдэх зөвлөлийн хуралдаанаас гаргасан шийдвэрийн дагуу Мэргэжлийн хяналтын улсын байцаагч нарын Зөрчлийн тухай болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль зөрчиж шийтгэл оногдуулсан шийтгэлийн хуудсыг хүчингүй болгуулах шаардлага бүхий 49 нэхэмжлэл шүүхэд ирсэн. Тус нэхэмжлэлүүдэд захиргааны хэрэг үүсгэж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулсан байна. Мөн Увс аймгийн хувьд 2021 онд 83 хэрэг шийдвэрлэж өмнөх оноос 57 хэргээр 3.2 дахин өссөн байна. Энэ нь 2021 оны орон нутгийн сонгуульд нэр дэвшигчдийг сонгуулийн дансны дугаар банкны нэрийг Увс

аймгийн Төрийн аудитын газарт бүртгүүлээгүй зөрчил гаргасан гэж үзэж татварын улсын байцаагч торгох шийтгэл оногдуулсан байна. Үүний дагуу шүүхэд татварын байцаагчийн актыг хүчингүй болгуулах 27 нэхэмжлэл ирсэн бөгөөд тус нэхэмжлэлүүдэд захиргааны хэрэг үүсгэж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулсан байна.

№	Нөлөө үзүүлсэн шалтгаан, нөхцөл	Нөлөө үзүүлж буй шалтгаан нөхцөлийн утга
1	Хугацааны нөлөө	Шийдвэрлэсэн хэргийн тооны өгөгдлийн 2004-2021 оны хоорондох хугацаа нь аймгийн шүүхэд дунд болон сул нөлөөтэй байна. Харин Нийслэл дэх ЗХАШШ-д 91 хувийн хүчтэй нөлөөтэй байна.
2	Эрх зүйн орчин	Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрлэсэн хэргийн тооны өгөгдлийн 2004-2021 оны хоорондох хугацааны өсөлт бууралтад Захиргааны ерөнхий хууль, ЗХШШТХ-ийн өөрчлөлт болон холбогдох бусад хууль тогтоомжийн өөрчлөлт зэрэг нь тодорхой хэмжээнд нөлөөлж байна гэж үзэж байна.
3	Сонгуулийн нөхцөл байдал	Захиргааны хэрэг, маргааны өсөж, буурч байгаа гол шалтгаан, нөхцөлд УИХ, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль нөлөөлж байгаа нь статистик мэдээнээс харагдаж байна. Сонгуулийн жилүүдэд сонгуулийн маргаан огцом өсч, сонгуулийн дараагийн 1-2 жилд төрийн албаны маргаан, улмаар ажлаас үндэслэлгүй халагдсан хэрэг, маргаан өсч, захиргааны хэрэг, маргаан өсөх шалтгаан нөхцөл болж байна.
4	Бүс, шүүхийн онцлог болон тухай орон нутгийн онцлог	Сүүлийн жилүүдэд улсын байцаагчийн актыг хүчингүй болгуулахтай холбоотой маргаанууд өсч байна. Тухайлбал, Дундговь аймгийн хувьд 2021 онд 63 хэрэг маргаан хянан шийдвэрлэсэн бөгөөд энэ нь өмнөх оноос 6 хэргээр буюу 3.7 дахин өссөн байна. Дундговь аймгийн Ерөнхий прокурорын дэргэдэх зөвлөлийн хуралдаанаас гаргасан шийдвэрийн дагуу Мэргэжлийн хяналтын улсын байцаагч нарын Зөрчлийн тухай болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль зөрчиж шийтгэл оногдуулсан шийтгэлийн хуудсыг хүчингүй болгуулах шаардлага бүхий 49 нэхэмжлэл шүүхэд ирсэн. Тус нэхэмжлэлүүдэд захиргааны хэрэг үүсгэж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулсан байна.
5	Нийгэм эдийн засгийн хүчин зүйл	Нийгэм эдийн засгийн бусад хүчин зүйлс буюу хүн амын өсөлт, шилжилт хөдөлгөөн, төрийн байгууллагын тоо, улс төрийн бодлого ажилгүйдэл, инфляци зэрэг хүчин зүйлс бага зэргийн нөлөө үзүүлж байна.

Хүснэгт 234 Захиргааны хэргийн шүүхэд нөлөөлж буй хүчин зүйл

Дүгнэлт

Үндсэн тайланд дурдсан 2017-2021 оны хооронд 1 шүүгч 1 жилд хянан шийдвэрлэж байгаа хэргийн тоог ашиглан 2024 оны байдлаар хянан шийдвэрлэх хэргийн тоог тооцож үзэхэд хамгийн ихдээ 27 /зөрчлийн хэрэг/ хүртэл хэргээр нэмэгдэх хандлагатай байна.

Ачаалал ихтэй дүүргийн шүүхүүдийн хувьд 2004-2021 оны өгөгдөл Шүүх байгуулах тухай хуулийн үйлчлэлээр гарах боломжгүй байдлыг нэмж судлан тодруулах шаардлагатай байна.

Бусад хүчин зүйлийн нөлөө нь хугацаанаас хамаарсан нөлөөллийн хэмжээтэй адил тодорхой тоон дүнгээр илэрхийлэгдэх боломж хязгаарлагдмал, эрх зүйн орчин, цаг үеийн нөхцөл байдал зэрэг нийгмийн үзэгдэл, хүний үйл ажиллагаанаас голлон хамаарч байна. Хугацаанаас гадна бусад шалтгаан нөхцөлүүдийг хэргийн төрөл тус бүрийн хувьд дүгнэвэл:

Эрүүгийн хэргийн болон иргэний хэргийн хувьд эрх зүйн орчны нөлөөлөл их байгаа бол захиргааны хэргийн хувьд улс төрийн, сонгуулийн үйл явцын нөлөөлөл

өндөр байна. Хууль эрх зүйн орчны нөлөөлөл өндөр байгаагаас шалтгаалан цаашид нөлөөллийг тодорхойлон гаргах боломжгүй байна.

Цаашид шүүхийн захиргааны үйл ажиллагаанд шүүхийн статистикийн болон бусад мэдээллийн бааз, сан бүрдүүлэхэд засаг захиргааны нэгж, шүүх бүрээр мэдээллийг бэлтгэн хугацааны цувааг олон жилээр нь үүсгэж, судалгааны эргэлтэд оруулж хэвших нь чухал байна.

Хүлээн авсан хэрэг, нэхэмжлэлийн тоонд үүсэх хэлбэлзэл нь шийдвэрлэсэн хэргийн тоонд мөн адил зүй тогтлоор хэлбэлзлийг үүсгэсэн байгаа нь тухай шүүхийн хүлээн авсан хэрэг, нэхэмжлэлийн тоо нь өмнөх жилийнхээс өөрчлөгдсөн ч хүлээн авсан хэрэг, нэхэмжлэлийн тоонд шийдвэрлэж байгаа хэргийн тооны эзлэх хэмжээ жил бүр ойролцоо болохыг харуулж байна. Энэ нь шүүгчийн орон тоог нэмээгүй жилүүдэд шүүгч хүлээн авсан хэмжээгээрээ ачаалал ихтэй эсвэл багатай ажиллаж байгаа дүр зургийг харуулж байна.

--oOo--

4.1. ШҮҮХИЙН ХЯНАН ШИЙДВЭРЛЭСЭН ХЭРГИЙН ТООНД НӨЛӨӨЛЖ БУЙ ХҮЧИН ЗҮЙЛИЙН ШИНЖИЛГЭЭНД ХИЙСЭН ДҮГНЭЛТ

Шүүхийн захиргааны сургалт, судалгааны төв болон Хэргийн хөдөлгөөний хэлтэс хамтран хийсэн анхан шатны шүүхийн шийдвэрлэсэн хэргийн тоонд нөлөөлж буй хүчин зүйлийн шинжилгээг судлан үзээд дараах мэдээлэл шүүх байгуулах асуудлын талаар санал боловсруулахад ашиглагдаж болохоор байна.

Энэхүү шинжилгээнд 2004-2021 оны хугацаан дахь 18 жилийн динамик өгөгдөл шүүх бүрээр гарах боломжгүй байсантай холбоотойгоор тус хугацаанд шүүхээс хянан шийдвэрлэсэн хэргийн тоонд хугацааны цуваан шинжилгээ хийгдээгүй байна. Энэ нь ирэх жилүүдэд шүүхийн хэргийн ачаалал нэмэгдэх урт хугацааны хандлагыг тооцон гаргах боломжгүй нөхцөл байдлыг үүсгэсэн байх тул уг 18 жилийн хугацаанд шүүхийн шийдвэрийн тоонд нөлөөлж байсан өнгөрсөн хугацааны хүчин зүйлсийн шинжилгээг нийслэл, аймгаар хийжээ.

Харин ХААИС-ийн судалгааны дүн буюу шүүхийн 2017-2021 онд шийдвэрлэсэн 5 жилийн өгөгдөлд үндэслэн ойрын 3 жилийн буюу 2024 он хүртэл богино хугацаанд шүүхээс шийдвэрлэж болох хэргийн ачааллын хандлагыг тооцож гаргасан байна. Үүнд:

Анхан шатны шүүх: Нийслэл дэх төвийн 6 дүүргийн хэмжээнд эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн ачаалал 2024 он хүртэл 1-2 хэргээр, зөрчлийн хэрэг 27 хэргээр, иргэний хэрэг 1 хэргээр өсөх бол захын 3 дүүрэгт эрүү 0.3, зөрчил 1-2, иргэн 3 хэргээр, захиргаа 0.21 хувь буюу 1 хэрэгт хүрэхгүй ачаалалтай байх бол аймгийн шүүхэд эрүүгийн 3 хэрэг, иргэний 6 хэрэг, зөрчлийн 6 хэрэг, сум дахь сум дундын шүүхэд эрүүгийн 0.09, зөрчлийн 1.2, иргэний 3 хэргээр нэмэгдэх бол захиргааны шүүх -0.39 хэргээр буурах тооцоо гарчээ.

Давж заалдах шатны шүүх: Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх 2 хэргээр нэмэгдэх бол захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх, аймгийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шийдвэрлэх хэрэг буурах, бусад давж заалдах шатны шүүхийн хянан шийдвэрлэх хэрэг тогтвортой байх хандлагын тооцоо гарсан байна.

Иймд дээрх тооцооллоос дүгнэхэд ХААИС-ийн үндсэн тайлангийн 4 дүгээр бүлэгт гаргасан шүүхийн дундаж ачаалалд үндэслэсэн шаардлагатай шүүгчийн тооны тооцоотой нийцэж байх тул уг шүүгчийн орон тоог нэмэгдүүлэх тооцоог ашиглах боломжтой байна. Энэхүү нэмэгдэх шүүгчийн орон тоотойгоор ажиллахад 2022-2024 он хүртэл шүүхэд орон тооны дутагдал үүсэхээргүй байна.

Мөн уг шинжилгээгээр зөрчлийн хэргийн тоо жилд 9 хэргээр нэмэгдэх хандлагатай байгаа нь ХААИС-ийн үндсэн тайлангийн 5 дугаар бүлэгт дурдсан нийслэл дэх төвийн 6 дүүргийн зөрчлийн хэргийн шүүх байгуулах саналтай нийцэж байна. Харин уг хандлагын судалгааны дүнгээс иргэний хэргийн анхан шатны шүүхийн хэргийн тоо хамгийн ихдээ 1 хэргээр нэмэгдэж байгаагаас дүгнэхэд тайлангийн 5 дугаар бүлэгт санал болгосон иргэний хэргийн бага үнийн дүнтэй шүүх байгуулах нь одоо байгаа төвийн 6 дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн ачааллыг багасгах үр нөлөөтэй байхаар байна.

Зургаа. ШҮҮХЭЭР ХЯНАН ШИЙДВЭРЛЭСЭН ЗАХИРГАА, ИРГЭН, ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ӨСӨЛТ БУУРАЛТАД ХУУЛИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ҮЗҮҮЛСЭН НӨЛӨӨЛӨЛ

Нэг. Захиргааны хэргийн шүүхийн хянан шийдвэрлэсэн хэргийн өсөлт бууралтад хуулийн өөрчлөлтийн үзүүлсэн нөлөөлөл

Хуульд оруулсан нэмэлт өөрчлөлт нь шүүхээр хянан шийдвэрлэсэн хэргийн өсөлт бууралтад нөлөөлдөг болох нь хавсралтад дурдагдсан хэрэг хянан шийдвэрлэсэн тоон мэдээллээс анзаарагдлаа.

Дараах хуулийн өөрчлөлтүүд нь захиргааны хэргийн шүүхээр хянан шийдвэрлэгдсэн хэргийн өсөлт, бууралтад нөлөөлсөн байна. Үүнд:

1.Захиргааны ерөнхий хууль /2016он/

Захиргааны ерөнхий хууль 2016 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд дагаж мөрдөж эхэлсэнтэй холбоотойгоор Захиргааны хэргийн анхан шатны шүүх улсын дүнгээр 2017 онд нийт 1908 хэргийг шийдвэрлэсэн нь өмнөх жилүүдээс хамгийн өндөр дүн гарсан байна.

Давж заалдах шатны шүүхийн хувьд улсын дүнгээр 2017 онд нийт 923 хэргийг шийдвэрлэсэн нь өмнөх жилүүдээс хамгийн өндөр дүн гарсан байна.

Хяналтын шатны шүүх Улсын дүнгээр Захиргааны ерөнхий хууль батлагдахаас өмнө буюу 2004 онд нийт 134, давж заалдах шатны шүүх нийт 15 хэргийг шийдвэрлэсэн нь хамгийн бага үзүүлэлт байна.

2.Шүүх байгуулах тухай хууль /2013 он/

2013 оны Шүүх байгуулах тухай хуулийг тус оны 4 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөж эхэлсэн.

1993-2013 он хүртэл Улсын дээд шүүх 1, Аймаг нийслэлийн шүүх 23, Сум буюу сум дундын дүүргийн шүүх 60, нийт 84 шүүх үйл ажиллагаа явуулж байсан.

Харин 2013 оны Шүүх байгуулах тухай хуулиар Улсын дээд шүүх 1, Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх, Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх тус бүр дөрөв, Захиргааны хэргийн анхан шатны шүүх 20, Сум дундын шүүх 29 нийт анхан шатны 57, Давж заалдах шатны шүүх 21 байгуулсан.

Шүүх байгуулах тухай хуулийг шинэчлэн баталснаар Захиргааны хэргийн анхан шатны шүүх 2014 онд нийт 1187 хэргийг шийдвэрлэсэн нь өмнөх онуудаас өссөн дүнтэй гарчээ.

Давж заалдах шатны шүүх 2014 онд 512 анхан шатны шүүхийн шийдвэрийг хянан шийдвэрлэсэн нь өссөн дүнтэй гарсан.

Хяналтын шатны шүүхийн хувьд 2013 онд улсын дүнгээр 245 хэрэг хянасан нь өмнөх жил буюу 2011 онд 240, 2012 онд 212 хэрэг тус тус шийдвэрлэсэн өссөн дүнтэй байна.

3.Шүүх байгуулах тухай хууль /2015 он/

2015 оны 6 дугаар сарын 19-ний өдөр батлагдсан Шүүх байгуулах тухай хууль нь тус оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж эхэлсэн. Тус хуулиар Нийслэлд Захиргааны хэргийн анхан шатны шүүхийг байгуулахдаа Нийслэлийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгжийг хамруулан нэг байхаар зохицуулсан.

Захиргааны хэргийн анхан шатны шүүх 2016 онд улсын хэмжээнд нийт 1780 хэрэг, үүнээс нийслэлд 1079 захиргааны хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэсэн нь өмнөх онуудынхаас өссөн дүнтэй гарсан байна.

Тухайлбал 2014 онд 1187, 2015 онд 1439 хэрэг тус тус шийдвэрлэсэн байна.

Давж заалдах шатны шүүх улсын дүнгээр 2016 онд 823 анхан шатны шүүхийн шийдвэрийг хянасан шийдвэрлэсэн өссөн дүнтэй гарсан. Харин 2014 онд 512 хэрэг шийдвэрлэсэн байна.

Хоёр. Иргэний хэргийн шүүхийн хянан шийдвэрлэсэн хэргийн өсөлт бууралтад хуулийн өөрчлөлтийн үзүүлсэн нөлөөлөл

Дараах хуулийн өөрчлөлтүүд нь иргэний хэргийн шүүхээр хянан шийдвэрлэгдсэн хэргийн өсөлт, бууралтад нөлөөлсөн байна.

1.Иргэний хууль

2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр батлагдан Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд дагаж мөрдөж эхэлсэн бөгөөд Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2004-2021 онд шийдвэрлэсэн хэргийн тоон үзүүлэлтийг харьцуулахад улсын дүнгээр 2004 онд нийт 23269 хэргийг шийдвэрлэсэн хамгийн бага тоон үзүүлэлтэй, улсын дүнгээр 2020 онд нийт 53678 хэргийг шийдвэрлэсэн нь хамгийн өндөр дүн гарсан байна.

Давж заалдах шатны шүүхийн хувьд улсын дүнгээр 2005 онд 1299 хэргийг хянасан хамгийн бага тоон үзүүлэлт гарсан бөгөөд 2017 онд нийт 3721 хэргийг шийдвэрлэсэн нь өмнөх жилүүдээс хамгийн өндөр дүн гарсан байна.

Иргэний хэргийн хяналтын шатны шүүхийн 2008-2021 онд шийдвэрлэсэн хэргийн тоон үзүүлэлтийг харьцуулахад 2008 онд нийт 589 хэргийг шийдвэрлэсэн хамгийн бага тоон үзүүлэлттэй бөгөөд улсын дүнгээр 2018 онд нийт 1932 хэргийг шийдвэрлэсэн нь өмнөх жилүүдээс хамгийн өндөр дүн гарсан байна.

2.Шүүх байгуулах тухай хууль /2013 он/

Шүүх байгуулах тухай хууль 2013 оны 4 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд дагаж мөрдөж эхэлсэн бөгөөд улсын дүнгээр Иргэний хэргийн анхан шатны шүүх 2014 онд нийт 33996 хэргийг шийдвэрлэсэн нь өмнөх онуудаас өссөн дүнтэй гарсан.

Давж заалдах шатны шүүх 2014 онд 1924 анхан шатны шүүхийн шийдвэрийг хянасан шийдвэрлэсэн нь өссөн дүнтэй гарсан. Үүний өмнөх жил буюу 2012 онд 1634, 2013 онд 1806 хэрэг тус тус шийдвэрлэсэн байна.

Хяналтын шатны шүүх улсын дүнгээр 2014 онд нийт 841 хэрэг хянасан нь өмнөх жил буюу 2012 онд 753, 2013 онд 759 хэрэг тус тус шийдвэрлэсэн өссөн дүнтэй байна.

3.Шүүх байгуулах тухай хууль /2015 он/

Шүүх байгуулах тухай хууль 2015 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд дагаж мөрдөж эхэлсэнтэй холбогдуулан улсын дүнгээр Иргэний хэргийн анхан шатны шүүх 2016 онд нийт 46578 хэргийг шийдвэрлэсэн нь мөн өмнөх онуудаас өссөн дүнтэй гарсан. Тухайлбал 2014 онд 33996, 2015 онд 40674 хэрэг тус тус шийдвэрлэсэн байна.

Давж заалдах шатны шүүх улсын дүнгээр 2016 онд 3108 анхан шатны шүүхийн шийдвэрийг хянасан шийдвэрлэсэн өссөн дүнтэй гарсан. Тухайлбал 2014 онд 1947, 2015 онд 2519 хэрэг тус тус шийдвэрлэсэн байна.

Гурав. Эрүүгийн хэргийн шүүхийн хянан шийдвэрлэсэн хэргийн өсөлт бууралтад хуулийн өөрчлөлтийн үзүүлсэн нөлөөлөл

Дараах хуулийн өөрчлөлтүүд нь Эрүүгийн хэргийн шүүхээр хянан шийдвэрлэгдсэн хэргийн өсөлт, бууралтад нөлөөлсөн байна.

1.Эрүүгийн хууль

2002 оны 9 дүгээр сарын 01-ний өдөр, 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрүүдээс эхлэн Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд дагаж мөрдөж эхэлсэнтэй холбоотойгоор Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх улсын дүнгээр 2003 онд нийт 5874 хэрэг, 2004 онд нийт 6272 хэрэг шийдвэрлэсэн, улсын дүнгээр 2017 онд нийт 8839 хэрэг, 2018 онд нийт 12551 хэрэг шийдвэрлэсэн нь өмнөх жилүүдээс өссөн дүн гарсан байна.

Давж заалдах шатны шүүхийн хувьд улсын дүнгээр 2003 онд нийт 1809 хэрэг, 2004 онд нийт 1888 хэрэг шийдвэрлэсэн, улсын дүнгээр 2017 онд нийт 1971 хэрэг, 2018 онд нийт 2166 хэрэг шийдвэрлэсэн нь өмнөх жилүүдээс өссөн дүн гарсан байна.

Хяналтын шатны шүүх 2017 онд 342, 2018 онд 851 хэрэг, 2019 онд 927 хэрэг хянасан өмнөх жилүүдээс хамгийн өндөр дүн гарсан байна.

2.Шүүх байгуулах тухай хууль /2013 он/

Шүүх байгуулах тухай хууль 2013 оны 4 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд дагаж мөрдөж эхэлсэн бөгөөд улсын дүнгээр Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 2014 онд нийт 6375 хэргийг шийдвэрлэсэн нь өмнөх оноос өссөн дүнтэй гарсан.

Давж заалдах шатны шүүх улсын дүнгээр Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 2014 онд нийт 2161 хэргийг шийдвэрлэсэн нь өмнөх оноос өссөн дүнтэй гарсан.

Хяналтын шатны шүүх улсын дүнгээр 2014 онд нийт 629 хэрэг хянасан байна.

3.Шүүх байгуулах тухай хууль /2015 он/

Шүүх байгуулах тухай хууль 2015 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд дагаж мөрдөж эхэлсэнтэй холбогдуулан улсын дүнгээр Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 2016 онд нийт 5762 хэргийг шийдвэрлэсэн нь өмнөх оноос буурсан дүнтэй гарсан. Тухайлбал 2014 онд 6375, 2015 онд 6756 хэргийг тус тус шийдвэрлэсэн байна.

Давж заалдах шатны шүүх улсын дүнгээр 2016 онд 1822 анхан шатны шүүхийн шийдвэрийг хянасан шийдвэрлэсэн буурсан дүнтэй гарсан. Тухайлбал 2014 онд 2161, 2015 онд 1971 хэрэг тус тус шийдвэрлэсэн байна.

--oOo--